



ХУУЛЬ ЗҮЙН  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



# ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, практикийн улирал тутмын сэргүүл

(01) 9 он. Цуврал 4 (74)

Улаанбаатар хот  
2019 он

## EDITORIAL BOARD

|                 |  |
|-----------------|--|
| J.Amarsanaa     | <i>Academician, Merited Lawyer of Mongolia</i> |
| Ts.Sarantuya    | <i>(Sc.D), Merited Lawyer of Mongolia</i>      |
| B.Bayarsaikhan  | <i>(Ph.D)</i>                                  |
| D.Gangabaatar   | <i>(LL.D)</i>                                  |
| D.Zumberellkham | <i>(Ph.D)</i>                                  |
| J.Oyuntungalag  | <i>(LL.D)</i>                                  |
| D.Sunjid        | <i>(Dr.jur)</i>                                |
| P.Amarjargal    | <i>(Ph.D)</i>                                  |
| Z.Sukhbaatar    | <i>(Ph.D)</i>                                  |
| Ts.Tsogt        | <i>(LL.D)</i>                                  |

*Executive Editor-in-Chief*  
Director, The National Legal Institute

S.Enkhtsetseg

*Acting Assistant Editor*  
Researcher, The National Legal Institute  
J.Bulgansuren

*Designed by*  
Designer, The National Legal Institute  
D.Munkhjargal

State Registration Number:279  
ISSN: 2226-9185  
The National Legal Institute  
publishes this law review five times  
per year.

Address: 4th Khoroo, Chingeltei District,  
Lawyer's Street-1, Ulaanbaatar-15160, Mongolia  
Phone:+(976)-11-315735  
Fax: 315735  
Website: [www.nli.gov.mn](http://www.nli.gov.mn)  
E-mail: [lawjournal@legalinstitute.mn](mailto:lawjournal@legalinstitute.mn)

# АГУУЛГА

## ХУУЛЬ ТӨРӨХИЙН ӨМНӨ /ОНЦЛОХ ӨГҮҮЛЭЛ, ЯРИЛЦЛАГА/

|   |    |
|---|----|
| Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн үзэл баримтдал, эрх зүйн шинжилгээ   | 9  |
| Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга,<br>хууль зүйн доктор, дэд профессор П.Амаржаргал                            |    |
| Хяналт угүй бол хариуцлага угүй   | 18 |
| МУИС-ийн ОУХНУС-ийн Нийтийн удирдлагын тэнхимийн эрхлээч<br>профессор, доктор Н.Бурмаа  |    |
| Захиргааны байгууллагын шийдвэр гаргахад бодит нөхцөл байдлыг хэрхэн<br>тогтоо вэ? Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тухайд        | 28 |
| Удирдлагын академийн багш, доктор, дэд профессор А.Алтанзул   |    |
| Эмийн хууль бус эргэлт, хэрэглээг хязгаарлах шаардлага, үндэслэл  | 33 |
| ҮЕПГ-ын Сургалт судалгааны төвийн алдах прокурор, хууль цаазын шадар<br>звэвэх, хууль зүйн доктор Б.Өнөрмард                                |    |
| Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн<br>зохицуулалт, зүйлээлийн асуудал   | 38 |
| МУИС-ийн Хууль зүйн сургуулын Нийтийн эрх зүйн тэнхимийн багш,<br>хууль зүйн доктор, дэд профессор Д.Бадам                                  |    |
| Хууль зүйн магистр У.Баянтоогох   |    |
| <b>ЭРХ ЗҮЙН СЭТГЭЛГЭЭ: ҮЗЭЛ БОДОЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ</b>   |    |
| Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд тулгамдаж буй асуудал  | 50 |
| Хэнтiiй аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны<br>шүүхийн шүүгч Д.Ганзориг  |    |
| Хүн барьцаалахын эсрэг олон улсын эрх зүйн зохицуулалт  | 55 |
| ДХИС-ийн УА-ийн УУПБ-ийн профессор, цагдаагийн хурандaa Д.Сундуйсүрэн   |    |
| Эрүүгийн процесс түргэвчилсэн ажиллагааны мөн чанарын талаарх   | 64 |
| Ромын эрх зүйн үзэл зүйлс   |    |
| ҮЕПГ-ын туслах прокурор, мониторингийн хэлтсийн дарга Б.Бат-Оршил   |    |
| Сонгуулийн тогтолцоог эргэцүүлэх нь   | 73 |
| МУИС-ийн ХЭС-ийн докторант С.Номынбаясгалан   |    |
| Үндсэн хууль дахь орлогын албан татварын зарчим   | 84 |
| МУИС-ийн ХЭС-ийн магистрант Л.Загдаа  |    |
| Эрүүгийн эрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь иргэний ихээмжлэлийг<br>шалган тогтоох, хянан шийдвэрлэлтийн хэрэгжилтийг хангаж буй практик | 92 |
| Үнээний батлан хамгаалахын их сургуулийн багш М.Ванчимаа  |    |

## ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ

|   |     |
|---|-----|
| Компанийн хууль зүйн зохицуулалтын оноолын асуудал<br>Печийн их сургуулийн докторант Б.Урнаа  | 101 |
| Шүүх дэх эвлэрүүлээ зуучлах ажиллагчанд тулгамдах буй асуудал<br>Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн<br>эвлэрүүлэн зуучлач Б.Дугармаа  | 107 |
| Захиргааны грээний маргааны хэргийн харьяалал<br>МУИС-ийн ХЭС-ийн магистрант Г.Урангуа  | 114 |
| Газар ээмшигч эрхтэй холбоотой хууль зүйн зарим асуудал<br>Хуульч А.Тувшинтөгс  | 123 |
| Иргэний хууль дахь мэдээ тараах ўйлдэл болон тайлбар, санал,<br>шүүмжлэл зэргийг ялгах нь<br>МУИС-ийн ХЭС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш Р.Пүрэвбаатар  | 132 |
| Уул уухайн тослуудийн нөлоөвлөлдөр ортон орон нутгийн иргэдэд иөхөх<br>олговор олгож буй практик<br>МУИС-ийн ХЭС-ийн магистрант П.Байгамаа  | 143 |
| Бүгд Найрамдах Чех улсын өмгөөлөгчдийн байгууллага<br>Монгол өмгөөлөгч ХХН-ийн өмгөөлөгч П.Оюун-Эрдэнэ  | 152 |
| Мансууруулах бодлостой холбоотой гэмт хэрэгт холбогдогчдын шүүхийн сэтгэгч<br>эмгэг судлалын магадлан шинжилгээ хийлгэх үеийн сэтгэцийн байдал<br>СЭМҮТ-ийн ШСЭСК-ийн эрхэгч, АУ-ны магистрант С.Байгальмаа | 157 |
| Татвар төлөхөөс зугтаг гэмт хэрэг, түүний онцлог шинж<br>ХҮИС-ийн ахлах багш С.Рензэндорж<br>Өмгөөлөгч О.Чудуунцээг   | 161 |
| Шашны байгууллагын санхүүжилт ба эрх зүйн зохицуулалт<br>УБХИС-ын Аюулгүй байдал судлалын докторант Х.Мариям  | 169 |

## ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА, ТОЙМ , ҮР ДҮН

|   |     |
|---|-----|
| Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 19 дүгээр зүйлтэй<br>үндэсний хүчин төгөлдөр хууль тогтоомж нийцэж байгаа эсэх болон тэдгээр<br>хуулийн хэргжилтийн үр дагаварт хийсэн үзүүлэлт<br>Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төв<br>АНУ, Япон, Монгол Улс дахь бахирдалыг артилгах тогтолцоо: харьцуулсан судалгаа | 174 |
| Нагоягийн Их Сургуулийн багши, хууль зүйн доктор Г.Давааням<br>Гадаадын хөгжлийн орнуудын эрүүгийн эрх зүй дэх нийтэд тустай ажил<br>хийлгэх яланг зарим харьцуулсан судалгаа, нийтлэг жишиг<br>МХХ-ны Хууль зүйн шинжээлэх ухаан, боловсралын хөгжлийг дэмжих хорооны<br>дараа Ц.Мөнхбат   | 193 |
| Шүүхээс оногдуулж буй яланг болдлого судалгааны тайлан<br>ҮЕПГ-ын Сургалт судалгааны төвийн багши, хянналтын прокурор Г.Оюунбагалд  | 201 |
| Монгол Улсын Ерөнхийлөгч, Бүгд Найрамдах Франц Улсын<br>Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг харьцуулсан судлах нь<br>Хар хорин сум дахь сум дундын прокурорын газрын ерөнхий прокурор,<br>хууль цаазын итгээмжит зөвлөх Ш.Баасандорж  | 218 |

# CONTENT

---

## BEFORE CREATING A LAW /UNDERLINE ARTICLE AND INTERVIEW/

|   |    |
|---|----|
| <b>The Concept and Legal Analyze for Veto Power of the President of Mongolia</b>  | 9  |
| <i>Amarjargal.P. (Ph.D.), Associate Professor, Academic secretary of the National Legal Institute of Mongolia</i>                                 |    |
| <b>How the Absence of the Review Leads to the Irresponsibility</b>  | 18 |
| <i>Burmaa.N. Dr.rer.republ., Professor of the School of International relations and Public administrations, National University of Mongolia</i>   |    |
| <b>How to Determine Actual Facts in the Administrative Decision-Making Procedure?</b>   | 28 |
| <b>On Developments of A Legal Regulation</b>  | 28 |
| <i>Altanzul.A. (Ph.D.), Associate Prof., National Academy of Governance</i>   |    |
| <b>Requirement and Grounds Limiting Illegal Trade or usage of Prescription Drugs</b>  | 33 |
| <i>Unurmaa.B. (Ph.D.), Supervising Prosecutor, Legal senior consultant of the Training and research center of the Prosecutor General's Office</i> |    |
| <b>Regulation of Domestic Violence in Criminal Law and its Classifications</b>  | 38 |
| <i>Badam.D. (Ph.D.), Associate Professor of Public Law Department, School of Law, National University of Mongolia</i>                             |    |
| <i>Buyantogtokh.U. LL.M. of the School of Law, National University of Mongolia</i>  |    |

## LEGAL THINKING: VIEWS AND REFLECTIONS

|  |    |
|--|----|
| <b>Issues on Criminal Liability of Legal Persons</b>   | 50 |
| <i>Ganzorig.D. Judge of the Inter-soum first instance court for criminal cases of the Khentii province</i> |    |
| <b>International Legal Regulation Against the Taking of Hostages</b>                                       | 55 |
| <i>Sunduisuren.D. Police Colonel and Professor at the University of Internal Affairs</i>                   |    |
| <b>Roman Law Values on the Effects of Simpler and Faster Forms on Criminal Procedure</b>                   | 64 |
| <i>Bai-Orshikh.B. Assistant Prosecutor, Head of Monitoring Center at the Prosecutor General's Office</i>   |    |
| <b>Consideration of Electoral System</b>   | 73 |
| <i>Nomynbayasgalan S. Ph.D. candidate of the School of Law, National University of Mongolia</i>            |    |
| <b>Principle of Income-tax in the Constitution of Mongolia</b>   | 84 |
| <i>Zagdaa.L. LL.M. candidate of the School of Law, National University of Mongolia</i>                     |    |
| <b>Practical Challenges Determining or Satisfying Civil Suit in a Criminal Case</b>                        | 92 |
| <i>Yanchigmaa. M. Lecturer at National Security School of the Law Enforcement University</i>               |    |

## **IMPLEMENTATION OF EFFICIENCY AND LAW**

|  |     |
|--|-----|
| <b>Legal Theories of Company Groups</b>  | 101 |
| Urnaa.B, Ph.D candidate, University of Pecs  |     |
| <b>Issues of the Court Consolidation Procedures</b>  | 107 |
| Dugarmaa.B, Consolidator at Inter-soum first instance court for civil cases of the Umnugobi province   |     |
| <b>Administrative Contract Jurisdiction</b>  | 114 |
| Urangua.G, LL.M. candidate of the School of Law, National University of Mongolia   |     |
| <b>Legal Issues for Land Ownership Rights</b>  | 123 |
| Tuvshintugs.A, Advocate  |     |
| <b>Distinguishing Terms in Civil law: Comment, Opinion, Criticism and Information Spreading</b>  | 132 |
| Purevbaatar.R, (LL.M), Lecturer of the Private Law Department at School of Law, National University of Mongolia  |     |
| <b>Practices for Mining Project Compensation for Local Citizens</b>  | 143 |
| Baigalmaa.P, LL.M. candidate of the School of Law, National University of Mongolia   |     |
| <b>Czech Bar Association</b>   | 152 |
| Oyun-Erdene.P, Advocate at Mongol Advocate Partnership LLC   |     |
| <b>Suspected Person's Psychological Condition During Examination for Forensic Psychology Assessment for Narcotic Substance-Related Offenses</b>            | 157 |
| Baigalmaa.S, Director of Forensic psychology department at the National Center for Mental health, MMedSc candidate, National University of Medical Science |     |
| <b>Tax Evasion Felony and its Characteristics</b>  | 161 |
| Rentsendorj.C, Senior lecturer at the University of Commerce and Business  |     |
| Chuluuntseseg.O, Advocate  |     |
| <b>Religious Risks as a Threat to National Security</b>  | 169 |
| Mariyam.Kh, Ph.D candidate, National Defense University of Mongolia  |     |

## **LEGAL RESEARCH OVERVIEW**

|   |     |
|---|-----|
| <b>Analyzes on the Compatibility of the Article 19 of the Iccpr With Valid National Laws and Research Report on the Implementational Consequences of the Legislations</b> | 174 |
| Legal Research Center of the National Legal Institute   |     |
| <b>Comparative Research of the Waste Removal System in the Usa, Japan and Mongolia</b>  | 184 |
| Davaanyam.G, Ph.D., Lecturer at CJLM of the Nagoya University   |     |
| <b>Comparative Research, Common Precedence on Criminal Liability of Community Service of the Developing Countries</b>   | 193 |
| Munkhbat.Ts, Supervising Prosecutor and researcher, Training and research center of the Prosecutor General's Office   |     |
| <b>"Sentencing Policy Implemented by the Courts" Research Report</b>  | 201 |
| Oynbold.G, Supervising Prosecutor and researcher, Training and research center of the Prosecutor General's Office   |     |
| <b>A Comparison Research on the Presidential Powers of France and Mongolia</b>  | 218 |
| Baasandorj.Sh, General prosecutor and legal consultant of the Inter-soum Prosecutor General's office of the Khar-Khorum soum  |     |

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХОРИГИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн  
Эрдэмтэн нарийн бичгийн дэргэ,  
хууль зүйн доктор, дэд профессор  
**П.Амаржаргал**

Манай улсад хууль тогтоох байгууллага болох Улсын Их Хурал, төрийн тэргүүний чиг үүргийг гүйцэтгэх Ерөнхийлөгчийн институтийн аль аль нь ард түмнээс сонгогдлог, төлөөллийн багтууллагын шинжлэгчийг билээ.

Дэлхийн улс орнуудад Ерөнхийлөгчийн институт нь төрийн тэргүүний эсхүл гүйцэтгэх эрх мэдлийн чиг үүргийн аль нэгийг, эсхүл хослуулан хэрэгжүүлдгээс шалтгаалан төрийн засаглалын хэлбэр тодорхойлгодог тул Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн хоорондын харилцааны асуудлыг Үндсэн хуулиар тухайллан зохицуулах шаардлагатай болдог.

Эдгээрийг тоймлои авч үзвэл нэг талаас Ерөнхийлөгч Улсын Их Хурлын хууль тогтоох ўйл ажиллагаанд, негеэ талаас Улсын Их Хурал Ерөнхийлөгчийг бүрэн эрхээ хэрэгжүүлжээд нь тодорхой байдлаар оролцож зэрэг харилсан хяналтын шинжлэгчийг үзүүлдэг Үндсэн хуулиар

тодорхойлсон байдаг.<sup>1</sup>

Ерөнхийлөгчийн холбоотой хэрэгжүүлэх Улсын Их Хурал бүрэн эрхийн талаарх Үидсэн хуулийн зохицуулалтыг нарийвчлан зохицуулсан хуулийн заалтууд, практикаас үзэхдээ Ерөнхийлөгчийн сонгууль зарлах, бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх, хууль бус шийдвэрийн нь хүчингүй болгох болон Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд ажлаа тайлмагнах, томилгооны талаар танилцуулах бүрэн эрхийн хувьд ёсчлох агуулгатай, харин Ерөнхийлөгчийн сонгуульд изэр дэвшиүүлэх, Ерөнхий прокурор, түүний орлогч, гадаад улсад суух бүрэн эрхт төвлөгөгчийн газрын тэргүүн, Зэвсэгт хүчиний жанжин штабын дарга зэрэг албан тушаалтныг томилоход тодорхой нөлөө, ач холбогдолтой оролцож байна. Тодруулбал, зарим албан тушаалтныг томилохи бүрэн эрхийг Ерөнхийлөгчид олгогдоюуг бүрэн эрхээ урвуулан ашиглах, ийгэмд илт хүлээн зөвшөөрөгдөхгүй томилгоо хийхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор Улсын Их Хуралтай зөвшилцдэг, санал авдаг, танилцуулдаг эзижүү механизмыг Үндсэн хуульд заасан гэж үзэхээр байна.<sup>2</sup>

Түүнчлэн ард түмнээс шууд сонгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлдэг Ерөнхийлөгчийн хувьд түүнд харинчлагага тооцох тодорхой субъект байдагтгүй тул ерөнхийлөгч үндсэн хуулийг зөрчсөн талаар Үндсэн хуулийн цэээс дүгнэлэг гаргавал Улсын Их Хурал дийлэнх олонхоороо шийдвэрлэн огцруулах боломжийг Үндсэн хуулиар олгожээ.

<sup>1</sup> П.Амаржаргал. "Улсын Их Хурлын хууль тогтоох ўйл ажиллагааны давхар Ерөнхийлөгчийн оролцоо: хууль тогтоомжийн тавих кориг", Үндсэн хууль ёс ба Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн олон усмын оногдлын практикнын бага хурал, Уб., 2015 он, №3 даал тал.

<sup>2</sup> П.Амаржаргал. "Парламентын хууль тогтоох бүрэн эрх ба ерөнхийлөгчийн кориг" Хууль дээдэлж ёс сэссүүл, Уб., 2014 он № 2.

Ерөнхийлөгчийн зүгээс Улсын Их Хурлын үйл ажиллагаанд оролцож хүрээ хязгаарын тухайд Улсын Их Хурлыг тараах, хууль санаачлах, хууль тогтоомжийн талаар саналаа илэрхийлэх, хориг тавих зэрэг бүрэн эрхийг ёсчлоо агуулгатай гэж үзж болохгүй юм. Учир нь эдгээр бүрэн эрх хууль зүйн тодорхой ур дагавар үсгэдэг хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааг хязгаарлах чухал хөшүүргэл болдог. Гэхдээ эдгээр бүх бүрэн эрхийг нэг сэдийн хүрээнд нарийвчлан задлан шинжлэх боломжгүй тул төлөөллийн байгууллагын үндсэн үйл ажиллагаа болох хууль тогтоох үйл ажиллагаанд Ерөнхийлөгчийн зүгээс хориг тавин оролцохтой холбоотой онол, практикийн асуудлыг энэ илтгэлийн хүрээнд авч үзээ.

Ерөнхийлөгчийн хориг нь парламентын хууль тогтоох бүрэн эрхэд нөлөөлөх чухал хэрэгслэл болон өргөнөөр хэрэглэдэж байна. Манай улсын хувьд энэ жишгийг дагаж багааг бил Ерөнхийлөгчийн хоригийн таларх Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтаас харж болно. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх эхийн 1-д “Ерөнхийлөгч... Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бухгалд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих эрхтэй. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнз” гэж заажээ.

Ерөнхийлөгчийн хоригийн энэхүү механизмыг ашиглах хууль зүйн болон улс төрийн зорилго, ур дагавар зэргийг судалсны үндсэн дээр Ерөнхийлөгчөөс парламентын баталсан хууль тогтоомжид хориг тавих тухай Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх завалтын агуулга, түүний Үндсэн хуулийн тогтолцоонд гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг тодорхойлох юм.

### “Хориг”-ийн тухай ойлголт

Ерөнхийлөгчийн хоригийн талаар судалтын, дүгнэлт хийхийн өмнө “ориг”-ийг нэр томъёо болон эрх зүйн үзүүг баримтлалын хувьд гадаад, тоотооны эх сурвалжруудад хэрхэг гэмдлэжжэйт авч үзье. Хориг буюу “veto” хэзээх нэр томъёо нь Үлээгийн хууль зүйн тайлбар тольд бичсээвэр латин хэлний “I forbid” буюу “бий хоригжжэх байна” гэсэн үтийс гаралтай, засаглалын нэг салaa мөчир нь ногөөгийнхөө үйл ажиллагааг хориглж эрх мэдэл юм. Үндсэн хуулийн эрх зүйд гүйцэтгэх засаглалын тэргүүн нь хууль тогтоогчийн баталсан хуульд гарын үсэг зурахаас татгалзах гэж хоригийг тодорхойлсон байна.<sup>3</sup>

Түүнчлэн Олон улсын эрх зүйд “хориг”-ийг санал иштгэйтэй шийдвэр гаргах шаардлагатай чухал асуудалд аль нэг гишүүн нь эсрэг саналтай байх буюу татгалзах гэсэн агуулгаар тодорхойлсон байдал.<sup>4</sup>

Хоригийн институтуу нь эртний Ромд манийн эрнэх VI зуунд *сенатад давамгайлал патриканудаас блебудын ашиг сонирхлыг хамгаалах боломжийг трибуунд алгож зорилгоор хэрэгжээдээ байсан “intercessio” хэмээх тогтолцоонос үзслэтийг юм. Трибууны хориг нь сенатаас хууль батлахыг болиулахгүй боловч хуулийн хучин чадлыг сууриндаг байжээ.*

**Хоригийн тухай үзэл баримтлал, гадаад орны загварууд**

Орчин үед хориг нь ихэвчлэн Ерөнхийлөгчийн институуцаар дамжуулж хэрэгждэг болсон. Тухайн улсын Ерөнхийлөгчийн үзэл бодол, зорилтой зөрчилдэж буй хуульд “муу хууль”, Үндсэн хуульд нийцэгүй, эсхүл Ерөнхийлөгчийн улс төрийн үзэл санаанд харш гэсэн үндэслэлээр хориг тавих байдлаар хэрэглэдэг болсон. Жишээлбэл, АНУ-ын Ерөнхийлөгч нь Конгрессоос баталж байгаа хуулийн агуулгад хоригоор дамжуулан нөлөөлөх боломжтой байдал

<sup>3</sup> Black's Law Dictionary, 8 th. ed., (2004), 1595.

<sup>4</sup> Oxford Dictionary of Law, 6 th. ed., by Elizabeth A. Martin J. Law (2006), 564

түл Ерөнхийлөгчийн улс төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал хэрэгсэл болдог.

Ерөнхийлөгчийн засаглалтай улс орнуудын хувьд ерөнхийлөгч нь төрийн тэргүүн болон гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүний үүргийт нээн зэрэг гүйцэтгээг бөгөөд төрийн тэргүүнийхээс хувьд хууль тогтоох уйл ажиллагаанд хориг тавих эрхтэй, харин гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүний хувьд хориг тавих эрхгүй байна.

Харин эрх мэдэл хуваарилах онолын дагуу хоригийг ихэвчлэн гүйцэтгээ засаглалын, эсхүл шүүгчийн чиг үүргэгээ үздэг. Өөрийн болдоглыг хэрэгжүүлэхэд хувь зөрчихөөн урьдчилан сэргийтийх, мөн муу боловсрогдсон, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжгүй хуулиас татгалзах боломжийг хориг нь Ерөнхийлөгчид олгодог. Гэхдээ хоригоор дамжуулан Ерөнхийлөгчийн болдогтын зэрэг хувь тогтоомжийг өөрчлөх, хүчингүй болгох тухай орчин үеийн үзэл баримтлал нь эрх мэдлийн хуваарилалт, бүгд найрамдах засаг болон хувь тогтоох дээд эрх мэдлийн тухай үзэл баримтлалд харш гэж үздэг.<sup>5</sup>

Вэстминстрийн загварын<sup>6</sup> хориг буюу Үндэснэ хуульт хаант засаглалын тогтолцоонд Ерөнхий сайдын зөвлөсөнөөр өзүү хаан нь өөрийн дээд эрх мэдлийг хэрэгжүүлэх уламжлалт байдал ч энэ нь маш ховор тохонлоддот. Лордын танхимд байсан хориг тавих эрхийт сүүлд хуулиар хязгаарласан байдал. Тухайлбал, 1911, 1949 оны Парламентийн тухай актуудаар уг бүрэн эрх нь хумигдаж зөвхөн хууль тогтоомжийг нэг жил хүртэл хутацаагаар хойшилуулах эрхтэй болсои. 1911 оны хуулийн дагуу санхүүгийн хуулийг, түүнчлэн Салисбурын уламжлалын дагуу Лордууд нь эрх баригч намын мөрийн хотойбөрт туссан хуулийг хойшилуулах эрхгүй юм.

Хоригийн тухай үзэл баримтлал, хэрэглээнээс үзүүлэх хориг тавих бүрэн эрх нь тодорхой зорилго, чиг үүрэгтэй холбоотойгоор хязгаартай хэрэгждэгэрээ

төрийн эрх мэдлийн бусад бүрэн эрхээс онцлог юм.

### Хоригийн хүчин чадал

Хоригийг хүчин чадлын хувьд туйлын, эсхүл харьцангуй байдлаар хэрэглэдэг байна. Тухайлбал, Нэгдсэн Үндэстний байгууллагын Аюулгүй зөвлөлийн шийдвэрт байнгын гишүүн улсууд хориг тавих эрхтэй буюу аль нэг гишүүн зөвшөөрөл өгөөгүй бол шийдвэр хүчинтэй болж чадахгүй. Үүнийг туйлын хориг гэнэ. Харин хоригийг хүлээн авахгүй байж болдог бол харьцангуй хориг хэмээн нэрлэдэг байна. Жишээлбэл, гүйцэтгэх эрх мэдлийн зүтгээс хууль тогтоогчийн баталсан хуульд тавьж буй хориг энэ ангилалд багтана.

Мен хоригийг анхдагч хууль болон нэмэлт, өөрчлөлтийн аль алинд нь хамааралтай “өргөн хүрээний”, эсхүл зөвхөн хуулийн өөрчлөлтөд л тавих буюу статускво хадгалахад чиглэсэн хориг гэсэн хувилбарууд байдаг. Өргөн хүрээний хоригийн хувь төрийн болдогод нөлөөлөх хэрэгсэл болдог бол, статуского хадгалахад чиглэсэн хоригийг одоо үйлчилж буй хууль тогтоомжийг тогтвортой байлгахад илүү чиглэсэн гэж үзж байна.

Дээр дурдсан хоригийн хууль тогтоох эрх мэдээлд үзүүлэх нөлөөллийн талаарх дээрх ангилал, шалтуурлыг манай орны зарим судлаач хөндөн авч узсан байдал. Тухайлбал, Ч.Энхбаатар, Т.Доохүү нар заавал хүлээж авах төрийн тэргүүний үзмэлхүү хориг нь үзээлэсэн болохыг дурдаад харьцангуй хориг тавьсан хуулийг парламент дахин хэлэлцэж уг хоригийг хүлээн авах эсэхээ шийдвэрлэдэг журмын талаар танилцуулжээ. Цаашилаад "...ихэнх оронд хориг нь хуулийг бүхэлд нь хамардаг боловч Франц, Филиппин, Мексик зэрэг оронд төрийн тэргүүн нь хуулийн зарим зүйл, заалтад хориг тавих боломжтой. Ийм хоригийг сонголтын хориг гэж нэрэлж боломжтой"<sup>7</sup> гэж тодорхойлон тайлбарласан байна.

<sup>5</sup> Nelson McCarty, "Presidential veto in the early republic" Princeton University <http://www.nyu.edu/gsas/dept/polisci/american-politics/pdf>

<sup>6</sup> И.Лункиндорж. Төрийн онол, Уб., 2005 он, 377 дахь тал.

<sup>7</sup> Ч.Энхбаатар, Т.Доохүү. Гадаад орнуудын Үндэснэ хуулийн эрх зүйл, Уб., 2006 он, 151 дахь тал.

Дээрх ангиллыг шалгуур болгон авч үзвэл Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин изгдүгээр зүйлээр Монгол Улсын Ерөнхийлөгчид олгосон хориг тавих бүрэн эрх нь “статускво”-г хадгалах буюу хуулийг өөрчлөхөөс сэргийлж гэдгээр хязгаарлагдахгүй, өргөн хүрээнд хэрэглэгдэж, төрийн бодлогод нөлөөлөх боломжтой ерөнхий хүрээний, парламентын зүгээс хэрэгсэхгүй болгож болдог харьцангуй хориг юм.

**Хоригийн хууль зүйн болон улс төрийн чиг үүргээ**

Одоогийн дэлхий нийтэд тогтсон жишгээр Ерөнхийлөгчийн институтийн зүгээс хоригийг улс төрийн, эсхүл хууль зүйн гэсэн хоёр үндсэн зорилгоор хэрэглэж байна. Улс төрийн зорилгын хувьд нам, улс төрийн хүчиний хоорондын тэнцвэрийг хадгалах, төрийн бодлогын талаар баримталж буй байр сууриа таниулах замаар сонгогчдыг татах зэрэг зорилгоор хэрэглэгдэдгээр улс төрийн стратегийн хэрэгсэл гэж судлаачид тэмдэглэжээ. Хууль зүйн зорилгын хувьд парламентийн баталж буй хууль тогтоомжийг тухайн улсын Үндсэн хууль, хууль зүйн бодлогод нийцүүлж байх зорилгоор хоригийг хэрэглэж явдлын ойлгоно.

Манай улсын хувьд Ерөнхийлөгчийн хоригийг дээрх хоёр зорилгын алинд нь илүү хэрэглэдэг тухай асуудал нээлттэй байгаа боловч улс төрийн, олон нийтэд намын бодлого, хөтөлбөрийг таницуулах зорилготой байсан гэж дүгнэх болохуйц тохиолдол харагдажхай байна. Энэ талаар судлаачид болон иргэд хэрхэн үзэгдгүйг дараахаа байдлаар авч үзлээ.

**Хоригийн талаар монголын судлаач, улс төрчдийн үзэл бодол**

Монголын судлаачид, улс төрчдийн энэ талаар хийсэн судалгааны бүтээл, илтгэлүүдийг тоймлон дүгнэвэл “Ерөнхийлөгчийн хориг”-ийг түүний бүрэн эрх, эсхүл парламентийн харицааны хэлбэр гэсэн хоёр чиг хандлага харагдаж байна.

Ерөнхийлөгчийн хоригийт Улсын Их Хуралтай Ерөнхийлөгчийн зүгээс харицааны хэлбэр гэснэ агуулгаар нь тодорхойлсон судлаачид байна. Тухайлбал, Монгол Улсын анхны Ерөнхийлөгч асан П.Очирибат “... Ерөнхийлөгчийн хориг нь Улсын Их Хурлын шийдвэрт ямар нэг хэмжээгээр ул итгэсэй байдал илэрхийлж биш, хуулийг аль болох алдаа мадатгүй гаргах, эцсийн анхааруулга, дахин бодох, дуттуугаа гүйцэх, буруугаа зөвтгэх, цаг үеэ олох боломж олгох, төрийн бодлогын нэгдмэл чанарагт илэрхийлжээд ач тустай арга зам мөн ...”<sup>8</sup> гэж, доктор, профессор С.Төмөр “Ерөнхийлөгчийн хууль санаачлахас гадна бусдын санаачилсан хууль санал иөхөг, узлын баримтлалын асуудлаар илрээлт явуулах, парламентын баталсан хуульд хориг тавих зэрэг үндсэн хэлбэрээр хууль тогтоох үйл ажиллагаанд парламенттaiх харилцан ажилласлаг”<sup>9</sup> гэж тодорхойлсонтой төстэй санааг доктор Б.Даш-Эндон<sup>10</sup> илрэхийлсэн байдал.

Дээрх байдлаар Ерөнхийлөгчийн хоригийг парламенттaiх харилцаан нэг хэлбэр гэж үсээнээрээ “хориг” бол парламентийн хууль тогтоох бүрэн эрхэд хөндлөнгөөс оролцож байгаа явдал гэсэн хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, доктор С.Төмөр “...1991 оны Ерөнхийлөгчийн хуулиар Ерөнхийлөгч Ардын Их Хурал, Улсын Бага Хурлын баталсан хуулийг гарын үсэг зурж батламжилдаг байв. Уг нь бусад улсын жишигт нийцэн заалт байсан боловч 1992 оны Үндсэн хуулиар дээрх бүрэн эрхийг олгоогүй юм... Харин эл бүрэн эрх /хориг тавих/ нь Улсын Их Хурлын хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлжээд Ерөнхийлөгч “хөндлөнгөөс” оролцож

<sup>8</sup> П.Очирибат. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийн бүрэн эрх актын зам мөр, УБ., 2001 он, 17-18, 27 дахь тал.

<sup>9</sup> С.Төмөр. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх түй: Монгол Улсад парламенттaiын бэсгэ төвлөвшүүлэх асуудал. Дэлхийн тал, УБ., 2006 он, 10 дахь тал.

<sup>10</sup> Б.Даш-Эндон. Төрийн тэргүүн, парламентийн засаглалтai улсын Ерөнхийлөгчийн институт. Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын зарим асуудал, УБ., 1999 он, 91-121 дахь тал.

байгаа нэг хэлбэр юм.”<sup>11</sup> гэж түүхэн харьцуулалт хийж тайлбарласны Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү, доктор Б.Даш-Эндон зэрэг хүмүүсний бүтээлд дэмжсэн агуулгаар дурдсан байдал.

Ерөнхийлөгчийн хоригийт парламенттай харилцааны хэлбэр хэмээн тодорхойлсноор түүний улс төрийн агуулгатай, төрийн бодлогод нөлөөлөх хэрэгсэл гэсэн санааг илрэхийлсэн гэж дүгнэж болохоор байна.

Удирдлага, бодлого судлалын хүрээлэнгээс Ерөнхийлөгчийн институцийн чиг үүрэг, төрийн байгуулалт дахь оролцооны талаар олон нийт, хуульчид, төрийн албан хаагчид зэрэг хүмүүсийн дунд санал асуултын судалгаа хийжээ. Санал асуултын 68,6 хувь нь Ерөнхийлөгчийн хориг тавихыг зөв гэж хариулт өгсөн ба эдгэрээс 52,3 хувь нь “Ерөнхийлөгч ард түмнээс шууд сонгогдог тул тэнцивэрт байдлын бий болгоход чухал үүргэтийн” гэж, 47 хувь нь “Ерөнхийлөгчард түүний эв нэгдлийн илрэхийлэгч болохын хувьд хориг тавихыг зүйтгэй” гэж, 0,7 хувь нь бусад байдлаар хариулжээ.<sup>12</sup>

Энэхүү санал асуултын дунгээс үзүүлэхдээ Ерөнхийлөгчийн хориг тавих эрхийг Үндсэн хуулиар бий болсон Ерөнхийлөгчийн институцийн мөн чанар, төлөөллийн талаас нь иргэд хүлээн зөвшөөрч, үүний цаана Ерөнхийлөгчийн хоригийг төрийн бодлогод нөлөөлөх хэрэгсэл гэсэн дээрх судлаачдын үзлэл болдлыг дэмжсэн гэж үзэж болохоор байна.

Нөгөө талаас, хууль зүйн салбарын эрдэмтэн, судлаачид хоригийг ерөнхийлөгчид олгогдсон онцгой “бүрэн

эрх” гэж тайлбарласан байна.<sup>13</sup>

Тухайлбал, Б.Чимид, Ц.Түмэнбаяр нар Улсын Их Хурлаас Ерөнхийлөгчийн “хоригийг хүлээн аваагүй” байгаат шүүмжилж, эрх мэдэл хуваарилдаа зарчим, парламентын байнгын үйл ажиллагаа, олонхиын зарчим, санал хураах ардчилсан ёс, Ерөнхийлөгчөөс Ерөнхий сайдтай албан ёсоор харилцах хууль зүйн үндэслэлийн тасалсан заалтуудад тавьсан ерөнхийлөгчийн хоригийг хэрэгсхүгүй орхисны буруушаасан байна. Үндсэн хуулийн зарчим, агуулгад харшилсан хууль тогтоомжид тавьсай хоригийг хүлээн аваагүй байх нь өөрөө парламентын “хууль бус” үйлдэл болно гэсэн санааг илрэхийлжээ.<sup>14</sup>

Зарим судлаачид Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болои байнгийн хорооны хуралдааны ирц, санал хуралдааны талаараа 2000 оны Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбон Ерөнхийлөгчийн хориг тавих бүрэн эрх хязгаарлгардсан гэж шүүмжилжээ.<sup>15</sup>

Түүнчлэн, Ерөнхийлөгчийн хориг тавих эрхийг, төрийн тэргүүний гзхэрээсээ илүүтэй гүйцэтгэх засаглалын тэргүүний хууль хэрэгжүүлэх эрх мэдэлтэй зарим судлаач холбон тайлбарласан байна. Манай улсын хувьд Ерөнхийлөгчийн институт

<sup>11</sup> Д.Солонго. Төрийн эрх зүйн тайлбар толь, Уб., 2003 он, 57-58 дахь тал, Ч.Энхбаттар, Д.Солонго, П.Амаржаргал, Т.Гинсбург, “Монгол Улсад ардчиллагыг блокчүүлэхдээ үндсэн хуулийн гүйцэтгэснүүрээ: дун шинжилгээ”, судлалын тайлан, Уб., 2015 он, 91-92 дахь тал, Ч.Энхбаттар. Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдал, Үндсэн хуулийн зөхнүүдэлд ба оногдлын практик слэдэв нийтгэл, “Арчилсан Улсын үзүүл-20” Эрээм шинжилгээнд курмын эмхтгээ/тэжээгээ. П.Амаржаргал нар, Уб., 2012 он, Н.Лүнзандорж. Шилжилжилтний үе: улс төр, эрх зүйн асуудал, Уб., 2010 он, 174-175 дахь тал.

Г.Баткуу, “Парламент ба төрийн институциин хоорондын харилцаа” Монгол Улсын байнгын ажиллагатай парламентийн төлөвлөлийн хөгжлийн онол практикийн курлын илтгэлүүдийн эмчтэл Эмчилгэн Л.Батгаян, Уб., 2010 он, 15-28 дахь тал, Б.Чимид, Ц.Түмэнбаяр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлын тодорхойлолын “Төслийн багийн судлалын ажлын тайлан, Уб., 2005 он, 28-29 дахь тал.

<sup>12</sup> Б.Чимид, Ц.Түмэнбаяр. Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлын тодорхойлолын “Төслийн багийн судлалын ажлын тайлан, Уб., 2005 он, 28-29 дахь тал.

<sup>13</sup> Монгол Улсын төрийн байгуулалтын тогтолцоогүүлэх боломж, арга зам /Судалгавын тайлан/ Удирдлагын академи, Удирдлага, бодлого судлалын күргүүлж Уб., 2011 он, 59 дахь тал.

гүйцэтгэх засаглалд хамаарах эсэх нь одоог хүртэл маргаантай асуудал байдаг тул төрийн тэргүүний чиг үүрэгтэй нь илүү холбон авч үзэх нь зүйтэй юм. Гүйцэтгэх засаглалын тэргүүний хувьд хуулийг бодитойгоор хэрэгжүүлэх шаардлагын үүдиэс хориг тавьдаг бол төрийн тэргүүний хувьд ард түмний нийтлэг эрх ашиг гэсэн шалтгаан нь илүү бодитой байх болов уу.

### Парламентын хууль тогтоох бүрэн эрх ба хориг

Хоригийг парламент хүлээн авах эсэхээс шалтгаалан хоригийн үндсэн хуулийн тогтолцоонд гүйцэтгэх үүрэг, үр дагавар хамаардаг байна. Ерөнхийлөгчийн хоригийг парламентын зүгээс хүлээн авахгүй байх буюу хэрэгсэхгүй болгоход тавих болсого, шаардлага нь сүл байх тусам энэ нь Ерөнхийлөгчийн хориг тавих эрх мэдэл нь сүл байдаг. Жишээлбэл, Венесуэль Улсын Үндсэн хуулийн 173 дугаар зүйл зааснаар Ерөнхийлөгч нь дийлэнх олонхын саналаар батлагдан хуульд хориг тавих боломжгүй байгаас гадна хориг тавигдаж буусан хуулийн төслийг парламент нь ердийн одонхоор дахин баталвал хууль батлагддаг сүл хориг байна. Ерөнхийлөгч хориг тавьсан хуулийн төслийг Дээд шүүх нь мөн адил Үндсэн хууль зөрчсөн гэсэн шийдвэр гаргасан тохнондолд л парламент хоригийг гарцаагүй хүлээн авах журамтай байна.<sup>16</sup>

Энэхүү жишээ болгож авсан зохицуулaltaас хараад хориг тавих, түүнийг хүлээн авах, эсхүл хэрэгсэхгүй болгох журам нь эрх мэдлийн хуваарилалтын агуулгатай байгааг харж болно. Хэдийгээр Франц Улсын Ерөнхийлөгчийн институуди хүчтэй байдаг ч хоригийн бүрэн эрх нь сүл буюу хууль тогтоох байгууллага дахь олонхын саналаар хориг няцаагддаг.<sup>17</sup>

Мөн Венесуэль Улсын жишээнээс гүйцэтгэх эрх мэдэл, шүүх эрх мэдэл хөёрын аль аль нь төслийн эсрэргүүцж байгаа

тохиолдолд хууль болсгүй буюу хууль тогтоох эрх мэдэл ньтөө хөөр засаглалын зүгээс тавьж буй хяналт хэсэгзарлалтыг харж болно.

Манай улсын хувь Үндсэн хуулийн үзэл бернимтлал, заалтуулдай парламентын баталсан хуулийг нийтийн зорилгоор Ерөнхийлөгчийн хориг тавьдаг гэж судлаачид дүгнэсэн байгаа.<sup>18</sup>

Энэ нь Ерөнхийлөгчийн хоригийт Үндсэн хуулийн хяналтын чиг үүрэгтэй болгож байгаа буюу Үндсэн хуулийн цээшиг чиг үүрэгтэй онолын хувь дэвхардаж болохоор байна. Гэвч ийм тогтолцоо нь дээр дурдсан гадаад улсын жишээн дээрх шиг хууль тогтоох эрх мэдэлд тавих хяналт, хязгаарлалт болж бас болох юм.

Харин Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг дийлэнх олонхын шийдвэрээр хэрэгсэхгүй болгодог тогтолцоонд Ерөнхийлөгчийн хоригийн бүрэн эрх хүчтэй бодлог. Учир нь хууль тогтоох байгууллага дахь төлөөлгчдийн дийлэнх нь улс төрийн хувьд Ерөнхийлөгчийн эсрэг биш л бол хоригийг дийлэнх олонхоор эсрэргүүцэх боломж бага байдаг. Ийм тогтолцоонд Ерөнхийлөгч нь хориг тавих бүрэн эрхээрээ дамжуулан хууль тогтоох үйл ажиллагаанд иелөлөх боломж өвдөр байдаг тул зарни судлаач үүнийг хууль тогтоох нэг төрийн “танхим” гэж нэрлэсэн нь ч бий. Тухайлбал, Вилиам X. Райкер Ерөнхийлөгчийн хориг тавих бүрэн эрхийг “Америкийн Нэгдсэн Улсад гурван танхимтай хууль тогтоох байгууллага” байна гэж илэрхийлжээ.<sup>19</sup>

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйл зааснаар Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүдийн гуравны хөөр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ” гэж заасан. Энэ зохицуулaltaас үзвэл манай улсын

<sup>16</sup> Б.Чимин, Ц.Түмнөнбаяр. Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдалын тодорхойллог нь Төслийн багийн судалчны албан тайлан, УБ., 2005 он, 28-29 дэх тий.

<sup>17</sup> The failure of presidential democracy: Comparative perspectives Volume 1 Edited by Juan J.Linz and Arturo Valenzuela (1994), P.335

<sup>18</sup> Мон тэнд.

Ерөнхийлөгчийн хориг тавих бүрэн эрх нь дээр дурдсанчлан нилээн хүчтэй байхаар журамлагдсан мэт боловч 76 гишүүнийн 39 нь ирснээр хүчинтэй болсон хуралдаан 27 гишүүний саналаар хоригийт хүлээн авахгүй байж болно. Энэ нь днйлэнх олонхыг шаардлаг ижил босго бүхий бусад улстай харьцуулажад эсрэг дур зурагдаж болохоор байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн дүн шинжилгээ /1993-2019 оны 8 лутгаар сарын 5-ны өдрний байдлаар/

Монгол Улсын шинэг Үндсэн хуулиар 1992 онд Ерөнхийлөгчийн институцийг бий болгосноос хойши Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өөрийн бүрэн эрхийн хүрээнд 1993-2019 оны хооронд 27 жилийн хугацаанд нийт 61 удаа хориг тавьсаны 23 нь хууль тогтоомжид бүхэлд нь, 38 нь хэсэгчлэн тавьсан хориг байна.<sup>20</sup>

#### Хүснэгт 1. Ерөнхийлөгчийн хориг (1993-2019)


| № | Монгол Улсын Ерөнхийлөгчийн төрөл    | Бүрэн эрхийн хугацаан | Бүхэлд нь тавьсан хориг | Хосчилсан тавьсан хориг | Хуулиан тасан эхийн тоо, үзүүлжсан тасан хувь |      | Хоригийн эхийн тоо, үзүүлжсан тасан хувь |
|---|--------------------------------------|-----------------------|-------------------------|-------------------------|---|------|--|
|   |                                      |                       |                         |                         | Тийм  | Үгүй |  |
| 1 | Пүршээ мэдэгжүүлэгчийн<br>Онцгойлалт | 1993-1997             | 2                       | 5                       | 3   | 4    | 7 (42 хувь)                              |
| 2 | Нийтийн<br>Задчийн<br>Багасгын       | 1997-<br>2001         | 6                       | 9                       | 11  | 4    | 15 (73 хувь)                             |
| 3 | Нийтийн<br>Багасгын<br>Эзбэрэлж      | 2001-<br>2005         | 4                       | 11                      | 9   | 6    | 15 (66 хувь)                             |
| 4 | Нийтийн<br>Эзбэрэлж                  | 2005-<br>2009         | 3                       | 6                       | 7   | 2    | 9 (78 хувь)                              |
| 5 | Цахилгаан<br>Эзбэрэлж                | 2009-<br>2013         | 2                       | 3                       | 4   | 1    | 5 (80 хувь)                              |
| 6 | Цахилгаан<br>Эзбэрэлж                | 2013-<br>2017         | 3                       | 1                       | 3   | 1    | 4 (75 хувь)                              |
| 7 | Халтмаагийн<br>Багтуулга             | 2017-                 | 3                       | 3                       | 2   | 4    | 6 (35 хувь)                              |

Нийт хоригийн 2/3-г хүлээн зөвшөөрч, үлдэх хэсэг буюу 1/3-г хүлээн зөвшөөрх боловижгүй гэсэн тогтоол гарсан байна. Ерөнхийлөгчөөс тавьсан нийт хоригийн агуулгыг авч үзвэл Улсын Их Хурал нь төрийн алба, Засгийн газар, Улсын Их Хурлын ўл ажиллагааг, Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, төрийн байгуулалт, улс төрийн нам, татвар, шүүх эрх мэдлийн үйл ажиллагаатай холбоотой

<sup>20</sup> П.Амаршаргал “Парламентийн хууль тогтоо бүрэн траяа ба ерөнхийлөгчийн хориг” Хууль дээдлэг бс сүүтгүү УБ, 2014 № 2, Г.Мянгобод, Г.Мянгутуулга. Ерөнхийлөгчийн хориг, УБ, 2018 он, 261-265 дэвс таа.

/прокурорын байгууллага, шийдвэр гүйцэтгэлийг оруулав/хууль тогтоомжуудад хориг тавьсан байна. Хүлээн зөвшөөрөгүй гэсэн хариу өгсөн тогтоолын хувьд төрийн ондөр албан тушаалтны зэрэг дав, хангамж, Засгийн газрын бүтэц, гүйцэтгэх ажлын тухай, Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн тухай, шүүх эрх мэдлийн үйл ажиллагаанд оруулсан өөрчлөлт, улс төрийн нам, төсөв, сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт зэрэг өөрчлөлттэй холбоотой асуудлууд байна.<sup>21</sup>

#### Хүснэгт 2. Хоригийн тоо, хүлээн авсан байдал



Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдуугаар зүйлд “... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” гэж заснаар Улсын Их Хурал нь хууль тогтоох бүрэн эрхийг хэрэгжүүлж байгууллага байх үзэл баримтлалын Үүднээс тайлбарлавал Улсын Их Хурлаас Ерөнхийлөгчийн хоригийт хүлээн авах эсэх нь түүний бүрэн эрхийн асуудал юм.

Улсын Их Хурал хууль тогтоох дээд эрх мэдлийг хэрэгжүүлж тохиолдолд түүний тогтоосон хуулийг “хууль ёсны”, эсхүл “хууль ёсны бус” гэж үзэх боломжтой эсэх асуудал гарч байна. Улсын Их Хурлын хууль тогтоох эрх мэдэлд тавих хязгаарлалт нь Үндсэн хуулийн хяналтын хүрээнд л хэрэгжих боломжтой юм. Нөгөөтэйгүүр парламентийн хууль тогтоох бүрэн эрхийг эрх зүйт ёсны үүднээс хязгаартай гэж үздэг үзэл баримтлалын<sup>22</sup> үүднээс тайлбарлан авч үзвэл Ерөнхийлөгчийн хориг нь

<sup>21</sup> Ч.Энхбаатар, Д.Солонго, Н.Амархагж, Т.Гинсбург. “Монгол Улсын арилчилыг бэлжүүлжээ үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүргүү дүн шинжилгээ” судалгааны тайлан, УБ, 2015 он.

<sup>22</sup> Albert Venn Dicey. Introduction to the Study of the Law of the Constitution (2005), pp.179-200

парламентын баталсан хуулний эрх зүйт ёсны зарчим, стандартад нийцэлтгүй гэсэн үндэслэлтэй байвал үүнийг парламент хүлээн авах эсэх нь түүний үзмэжийн асуудал байх боломжтуй мэт саагдана.

Ерөнхийлөгч нь Үндсэн хуулний хяналтыг хэрэгжүүлэгч биш, харин гүйцэтгэх засаглалд хамаарах<sup>23</sup> бол хууль тогтоох эрх мэдэлд оролцох түүний эрхийг нь туйлын утгаар ойлгох боломжтуй юм. Харин хууль тогтоох эрх мэдэл гэдгийг “телөөллийн” талаас нь авч үздэг номлолыг<sup>24</sup> баримталбай Монгол Улсын хувьд Ерөнхийлөгч нь Улсын Их Хурлын нэгэн адил арг түмнээш шууд сонгогддог институци тул тодорхой хэмжээнд хууль тогтоох үйл ажиллагаанд нөлөөлөх боломжтуй юм. Үүний хоригийн хүрээнд шийдвэрлэх нь зөв болсны хоригийг ямар хүрээнд тавих, түүнийг хүлээн аваагүй байх тохиолдол, журмын таадаар нарийвчилсан зохицуулалт байхгүй, зөвхөн Улсын Их Хурлын гишүүдийн саналын хувь хэмжээг шалгуур болгосон нь хангалигтай байна.

Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрх, түүний гол чиг үүрэг, төрийн байгуулалтын тогтолцоо, ард түмний ашиг сонирхол, эв нэгдлийн илрэхийлэл гэсэн агуулгаар хориг тавих хүрээг тодорхой болгох, харин энэхүү Үндсэн хуулиар олгогдсан тодорхой бүрэн эрхийнхээ хүрээнд тавьсан хоригийг хүлээн аваагүй тохондолд парламент үндэслэлээ тодорхой заах, гишүүдийн оролцоо, хэлэлцүүлэг хэрхэн явагдах зэрэг журам буюу процесийн шинжтэй асуудлуудыг хуульчлах нь “хууль тогтоох эрх мэдэл” оролцох Ерөнхийлөгчийн оролцоо, Улсын Их Хурлын энэ бүрэн эрхийг тодорхой болгох ач холбогдолтой юм.

## Ном зүй

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн /1993-2009/ Сонгуулийн ерөнхий хороо (2011)
2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн эрх зүйн баримт бичгийн эмхтгэл, Сонгуулийн ерөнхий хороо, (2013)
3. Black's Law Dictionary, 8 th. ed., (2004)
4. Oxford Dictionary of Law, 6 th.ed., by Elizabeth A. Martin J. Law (2006)
5. П.Очирбат. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийн бүрэн эрх анхны зам мөр (2001)
6. С.Төмөр. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй: Монгол Улсад парламенттэй ёсиг төлөвшүүлэх асуудал. Дэд дэвтэр, (2006)
7. Б.Даш-Ёндон. Төрийн тэргүүн, парламентын засаглалтай улсын Ерөнхийлөгчийн институт: Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын зарим асуудал (1999)
8. Д.Солонго. Төрийн эрх зүйн тайлбар толь (2003)
9. Ч.Энхбаатар. Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдал: Үндсэн хуулийн зохицуулалт ба ёнөөгийн практик сэдэвт илтгэл, “Ардчилсан Үндсэн хууль-20” /Эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл/ эмхтгэсэн: П.Амаржаргал нар (2012)
10. Н.Лүндэндорж. Шилжилтийн үе: улс төр, эрх зүйн асуудал (2010)
11. Н.Лүндэндорж. Төрийн онол (2005)
12. Г.Батхүү. “Парламент ба төрийн институци хоорондын харицаа” Монгол Улсын байнтын ажиллагаатай парламентын төлөвшүүлэх хөгжил: онол практикийн хурлын илтгэлүүдийн эмхтгэл. Эмхтгэсэн Л.Батжав (2010)
13. Б.Чимид, Ц.Түмэнбаяр. Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлох нь Гөслийн багийн судалгааны ажлын тайлан/ (2005)

<sup>23</sup> Б.Чимид. Үндсэн хуулийг лэхэлэн шүтгэх ёС Уб., 2006 он, 90 дэх тал.

<sup>24</sup> W.B.McAulay. Law, Legitimacy and the Constitution (1985), pp. 62-82

14. Б.Чимид. Үндсэн хуулийг дээдлэн шүтгэх ёс (2006)
15. Ч.Энхбаатар, Т.Доохүү. Гадаад орнуудын Үндсэн хуулийн эрх зүй (2006)
16. Монгол Улсын төрийн байгуулалтыг төгөлдержүүлэх боломж, арга зам /Судалгааны тайлан/ Удирдлагын академи. Удирдлага, болдого судалалын хүрээлэн (2011)
17. W.B.McAuslan. Law, Legitimacy and the Constitution (1985)
18. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 1993-2013 оны хооронд Улсын Их Хуралд хоригийн талаар илгээсэн албан бичгүүд
19. Монгол Улсын Их Хурлаас 1993-2013 оны хооронд Ерөнхийлөгчийн хоригийн талаар гаргасан тогтооудууд
20. Nolan McCarty. "Presidential vetoes in the early republic" Princeton University <http://www.nyu.edu/gsas/dept/politics/seminars/mccarty.pdf>
21. The failure of presidential democracy: Comparative perspectives Volume 1 Edited by Juan J.Linz and Arturo Valenzuela (1994)
22. Albert Venn Dicey. Introduction to the study of the Law of the Constitution (2005)
23. Ч.Энхбаатар, Д.Солонго. П.Амаржаргал, Т.Гинсбург. "Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: дүн шинжилгээ" судалгааны тайлан (2015)
24. П.Амаржаргал. "Парламентын хууль тогтоох бүрэн эрх ба ерөнхийлөгчийн хориг" Хууль дээдлэх ёс сэргүүл (2014) № 2
25. П.Амаржаргал. "Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаан дахь Ерөнхийлөгчийн оролцоо: хууль тогтоомжид тавих хориг", Үндсэн хуулыт ёс ба Ерөнхийлөгчийн бүрэн эрх олон улсын онол практикийн бага хурал (2015) 103-116 дахь тал
26. Г.Менхболд, Г.Мөнхтулга. Ерөнхийлөгчийн хориг (2018)
27. П.Амаржаргал. УИХ Ерөнхийлөгчийн нийт хоригийн 72 хувийг хуяган зөвшөөрсөн байдал (2015)

---000---



## ХЯНАЛТ ҮГҮЙ БОЛ ХАРИУЦЛАГА ҮГҮЙ



*МУИС-ийн ОУХНУС-ийн Нийтийн  
удирдлагын тэнхимийн эрхлэгч профессор,  
доктор Н.Бурмаа*

### 1.Хяналтын ерөнхий ойлголт, ухагдахуун

Улс орны түүх, соёлын удамжлал, нийтэм, улс төр, эдийн засгийн хөгжлийн түвшингээс шалтгаалан “хяналт”-ын ойлголтод хэрэглэгдэх томъёолол, хэрэглэх үсгийн сангийн баялаг улс орон бүрт язь бүр байна.

Хяналт, шалгалт нь “contra rotulus” гэсэн латин үгнээс үүсэлтэй ба англи хэлний “to control”, франц хэлний “contra rôle”, герман хэлний “kontrolle” зэрэг үгсээр илэрхийлгэдэг боловч эдгээр үгсийн утгын тайлбар өвөрмөц ялгаатай. Энэ ялгаанд эрдэмтэд одоо болтол нэгдсэн нэг тайлбар өгч чадаагүй. Харин “Хяналт” бол “Хариуцлага” гэдэг ухагдахууны хувьд эрдэмтэд санал нэгддэг. Англо-америкийн удирдахуйн ухааны сурх бичгүүдэд “хяналт” удирдлагын үйл ажиллагааны нээнэх кэсэг хэмээн тайлбарласан бол германы эрдэмтэн Artur Fuchs хяналт зөвхөн тооцооллын үнэн зөвийг шалгаад зогсохгүй удирдлагын үйл ажиллагааг хянадаг гэжээ. Харин Krebs хяналтыг “харьцуулах” үйл ажиллагаа гэж хэлсэн байдал. Хяналт төлөвлөх,

гүйцэтгэх, үнэлж дүтиж, шийдвэр гаргах үйл ажиллагаатай нягт уялдаатай тул дүгнэлт гаргах, зөвлөөс өгөх, оновчтой шийдвэр гаргах, хариуцлага тооцох үйл ажиллагаатай холбогдоно. Германы эрдэмтэн судлаачид төрийн хяналтыг ардчилсан нийгмийн төрийн эрх мээл, засаглал хуваарилалт, зарчмытай холбон тайлбарладаг. “Eichenberger, төрийн хяналт бол хянаж буй болон хянагдж буй төрийн үйл ажиллагаа” гэжээ. Төрийн хяналт ардчилал, ардчиллын үндсэн заримуудтай салшгүй уялдаатай. Хяналт нь ардчилал хөгжсөн нийгэмд хүндэтэй байр суурийт эзлэх төрийн эрх мэдлийн хүччүүдийн засаглал хуваарилалт, төрийн удирдлага, сайн засаглалаа илүү юйр орших ажээ. Хяналтын тухай дээрээ тайлбар ухагдахуунууд улс орны түүх, түүхэн уламжлалт ёс, зан заншил, төр эрх зүй, төрийн удирдлага, төрийн байгууламжийн онцлог, улс төр, ардчилал, нийтэм эдийн засгийн хөгжлийн харилцаатай шүүд холбоотойгоор тайлбарлагдана. Эрдэмтэн судлаачид хяналтын тухай нэгдмээс ойлголтод хүрч чадаагүй. Төрийн хяналт бол төрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн удирдлагын үйл ажиллагааны ханах, дахин хянах тасралтгүй үйл явц. Хяналтыг хууль тогтоох байгууллагын-парламентын, гүйцэтгэх засалт-засгийн газрын хяналт (доодоо хяналт), шүүх засаглал-шүүхийн, олон нийтийн гэж ерөнхийлөн ангилалаас гадна хянах гэж байгаа объект, субъект, зорилго, зорилт, агуулга, хамрах хүрээ, хэлбэр, үйл ажиллагааны онцлог, орон зайд болон цаг хугацаанаас хамааруулан нарийвчлан ангинддаг. Эдгээрээс дүгнэхэд хяналтыг түүний үйл ажиллагааны үүргээ, даалгавар, үйлчилэх хүчин зүйлийн нэгдлээс цогц системт үйл ажиллагаа болгон авч үздэгтийг илтгэж байна.

## 2. Хяналт бол систем болох нь

Хяналтын тухай ойлголтыг авч үзэхдээ үгийях нь үүсэл гарлын хувьд мэтгэлийх бус “үйл ажиллагаа” гэдэг угтаар нь бие биетгэйгээ холбоотой удирдлагын үйл ажиллагааны багц “систем” гэж үзвэл илүү зохицтой. Системийн тухай ерөнхий онол нь юм үзэгдэл, үйл ажиллагааг зөвхөн нэг талаас бус олон талаас авч судалдаг тул хяналт бол “систем” мөн.

Зураг 1. Хяналт бол систем мөн



Эх сурвалж: Зохиогч

Хяналт “систем” мөн тул системийн ерөнхий онолоор хариуцан үйлчлэл бүхий элементүүдийн багцын хангалттай шинж чанаруудыг агуулан тэнцвэрт байдлаа хадгалахын зэрэгцээ оршии тогтиол, аюулгүй байдлаа хадгалах хуулинд захирагдана. Тодруулбал: удирдлагын шийдвэр, санхүү, иөөц, гадаад, дотоод орчин, эрх зүй, мэдээллийн технологи, дотоод хяналтаар удирдлагын үйл ажиллагааны багц системийн бүтцийг бүрэлдүүлэн бусад зайлшгүй шаардлагатай дэд системээр бүтцээ өргөжүүлдэг. Систем, түүний дэд системүүд хариуцан уялдаа бүхий хамаарлын олонлогоор хамгаалагдсан байна. Pitschas: хяналт бол “үйл ажиллагаа”-г илүү тодорхой болгодог тул “үйл ажиллагааны” өөрийн нь бүтцийн элемент гэжээ. Хяналтыг бүрдүүлэгч олонлог болон элементүүдийн нэгдэл хяналтын дэд систем болох бөгөөд дараах байдлаар ангилан авч үзж болно.

## Зураг 2. Хяналтын дэд “систем”



Эх сурвалж: Зохиогч

Хяналтыг бүрдүүлэгч олонлог болон элементүүдийн нэгдэл хяналтын дэд систем болно. Хяналтын үйл ажиллагааг дараах ерөнхий үе шатуудаар ангилсанар түүнийг бүрдүүлэгч олонлог болон элементүүдийн талаарх ойлголтыг тодорхой болгоно. Хяналт хийх үйл ажиллагааны ерөнхий үе шатууд: 1. Бэлтгэл үе шат ба төлөвлөлт 2. Хяналт 3. Үр дун 4. Үр нөлөө, дахин буюу эргэн хяналт (feedback) гэж ангилна.

### Нэгдүгээр үе шат: Бэлтгэл үе ба төлөвлөлт

- хяналтын үйл ажиллагаанд бэлтгэнэ;
- хяналт хийх багийг бүрдүүлнэ;
- хянах үйл ажиллагааны нарийчилсан төлөвлөлтийг хийнэ;
- хяналтын эрдээлийг тооцно;
- хяналт хийх объектын онслог, цаг хугацааны хүчин зүйл буюу хяналтын эзлэх, үргэлжлэх, дуусах хугацааг тооцно.

### Хоёрдугаар үе шат: Хяналт

- хяналтын үйл ажиллагаа;
- хяналтын үйл ажиллагаа төлөвлөлтийн дагуу хийгдэж буй эсэхийг хяналтын үйл ажиллагааны туршид байнга хянална;
- үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянална;
- хяналттай холбогдон гарах эрдээлийг байнга хянах байх;
- төлөвлөгөө, гүйцэтгэл, ирээдүйд хүрэх үр дүнд харьцуулалт хийнэ;
- хяналт, шинжилгээний үр дүнг задлан шинжилж нэгтгэнэ.

### Гуравдугаар үе шат: Үр дүн

- тайлан, тайлгайл;
- зөвлөгөө.

### Дөрөвдүгээр үе шат: Үр нөлөө, дахин буюу эргэн хяналт (feedback)

- үр нөлөө;
- дахин буюу эргэн хяналт (feedback).

Тухайн үйл ажиллагааны дараагийн түвшинд эдгээр үе шатууд давтагсанаар хяналтын системийн “орцил эргэлт” болно. Хяналтын “систем”-г шинжилснээр уг системийг үзэлж боломж бурдэнэ. Системийн үзэлгээ нь харилсан үйлчилгээ хангалттай ба хангалтгүй системийн үйлчлэлийн үр дүн /дэд систем/, түүний зорилт хоорондын зохицлоор тодорхойлогдоно. Хэрэв систем егэгдсөн зорилтууд гүйцэтгэж байвал хангалттай, чадахгүй бол хангалтгүй гэж үзүй<sup>1</sup>. Системийн шинжилгээ хийхдээ уг системийг бүрдүүлэгч дэд системийн зохицолдоо зорилтын дагуу хангалттай уялдах буйг системийн доотоо хяналтаар давхар хянана<sup>2</sup>. Системийн давхар хяналтаар эрдээлийн нөлөөллөөс хамгаалагдан системийн бүтцийн олонлог, элементүүдийн харидан үйлчиллийн иөлөөлөлт хэвийн болсistemийн үйлчлэлийг хангалттай гэж үзүй. Хэрэв системийг бүрдүүлэгч олонлог, элементүүдийн уялдаа эрдээлээс хамгаалагдах чадваргүй, уялдаа зохицолдоогүй бол уг “систем” зорилго, зорилтоо биелүүлж чадахгүйд хүрч “систем” үйлчилгээ доголдоно. “Систем”-ийн нөлөөллийн хэвийн үйл ажиллагааг хангах, учир шалтгааныг тодорхойлох, ил тод байлагх зорилгоор эхлэл, явц, үр дүн, эргэх холбооны хяналтын аналитик шинжилгээг хийн нь уг системийн оршин тогтоно, аюулгүй байлаа хадгалахад чиглэнэ. Системийн онолын хуулийн үйлчлэх зүй тогтол хяналтын системийн зорилго, зорилтоо биелүүлэхэд үйлчилнэ. Krebs: төрийн санхүүгийн хяналт санхүү,

төсөв, төрийн бүхий л нөөцийн ашиглалт, заршуулалт, хөрөнгө оруулалттай нягт уялдаатай<sup>3</sup> гэжээ. Төрийн хяналтын систем эрх зүй, төрийн удирдлага, санхүү, төр иргэний нийтгэйн хариццаанд чухал Үүргийн гүйцэтгэдэг. Ногуяан: “Хяналт бол ханаа алдаа гарч байна, түүнийг хэрхэн засаж замруулах, алдаа давтагдаа буй талаар удирдлагын мэдээлэлээр хангагч удирдлагын дэд систем. Төрийн удирдлагын түвшиний хяналт бол удирдлагад зөвлөгөөгөөгөө өгөх үйлчилгээ<sup>4</sup>” гэжээ. Хяналтын үйл ажиллагааг удирдлагас гарах болон гаргасан шийдвэр, шийдвэрэйн үр дүн, хариншлагын тогтолцоонд чиглэгдэж байдаг. Төрийн хяналт төрийн үйл ажиллагааг ил тод байлагчад чухал үүргийг гүйцэтгээ. Төрийн үйл ажиллагаа, төрийн хяналтын тайлагчад иргэдэд ил тод байх нь ардилсаа нийтгийн зарчмын. Төвя дүгнэзвээ төрийн хяналт иль төрийн үйл ажиллагааг ил тод байлагчад чухалыг хадгалаад онцлогтой. Сүрчин чийн төрийн санхүүгийн хяналтын хүрээ “хил хязгаартгүй” зарчмыг баримталдаг тул төрийн хяналт хил хязгаартгүй тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаа юм.

### 3.Хяналтын үндсэн ухагдахууныг бүрдүүлэгч элементүүд

Хяналтын ухагдахууныг тодорхойлоход хамгийн багаар тооцоход 2 элемент буюу хүчин зүйлс шаардлагадаа бөгөөд харьцуулагдах шинж чанарыг хадгалсан байна. Хяналт нь “байх ёстой” эд баялаг, нөөц<sup>5</sup> эсвэл хүчин зүйлсийг “жинхэнэ буюу одоо байгаа”, эсвэл “ирээдүйд бий болгох төвлөлөсөн” эд баялаг, нөөц, хүчин зүйлстэй харьцуулсан үр дүн юм. “Жинхэнэ буюу одоо байгаа”, “байх ёстой”, “ирээдүйд бий болгох” эд баялаг, нөөц хүчин зүйлсийн харьцуулалтын үр

<sup>1</sup> Krebs, Walter. Төрийн шийдвэр гаргах үйл ажиллагааны дэхь хяналтын үүрэл. Төрийн санхүү, парламент болон шүүхийн хяналтад тухайн тайланс оруулсан хувь нэмэр. Ненделбет, УБ., 1984 он, 4 дэх тал. герман хэлнийсээс орч.

<sup>2</sup> Norvath, Peter: Хяналт шалтгаалж. 9 дэх калдал. Muenchen, УБ., 2003 он, 233 дахь тал. герман хэлнийсээс орч.

<sup>3</sup> Төрийн санхүүгийн хяналтын элемент нь төсөв, санхүү, хөроогч оруулж эхрэг орган ухагдахууныг агуулдаг тул хураагийнслан иэрээр за баялаг, нөөц хэмжээн иэрэгслий болно.

дүн уялдах, өнгөрсөн, одоо, ирээдүйн цаг хугацааны шинж чанарыг хадгалсан байдал. Харьцуулалтын үр дүн зорилгодоо хэрхэн хүрэх, хүрсэн эсэх, илүү үр дүнд хүрэхийн тулд ямар оновчтой арга хэмжээ авч ажиллавал зохицтой вэ? гэдгийг тодорхойлдог. Товчоор хэлбэл төлөвлөсөн ба гүйцэтгэсэн үйл ажиллагаагаа харьцуулан ирээдүйд хүрэх зорилтыг шинжлэх ухааны үндэслэлтэйээр тодорхойно гэсэн утгатай. Энэ утгаараа хяналт Pitschas-<sup>6</sup> “байх ёстой” мөн “жинхэнэ буюу одоо байгаа” болон “ирээдүйд бий болгохоор төлөвлөсөн” үйл ажиллагааны энгийн харьцуулалтаас эхлэх бөгөөд хянагдаж байгаа объект, хяналтын хүрээнээс шалтгаалан үйл ажиллагааны шаттууд хүрээгээ тэлэх, нарийвчлах шаардлага бий болдог. Хяналтын хүрээг тэлэх, нарийвчлах шаардлага тодорхой бус хүчин зүйлсийн нөлөөтэй болгоотой. Хяналтын систем хянах, хянагдах объект, субъект, хяналтын хүрээ, хяналтын үйл ажиллагаа, хамрагдах хугацаа, хяналтын үр дүн, үр дагавар зэрэг олонлогийн элементийг агуулан<sup>7</sup> удирдлагын шийдвэрнийг оновчтой болгоход чиглэгдэнэ. Үр дүн бол удирдлагын гаргасан шийдвэр, түүний гүйцэтгэлээр хэмжигдэх узүүлэлт, харин үр дүнд чиглэсэн хяналт нь жинхэнэ болсон үйлдэл болон урьдчилан төлөвлөгдсөн үйл ажиллагааны тодорхой мэдээ, мэдээллийн харьцуулалтад үндэслэгдэнэ. Үр дүнтэй байх нь зорилгоо биендуулж хэмжигдэхүүн, удирдлагын шийдвэрийг төлөвлөсөн зорилтод хүргэждэх хэрэгжүүлэх хүний нөөцийн үр чадвар, санаачилга зонхилох байр сууринтэй эзлийн. Харин “үр ашиг”-т чиглэсэн хяналт бол хүрсэн үр дүнг тавьсан зорилгод харьцуулснаар тодорхойлгодно. Тодруулбал удирдлагын шийдвэрийн зорилго, “хэрэгжүүлэлт” ба “үр дүн”-д чиглэсэн хяналтуудын нэгдэл. Хяналтын үр нөлөөг өргөн утгаар нь шийдвэрийн үр

дунгийн илрэл гэж үзэж болно. Үр нөлөө нь үр ашиг хэмжээ ойлголтой салшгүй холбоотой. Үр нөлөө бол удирдлагын шийдвэр, шийдвэрийн хэрэгжилт болно.

#### 4. Хяналтын судлах зүйл

Хяналтын объект удирдлагын<sup>8</sup> шийдвэр, шийдвэрийн хэрэгжилт, үр дүнгийн агуулгын нэгэн зэрэг багтаадаг. Хяналтын судлах зүйл бол хяналтын объект, субъект, үйлдэл, дүрээм журам, систем, зохион байгуулалт, үр дүн, үр ашиг, үр нөлөө юм. Хяналтын эцсийн зорилго бол удирдлагын үйл ажиллагаа, түүний үр дүн, үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх, удирдлагын шийдвэрийн оновчтой болгох оршино. Rehm<sup>9</sup>-ний онолоор үр ашигийг ашигт ажиллагаагаар илрхийлж дараах байдлаар томъёолдог:

$$AA=(B-Z);(R-Z)$$

АА - ашигт ажиллагаа

В-“байх ёстой” хүчин зүйл

R-“одоо байгаа” хүчин зүйл

Z-зорилго

Үйл ажиллагааны ашигт ажиллагааг тооцсоноор удирдлагын үйл ажиллагааг илүү үр дүнтэй болго, цаг үеэс олонс оновчтой арга хэмжээ авах, хариуцлагыг ондёржүүлэх боломжийг бий болгоно. Орчин цагийн хяналтын судлах зүйл төр, бизнесийн байгууллагын хамтын үйл ажиллагааны “бүтээгдэхүүн” юм. Бүтээгдэхүүн, үйлчилгээний ашигт ажиллагааг нийт бүтээгдэхүүн, үйлчилгээ болон түүний нэр төрөл тус бүрээр тооцож болно. Бүтээгдэхүүн, үйлчилгээнд удирдлагын бодлого шийдвэр бүрэн хэмжээгээр хамрагдана. Эдгэр үзүүлэлтийг тухайн үйл ажиллагааны түвшин бүрт тооцож болох ба төрийн оновчтой бодлого шийдвэрийн үр дүн, үр ашиг эдийн засгийн утга агуулгаргаа нэг хүнд ноогох үндэсний орлогын есөлтөөр тодорхойлгодог. Удирдлагын үйл ажиллагаа боловсронгуй болох тусам түүнийг хянах, хяналтын арга, технологи, хүрээ илүү боловсронгуй

<sup>6</sup> Pitschas, Rainier. Закиргавын хариуцлагы ба захирагчны үйл ажиллагааны бүтгийн тааргуутай асуудлуудыг захирагчны эрх зүйн үзүүлэлт шийдвэрийн нийтийн. Münchener, Уб., 1990 он, 391 дэл тал. герман хэлнээс орч.

<sup>7</sup> Karchule, Helmut. Хяналт бол үндэснэ хуулийн үр дүйн ниймжлийн фунцийн мөн. Төрийн төслийн сэргүүл №16 Уб., 1975 он, 146 дэл тал. герман хэлнээс орч.

болж удирдлагаас гарах болон гаргасан шийдвэрт шинжилгээ, дүгнэлт хийх, оновчтой болгох зөвлөгөө өгдгөөрөө удирдлага, хяналт, судалгааны үйл ажиллагаа салшгүй холбоотой. Удирдлага, хяналт, шинжлэх ухааны судалгааны үйл ажиллагаа шугаман хамаарлтай. Хяналтад хамрагдах объект, субъект, зорилго, төрөл, цаг хугацаа, хүрээнээс хамаарж хяналтын төрлүүд нарийвчлан ангилагддаг тухай дээр дурдсан. Хяналтын үйл ажиллагаанд хяналтын объект чухал байр суурийг эзэлнэ. Хяналтын объект бүр оишлог шинжийг агуулсан байна. Weber<sup>10</sup> хяналтын объектыг:

1. Төлөвлөсөн зорилго, зорилт биелгэсэн;

2.Хууль ёсны дагуу ажилласан;

3.Удирдлагаас гарсан шийдвэрийн дагуу ажилласан эсэх;

4.Дүрэм жurmыг мөрдөж ажилласан эсэх зэрэг ерөнхий чиглэлэр ангилсан.

Эдгээр ерөнхий чиглэл тухайн хяналтын объектын үйл ажиллагаа, үр дунгийн оишлогосо шалтгаалан хяналтын дараагийн үе шатны мөчлөг буюу цаашид боловсронгуй болгох системт үйл ажиллагаанд шилжээг тул хяналт нь аливаа зорилго, зорилтдоо хүрэх үйл ажиллагааны алхмуудыг боловсронгуй оновчтой болгох тасралтгүй үйл ажиллагаа.

## 5. Хяналтын ангилал

Хяналтын ангилал хяналтын системийг бүрдүүлэгч чухал элементүүдийн нэг. Хяналтын ангиллыг хөрхэн зөв сонгосноо хяналтын үйл ажиллагааны үр дүн шалтгаална. Хянан шалтагч нарын үр чадвар, хариуцлага зэрэг нь хяналтын үр дүн нөлөөлөх шууд хүчин зүйл юм. Хяналтыг хууль эрх зүйн, санхүүгийн, үр дүнгийн, гүйцэтгэлийн хэмээн ерөнхийлон ангилдаг. Эдгээр ерөнхий ангилал хяналтын төрөл бүрт өөр өөрний оишлог шинжийт хадгалдаг. Тодруулбал санхүүгийн, шүүх засаглалын, парламентын, олон нийтийн хяналтад хяналтын хэлбэрүүд тодорхой бие даасан

оишлогийг халгалаа. Хяналтыг амжилттай хэрэгжүүлснээр удирдлагын үйл ажиллагааны (бэлтгэж-төлөвлөх, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт-кариүүлэг) ямар үе шатанд эрсдэл гарсан тухай үзүүлэлт дүгнэлт өгч цашид хэрээн алдагсан боломжоо нехех, илүү үр дүнтэй ажиллах боломжийн будруулж арга замын нэх аж холбогдолтой. Хяналтын үр дүн, дүгнэлтэд үндэслэн удирдлагын үйл ажиллагааг шуурхай, уян хатан, оновчтой төлжэсэн зорилтдоо хүрж боломжийг олгон. Хууль эрх зүйн хяналт хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагаага явуулж буйг хянадаг бол санхүүгийн хяналт тухай хяналтын объектын санхүүгийн үйл ажиллагаанд үндэслэлдэг. Үр дүнгийн хяналт тухайн шалтгаждаж байгаа “үйл ажиллагаа”-ны гүйцэтгэлийн үр дүнд шинжилгээ хийнэ. Үр ашигтай хяналт эдийн застийн үр ашигтай ажиллан хамгийн бага зардлаар хамгийн их үр дүнд хүрэх эсвэл өгөгдсөн зардлаар хамгийн боломжит үр дүнд хүрсэн эсэхийг хэмждэг. Эдийн застгийн үр ашигтай ажиллах, бага зардал гаргах зэрэг нь олон боломжит сонголтуудас хамгийн хамгыд сонгох биш харин хамгийн илүү оновчтойг сонгох сонголт мен.

## 6. Хяналтын үйл ажиллагаа

Хяналтын объект, хэлбэр хяналтын системийн бүрэлдэхүүн хэсгүүд мөн. Хяналт бие биенээсээ хараат бус үйл ажиллагааны нэгдлээс бүрдэх ба түүнийг бүрдүүлэгч элементүүд шуд би шууд бус хамаарлтай эсвэл хамааралтгүй байж болно. Энэхүү хамаарал, үл хамаарлын уялдаа нь гадаад, дотоод орчны зохицуулалт, ноёцийн хуваарилалт, мэдээлэл технологи, тоон ба чанарын үзүүлэлтгүүдийн оишлогоор зохицуулагдана.

<sup>10</sup> Weber, Jürgen: Хяналтын тухай ойлголт. Stuttgart УБ., 1994 он, 153 дахь тал. герман хэлээс орч.

Зураг 3. Шийдвэрийн буюу орцын хяналт.




Эх сурвалж: Зохиогч

Дээр тайлбарласнаар хяналт нь “байх ёстой” мөн “жинхэнэ буюу одоо байгаа” болон “ирээдүйд бий болгох” эд баялаг, хучин зүйлсийн харьцуулалт тул тодорхой үйлдлээр биеллээ олж хэмжигдэнэ. Хяналт хийх үйл ажиллагааг Scheuner<sup>11</sup> дараах элементтэй бурдэнэ гэжээ:

1. хяналт хийх, хийлгэх байгууллага, нэгжийн хүсслэг, шийдвэр
  2. хяналт хийх субъект:
    - бие даасан хэрэгтэй бус (гадаад хяналт)
    - салбар, байгууллага дотооддоо хийх хяналт (дотоод хяналт)
  3. хяналтын объект
  4. хяналтын хэлбэр
  5. хяналтын хүрээ
  6. хяналтын үйл ажиллагаа
  7. хяналтын үр дүн
- Хяналтын системийн элемент бүрдсэнээр хяналт хийх боломж бий болно.

Зураг 4. Шийдвэрийн буюу орцын хяналт.



Эх сурвалж: Зохиогч

Тайлбар: Аливаа шийдвэр буюу орци, хэрэгжүүлэх буюу боловсруулах үйл ажиллагаа үр дун, гард нь үш шат бурдээ хяналтын функцийн холбогдон буцах холбоогоор зорилтоо төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл бурдэнэ.

Харьцуулалт буюу хяналтын үйл ажиллагаа нь хянагдсан байгууллага, объектын удирдлагын үйл ажиллагааны үр нелөө, үр дун, үр ашгийг илтгэнэ. Удирдлагын үйл ажиллагааны үр дүн хяналтад хамрагдсан цаг хугацаатай шууд хамааралтай ба богино, дунд, урт хугацааг хамарч болно. Хяналт хийх хугацааны хоорондын зайд иксэж тусам удирдлагын шийдвэр, шийдвэрийн хэрэгжүүлэлтэд алдаа гарах, алдаа давтагдах магадлал өсөх болзошгүй шийдвэрийг оновчтой болгох боломжууд алдагддаг. Алдагдсан боломжийн нөхөх боломж багасан эрсдэл бий болох тул цаг хугацаа хяналтын үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэнэ.

#### 7. Хяналтын үүрэг, үндсэн хуулийн эрх зүйн орчинд хяналтын гүйцэтгэх үүрэг

Хяналт төр эрх зүй, ардчиллын үндсэн агуулгатай нийт уялдаатай. Хяналт ардчилсан төртэй улс орны төрнийн байгуулалтын системд зонхилох байр суурийг эзлэн засаглалын эрх мэдлийн хүчинчүүдэд хязгаарлалт хийх, хянах

<sup>11</sup> Scheuner, Ulrich: Адмачжиний нийгэм дэх төрнийн эрх мэдлийн хийдээ. Нийтээ, УБ., 1977 он, 11 дахь таан. герман хийнсүүс орч.

хэрэгсэл болдог. Аливаа улсын үндсэн хууль эрх мэдлийг хянах үндсэн суурь болдог<sup>12</sup>. Энэ утгаараа хяналт бол орчин үеийн төрийн байгууламжийн тогтолцооны үндэс. Төрийн гүйцэтгэх үүрэг “харилсан хянах, хяангах” зарчмыг үндэслэгдэн төрийн эрх мэдлийг хязгаарлаж, хянахын зэрэгцээ боловсронгуй болгох зорилгод тулгуурлана<sup>13</sup>. “Хяналтгүй эрх мэдэл түрэмгийлэл, дарангуйсан төрийн системийг аяндаа бий болгодог”<sup>14</sup>. Улс төрийн эрх мэдлийг хязгаарлагч хяналтын үүрэг даалгаврын тухайд эрх мэдлийн тухай давхар ойлголтыг агуулж байна уу? гэдгийг ялгахад бэрхшээл гардаг. Иймд Meup<sup>15</sup>: хяналт бол “эрх мэдлийн” хязгаарлах “эрх мэдэл” бөгөөд арчилсан нийгэм дэх төрийн хяналт эрх мэдлийг хязгаарлах хэрэгсэл, эрх мэдлийг өмчлөн зээмшигч биш гэжээ. Арчилсан эрх зүйт төргтэй улс орууудал хяналтын үүргийг нарийн зохион байгуулалттай зохицуулж чадсан хэдий ч дээр дурдсан үүргүүдийг онолын хувьд нэг бүрчлэн тайлбарласан нэгдмэл ойлголт байдаггүй. Харин төрийн үйл ажиллагааны тодорхой түвшин бүрт хяналтын үүргийг аргачлалын хувьд ялган зааглаадаа, Meup<sup>16</sup> хяналт үндсэн хуулийн эрх зүй, улс төрийн үйл ажиллагаанд үнэ цэнэтэй онцгой үүрэг гүйцэтгэдэг хэмээн дутгисэн байдал.

### 8. Төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь хяналтын үүрэг, хариуцлага

Төрийн засаглал хуваарилалтын эрх мэдэл хууль тогтоох засаглал-парламент, гүйцэтгэх засаглал-засгийн газар, шүүх засаглалд хуваарилагддаг. “Төрийн эрх мэдлийг хуваарилах онол зөвхөн төрийн удирдлагыг боловсронгуй тогтолцоог

хангах үүднээс бус”<sup>17</sup> төрийн эрх мэдлийн иргэний эрхийг хамгаалах зорилтол нийцдэг тул иргэний эрх, төрийн эрх мэдлийн хуваарилалт шугаман хамаагаад орших зүй тогтолцой. Төрийн бодлогын шийдвэр эрх мэдлийн хүчинчүүдийн харилсан хяналтад байна. Krebs<sup>18</sup> төрийн үүргийт төрийн бодлогын шийдвэр гаргах, шийдвэрийн хэрэгжүүлэлт, хэрэгжүүлэлтийн хяналт гэж срөнхийлэн ангилсан нь давхар хяналт болон хариуцлагатай холбогдох нь Pitschach<sup>19</sup>-н “хяналт үүгүй бол хариуцлага ба байхгүй, хариуцлага угүй бол хяналт байхгүй” хэмээн дэвшуулсан оюондро нотлогдоно. Аливаа удирдлагын шийдвэр хяналт, хариуцлагын үүргийг давхар агуулна. Хариуцлага нь эрх зүйн шинжлэх үхааны үндсэн ойлголт, харин хяналт бол хууль эрх зүйн үндсэн ойлголт биш. Хариуцлага ба хяналт арчилалаа, сайн засалалын үндсэн зарчмуудтай нягт уялдана. Хариуцлагын үлс төрийн, санхүүгийн, захиргааны гэсэн төрөлд ангилан авч үзж болно<sup>20</sup>.

### Зураг б. Хариуцлагын онцгол

| Хариуцлага   |
|--|
| Үз төрийн<br>(Төрийн эрх мэдлийн үзүү, хасагын хариуцлын үзүүлэлт)                       |
| Санхүүгийн<br>(Үз баялаг, ноёнцдийн хариуцлагын комбонойн үзүүлэлт)                      |
| Захиргааны<br>(Төрийн албаны үзүүн өмнөх замаар, стандарт, замын гаргын дотоод үзүүлэлт) |

Эх сурвалж: G.Shabbir Cheeta: Арадчилсан засаглал төр ба иргэний холбох нь. Төрийн захиргаа ба арадчилсан засаглал. Нээдээн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр. Улаанбаатар 2008. х. 32-33.

<sup>12</sup> Schäffer, Heinz: Төрийн эрх мэдэл ба хяналт. Эмсгүүтгэсэн Andreas Kohl, Wien, Уб., 1979 он, 83 дахь тал. герман хэлнээс орч.

<sup>13</sup> Degenhart, Christoph: Төрийн санхүүгийн хяналт. Германы төрийн эрх зүйн нийгмийг №55, Уб., 1996 он, 196-197 дахь тал. герман хэлнээс орч.

<sup>14</sup> Brummer, Georg: Герман улс дахь хяналт. Koeln, Уб., 1972 он, 35 дахь тал. герман хэлнээс орч.

<sup>15</sup> Meup, Karl-Ulrich: Хяналтын үндсэн хуулийн эрх зүйн зарчмын 2 дахь Хэвлэл. Baden-Baden, Уб., 1982 он, 119 дахь тал.

<sup>16</sup> Meup, Karl-Ulrich: Хяналтын үндсэн хуулийн эрх зүйн зарчмын 2 дахь Хэвлэл. Baden-Baden, Уб., 1982 он, 119 дахь тал.

<sup>17</sup> Н.Лүнгэндорж, Төрийн онол. Уб., 2008 он, 205 дахь тал.

<sup>18</sup> Krebs, Walter: Төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь хяналтын үүргийн роль. Төрийн санхүү, парламент болон шүүхийн хяналтад эрх зүйн таллас оруулсан хувь ижсэр. Niedelberg, Уб., 1984 он, 8 дахь тал. герман хэлнээс орч.

<sup>19</sup> Pitschach, Rainer: Захиргааны хариуцлага ба захиргааны үйл ажиллагааны бүтцийн эзэрхүчтэй асуудалдууд захиргааны эрх зүйн хувьжээс хэлэвэрдэж нь. Muenchen, Уб., 1990 он, 391-393 дахь тал. герман хэлнээс орч.

<sup>20</sup> G.Shabbir, Cheeta: Арадчилсан засаглал төр ба иргэний холбох нь. Төрийн захиргаа ба арадчилсан засаглал. Нээдээн Үндэстний Байгууллагын Хөтөлбөр, Уб., 2008 он, 32-33 дахь тал.

Scheuner; Pitschas<sup>21</sup> нар хяналтыг хариуцлагатай холбон “хариуцлага ба хяналт арчилсан эрх зүйт төрийн байгуулалтын үндсэн бүрэлдэхүүн хэмээн тайлбарлажээ. Эрх мэдэл нь хариуцлага, хяналт гэсэн бүрэлдэхүүнтэй зайлшгүй нэгдмэл байдаг иргэдийн ийтилэг хүсэл зоригийг илрэхийлсэн үндсэн хуулийн анхдагч ойлголт. Товчоор хэлбэл хаана шийдвэр гаргах эрх мэдэл байна? тэнд хариуцлага ба хяналт заавал байх ёстай.

#### Зураг 7. Төрийн шийдвэр

|                    |                           |
|--------------------|---------------------------|
| Эрх мэдэл, шийдвэр | *хяналт<br>*хариуцлага    |
| Хяналт             | *эрх мэдэл<br>*хариуцлага |
| Хариуцлага         | *хяналт<br>*эрх мэдэл     |

Эх сурвалж: Зохиогч

Тайлбар: Шийдвэр гаргах эрх мэдэл хариуцлага, хяналттай зайлшгүй нэгдмэл байх нь үндсэн хуулийн эрх зүйн үндсэн ухадахаануун.

Эдгээр хүчин зүйлийн нэгдлийг төр эрх зүй, төрийн байгууламж, удирдлагын, түүний эрх зүйн орчинд хэрхэн хэрэгжүүлж нь арчилсан нийгмийн төрийн үйл ажиллагаатай салшгүй холбоотой. Засаглалын эрх мэдэл хуваарилалт харилсан хяналтгүй бол арчилал, тэгш эрх, ил тод, шударга ийгмийн талаараа хөндөж ярийн шаардлагатай. Хяналт, харилсан хяналт эрх мэдлийн хязгаарлах үзүүлэгч хэрэгсэл. Арчилсан нийгмийн үнэ цээ бол эрх мэдлийг зөв удирдах, зорчилдоөнийн шударга зохицуулалтаар илрэхийлэгдэн. Эрээмтэн Eichenberger<sup>22</sup> төрийн шийдвэр гаргах үйл ажиллагааг хяналттай холбон үзсэнээр:

1. Эрх мэдэлд хязгаарлалт хийх;
2. Бодит хариуцлагыг бий болгох;

<sup>21</sup> Scheuner, Ulrich. Arachisсан нийгмийн дэх төрийн эрх мэдлийн хяналт Нанкверт, УБ., 1977 он, 11 дэх тал. герман хлиентс орч. Pitschas, Rainer. Захиргыны хариуцлага ба захиргыны үйл ажиллагааны бүтцийн тэргүүтэй асуудлуудын захиргыны эрх зүйн үүдээс шийдвүүртэй нь. Miethen, УБ., 1990 он, 391-393 дэх тал. герман хлиентс орч.

<sup>22</sup> Eichenberger, Kurt. Төрийн эрх мэдэл ба хяналт. Эмчилгээн Andreas Kohl Wien, УБ., 1979 он, 24 дэх тал. герман хлиентс орч.

3. Ардчиллыг бэхжүүлэх;

4. Удирдлагын шийдвэрийг хянах, хэрэгжүүлэх, хариуцлагыг өндөржүүлэх үндсийг бурдүүлийг эзжээ.

Хяналт арчилсан нийгэмлэд арчиллыг бэхжүүлэх, эрх мэдлийг хязгаарлах хэрэгсэл байж хариуцлагыг өндөржүүлэх, хуулийг дээлэхэд гол үүрэг гүйцэтгэнэ. Хяналт ба эрх мэдэл тодорхой тэнцвэртэй хадгалах хуулинд захирагдах ба харин хяналтыг эрх мэдлэгэй хэрхэвч адилтган үзэж болохгүй. Төрийн эрх мэдэл хуваарилалтад хяналтын гүйцэтгэх үүрэг арчиллын тухай ойлголтой салшгүй холбоотой. 17-18 дугаар зууны үед Англи, Франциад орчин үеийн эрх зүйт төр, төрийн эрх мэдлийн хүчиний тухай онод бий болсон түүхтэй. Эрх мэдлийн засаглал хуваарилалтыг механик аргаар хуваарилажгүй ба нарийн уялдаа холбоотой, бие даасан, харилсан нелөтэй, эв нэгдэлтэй, тэнцвэр бүхий хүчинчүүдэд хуваарилдаг. Төрийн эрх мэдлийн хүчиний хуваарилалтын зорилго нь хувь хүн, иргэний эрх, эрх чөлөөг хамгаалахад оршино<sup>23</sup>.

Арчилсан төрийн эрх зүй, арчилсан ёсны харилсан хяналтад сууриссан зарчимд үндэслэн төрийн эрх мэдлийг тэнцвэртэй хуваарилсанараа хариуцлагыг өндөржүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, шударга ёыг эрхэмлэх зорилтуудыг цогцоор нь агуулдаг. Төр хүний эрх, эрх чөлөөг хамгаалдаг боловч бас хамгийн ноцтой хохироогч байхын үгүйгээгүй ба төрийн эрх мэдлийн хуваарилалтыг орчин цагийн төрийн үнэт зүйл хэмээн хулээн зөвшөөрдөг<sup>24</sup>. Төрийн бодлого, шийдвэр засаглалын харилсан хяналтад суурислан иргэний нийгмийн хяналттай уялдсанараа арчилсан нийгмийн тулгуур зарчмын хэрэгжин хяналтын тэнцвэртэй бурдүүлнэ. Иргэний эрх чөлөө эрх зүйт төрийн үндэс<sup>25</sup>түн иргэн төрийн үйл хэрэгтэй шүүл оролцох, хууль ёсны эрхээс хамгаалах, хамгаалаулах, төрийн үйл ажиллагаанд

<sup>23</sup> Brunner, Georg: Герман улс дахь хяналт. Koeln, УБ., 1972 он, 39 дэх тал. герман хлиентс орч.

<sup>24</sup> Лундандорж Н: Төрийн оюн. УБ., 2008 он, 209 дэх тал.

<sup>25</sup> Лундандорж Н: Төрийн оюн. УБ., 2008 он, 223 дахь тал.

хяналт тавих эрхийг нээлттэй байлгах асуудал мөн.

#### 9. Удирдлагын хяналтын төрөл, хариуцлага

Хяналтыг гүйцэтгэх үүргээр нь парламентын, шүүхийн, санхүүгийн, удирдлага-захиргааны, намын, хэвлэл мэдээлэл, иргэд, олон нийтийн гэж ерөнхийлөн ангилдаг. Эдгэр хяналтуудаас удирдлага захиргааны хяналтыг төрийн эрх зүйн сонгодог хяналтын нэг хэмээн тодорхойлсон. Удирдлагын хяналтыг цаг хугацаа, орон зай, агуулга, зорилго, хяналт хийх субъектээр нарийвчлан ангилж болно. Хяналтыг цаг хугацаа, орон зайдгаар өнгөрсөн, одоо, ирээдүйн, давттан буюу эргэх (feed back) гэж ангилхаас гадна агуулга, зорилгын хувьд эрх зүйн, гүйцэтглийн, нарийн мэргэшсэлийн гэж ангилдаг. Хяналт хийх субъектээр дотоод, гадаад /хөндлөнгийн/ хяналт буюу шууд ба шууд бус гэж ангидна. Schmidt-Assmann<sup>26</sup> дотоод хяналт бол тухайн хяналт хийх системийн болон байгууллагын удирдлагад шууд харьялагдах байгууллагад хийх хяналт юм. Байгууллагын дотоод бүтцийд ажиллах хяналтын хэлтэс тасгийт мөн дотоод хяналт гэх узэх болно гэжээ. Тодруулбал: байгууллагын дотоод бүтцийн эсвэл харьял байгууллагын үйл ажиллагаанд хийх хяналтыг изрэлдэг байна. Гадна буюу хөндлөнгийн хяналтад парламент, төрийн санхүүгийн хяналтын дээд байгууллага, шүүхийн хяналт болон олон нийтийн хяналтыг тооцдог. Karehnke<sup>27</sup> хяналтыг улс төрийн, мэргэжлийн гэж ерөнхийлөн ангилж мэргэжлийн хяналтыг материаллаг, материаллаг бус гэж авч үзсэнээс гадна хууль эрх зүйн, удирдлагын захиргааны, санхүүгийн хэмээн нарийвчлан ангилж болно гэжээ. Улс төрийн хяналтыг парламентаас гүйцэтгэх бөгөөд хууль эрх зүйн хяналтыг шүүх засаглал, төрийн

эдийн застийн удирдлагага, төсвийн нөөцийн зарцуулалтыг төрийн санхүүгийн хяналтын дээд байгууллагыг хяналт үүргийт тус гүйцэтгэдэг. Хяналтын эрх статус бүхий субъектүүд гүйцэтгэх үүрэг, зохион байгуулалт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, авах арга хэмжээгээрээ ялгагдана. Хяналт болгон онцлог зорилго чиглэлтэй. Онцлог ялгатай шинж нь тухайн хяналтын байгууллагын гүйцэтгэх үүрэг даалгавраас шалтгаалина. Эдгэр хяналт хариуцан нарийн улдлаатай ба нэг хяналт чөгөө хяналтын байхгүй орон зайд нөхөн, дэмжих, иөлөлөх, хамтрах зэрэг нарийн холбоотой. Парламентын, засгийн изэryн, шүүхийн хяналт нь санхүүгийн хяналтыг эрчимтэй хийдэгтүү боловч санхүүгийн хяналтын системийн зарим хийж гүйцэтгэдэг<sup>28</sup> онцлогтой.

#### Ашигласан материал

- Fuchs, Arthur: Хяналтын тухай мэдэг буюу түүний иөлөө. Tuebingen Уб., 1966 он.
- Krebs, Walter: Төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь хяналтын үүрэг. Төрийн санхүү, парламент болон шүүхийн хяналтад эрх зүйн талаас оруулсан хувь нэмэр. Heidelberg, Уб., 1984 он.
- Бурма Нацагийн: Тэрийн аудит. Диссертаци. Muenchen, Уб., 2009 он.
- Eichenberger, Kurt: Энэ мэдэл ба хяналт. Эмхэтгэсэн Andreas Kohl., Wien, Уб., 1979 он.
- Бодсайхан Б: Системийн аюулгүй байдлын асууллууд, Уб., 2008 он.
- Pitschas, Rainer: Засигр ааны хариуцлага ба захиргааны үйл ажилдаа заны бүтцийн эздрээгэй асуудлуудыг захиргааны эрх зүйн үүдиээс шийдвэрлэх нь. Muenchen, Уб., 1990 он.
- Horvath, Peter: Хяналт шалгалт. 9 дэх хэвлэл. Muenchen, Уб., 2003 он.
- Karehnke, Helmut: Хяналт бол үндэснэ хуулийн эрх зүйн эмзэгт функц мөн. Төрийн тесов сэргүүл, №16 Уб., 1975 он.
- Vogel, Stefan: Удирдлага ба удирдлагыг бүрдүүлэх нэгж хэсэг. Zuerich, Уб., 2008 он, 247 дэх тал. герман хэлнээс орч.

<sup>26</sup> Schmidt-Assmann, Eberhard; Hoffmann-Riem, Wolfgang: Удирдлагын хяналт. Baden-Baden, Уб., 2001 он, 17-18 дахь тал герман хэлнээс орч.

<sup>27</sup> Karehnke, Helmut: Санхүүгийн хяналт бол удирдлагын хяналтын нэгэн хэсэг мөн, үүдсэн хууль, Удирдлага, Санхүүгийн хяналт. Schäfer Eckart-ийн энэхүүтэй. Muenchen, Уб., 1975 он, 237 дахь тал. герман хэлнээс орч.

- Rehm, Hannes: Төрийн байгууллага дахь арвилан хэмнэлт ба үр ашигтай ажиллагаа. Төрийн удирдлага сэлтүүл №13, Уб., 1980 он.
- Weber, Juergen: Хяналтын тухай ойлголт. Stuttgart, Уб., 1994 он.
- Scheuener, Ulrich: Ардчилсан нийгэм дахь төрийн эрх мэдлийн хяналт. Hannover, Уб., 1977 он.
- Schäfer, Heinz: Төрийн эрх мэдэл ба хяналт. Эмхэтгэсэн Andreas Kohl. Wien, Уб., 1979 он.
- Degenhart, Christoph: Төрийн санхүүгийн орч.хяналт. Германы төрийн эрх зүйн ийнхүүлэл №55, Уб., 1996 он.
- Brunner, Georg: Герман улс дахь хяналт. Koeln, Уб., 1972 он.
- Meun, Karl-Ulrich: Хяналтын үндсэн хуулийн эрх зүйн зарчим. 2 дахь Хэвлэл. Baden-Baden, Уб., 1982 он.
- Лүндэндорж Н: Төрийн онол, Уб., 2008 он.
- G.Shabbir, Cheema: Ардчилсан засаглал төр ба иргэнийн холбох нь. Төрийн захиргаа ба ардчилсан засаглал. Нэгдээн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, Уб., 2008 он.
- Eichenberger, Kurt: Төрийн эрх мэдэл ба хяналт. Эмхэтгэсэн Andreas Kohl. Wien, Уб., 1979 он.
- Brunner, Georg: Герман улс дахь хяналт. Koeln, Уб., 1972 он.
- Лүндэндорж Н: Төрийн онол, Уб., 2008 он.
- Schmidt-Assmann, Eberhard; Hoffmann-Riem, Wolfgang: Удирдлагын хяналт. Baden-Baden, Уб., 2001 он.
- Krehnke, Helmut: Санхүүгийн хяналт бол удирдлагын хяналтын нэгэн хэсэг мөн, үндсэн хууль. Удирдлага, Санхүүгийн хяналт. Schiffer Eckart-ийн эмхэтгэл. Muenchen, Уб., 1975 он.
- Vogel, Stefan: Удирдлага ба удирдлагыг бүрдүүлэх нэгж хэсэг. Zuerich, Уб., 2008 он.

---оо---

**ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭР ГАРГАХАД БОДИТ НӨХЦӨЛ  
БАЙДЛЫГ ХЭРХЭН ТОГТООХ НЭ? ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ  
БОЛВСРОНТГҮЙ БОЛГОХ ТУХАЙД**



Удирдлагын академийн баатар,  
доктор, дэд профессор А.Алтанзул

**Товч агуулга**

Захиргааны Ерөнхий хуульд (цаашид ЗЕХ) заасан үр нөлөөтэй байх (4.2.4), зорилгоодо нийцсэн, бодит нөхцөл байдалд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх (4.2.5) зарчим, захиргааны байгууллага захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хамаараад бодит нөхцөл байдлыг тогтооно (24.1), 24.1-д заасан бодит нөхцөл байдлыг тогтооход ач холбогдол бүхий шаардлагатай ажиллагааг хийх, иотлох баримтыг цуглуулах, үнэлж үүргийг захиргааны байгууллага хүлээнэ (24.2), тухайн захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хамааралтай тохиолдол бүрийн үндэслэлийг захиргааны байгууллага нарийвчлан шинжлэн судлах үүрэгтэй бөгөөд оролцогчийн хувьд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтооно (24.4), 40.2.3-д “захиргааны актыг гаргах бодит нөхцөл байдал, хууль зүйн үндэслэлийг заах” ээрэг заалтуудын хэрэгжилтийн талаар уг илтгэлдээ авч үзсэн болно.

Нийгмийн бүхий л салбарт оршин буй захиргаа, түүний үйл ажиллагааны эрх зүйн хэм хэмжээний зохицуулалтыг захиргааны эрх зүйд авч үздэг. Гэхдээ

орчин үеийн хөгжлийн онцлогтоос улбаатай захиргааны үйл ажиллагааны хүрээт зөвхөн эрх зүйн хэм хэмжээнд тусгагдсан байдлаар бус түүний үр дүнтэй, зөргөх хандлага бий болгох үүргээр тодорхойлох болсон. Тухайлбал, ЗЕХ-д (5.1) захиргааны байгууллага бол нийтийн ашиг сонирхлыг илрэхийдэн захиржилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно гэж заасан байдал.

Захиргааны эрх зүйн зохицуулалт нь нийтийн ашиг сонирхлыг бүрэн хангах захиргааны зорилтыг агуулдаг чөноөдрийн явж ирсэн байдал нь захиргааны чиг үүрэг, бүтэц, оролцогчдын бүрэн эрх, хариуцлагыг зохицуулнаар хязгаарлагдаж, харин түүний үр дүнтэй байх, зөргөх хандлагатай болгоход чиглэгдсэн захиргааны эрх зүйн зохицуулалт тодорхойтүй байна гэж илтгэгч үзэн энэхүү илтгэлээ бичизэ.

**Сэдвийн гол үндэслэл, ач холбогдол**

Захиргааны эрх зүй нь бусад эрх зүйн салбартай харьцуулахад өргөн хүрээтэй харилцааг багтаадгийн хувьд онол, арга зүйн байна шинчлэгдэж, өөрчлөгджэй байхыг шаарддаг. Иймд нийгмийн захиргааны харилцаанд гарч буй шинэ хандлага, мөн эрх зүйн тодорхой бус ойлголтыг судалж, тэдгээрийг эрх зүйн хэм хэмжээ буюу зохицуулалтад оруулах шаардлагатай эсэхийг тогтоож шинжилж байх нь захиргааны эрх зүйн хөгжилд чухал ач холбогдолтой юм.

Захиргаа шийдвэр гаргахдаа тухайн шийдвэрт хамааралтай болсои үйл явдал, бодит байдлыг судлан тогтоох шаардлагатай. Бодит нөхцөл байдлыг тогтоосноор олон төрлийн хувилбарыг ялган таних, дүгнэлт хийх, оновчтой, зөв шийдвэр гаргахад ач холбогдолтой<sup>1</sup>.

<sup>1</sup> Монгол Улсын Захиргааны Ерөнхий хуулийн тайлбар. Уб. 2017 он, 132-133 дахь тал.

Ингэхдээ захирагааны байгууллага шийдвэрт хамаарал бүхий нотлох баримтуудыг цуглуулах ба олж авсан нотлох баримтуудаа үзлэх үүргийг ЗЭХ-нар хүлээн.

### Сэдвийн тулгамдсан асуудал

Өнөөдөр захирагааны байгууллага тухайн шийдвэрт хамаарах болдит ивхцэл байдлыг тогтоон, нотлох баримтуудыг үзлэхдээ ЗЭХ-д заасан тусгай зарчмын болох үр нөлөөтэй байх (4.2.4), зорилгоодоо нийссэн, болдит нөхцөл байдалд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх (4.2.5) зарчмыг баримтлан шийдвэр гаргаж буй практик хангальтгүй байна.

### Сэдэвтэй холбоотойгоор авсан судалгаа


ЗЭХ-ийг сургалчлах таниулах зорилгоор 2016 оны 2 дугаар сарыас хойш өнөөдөр хүргэлт тасралтгүй танхмын ба танхмын бус сургалтыг хот, хөдөөгийн давхардсан тоогоор нийт 2000 гаруй албан хаагчдад явуулсан. Сургалтын явцад ЗЭХ-ийн зүйл, заалтуудыг тайлбарлахад оролцогчдоос хамгийн их асууж байсан нь дээрх заалтууд байв. Түүнчлэн 2018 оны 3-б дугаар сарын хутгаанд ХЭДХЯ-ны захналгаар Эрх зүйн боловсрол академи, Хаис-Зайделийн сангаас зохион байгуулсан “Захирагааны Ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт”-ийн судалгааны оролцоходоо дээрх заалтуудын хэрэгжилтийн талаар судалсан.

#### Анкетын судалгаа:

Судалгаанд 14 захирагааны байгууллага болох яам, агентлаг, ийнслэл, аймаг, дүүрэг, сумын нийт 50 албан тушаалтан, албан хаагчаас асуумж авав.

Судалгаанд оролцогчид дараах асуултыг тавьсан болио. Үүнд:

1. ЗЭХ-ийн 4.2.4, 4.2.5, 24, 25 зүйлд заасан журмын дагуу шийдвэрээ гаргаж байгаа ю?



Зураг 1. Судлаачийн судалгаа

Зураг 1-ээс хараад ихэнх захирагааны байгууллага шийдвэр гаргахдаа ЗЭХ-д заасан журмыг баримтлан болдит нөхцөл байдлыг тогтоодогтүй байна гэсэн дүтнэлт хийсzi.

#### Баримтын судалгаа:

ЗЭХ хэрэгжиж эхэлсэнээс хойш нийслэл, 15 аймгийн нийт 61 захирагааны хэргийн шүүх хуралдааны шийдвэр, магадлал тогтоолд захирагааны шийдвэр гаргах ажиллагаатай маргаан гарсан эсэхэд судалгаа хийв. Эдгэр 61 шийдвэрнийн 7 шийдвэрт ЗЭХ-ийн 24, 25 дугаар зүйлийн хэрэгжилтийн холбоотой асуудлыг хөндсөн байна.

Хүснэгт 1.

| № | Захирагааны хэргийн шүүх хуралдааны шийдвэрүүлэх                            | Холбогдох хуулийн зүйл, заалт   |   |   |
|---|---|---|---|---|
|   |   | Тодорхойлох хэсэгт  | Үндэслэх хэсэгт   | Тогтоох хэсэгт  |
|   |   |   |   |   |
| 1 | Төв аймаг дахь Захирагааны хэргийн анхан шатны шүүчүүйн шийдвэр, 2017.12.19 | Захирагааны ерөнхий хуулийн 24-р зүйлийн 24.2, 24.3, 24.4, 25-р зүйлийн 26.1, 27-р зүйлийн 27.4, 27.5   | Захирагааны ерөнхий хуулийн 24-р зүйлийн 24.2, 24.3, 24.4, 25-р зүйлийн 26.1, 27-р зүйлийн 27.4, 27.5 | Захирагааны ерөнхий хуулийн 24-р зүйлийн 24.2, 24.3, 24.4, 25-р зүйлийн 26.1, 27-р зүйлийн 27.4, 27.5 |
| 2 | Нийслэлд дэх Захирагааны хэргийн анхан шатны шүүчүүйн шийдвэр, 2017.12.15   | Захирагааны ерөнхий хуулийн 92.1, 92.2, 93-р зүйлийн 93.1, 94-р зүйлийн 94.1, 98-р зүйлийн 98.1.5, мөн хуулийн 37-р зүйлийн 37.1, 27-р зүйлийн 27.2.2 | Захирагааны ерөнхий хуулийн 24-р зүйлийн 24.1, 24.2, 24.4   | Захирагааны ерөнхий хуулийн 24-р зүйлийн 24.1, 24.2, 24.4   |

|   |  |   |  |  |
|---|--|---|--|--|
| 3 | Архангай аймаг дахь Захиргааны хөргийн анхан шатны шүүхийн шийдвэр,<br>2018.02.09  | Захиргааны сронхий хуулийн 27-р зүйл  | Захиргааны сронхий хуулийн 4-р зүйлийн 4.2.6, 24.1, 24.4, 25-р зүйлийн 25.1, 26-р зүйлийн 27.5, 27.6   | Захиргааны сронхий хуулийн 4-р зүйл, 24.6, 24-р зүйл, 27-р зүйл  |
| 4 | Завхан аймаг дахь Захиргааны хөргийн анхан шатны шүүхийн шийдвэр,<br>2017.11.17    | Захиргааны сронхий хуулийн 4-р зүйлийн 4.2.3, 4.2.6, 13-р зүйлийн 13.2, 13.2, 24-р зүйлийн 24.1   | Захиргааны сронхий хуулийн 4-р зүйлийн 4.2.3, 4.2.6, 13-р зүйлийн 13.2, 13.2, 24-р зүйлийн 24.1, 27-р зүйл, 47-р зүйлийн 47.1  |  |
| 5 | Булган аймаг дахь Захиргааны хөргийн анхан шатны шүүхийн шийдвэр,<br>2017.10.23    | Захиргааны сронхий хуулийн 27-р зүйл, 28-р зүйлийн 28.1.3, 40-р зүйлийн 40.2.3, 47-р зүйлийн 47.1.6   | Захиргааны сронхий хуулийн 24-р зүйл, 26-р зүйлийн 26.1, 27-р зүйл, 28-р зүйлийн 28.1.3  | Захиргааны сронхий хуулийн 24-р зүйл, 24.1, 24.2, 26-р зүйлийн 26.1, 27-р зүйл, 28-р зүйлийн 28.1.3, 40-р зүйлийн 40.2.3 |
| 6 | Дорноговь аймаг дахь Захиргааны хөргийн анхан шатны шүүхийн шийдвэр,<br>2018.03.15 |   | Захиргааны сронхий хуулийн 4-р зүйлийн 4.2.6, 5-р зүйлийн 5.1, 5.4, 11-р зүйлийн 11.1.1, 11-р зүйлийн 12.1, 15-р зүйлийн 15.1.4, 24-р зүйлийн 24.1, 24.2, 25-р зүйлийн 25.1.2, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 27-р зүйлийн 27.2, 27.6, 92-94-р зүйл |  |
| 7 | Нийслэл дахь Захиргааны хөргийн анхан шатны шүүхийн шийдвэр,<br>2017.12.15         | Захиргааны сронхий хуулийн 27-р зүйлийн 27.2.2, 27.6, 37-р зүйлийн 37.1, 92-р зүйлийн 92.1, 93-р зүйлийн 93.1, 94-р зүйлийн 94.1, 98-р зүйлийн 98.1.5 | Захиргааны сронхий хуулийн 24-р зүйлийн 24.1, 24.2, 24.4   | Захиргааны сронхий хуулийн 24-р зүйлийн 24.1, 24.2, 24.4   |

**Ярилцлагын судалгаа:**

Судлаачид, иргэд, төрийн бус байгууллагын гаргасан 30 гаруй тайлан, нийтэл, өгүүлэлд шинжилгээ хийлзээ.

**Судлаачийн ярилцлагас:**

Шийдвэр гаргалтыг судалдаг нийзэн хэдэн салбар байна. Үүнд: сэтгүйжүүлж ухаан буюу сэтгэж судал, битнесийн удирдлага орио. Анааахын шинжлэх ухаан ү мөн судалдаг. Гэхдээ нийгмийн шинжлэх ухаан, төрийн удирдлага яг шогц байдлаар нь шийдвэр гаргалтыг судалдагтгүй. Үзүүлдээ нийгмийн шинжлэх ухаан, төрийн удирдлага хамгийн сайн мэдээж, ойлгосон байх ёстой зүйл гэж болно. Төр нь нийтээ ус өрнүү, хүмүүсийн амьдралтай холбоотой, олон хүнд шууд нөлөөлөх чухал шийдвэрүүдийг байнга гаргалаг учраас энэ тал дээр их боловсорсон байх ёстой болов уу. Хууль тогтоо, шийдвэр салбарсаас хамаараад тус тусын мэдээлэл, статистик тоо, дун шинжийн эзэнтүүлэлтэй арга барилд дээр түүлгүүрээр гарах ёстой. Зөвхөн нэг барилгын зураг төсөл зохиход нийт 15-17 инженер техникийн ажилтан оролцож байж чанартай, алдаагүй зураг, төсөл болгошурулахад оршино. Хэрэв алдтаатай чанартгүй зураг, тооцоо гарвал энэ нь цаанаа олон хүний амь амьдралтай холбоотой амьдралын олон үнэт зүйлсийг үгүй хийх эрсдэлтэй шүү дээ. Гэтээн нийгмийн шинжлэх ухаан, төрийн удирдлага бол үзүүлдээ их задгай, олон талаас нь бодож цогцээгүй тэр хирээрээ буруу, алдаатай, эдийн засгийн алдагдалтай, ёс суртакуун, хүний эрхийн асуудлыг авч хэлэлцээгүй их л бүрхэг сэтгэлийн хөөрөлөөр бутдгэ нь харагдаж байлаа. Дээрээс нь намуудын болон хувь хүний өөрийн ашиг сонирхол ороод бур улс төржсөн шийдвэрүүд гарах жишэээтэй.

**Б.Наранзуу**

Эх сурвалж: Time Mongolia. 2012

Захиргааны байгууллага шийдвэр гаргахдаа ЗЭХ-ийн дээрх заалтуудыг хангальтгүй хэрэгжүүлж байгаагийн шалтгааныг судлаач дараах байдлаар тодорхойлсон.

Илтгэлийн сэдвийн судлалдахуун болж буй ЗЭХ-ийн дээрх заалтуудыг эрх зүй тодорхой бус ойлголтод хамруулж авч үзэж байна. Учир нь ЗЭХ-ийн 24, 25, 26, 27 дугаар зүйлийн зохицуулалтууд нь шинэлэг

зохицуулалт<sup>2</sup> юм. Захиргааны байгууллага тодорхой бус эрх зүйн ойлголтыг өөрийн зүгээс үзлэх боломжтой байх ба харин шүүхийн зүгээс тавих хяналт ямар түвшинд байх вэ? гэдгийг тодорхойлохыг илтгэгч оролдсон.

Энэ талаар захиргааны эрх зүйн судлаачид өөрсдийн бүтээлдээ дурдсан байдаг. Үүнд: Хуулийг хэрэглэх явцад эрх зүйн тодорхой бус ойлголтой тулгарч эргэлзээтэй байдал үүсдэг. Хуульд өргөнөөр хэрэглэгддэг “нийтийн ашиг сонирхол, “ийтийн сайн сайхан” зэрэг ойлголтууд зарим тохиолдолд яг ямар уттыг илэрхийлж их тодорхой бус байдаг. Харин захиргаанас тухай тохиолдолд уг ойлголтыг хэрэглэн тийм эсвэл угийг гэсэн зөвхөн иргээдээрнийг гаргах ёстой болдог. Уг эргэлзээтэй байдлаас үүдэн захиргаа ба иргэдийн хооронд маргаан үүсэх магадлал их байна. Эрх зүйн ойлголтын тодорхой бус байдал ба гүүнд хяналт тавих нь захиргааны хэртгийн шүүхийн хувьд байнтын маргаантай асуудлын иег юм<sup>3</sup>.

Харин иотлох баримтыг үзлэх болон иотлох ажлын хэрхэн хийх талаар ЗЕХ-д тодорхой зохицуулалт байдагтүй<sup>4</sup>.

#### **Сэдүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга, боломж**

Бодит нөхцөл байлыг судалгааныхаа үр дүнгээр нотлон тогтоож, түүний бодитой, үр дүнтэй гэдэг итгэл үзэмшилнийг бий болгоход дур зоргоор бус хэмжихүйц, нотлогдохуйн шинжтэй байхын шаардлаг. Захиргааны байгууллагын албан тушаалтины субъективт итгэл үзүүмшил дээр бус обектив нөхцөл байдлыг тогтоо загвар, аргачлал дээр шийдвэр гарч байхыг өнөөгийн цаг үеийн хэрэгтээ тодорхойлогдож байна.

ЗЕХ-ийн хуулний үзэл баримтлалын нэг чухал санааны захиргааны байгууллагын дур зоргоор буюу үзэмжээрээ, мөн үр нөлөөгүй шийдвэр гаргахаас урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн билээ.

<sup>2</sup> Ц.Цогт. Захиргааны эрх түйн огтуулэл, нийтлэлийн эмчилгээн, Уб., 2016 он.

<sup>3</sup> П.Одгурцэл. Захиргааны эрх түйн сренийн ангэ, Уб., 2016 он, 84 дж тал.

<sup>4</sup> П.Одгурцэл Захиргааны эрх түйн сренийн ангэ, Уб., 2016 он, 146 дж тал.

Нотлох баримтыг хэмжихүйц, нотлохуйц байхыг ямар арга зүйгээр тогтоо боломжтой вэ?

Сэдүйн онол арга зүйн үндэслэл

Захиргааг захиргааны эрх зүй болон удирдлагын буюу захиргааны шинжлэх ухааны үүднээс судаан авч үздэгийг бил мэднэ. Илтгэлийн гол судалгаахуун болох захиргааны байгууллагын шийдвэр зорилгоодоо нийцсэн, бодит байдлыг тогтоосон байх, үр нөлөөтэй байх зарчмын үзэл санаа, онолын суурин чиглэл нь захиргааны шинжлэх ухаанд гаргасан онол, судалгаанаас гарч ирсэн. Үүнд: Уламжлалт буюу германы эрдэмтэн, М.Вебер, американский профессор В.Вильсон, Ф.Гуднау нарын дэвшүүлсэн үзэл санаанаас эхээл орчин үеийн зал авирьын, системийн, нөхцөл байдлыи онолуудыг дурдаж байна. Жишээлбэл: АНУ-ын профессор Вудро Вильсон тэртээ 1887 онд төрийн захиргааны удирдлагад бизнесийн салбар дахь удирдлага, зохион байгуулалтын аргутудын зохистой хийгээд ажил хэрэгчээр хэрэглэхийг санал болгон, “захиргаа үр ашигтай байх” загварыг боловсруулсан<sup>5</sup>.

1960 -аад оны эхэн үеэс захиргаанад системийн үүднээс хандах хандлага бий болж, гол төлөөлгөгчид Д.Истон, Г.Алмонд, Т.Парсонс нар юм. Тэд захиргааны шийдвэр гаргагч албан тушаалтан байгууллагын гадаад орчинийт холбоотой бүхий л хучни түйлэж шинжилж, нэгдмэл шинж чанарыг тодорхойлох явдал чухал гэлгүйг авч үссэн. Ингээдээ шийдвэр гаргахдаа хамаараач, үл хамаараач хувьсагчийн харилцан нэгдлийг тооцон гаргахаас загвар юм.

Мен энэ онолын үргэлжлэл нийгмийн хувьсах өөрчлөлтийд болон захиргааны бүтцийн үр ашигт нөлөөлөх нөлөөллийг тодорхойлох нь нөхцөл байлын онол юм.

Захиргааны шийдвэр гаргальтын онолд Х.Симоныг дурдах хэрэгтэй

Захиргааны байгууллагын шийдвэр гаргах зарчим, журмыг хэрэгжүүлэхэд дараах үндсэн захиргааны шинжлэх ухааны үүднээс 3 онол, хандлага байдаг. Үүнд:

<sup>5</sup> Я.Долгоржав. төрийн захиргааны шинжлэх ухааны үүсмлэл, хөгжлийн тухайд. Төрийн захиргаа, Уб., 2012 он, 12 дэх гал.

1. Рациональ шийдвэр гаргалт;
2. Инкрементал шийдвэр гаргалт;
3. Холимог шийдвэр гаргалт.

Рациональ шийдвэр гаргалт бол маш тодорхой, нотлох баримтын хувьд илрүүж тохиолдол дээр хэрэглэдэг юм. Ж: ажлын байранд согтуураах ундаа хэрэглэсэн албан хаагчдад сахилтын шийтгэл очигдуулах шийдвэр гаргах үед хэрэглэнэ гэсэн ёт.


Инкрементал шийдвэр гаргалт бол ихэвчилэн нийтийн ашиг сонирхолтой холбоотойгоор захиргааны байгууллагын гаргасан шийдвэрийг бодит үр дүн ба ирээдүйд гарч болзошгүй эрдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тооцсон байхыг шаарддаг. Ж: замын түгжрэлийг бууруулах зорилгоор дугаарын хязгаарлалт хийх, төлөвлөлттэй холбоотой шийдвэрүүд ордог.

Холимог шийдвэр гаргалт бол ёмнөх 2 хэлбэрийг хослуулахыг хэлнэ.

Орчин үед захиргааны байгууллага бодит нөхцөл байдлыг тогтоохын тулд цутгуулсан нотлох баримтуудыг шутаман, тоглоомын, хүгарлын цэгийн шинжилгээ зэрэг математик загварчалын аргачлалаар үнэлэх нь илүү үр дунтгээ гэх үзэх хандлага гарч ирж байна. Энэ нь шийдвэр гаргагч субъектив байдлаас татгалзаж, бодит байдлыг илүү объектив талаас харж дүгнэхэд ач холбогдолтой юм. Тодруулбал, цугларсан ноглох баримтуудыг үзлэхдээ өөрийн итгэл үзүүшил, эсхүл хэн нэгний даалгавар, хүснэгтээр (дара, эсхүл иргэдийн), мөн “хуурай” тоон үзүүлэлтээр бус тохиолдол бүрийг өгөгдөл гэж үзэн хамаарах, үл хамаарах хувьсагчийн шинжилгээ хийн, программд оруулах гэж ойлж болно.

Манай төрийн захиргааны байгууллага ЗЭХ-ийн 24 дүгээр зүйлний 4-заалтын дагуу шийдвэр гаргахдаа дээр дурдсан аргачлалуудыг төдийлэн ашигладагтүй байна.

2. Та захиргааны шийдвэр гаргах бодит нөхцөл байдлыг тогтоох тохиолдол бүрийг шинжилж судлаадаа ямар арга зүй, аргачлалыг баримталдаг вэ?



Захиргааны байгууллага бодит нөхцөл байдлыг тогтоох тохиолдол бүрийг шийдвэр гаргалтын математик загварчлалаар шинжилж, судалгааныхаа дунд дээр үндэслэж хуулдийг тохицуулсан хэрэглэх гэсэн дарааллаар шийдвэр гаргах нийтийн зарчмыг хийнчилж, төслийн төслийн зарчмыг хийнчилж, судалгаач узжж байна.

Эдгээр онолын болон практикт судалгаа шинжилгээ хийснээр дараах асуулт гарч ирсэн.

нэгдүгээрт, ЗЭХ-ийн 24 дүгээр зүйлийн 4-т засцын дагуу бодит нөхцөл байдлыг тогтоохын тулд тохиолдоо бүр нийг шинжилж судлаадаа здийн засаг, менежмент, социологи, статистикийн шинжилж ухааны аргутдын туслаамжтайгаар тогтоосон нотлох баримтад эрх зүйн үүдиэсэх хэрхэн үзүүлжтэй гэх вэ?

хоёрдугаарт, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх нэхэмжлэл гаргах зэрэг тодорхой бус эрх зүйн ойлголтыг тодорхойлоход дээрх аргуд баримтлаар стандарт, аргачлал болж чадах уу?

гурвуудгаарт, Бодит нөхцөл байдалд шинжилгээ хийгээд гарсан шийдвэр нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан журмын зохиц заалттай зөрчилдөх, тухайлбал хуулиар эрх олгогдоогүй, хуулиид энэ талаар зохицуулалт байхгүй зэрэг байвал уг шийдвэрийг гаргахгүй байж уу?

дерөвдүгээрт, Захиргааны байгууллага математик загварчалын дагуу нотлох баримтын үзлэсэн талаар маргаан гарвал шүүх хэрхэн шийдвэрлэх вэ? гэсэн асуулт гарч ирж байна.

## ЭМИЙН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТ, ХЭРЭГЛЭЭГ ХЯЗГААРЛАХ ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ



УЕПГ-ын Сургалт судалгааны төвийн ахлах прокурор, хууль цэвээн шадар зөвлөх, хууль зүйн доктор Б.Өнөрмар

### ТУЛХҮҮР ҮГ:

Эм, уламжлалт эм, биобэлдмэл, эмийн хууль бус эргэлт, уламжлалт эмчилгээ.

### УДИРДГАЛ

Сүүлийн жилүүдэд эм, эмнэлгийн хэрэгслээс гадна биобэлдмэл үйлдвэрлэх, худалдах, түгэж, импортлох явдал нэмэглэж, тусгай зөвшөөрөлгүй иргэн, хуулийн этгээд энэхүү үйл ажиллагааг ямар нэгэн зөвшөөрөлгүйгээр эрхэлж байгаагас хүн амын эрүүл мэндэд аюул учруулах болсон бөгөөд малын эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн чанар, эрүүл ахуйн шаардлагын талаар ноцтой мэдээлэл нийгмдэл түгээгдэж болсон.

Иргэдийн гарцаагүй байдал буюу хүнд өвчиний өмнө хүчин мөхөстсөн байдлыг далимдуулан малд хэрэглэгдэг эм, бэлдмэлний хорт хавдар элгээдэг, элдэв төрлийн ургамлыг ахуйн хүрээнд бэлдэж төрөл бүрний өвчин анаагадаг гжиттуулэн нууцшар зарж борлуулсаар байгаа нь одоог ч хүртэл түгээмэл байна.

Мөн БНХАУ, БНСУ-ын уламжлалт эмчилгээ хийх эрх бүхий турав дахь шаталын эмнэлгэгт тухайн улсад үйлдвэрлэсэн “тан”-г иргэдэд санал болгох, түүнийг иргэд хэрэглэж байгаа нь нууц биш юм.

### НЭГ. Хуулийн агуулга тодорхой бус байдал

Хууль бол эрх зүйн хэм хэмжээний акт бөгөөд бүх нийт заавал дагаж мөрдөхөөр төрөс батлан гаргасан дээд хүчин чадал бүхий баримт бичиг байдал. Тиймээс ч хуулийн заалт бүх хүнд ойлгомжтой, тодорхой байх ёстой гэсэн зарчим байдал.

Түхайлбал, Герман улсын Холбооны улсын ийнтийг журмын 42 дугаар зүйлд “Хууль, хэл зүйн хувь зөв, алз болго бүх хүнд ойлгогдохоор байх ёстой бөгөөд эрх зүйн хэм хэмжээг тодорхойлоходо тухайн зохицуулах гэж буй хариулцаанд хэрэглэгдэх хэм хэмжээ хэл зүйн хувьд яг тохирсон” байхыг шаарддаг.<sup>1</sup>

Эрх зүйн хэм хэмжээний нөхцөл, үндэслэл, заалт, журмууд нь хоорондоо логик зүй тогтолцоо холбогдсон тэнцивэржих, хийдэлгүй зөрчилгүй уялдан хуулиялгдсан байх ёстой.<sup>2</sup>

Тэгвэл Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.14 дутгэр зүйлийн I дэх хэсэг нь ойлгомжгүй томъёологдсон байгааг доорх хүснэгтээс харж болно.

**20.14 дутгэр зүйл.** Хууль бусаар эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх

1.Эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хүн, малын эмчилгээнд хэрэглэхийг хориглосон, зөвшөөрөгдөөгүй, хугацаа дууссан эм,

<sup>1</sup> Gesetze bedienen sich einer Gesetzessprache, die oft nicht mit der Umgangssprache übereinstimmt.

<sup>2</sup> С.Нарангарэл, Эрх түйн эх толь бичиг, УБ., 2012 он.

эмнүүдийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслүүдийг үйлдвэрлэсэн, импортолсон, хулалсан, түгэсэн бол .....

ЧИЛДЫН ЭМЧИЛГЭН ЭРДЭЛХИЙН ЗОВШРОБОН, ЧУГААН ДУУСАНЫ  
ЭМЧИЙН ХОРТ ХАВДАР ЭМЧИЛГЭД ГҮХ ИНГЕН АЯ ХЭРЭСПЛЭЖ БАЙГАА ХҮН НЕГӨӨ  
ТАЛААС ҮҮНИЙН АШИГЛААН ЗАРХ БАЙГАА ХҮННИЙ ҮЛДЛЭЭД ХУУЛЬ ТҮҮН ТАЛААС  
ХЭРЭХЭН ДҮТГЭЛТЭНД ХИЙХ ВЭ?

ХОЁР ХУУЛИЙН ХИЙДЭЛ

Нэрлэгдсэн халдлагын зүйлийг хувьд зааснаар тодорхойлж бол:

- “эм” гэж хүний бодо мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийт оношлох, эмчлэх, дархлаажуулах зориулалттай, үйлчлэл нь эм судалал, эмзэлгүйн сорилт туршилтгаар нотлогдсон, нийнэг буюу амьтai, ургамал, эрдсийн гаралтай бодисыг тодорхой хэлбэрт оруулсан, зохиц тун, хэмжээгээр хэрэглэдэг бэлдмэлийг;

- "биобэлдмэл" гэж хүний болои мал, амьтны өвчнийг эмчлэх, оношлох, өвчинеөс урьдчилан сэргийлэх зориулалтаар амьз бие, бие махбоды, түүний эд, эсэс болон лабораторийн аргаар гаргаж авсан бутаатгахийн:

- "уламжлалт эм" гэж хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх зорилгоор тодорхой тун, хэмжээгээр хэрэглэдэг, уламжлалт анагаах ухааны жорын дагуу ургамлал, амьтан, эрдсийн гаралтад бодис болон үнэт эрдэнэс оруулан уламжлалт болон үйлзврийн аргаар бэлдэснээ

байгалийн гаралтай бүтээгдэжүүнийг<sup>4</sup> ойлгоно гэжээ.

Нийгэмд уламжлалт аргаар болжээ, хүний эрүүл мэндэд ач холбогдолтой, тодорхой төрлийн өвчний илэршиүүлэх чадалтай гэж итгүүлэн мал, амьтын эсхүл ургамлын гаралтай “тав” гэж нэршигийт уламжлалт эмийг ахуйн дүрээнд бэлтгэж боловсруулан, зарж борлуулж, ашиг олж байгаа үйлдэл тутгээмэл байгаа нь нутгийн биш болоч уламжлалт эмийг зөвшөөрэгүүгүй үйлдвэрлэсэн, импортолсон, худалсан, тутгэсэн үйлдлийг хуулиар хориглоогүй зөвхөн “эм, биобэлдэмэй” гэж хязгаарласан бөгөөд, уг үйлдлийн улмаас буслад кор уришгийн чиглэлийн тохиолдод ямар хуулиар харинчлагаяа хүлэгэх нь толдохийн бсий байна.

Уламжлалт эм нь эм гэсэн ангилалдаа багтах эсэх нь Эрүүтийн хуулийн дээрх залтад тодорхойгүй байна. Учир нь “Эм, эмзилгийн хэрэгслийн тухай хууль”-д “эм”, “уламжлалт эм” гэдгийг хоёр салгаж тайлбарлажээ.

Мөн уламжлалт арга буюу уламжлалт анаагах ухаан дээр сууринсан, эм бэлдэх арга гэгдгийг хуульчлаагүй тохиолдолд уламжлалт аргаар эмчилгээ хийж Хятад, Солонгосын уламжлалт эм нэрийн доор иргэдэд зарж борлуулан эмчилгээндээ хэрэглэж буй “тан” ийн тухайн улсдаа эм боловсруулах стандарт, нехцэлдээ уйлдвэрлэгдсэн эсхийг шалгах, тогтоох боломжгүй бөгөөд журмаар зохицууллагдах стандарт зөрчсөн тохиолдолд мөн л хүлээлгэх хуулийн хариуцлага төдорхой бий байна.

Монгол оронд нийтдээ 2100 гаруй байгалийн гуурст ургамал ургадгаас 1100 нь эмийн ургамал юм. Үүнээс аж ахуй, үйлдвэрлэлд 200 гаруй нь ашиглах байна.

Сүүлийн таван жилийн тоон судалгаанаас узэхэд байгалийн ургамлыг хуул бусаар бэлтгэж гэмт хэрэг 2015 онд 14, 2016 онд 17, 2017 онд 42, 2018 онд 19, энд энд одогийг байдлаар 4 тохиолд бүртгэгдээд байна. Гэмт хэрэг ўйлдэж буй

<sup>3</sup> Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Төрийн мэдээллийн эмхэтгэл №25 УБ., 2010 он, 3 дугаар зүйн.

<sup>4</sup> Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Төрийн мэдээлэл №25 УБ, 2010-ын 3 чиглэлийн тийз.

шалтгаан нь улсын хилээр нэвтрүүлж ашиг олох зорилготой. Монгол орон байгалийн ургамлыг экспортлогч орон болсон<sup>5</sup> талаар албаны эх сурвалжид дурдагдсан байдал.

Гэтэл Эрүүгийн хуулний тусгай антгийн 20.14 дутгээр зүйлд “уламжлалт эм” болон гзрийн тэжээвэр амьтныг / нохой, муур, гахай, тахиа г.м/ эмчлэжээд хэрэгзэх эм, биоблэдмэл түүнийг хууль бусаар үйлдвэрлэсэн, худалдсан, түгээсэн, импортолсон талаар хориглосон зохицуулалт огт байхгүй бөгөөд мөн хуулийн тусгай ангийн “Улын хилээр бараг хууль бусаар нэвтрүүлэх” буюу 18.5 дугаар зүйлийн 18.5.2.3 дахь хэсэгт “ургамлын өвөрмөц ховор унэт одловор”ыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлжийн замдсан, нэвтрүүлсэн тохиолдолд гэмт хэрэгт тооцоогоо заажээ.<sup>6</sup>

Мөн хуулийн 24.8 дугаар зүйлд  
“нэн ховор, ховор ургамал”-ыг “түүсэн,  
бэлгээсэв, худалдсан, худалдан авсан,  
хадгалсан, тээвэрлэсэн, боловсруулсан”  
бол эрүүгийн хариншлага хүзүүлжэээр  
заасан байна.

Гэвч “эн ховор, ховор” ангилалд багтаагүй атлаа уламжлалт хэрэглээс эсхүл ам дамжсан яринаас үзүүлэлтэй, хүний эрүүл мэнэд ноцтой хохирол учруулж бэлэншгүй, эмийн үйлчилгээгээ “тан” гэх нэршилтэй, шинжлэх ухааны хувьд эмчилгээний эсхүл аливаа өвчний эсрэг үйлчилж нь батлагдаагүй уламжлалт эмийг хувнаараа болгүйн болтуулж байгаа үйлдлийг хуулиар зохицуулах шаардлагатай байна.

“Уламжлалт эм”-ийн гаж нөлөө нь шууд болон шууд бусаар буюу тодорхой цаг хугацааны дараа илэрх болох бөгөөд зарим тохиолдолд аливаа өвчний явцыг түргэсгэх аюултай байж болоу иргэд өвчинн,

зовиураас салах магадгүй анагаахын шинжлэх ухаан хүчин мөхөстсөн өвчний үед хувиаараа "тан" барьдаг гэх хүмүүс дээр сайн дураараа очдог нөгөө талаас бусдын өвчин, шаналтлыг мэнгэ олох хэрэгж болгож буй хүмүүсийн золнос болж байгаад анхаарлаа хандуулах шаардлагатай болжээ.

Анагаахын шинжлэх ухаан хүчин мөхестсэн өвчний үед хүн уламжлалт эм нэртэй төрөл бурийн зүйл хэрэгжээ гайдаагаар улмаар нас барсан тохиолдлоод уг өвчний улмаасаа эсхүл хэрэгжсэн ургамал болон амьтын гаралтай бэлдмэлээс болсонд уу Нэгөө талаас угаасаа тавилан багатай өвчний явцыг уг бэлдмэл түргэтгэсэн үү гэдгийг нотох боломж манайд бий юу гэдэг нь эргэлзээцэй.

Эрүүгийн хуульд зөвхөн “Эм, эмийн түүхий эд, биоблэдмэл, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн уйл ажиллагааг эрэхжэл байгаа хүн, малын эмчилгэнээд хэрэглэхийг хориглосон, зөвшнөөргөдөөгүй, хугацаа дууссан эм, эмийн түүхий эд, биоблэдмэл, эмнэлгийн хэрэгслийн уйлдвэрэлсэн, импортолсон, худалдаасан, түгээсэн” үйлдлийг гэмт хэрэгт тооцооснайв атлаа экспортлох уйл ажиллагаагаар орхигдуулсан нь учир дутгагдалтай байна.<sup>7</sup>

Монгол Улс эмийн ургамлын нөөцийн баяглаар зэлбэг гэдгийг зөвхөн Монгол Улсын иргээсэд гадна гадаадын иргээдэг мэддэг болсон, жуулчны визээр Монголын улсад ирж эмийн ургамлыг судалдаг болсон нь нэгэнт ил болсон зүйл.

<sup>5</sup> <http://cllcc.mny/n/64616.html>

\* Эрүүгийн хуулийн 185 дутвар түйл. Улсын хилээр бараагт кууль бусаар иштэрүүлж. Хууль, Монгол Улсын олон улсын гэртээд замны дагуу кориглосон, хязгаарлалт тогтоосон барааг Монгол Улсын хилээр, гавлийн хилээр кууль бусаар иштэрүүлж. ....

3. Энэ газын ажлын соёлын дурсгалт түлл, музейн үзүүр, яргийн замтын, ургамлын өвөрмийн хөвөр үүсгэлтэй алдвар, археологийн, палеонтологийн алдвар, эд олонийн зүйлийн мансууруулалт, стипендийн нийгмийт бодисын үлсын хилээр куудаа бусад ишгүүрүүдийг үйлчилж бол

Уламжлалт эмчилгээнд хэрэглэгддэг, нэн эсхүл ховор эмийн жагсаалтад бүртгэгдээгүй, Монгол Улсын эм болон уламжлалт эмчилгээнд танилдаагүй боловч гадны улсад тэр тусмаа уламжлалт эмчилгээг эрхэмлэдэг Азийн улс оронд өргөнөөр хэрэглэдэг ургамлыг Монгол Улсад боловсруулан, хилээр ивтрүүлэхийг зөвшөөрсөн баарга /эмчилгээний зориулалт бүхий дэр, хөнжил г.м./, бүтээгдэхүүн /биологийн нэмэлт бүтээгдэхүүн, амттан, эмчилгээний зориулалт бүхий тос, тосон турхлэг г.м/ болгон экспортлох бүрэн боломжтой байгаа нь хуулийн дээрх зохицуулалтаас харагдаж байна.

Энэ нь Монгол Улсын эмийн ургамлын нөөц болон судллагаагүй боловч цаашид уламжлалт эмчилгээнд хэрэглэгдэж болох ургамлын нөөц устаж угий болох эрдээлийг дагуулж байна.

Хэрэв “Эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хүн, малын эмчилгээнд хэрэглэхийг хориглон, зөвшөөрөгдөөгүй, хугацаа дууссан эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл”-ийн зарим нь тухайлбал эмийн түүхий эд /хэдий хугацаанд хадгалахыг журамлаагүй эсхүл тодорхой бус, хугацаагүй хадгалж болох/, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсл нь хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу хориглон, хязгаарлалт тогтоосон баарын жагсаалтад иершиэрээ ороогуй байгаа тохиолдолд түүнийг экспортлоход ямар хариуцлага хүлээлгэх нь тодорхой бус байна.

Зөрчлийн тухай хуулийн 6.6 дугаар зүйл буюу “Эм, эмнэлгийн хэрэгслийн

тухай хууль зөрчих” заалтад “Эм, эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгслэгдэг үйлдвэрээр”, шинэ эм хэрэглээнд гаргах шаардлагатай, нөхцөлийг зөрчсөн импортою, эсхүл экспортлоход тавигдах шаардлагатай, эсхүл хориглох зүйлийг зөрчсөн” тохиолдолд зөрчилд тооцож хариуцлага хүлээлгэээр байгаа нь хуулийн хийдлийг ашиглах боломж гарч ирж байна. Тухайлбал, “уламжлалт эм” үйлдвэрэлж хэрэглээнд гаргах шаардлагатай, нөхцлийг зөрчсөн тохиолдолд хэрхэн хариуцлага хүлээлгэж эсж нь тодорхойгүй байна.

Хуульд тодорхойлсон “эм барих эрхгүй” атлаа бусад санал болгож, итигүүлж буй “тан”-г өөрийн бие дээр хэрэглэж үзсэн эсхүл олон хүн үүнийг хэрэглээд илаадирсан талаар итгэл үнэмшил бий болсов, энэ нь аяагаахын шинжлэх ухаанаар батлагдаагүй эсхүл үүгүйсгэдээгүй тохиолдолд тухайн уламжлалт эс буюу “тан”-г хэрэглэсэн хүний эрүүл мизд нь муудсан бүр цаашлаад амь нас нь хохирсон тохиолдолд ямар хуулийн заалтаар хэрхэн хариуцлага хүлээлгэх нь тодорхой бус байгаа хуулийн хийдлийг арилгах шаардлагатай.

## ДҮГНЭЛТ

Нэг. Аливаа хуулийн тодорхой бус зохицуулалтаас шалтгаалж нийтэд бий болсон эсхүл бий болзошгүй нөхцөлийг арилгах нь өөрөө аливаа гэмт хэрэгэс

<sup>1</sup> Эрүүгийн хуулийн 6.6 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн түзүүдийн зорилтуудыг хувь зөрчих. 1.Эм, эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгслэгдэг үйлдвэрээр, шинэ эм хэрэглээнд гаргах шаардлагатай, нөхцөлийг зөрчсөн бол зөрчилд үйлдэхэд ашигласан за зүйл, хэрэгслэ, хууль бусар алсон хөрөнгө, орлогыг хураах, ууруулсан хөхирол, ихэнх толборийг гаргужуулж, үйл ажиллагаа эрхэлж тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хүнийг иж зүүн тавин нийгэтийг тийнхүүхийн тогтолцоог, хуулийн тэтгээдийг ног мянган таван зуун нийгэтийг тийнхүүхийн хэмжээний тогтолцоог тогтолцоо. 2.Эм, эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгслэгдэг импортою, эсхүл экспортлоход тавигдах шаардлагатай эсхүл хориглох зүйлийг зөрчсөн бол зөрчилд үйлдэхэд ашигласан за зүйл, хэрэгслэ, хууль бусар алсон хөрөнгө, орлогыг хураах, ууруулсан хөхирол, ихэнх толборийг гаргужуулж хүнийг ног зүүн тавин нийгэтийг тийнхүүхийн хэмжээний тогтолцоог, хуулийн тэтгээдийг ног мянган таван зуун нийгэтийг тийнхүүхийн хэмжээний тогтолцоог тогтолцоо. Тайлбар: Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөрчил гаргасан эзээлэхийн ширэлзэр улсын бүртгэлийн загварас зөрүүтгэй /өнгө, дурс, бичгийн хэлбэр зорчт/ эм, эмнэлгийн хэрэгслэгдэг Монгол Улсын хэлсөн иквентруулжэгүйгээр гадилийн бүсээс бушашаа.

урьдчилан сэргийлэх чухал нөлөөтэй байдаг. Уламжлалт эмчилгээ, эмийг эртийн дээдэлж ирсэн Азийн улс орнууд тэр тусмаа Монгол улсын хувьд ургамлын гаралтай зөвшөөрөгдсөн “уламжлалт эм”-ийг хэргэлэх нь тутгээмл бөгөөд үүнийг дагаад хувнаараа эм буюу “тан” барьдаг, энэ нь амьдралын эх үүсвэр болсон хүн цөөнгүй байгааг бүтг мэддэг, нийтгэмд “хүлээн зөвшөөрөгдөөд” байгаа нь нууц биш юм.

Ургамлын гаж нөлөөнний талаар мэдлэг хомс түүнчлэн тухайн ургамал болон уламжлалт хэрэглээнийн талаар, мөн эмчилгээний батлагдаагүй зөрж үр дунгийн тухай ам дамжсан ярианд итгэж эрүүл мэнд, амь насаа эрсдэлд оруулж байгаа иргэдийг нөгөө талаас бусдын өвчин, шаналтыг мөнгө олох хэрэгсэл болгож буй хүмүүсийн үйлдлийг таслаи зогсоохын тусла Эрүүтийн хуулийн тусгай ангийн 20.14 дүгээр зүйлд “уламжлалт эм”-ийн тухай захицуулж өгөх.

Хоёр. Уламжлалт эмчилгээнд хэрэглэгддэг, нэн эсхүл ховор эмийн жагсаалтад бүртгэгдээгүй, Монгол Улсын эм болон уламжлалт эмчилгээнд танигдаагүй боловч гадны улсад тэр тусмаа уламжлалт эмчилгээг эрхэмлэдэг Азийн улс оронд өргөнөөр хэрэглэдэг ургамлыг Монгол Улсад боловсруулан, хилээр извтрүүлэхийг зөвшөөрсөн баардаа /эмчилгээний зориудалт бүхий дээр, хөнжил г.м/ бүтээгдэхүүн /биологийн нэмэлт бүтээгдэхүүн, амттан, эмчилгээний зориудалт бүхий тос, тосон түрхлэг г.м/ болгон экспортгүй бүрэн боломжтой байгааг анхаарч хязгаарлалт хийх. Ишгэнээр Монгол Улсын эмийн ургамлын нөештэй ороогүй эсхүл судлагдаагүй боловч цаашид уламжлалт эмчилгээнд хэрэглэгдэж болох ургамлын иөөц устаж үгүй болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой болно.

---000---

## ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ЗҮЙЛЧЛЭЛИЙН АСУУДАЛ



**МУИС-ийн Хууль зүйн сургуулийн  
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш,  
хууль зүйн доктор, дэд профессор  
Д.Бадам**



**Хууль зүйн магистр  
У.Баянтогтох**

### ТҮЛХҮҮР ҮГС:

Гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүлийн хамаарал бүхий хүн, гэмт хэргийн зүйлчлэл, зөрчил, гэмт хэрэг, байнга үйлдэх.

### ТОВЧЛОЛ:

Сүүлийн жилүүдэд манай улсын хувьд гэр бүлийн хүчирхийлэлээ үйлдэлтэй гэмт хэргийн гаралт өсөж, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдын тоо жил ирэх тусам нэмэгдэж, хүхүэд, эмзгүйчүүд, өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эсрэг чиглэсэн гэмт үйлдэл нь илүү харгис хэргийг шинжтэй болж байгаа нь энэтхэгийн гэмт хэргийн зохицуулалтын онол, практикийн маргаантай асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болохыг илтгэж байна.

### УДИРТГАЛ

2015 оны Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийг хуульчлан тогтоосон бөгөөд энэхүү гэмт хэрэг нь практикт маш их үйлдэгдэж буй нь шүүхийн статистикийн

судалгаанаас харагдаж байна. Тухайлбал, 2017 онд 59 гэмт хэрэгт 33 хүн, 2018 онд 115 гэмт хэрэгт 73 хүн, 2019 оны эхний 3 дугаар улирлын байдлаар 146 гэмт хэрэг тус тус үйлдэгдэж аихан шатны шүүхээр шийтгүүлжээ<sup>1</sup>.

Шүүхээр шийдвэрлэсэн зарим хэргүүдийн шийтгэх тогтоолтой танилцахад уг гэмт хэргийн зүйлчлэлийг ялгамжтай байдлаар хийж, хүний эрхийг зөрчих эсхүл ял завшуулж буй нь билдний хийсэн судалгаанаас харагдсан юм. Энэ нь нэг талаас эрүүгийн хуулийн зохицуулалт учир дутагдалтай, хийдэл, зөрчилдөөнийг агуулсан нөгөө талаас шинэ төрлийн гэмт хэрэг утгаар практикт тогтсон жишиг, уламжлал байхгүйтэй холбоотой.

Гадны орууудын ийтглэг жишиг хандлагаас харахад тухайн гэмт хэрэг Эрүүгийн хуулинд биц даасан гэмт хэрэг болон хуульчлагдаагүй, ихэнх тохиолдолд тодорхой төрлийн гэмт хэргийн “энэ гэмт хэргийг гэр бүлийн хамаарал бүхий хүний эсрэг үйлдэсэн” гэх хүндрүүлэх иөхцөлөөр.

<sup>1</sup> Шүүхийн ерөнхий эмчлийн цахмыг хуудас, [www.judipati.mn](http://www.judipati.mn) 2018, 2019 оны III улирлын шүүчин таслах ажиллагааны тайлайн.

Англи Саксон эрх зүйн бүлд хамаарах орнууд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай тусдаа хуулиар тус тус зохицуулсан байдаг.

Энэхүү огтууллийнхээ хүрээнд практикт түгээмэл үйлдвэрлэж буй ут гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт болон хэргийн зүйлчлэлийн асуудлыг судлан үзэж практикт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхийг зорьсон болно.

## ҮНДСЭН ХЭСЭГ

**Нэг.** Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн гаралтын байдал

Хэдийгээр Монгол Улсын Эрүүгийн хуульд “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг”-нгэй анх удаа эрүүлжүүлж, хуульчилсан ч хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хамгийн түгээмэл үйлдвэрлэг, гэмт хэрэг үйлдвэгчийн тоо жил бүр есөн нэмэгдхэг хандлагатай байгаа нь Цагдаагийн байгууллагын статистик судалгаанаас харагдаж байна. Ялангуяа энэ төслийн зөрчлийн тоо жил бүр есөж буй хандлага нь цаашид гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн гаралтад нөлөөлөх нь дамжигтгүй.

Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн статистик үзүүлэлтээс үзвэл<sup>2</sup> 2018 онд гэр бүлийн хүчирхийлийн улмаас үйлдвэгдсэн гэмт хэрэг 1070 бүртгэгдсэн ба уг гэмт хэрэгт 1192 хүн холбогдон шалгагдсан байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2018 оны байдлаар улсын хэмжээнд 210 үйлдвэгдсэн нь өнгөрсөн оньхаос 13 хэргээр буюу 5.8 хувиар буурсан үзүүлэлтэй байх ба тухайн жилд нийт гэмт хэргийн 0.6 хувийг, эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт 19.6 хувийг тус тус эзэлж байна. 2018 оны байдлаар тус гэмт хэргийн улмаас

797 хүн хохирч, үүнээс 5 хүн нас барж, 675 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүний тоо 4.4 хувиар, гэмтсэн хүний тоо 27.9 хувиар буурийз<sup>3</sup>.

Зөрчлийн тоон мэдээний хувьд улсын хэмжээнд нийт 1698178 зөрчил бүртгэгдсэн ба зөрчлийн 0.3 хувийг буюу 5812 зөрчил нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зөрчил эзэлж байна. Нийслэл хотын хэмжээнд 2018 онд үйлдвэгдсэн 121144 зөрчлийг шалгасны 3346 буюу 2.8 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зөрчил эзэлж байгаа нь энэ төслийн зөрчлийн тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад даруй 1318 зөрчлөөр буюу 64.9 хувиар есжээ<sup>4</sup>.

2019 оны эхийн 9 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 229 бүртгэгдсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 49 хэргээр буюу 27.7 хувийн есөн үзүүлэлттэй байна<sup>5</sup>.

Үүнээс үзвэл, Гэр бүлийн хүчирхийлийг гэмт хэрэг тооцсоны ҮР дунд гэмт хэргийн гаралт буурч харин Зөрчлийн дун есөн нь гэр бүлийн хүчирхийлийн талаарх мэдээллийг иргэд цагдаагийн байгууллагад шуурхай дамжуулдаг болж иргэний үүргээ билүүлж байгаатай, цагдаагийн байгууллагын зүгээс дээрх дуудлага, мэдээллийдүүдийг нэн тэрүүнэ шалгах хүчирхийлэл үйлдвэгчийн үйлдэл бүрд хуулийн харнишлага ногдуулж байгаатай холбоотой<sup>6</sup> хэмээн Цагдаагийн байгууллагаас дүгнэжээ.

Энэхүү халдлагад дийлэнх тохиолдолд бага наасны хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настнууд өртдөг төдийгүй тэд амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирж байдаг. Иймд уг гэмт хэргийн зүйлчлэлийн асуудлыг судлан үзэж эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нөхцөл боломжийг

<sup>2</sup> Мен гиш

<sup>4</sup> Цагдаагийн сронийн газар, Монгол Улсад бүртгэсэн гэмт хэрэг, зөрчлийн нийтийн байдал-ҮБ., 2018 он, (ҮБ: ЦБГ, 2019 он), 215 дэлж тал.

<sup>5</sup> <https://police.gov.mn>.

<sup>6</sup> ХДХЯ, “Эрүүгийн хууль тогтоомжийн хүрэгжилтийн тайлбар таницуулга, ҮБ, 2018 он.

судлан үзэх зайлшгүй шаардлага бий болоод байна.

**Хоёр. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг зүйлчлэхэд анхаарах зарим асуудал**

Шүүхийн практикийг судлах явцад гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн зүйлчлэлийг язь бүрээр хийж байна. Тухайлбал,

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлд заасан “Хүний алх” гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл болох “тэр бүлийн хүчирхийлэл үйлдэж” гэх ойлголтыг, мөн эл нөхцөлүүдийг эш татсан диспозици хэлбэртэйгээр хүний эрүүл мэндэд хүнд, хүндэвтэр, хөнгөн хохирол учруулсан гэмт хэргүүдэд хүндрүүлэх нөхцөл болгон хуульчилсан бөгөөд ийм хэргүүдийг зүйлчлэхэд эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дахь хэсэгт заасан гэмт хэрэгтэй нийлмэлээр, зарим тохиолдолд тухайн хүндрүүлэх нөхцөлийг дамгаар хэргэлэн зүйлчилэл Зүйлчилэгийг хэрхэн хуулийн үндэслэлтэй хийх, зүйлчилэл хийхэд ямар асуудал анхаарах талаарх асуудлыг авч эсэх.

1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүний санаатай алсан, хүнд, хүндэвтэр, хөнгөн хохирол учруулсан тохиолдолд нэг үйлдэлтэй нийлмэл гэмт хэрэг гэж зүйлчлэгдэх эсэх:

Нэг үйлдэл, эс үйлдохгүйгээр Эрүүгийн хуулийн хоёр буюу түүнээс дээш өөр зүйлд заасан гэмт хэргийг бие даасан бүрэлдэхүүнтэйгээр үйлдэснийг ойлгох бөгөөд шалтгаант холбооны онолын үүднээс эдгээр гэмт хэрэг нь хоёул материалилаг бүрэлдэхүүнтэй байх боломжтүү.

Дээрх тохиолдолд нийлмэлээр зүйлчлэгдэж буй гэмт хэргүүд төгс үйлдэгдсэн буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн диспозицид заасан объектив, субъектив бүх шинжүүдийг бүрэн хангасан байх шаардлагыг агуулна.

Тэгэхээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн заавал байх объектив шинж болох “байнга” зодсон, харгис хэргийг харысан, догшин авирласан, тарчлаасан, хувваарт болон дундмын эд хөрөнгийг ашиглах, эзэмших, захиран зарцуулах эрхэд халдсан гэмт үйлдэл, эс үйлдохгүйг гэм буруутгийн санаатай хэлбэрээр хэргүүдээн тохиолдолд дээр дурдсан гэмт хэргүүдтэй нийлмэлээр зүйлчлэгдэх боломжтой.

Харин нэг удаагийн үйлдээр өөрөөр хэлбээ зөрчил үйлдэх явцдаа гэр бүлийн хамаараал бүхий хүнийг санаатай алсан, хүнд, хүндэвтэр, хөнгөн хохирол учруулсан бол дангаар буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.8, 11.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 11.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгүүдээр тус тус зүйлчлэгдээз.

Учир нь хууль тогтоогч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.8 дахь заалтад заасан хүндрүүлэх нөхцөлд “тэр бүлийн хүчирхийлэл үйлдэж” гэж хуульчилсан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дахь заалтад “тэр бүлийн хүчирхийлэл” гэж энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчилд хамаараан хүний сэргэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдохгүй” хэмээн хуульчилсны дагуу ойлгох ба энэ нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжийт хангасан тохиолдолд энэхүү хүндрүүлэх нөхцөлийг хэрэглэнэ гэсэн үг огт биш юм. Хэрэв хууль тогтоогч “тэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийг үйлдэх явцад” гэж хуульчилсан бол 11.7 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжийт хангасан байхыг зайлшгүй шаардах ёстой.

Шүүхийн практикийг судалж үзэхэд:

Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 03 сарын 29-ны өдөр 229 дугаар бүхий шийтгэх тогтоол<sup>7</sup>:

-Энь 2017 оны 06 дугаар сарын 11-ны өдөр хамтран амьдрагч Ч.М-тай хүүхдээсээ болж маргаж, улмаар түүнийг зодож, эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан

-2017 оны 06 дугаар сарын 27-ны өдөр хамтран амьдрагч Ч.М-тай үл ялих шалтгаанаар маргаж түүнийг зодож, эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан

-2017 оны 07 дугаар сарын 04-ны өдөр дахин зодсон хөргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж түүний үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-т заасан гэр бүлийн хамаарал бүхий харицаатай хүний байнга зодсон гэмт хэрэг тус тус үйлдсэн гэм буруутайд тооцжээ.

Өөр нэг жишээг судлан узвэл, Өмнөговь аймаг дахь сүм дундын Эрүүгийн хөргийн анхан шатны шүүхийн 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 135 дугаар шийтгэх тогтоо:

Н.Б нь гэр бүлийн хамаарал бүхий хүн болох Ч.Э-г 2016 оны зүйн гурлилын илдүүрээр цохиж зодсон, 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдөр гарцаараа цохиж ухаан алдуулж байсан, мөн оны 2 сард хузүү рүү гарцаа цохиж зодсон, 2017 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр толгой руу цохиж, баруун талын хавирга руу хөлөөрөө өшиглесний улмаас хөнгөн хохирол учруулсан хөргийг шийдвэрлэж түүнийг гэм буруутай гэж үзж. Н.Б-н үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгээр зүйлчилжээ.

Дээрх хоёр кейсээс харахад гэмт хэрэг үйлдэгсэл өөрийн гэр бүлийн хамаарал бүхий хүмүүсийг байнга зодож гэр бүлийн хүчинрхийгээ үйлдэж байсан, ийнхүү хүчинрхийлэл үйлдэх явцдаа хохирогчийн эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан байна.

Үйлдсэн хөргүүд агуулгын хувьд адил боловч аихан шатны шүүхүүд хоёр өөр зүйлчилэлийг хийжээ.

Хууль зүйн үүднээс авч узвэл нэг үйлдэлтэй ниймлэл гэмт хэрэг бөгөөд тэдний үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчинрхийлэл үйлдэх, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлд заасан хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэргүүдийн үйлдсэн байна.

Харин Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлд заасан хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэргийн срдний бүрэлдэх үүнээр эсхүл хүндрүүлж зүйлчлэх асуудал тулгарах юм.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.8-д “гэр бүлийн хүчинрхийлэл үйлдэх” гэх хүндрүүлэх нөхцөлийг хуульчилсан ба эл ойлголтын мөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 11.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт иш татан хуульчилснаас узвал хууль тогтоогч гэр бүлийн хамаарал бүхий хүний амь насыг хохироосон, эрүүл мэндэд хүнд, хүндэвтэр, хөнгөн хохирлыг гагшкуу “гэр бүлийн хүчинрхийлэл үйлдэх явцад” учруулсан тохиолдлыг хүндрүүлэн зүйлчлэх, үүнээс өмнө хохирогчийн байнга зодсон, харгис хөрхгийн харьсан, догшин авирласан, тарчлаасан, хувваарт болон дундын эд хөрөнгийг ашиглах, эзэмшиж, захиран зарцуулах эрхэд халдсан өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд заасан гэмт хөргийг бие даасан бүрэлдхүүнтэйгээр үйлдсэн тохиолдолд нийлмэлээр зүйлчлэх үндэслэл бүрдэнэ гэж үзж байна.

Өөрөөр хэлбэл дээрх 2 кейсийн тухай: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйл, 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгээр нийлмэлээр зүйлчлэх нь хуулийн үндэслэлтэй зүйлчлэл болох юм.

2. Гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн гэмт хөргийг “гэр бүлийн хүчинрхийлэл” үйлдэх явцад хэмээн хүндрүүлэн зүйлчлэх шаардлагатай эсэх:

Шүүхийн практикаас үзэхэд тухайн нөхцөлд үйлдэгдсэн гэмт хөргийг

хүндрүүлэн зүйлчилж ял оногдуулж буй практик тохиолдож байх бөгөөд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д "...гэр бүлд хамаарац хүний сэргээн санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлэхүүгийг" гэр бүлийн хүчирхийлэл гээн гэж хуульчилсныг анхаарч үзэлгүйгээр зүйлчилж кэргийг шийдвэрлэсээр байна.

Гэр бүлийн гишүүдийн хоорондын тааралмажтуй харьцаа, хохирогчийн илтэд буруутай үйлдэл, үйл ажиллагаа, эр эмийн хардалт зэрэгээс улбаалан үйлдэгдэн гарсан хэргийг ийнхүү хүндрүүлэн зүйлчлэх нь хуулийн үндэслэлгүй зүйлчилэл болно. Энэ нь хувийн сэдэлтэд үндэслэгдсэн утгаар тухайн зүйл буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 11.1 дүгээр зүйлийн 1, 11.4 дүгээр эзүйлийн 1, 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, ердийн бүрэлдэхүүнээр зүйлчлэгдэх боломжтой. Гэхдээ дурдсан гэмт хэргүүдийн өөр бусад хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжийг хангасан эсэхийг шалгаж тогтоож, зүйлчлэл хийх нь зүйн хэрэг билээ.

3. Хуваарт болон дундын эд хөрөнгийг ашиглах, эзэмших, захиран зарцуулах эрхэд байнга халдсан тохиолдолд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгтэй нийлмэлээр зүйлчлэгдэх эсэх:

Дээрх тохиолдоор хэргийн зүйлчлэх хийхэд юуны өмнө гэр бүлийн хамаарал бүхий хүний өмчлөх эрхэд гурав буюу түүнээс дээш халдсан нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн объектив, субъектив шинжийг хангах буй эсэхийг, ийнхүү өмчлөх эрхэд халдахдаа хулгайллах, дээрэмдэх, завших, бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх, эд хөрөнгө устгах, гэмтээх аргуудаар үйлдсэн эсэх, энэ нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17 дугаар бүлгийн гэмт хэргүүдийн шинжийг хангаж байгаа эсэхийг тус тусад нь шалгаж улмаар нийлмэлээр зүйлчлэх эсэхийг шийдвэрлэнэ.

4. Гэр бүлийн хамаарал бүхий хүнийг хүчинидсэн, бэлгийн мөлжлэгт оруулсан тохиолдлыг хэрхэн зүйлчлэх:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн б дугаар зүйлд "Гэр бүлийн хүчирхийлийн үзлбэр"-ийг

- 6.1.1.бие махбодын хүчирхийлэл;
- 6.1.2.сэтгэл санааны хүчирхийлэл;
- 6.1.3.эдийн засгийн хүчирхийлэл;
- 6.1.4.бэлгийн хүчирхийлэл" хэмээн ангилсан хэдий ч гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн объектив шинжид хууль тогтоогч "бэлгийн хүчирхийлэл"-ийг хамааруулагч бөгөөд гэр бүлийн хамаарал бүхий хүнийг бэлгийн хүчирхийлэл оруулсан тухайлбал хүчиндээ, бэлгийн мөлжлэгт оруулсан тохиолдолд холбогдох зүйлүүдээр зүйлчлэдэг" ём.

Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйл даасан бэлгийн мөлжлэг үйлдэх гэмт хэргийн үндэснэй бүрэлдэхүүнийг "Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нехшэл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорих эрхийг хялгарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан" хэмээн хуульчилсан нь гэр бүлийн хамааралтай хүн уг гэмт хэргийн хохирогч байгаа тохиолдолд энэхүү зүйлэр, харин хүчиндэх гэмт хэргийн хувьд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.3-т зааснаар тус тус хэргийн зүйлчлэл хийгдэнэ.

5. Гэр бүлийн хүчирхийлийн гэмт хэрг болон зарим тодорхой герлийн гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний "тэр бүлийн хүчирхийлэл үйлдэж" гэсэн шинжийг тогтооход анхаарах зарим асуудлууд:

1. Гэмт хэргийн хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй "тэр бүлийн гишүүд" гэдэгт хамаарал байгаа хэмээн механикаар дүгнэж яллагдагч, шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулах ёсгүй гэдгийг онцгой анхаарах шаардлагатай.

Хэдийгээр хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй гэр бүлийн гишүүд мөн боловч тухайн гэмт хэргээг үйлдэгдэх шалтгаан.

<sup>1</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн б дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг.

сэдэлт нь хохирогчийн хууль бус, зүй бус үйлдлээс илтэд шалтгаалсан болох нь тогтоогдсон тухайн тохиолдолд яллагдагч, шүүтгээгчийг гэр бүлний хүчирхийлэл үйлдсэн гэж үзэхгүй байх үндэслэлтэй юм.

2. “Гэр бүлийн хүчирхийлэл” гэдэг нь “гэр бүлийн гишүүд” хооронд үүссэн байх гол утга агуулга, шалгууртай учраас “гэр бүлийн гишүүд”-тэй холбоотой суурь ойлголт, харицааг зохицуулсан Гэр бүлний тухай хуулийн нарийчилсан зохицуулалтын “Эрүүгийн хуулийн нэр томъёо, ухагдахууныг тайлбарлаад баримтлах” шаардлагатай болохыг анхаарах нь зүйтэй.

Эрүүгийн хуулний 1.2 дугаар зүйлийн 4 дахь хэсэгт: Энэ хуулийн иэр томъёо, ухагдахууныг тайлбарлаад Монгол Улсын хуулийн тайлбарласан нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойдолт, хэм хэмжээг баримтлана гэж заасан.

Шүүхийн практикт гэр бүлийн хүчирхийллийн “хөхирогчид” хамаарах этгээдийн талаар нэгдсэн ойлголт хэвшиж тогтоогүй буюу хуульчдын ойлголт эсрэг тэсрэг байна. Үүнийг тодорхой хэргийн кэйс дээр тайлбарлаж болох юм.

Яллагдагч В.Б нь 2018 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 16 цагийн үед Сонгинохайрхан дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэр, Баянбулагийн 1-82 тоотод оршин суух хадам эх Б-ийн гэрт “нүүж явахдаа хашаа цэвэрлээгүй явсан” гэх шалтгаанаар өөрийн эхизр Э-ийн төрсөн эгч Ш.-н нуруу, хөл рүү галын дэгээ төмрөөр цохиж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж зодон эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан гэмт хэрэгт холбогддажээ. Иймд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар зүйлчилж, ялан сонсгожээ.

Хохирогч, яллагдагч наар гэр бүлийн гишүүд мөн үү?

Гэр бүлийн тухай хуулийн 3 лугаар зүйлийн 3.1.4-т зааснаар “гэр бүлийн гишүүн” гэдигт “гэрлэгчид, тэдэнтгэй хамт амьдарч байгаа төрсөн, дававар, үрчлэн

авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг; мөн хуулийн 3.1.6.“садангийн хүн” гэж гэрлэгчийн төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг хамааруулан үйлгено.

Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулний үйлчлэлд хамаарах Гэр бүлийн гишүүний тайлбар: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1.-д “эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн” гэж заасан.

Тус хэргийн хохирогч нь яллагдагчийн хувьд садангийн хүн байх боловч гэрлэгчдээд хамт амьдардагчийг байх тул гэр бүлийн гишүүн гэж үзэхгүй байх үндэслэлтэй.

Түүнчлэн “ойр дотны хүн” гэдгийг тайлбарласан Эрүүгийн хуулийн 4.1 дүгээр зүйлийн тайлбараас үзэхэд гэр бүлийн гишүүдэд хамаарах этгээд бүрийт “ойр дотны хүн”-д хамааруулсанас гадна төрөл, садангийн хүмүүсийн хувьд гэрлэгчдээдтэй “хамт амьдарч байх” шалгуурыг тодотгон тайлбарласан байна.

Иймд хэдийгээр хохирогч, яллагдагч нар төрөл, садан боловч гагцхүү хамт амьдарч байгаа тохиолдолд яллагдагчийн хохирогчийн эсрэг халдсан үйлдлийг “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж” гэдэгт хамааруулах үндэслэлтэй болно.

3. “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” зөрчлийд нь “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэг”-т тооцогдох болон тухайн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой аихаарах асуудал.

Гэр бүлийн хүчирхийллэл үйлдэх гэмт хэргийн энгийн бүрэлдэхүүний үндэсн шинж нь гэр бүлийн хүчирхийллийг “байнга” буюу З ба түнээс дээш үйлдсэн байх шалгууртай учраас “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” зөрчлийдийг “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг”-т тооцоход, мөн тухайн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотойгоор дараах асуудлыг анхаарах нь зүйтэй. Үүнд :

а/ Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дахь хэсэгт заасан “гэр бүлийн хүчирхийлэл” үйлдэх зөрчлийг

З 3 удаа үйлдсэн ийн илэрч, шууд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татагдсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 2-т заасны дагуу: 1 ба 2 дахь, 2 дахь ба 3 дахь зөрчлийн хооронд тус бүр б 6 сарын хугацаа өнгөрөөгүй байх ёстой.

Мөн тухай 3 удаагийн бие даасан эхлэл, төгсгөл бүхий зөрчил нь Эрүүгийн хуулийн өрөнхий аягийн 2.2 дугаар зүйлийн 3-т зааснаар үргэлжилсэн нэг гэмт хэрэгт буюу Эрүүгийн хуулийн тусгай аягийн 11.7 дугаар зүйлийн 1-д заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хангаж буй учраас Эрүүгийн хуулийн өрөнхий аягийн 1.8 дугаар зүйлийн 2-т зааснаар гэр бүлийн хүчирхийллийн сүүлийн буюу 3 дахь удаагийн зөрчилдээс үеийн гэмт хэрэг үйлдэж төгссөн цаг хугацаа гэж үзэх ба тухайн гэмт хэрэг төгссөн үесээ эхлэн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Эрүүгийн хуульд заасан үндэслэл, журмын, дагуу тоолно.

6/ Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дахь хэсэгт заасан “Тэр бүлийн хүчирхийлэл” Үйлдэх зөрчлийнгүй 2 удаа буюу давтсан үйлдэж, захиргааны шийтгэл хүзээсэн этгээд дахин гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдсэн тохиолдолд шууд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээг үйлсэн гэж үзэх эсэхэд тодорхой бус, эргэлээс бүхий цөөнгүй асуудал багтаяа болно.

Тухай тохиолдолд шүүхийн 1 ба  
2 дахь удаагийн захирагааны шийтгэл  
оногдуулсан шийдвэрүүдийн хооронд  
хөөн хэлэлцэх ямар хугацааны шалгуур  
шаардлагай байх, түүнчлэн шүүхийн 2 дахь  
удаагийн захирагааны шийтгэл оногдуулсан  
шийдвэр ба 3 дахь удаагийн зөрчил хооронд  
хөөн хэлэлцэх ямар хугацааны ямар  
шалгуур шаардлага байх эсэхэй. Зөрчлийн  
тухай болон Эрүүгийн хуульд тусгайлсан  
зохицуулгаагүй гэж узэж боллоох байна.

Зүй нь Захиргааны шийтгэл хүлээсэн байна гэдэг нь тухайн зөрчил гаргагч гаргасан зөрчлийнхээ төлөө захиргааны харигууллага хүлээсэн гэж үзүүлэх болно.

харинчлалаа хүлээсэн гэдэг нь тухайн захиргааны зөрчлийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болж, улмаар зөрчи гаргатгач этгээд шүүхээс оногдуулсан захиргааны тухайн шийтгэлийг эзэлж дууссан байхыг ойлгоно.

Дээр үндэслэлдээр авч үзвэл “гэр бүлийн хүчирхийлэл” үйлдэх зөрчилтгүй 2 удаа буюу давтсан үйлдэж, захиргааны хариншага хүзүүсэн этгээд дахин гэр бүлийн хүчирхийллийн зөрчил үйлдэсэн тохиолдолд шууд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үүсгэж, яллагдагчаар татас боломжтүү.

Харин шүүхээс зөрчил гаргагчид оногдуулсан анхиы ба хоёр дахь удаагийн шийтгэвэр, мөн шүүхийн 2 дахь удаагийн шийтгэвэр ба зөрчил гаргагчийн 3 дахь удаагийн зөрчил хооронд тус тус шийтгэвэр хүчин төглөдөр болохос эсхүл тухайн захиргааны шийтгэлийг эзлж дусахаас өмнө үйлдсэн эсхүл тухайн захиргааны шийтгэлийг эзлж дууссан едрөөс хойш б сарын хугацаа өнгөрөөгүй байхад дахин зөрчил үйлдсэн байх зэрэг тодорхой шалтуур, нөхцөл журмыг залшгүй хуульчлан тогтоо шаардлагатай гэж үзэж байна.

Тийнхүү хуульчлах нь Эрүүгийн хуульд заасан хууль ёсны зарчмын утга агуулга, ялагдагч, шүүгдэгчийн эрх зүйн тогтолцоог дордуулажийн байх хууль ёсны шаардлагад хамаарна.

Зөрчлийн болон Эрүүгийн хуульд тусгайлан зохицуулаагүй бөгөөд үндэслэл бүхий эргэлзээтэй асуудлыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2-т заслааар яллагдагч, шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дээрдүүлж шийдвэрлэхийнг хуулиар зөвшөөрсөн байлаг.

в/ Уг гэмт хэргийн объектийн заавал байх шинж нь тухайн зүйлийн диспозицид хуульчлагдсан ўйлдлүүдийн давтамж буюу "байяга" гэх ойлголтыг зөв ойлгож хэрэглэж буй эсэх нь судалгааны явцад азваажсан юм.

Эл ойлголт нь Эрүүгийн эрх зүйд нэгэнт тогтсон, уламжлалт онолын ойлголт бөгөөд эрдэмтэд судлаачид дараах байдлаар тодорхойлжээ.

Академич С.Нарангэрэл “...янз бүрийн объектив болон субъектив нехцэл байдал цаг хугацааны нэлээд завсарлагатайгаар нэг гэмт хэргийг хөбоос дээш удаа үйлдэх нь гэмт хэргийг байгаа үйлдлийг байнга гэж үзэх үндэс болохгүй. Байнга бол гэмт хэрг үйлдэх явдал уе үе давтагдаж, тэдгээрийн хоорондын зай их бишийг харуулан гэмт буруутай этгээдийн зан үйлийн тодорхой чиглэл илрэсэн, гэмт хэрг давтан үйлдэх явдал юм. Гурав буюу түүнээс дээш гэмт хэрг үйлдэх нь байнга гэсэн ухадахууны зайлшгүй тоон үзүүлэлт мөн. Байнга гэсэн ойлголт нь төсөөтэй нэг ижил гэмт хэрг үйлдсэн байхыг харуулна<sup>9</sup>...”

Доктор С.Жанцан “Нэг этгээд нэлээд үргэлжилсэн хугацаанд нэг гэмт хэргийг дөрөв ба түүнээс дээш удаа үйлдэх тэдгээрийн алиинд ч шийтгэгээгүй бөгөөд эн нь түүний гэмт зан төлөвийн тогтсон хандлагыг илрэхлийн байгыг гэмт хэргийг байнга үйлдэх гэнэ<sup>10</sup>”

Дээрх эрдэмтдийн үзэл болдлын хүрээнд “байнга гэмт хэрг үйлдэх” гэх ойлголт нь:

1.Нэг гэмт хэргийг тодорхой хугацаани завсарлагатайгаар гурав ба түүнээс дээш удаа үйлдсэн байх

2.Тэгээрийн алиинд ч ял шийтгүүлэгүй байх

3.Гэмт хэргэг үйлдсэн хүний гэмт зан төлөвийн илрэл бөгөөд эн нь амьдралд хөвшиж тогтсон дадал зуршил хэмээн Эрүүгийн эрх зүйн онолд тайлбарлан авч үздэг байна.

Үүнээс үзвэл гэр бүлний хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн талаар хуульчилсан бөгөөд энэхүү гэмт хэргийг гэр бүлний гиншүүдээ хүч хэргэгжлэх, дарамт шахалт үзүүлсэн бол 2 жилээс доош хугацаагаар хорих, хорьж албадан хөдөлмөр хийлгэх, харин хүнд гэмтэлт учруулсан, амь наасаа хохироокод хүргэсэн бол 2 жилээс дээш 7 жил хүргэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна.

Харыцсан, догшин авирласан, тарчлаасан, хуваарыт болон дундын эд хөрөнгийг ашиглах, эзэмших, захиран зарцуулах эрхэд халдсан хэд хэдэн удаагийн идэвхтэй үйлдээ бөгөөд үйлдэх бур бие даасан гэмт хэргэг, зөрчлийн шинжийн агуулсан байхыг ойлгоно.

Жишээ нь: Зөрчлийн хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан зөрчлийг гурав ба түүнээс дээш удаа үйлдсэн тохиолдолд “байнга” гэж үзэж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дахь хэсэгт заасан гэмт хэргийн байнга зодсон гэх объектив шинжийн үйлдлийг хангах юм. Цаашид нийм ойлголт уг гэмт хэргийн тухайд байх эсэх нь эргэлзээтий, практикт янз бүрээр ойлгож хэргийн зүйлчлэл хийж ял завшуулах эсхүү хүний эрхийг зөрчсөөр байна.

Гурав. Гадаадын зарим орнуудын эрх зүйн зохицуулалт

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хийдэл зөрчилдөөнийг арилгахад гадны орнуудын жишиг хандлагыг судлах зайлшгүй шаардлагатай юм. Иймд гадаадын зарим улс орны хуульд дээрх асуудлыг хэрхэн зохицуулсаныг товч байдлаар судлан үзсэнээ танилцуулбал:

1. БНХАУ-ын Эрүүгийн хуульд гэр бүлний хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн талаар хуульчилсан бөгөөд энэхүү гэмт хэргийг гэр бүлний гиншүүдээ хүч хэргэгжлэх, дарамт шахалт үзүүлсэн бол 2 жилээс доош хугацаагаар хорих, хорьж албадан хөдөлмөр хийлгэх, харин хүнд гэмтэлт учруулсан, амь наасаа хохироокод хүргэсэн бол 2 жилээс дээш 7 жил хүргэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна.

Тус улсын Эрүүгийн хуульд Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг тусад нь бие даасан зүйл заалтаар зохицуулсан бөгөөд уг гэмт хэргийн хүндруүлэх нөхцөл /манай улсын эрүүгийн хуульйн тусгай ангид хүндруүлэх нэхцэл болгон хуульчилсан шиг бус/-ийг тодорхой заажээ.

<sup>9</sup> С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Уб. 1996 он, 262 дэхь та.

<sup>10</sup> С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. Уб. 2009 он, 594 дэхь та.

**2. БНСУ-ын Эрүүгийн хуулийн 260 дугаар зүйлд хүний бие махбодид хүчирхийлэл үйлдсэн бол 2 жил хүргэлх хугацаагаар хорих, эсхүл 5 сая хүргэлх воноор тorgох ял шийтгэж бөгөөд тус гэмт хэргийг гэр булийн хамаарал бүхий хүнд үйлдсэн бол хүндрүүлж 5 жил хүргэлх хугацаагаар хорих, эсхүл 7 сая хүргэлх воноор тorgох ял шийтгэж хуульчилсан байна. Түүнчлэн, БНСУ-д бие даасан гэмт хэргэг бус харин тодорхой төрлийн гэмт хэргүүдэд “гэр булийн хамаарал бүхий хүний эсрэг” үйлдсэн тохиолдлыг хүндрүүлэн үздэг.**

**3. Австралии улсад гэр булийн хүчирхийллийн “Гэр булийн болон хувь хүний хүчирхийллийн тухай хууль”-р зохицуулдаг бөгөөд уг хуульд гэр булийн хүчирхийллийн гэмт хэргийг “Гэр булийн харилцаатай байгаа болон харилцаатай байсан хүн нөгөөгийнхөө эсрэг гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийх” гэж тодорхойлдог. Жишээ нь: Хэрэвээ гэр булийн хамаарал бүхий хүнийг мөрдөж мөшгөх, айлгаж сурдүүлэх, биед нь гэмтэл учруулах зорилгоор заналхийлж сурдүүснийг гэмт хэрэгтэй тооцож ял оногдуулна. Ял шийтгэлийн хувьд 5 жил хүргэл хугацаагаар хорих эсхүл 50 шийтгэлийн нэгж (1 иэгж=\$161.19) –ээр тorgох ял оногдуулах санкцитай. Австралии улсад хэрэв цагдаа гэр булийн хүчирхийлэл болсон гэж үзэж, хүчирхийлэл үйлдсэн этгээднийг сэжиглэж байвал гэмт хэрэгтэng шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчлах эрхтэй байдал.**

Эрүүгийн хуулиар бус тусдаа бие даасан хуулиар шийтгэдэг улс орнуудын нэг нь Австралии улс юм. Тус хуулийн дагуу гэр булийн хүчирхийлэлд хамаараах гэмт үйлдлүүдэд хариуцлага хүлээнлгэнэ.

**4. АНУ-ын Эрүүгийн хуулийн 110а бүлэгт Гэр булийн хүчирхийлэл үйлдэх, гэр булийн хамаарал бүхий хүнийг мөрдөж мөшгөх гэмт хэргийн талаар хуульчилжээ. Тухайлбал,**

-Гэр булийн хамааралтай хүнийг алсан тохиолдолд бух насаар эсхүл шүүхээс

тогтоосон жилээр хорих ялаар шийтгэх;

-Хэрэв хохирогч насан туршидаа хөгжлийн бэрхшээлтэй болсон, эсхүл амь насанд аюултай гэмтээ учруулсан тохиолдолд 20 хүргэлх жил хорих ялаар шийтгэх;

-Хэрэв хохирогчийн биед ноцтой гэмтэл учруулсан, эсхүл гэмт хэрэг үйлдэхдээ аюултай зэвсэг хэрэглэсэн тохиолдолд 10 хүргэлх жил хорих ялаар шийтгэх;

-Дээрхээс бусад тохиолдуулдад 5 хүргэлх жил хорих ял эдлэх, эсхүл үүн дээр нэмж тorgох ял тус тус оногдуулдаг байна.

Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хяглаарлах ял ногдуулдаг бөгөөд нь уг ялыг 2 удаа зэрчсэн, эсхүл ут арга хэмжээ давтаан авагдсан бол 50 жил хүргэл хугацаагаар хорих ял шийтгэдэг байна.<sup>11</sup>

“Гэр булийн хүчирхийллийн хэргээр ял шийтгэдсэн хүмүүс нь Холбооны хуулиар галт зэвсэг, тэсэрг дэлбэрэх бодис биедээ авч явахыг хориглодог бөгөөд энэхүү хоригийг зөрчвэл 10 жил хүргэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ. Уг хоригтой холбоотой хууль хэд хэдэн Муж улсад байдал байна.”<sup>12</sup>

Эрүүгийн хуулийн өөр өөр гэмт хэргүүдэд бус “гэр булийн хүчирхийлэл үйлдэх, мөрдөн мөшгих” гэсэн нэг гэмт хэргийг тодорхойлж улмаар хүндрүүлэх тохирхийлж үйлдлийг хуульчилжээ.

**5. Их Британийн** гэр булийн хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд Гэр булийн хүчирхийллийн тухай хуулиар зохицуулдаг байна. Тухайлбал, Нэг гэр булийн гишүүн, байнга холбоотой байдаг байсан хүний буруутай үйлдлийн улмаас хүүхэд, асрамж, анхаарал шаардлагатай насандаа хурсан хүн (V) нас барах, эсхүл биед нь ноцтой гэмтэл учирсын гэмт хэргээт тооцож шийтгэл оногдуулдаг байна. Хэргийг шийдвэрлэхэд тухайн

<sup>11</sup> ХЭЗҮТ, Гэр булийн хүчирхийлэлтэй гэмцэх эрх зүйн орчиног болсворонгуй болгох хэрэгжээ шаардлагва, бодлогын хуудас, УБ, ХЭҮТ, 2010 он.

<sup>12</sup> Д.Баяржан, Харьдуулсан эрүүгийн эрх зүй, УБ, 2011 он.

гэмт хэрэг үйлдсэн хүн хохирогчтой гэр бүлийн хамаарал, харилцаатай хүн мөн эсэхийг тогтоох, түүний үйлдлнийн улмаас хохирогчийн биед ноцтой гэмтэл утрах боломжтой байсан, үхэл болон ноцтой гэмтэл учирсан, хохирогчийн амь нас эрүүл мэнд зредэлд орсон утрах эрдлийг мэдэж байсан ч хамгаалах арга хэмжээ аваагүй, мэдсээр байж ийм хор уршигт хүргэсэн нөхцөлийг тус тус гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгт тооцож хариушлага хүлээгээдзг байна.

Тусдаа хуулнаар зохицуулдаг орнуудын иэг бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн хүрээнд багтах тодорхой төрлүүлэд уг хуулиар хариушлага хүлээгээн.

6. ХБНГУ-ын Эрүүгийн хуульд “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэсэн бие даасан гэмт хэргийн бүрэлдэхүүн багийг бөгөөд дараах гэмт хэргүүлээр гэр бүлийн хүчирхийлэлд яланоо боломжтой байдаг:

- Бусдыг доромжлох (§ 185)
- Дарамтлах /шахалтад оруулах/ (§ 240)
- Бусдын эрх чөлөөг хязгаарлах (§ 239)
- Бусдын биед гэмтэл учруулах (§ 223)
  - Stalking/мөрдөн мешгех (§ 238)
  - Бэлгийн мөлжлэг (§§ 174)
  - Хүчиндэх (§ 177)
  - Хүнийг болгоомжгүй алах (§ 212)
  - Хүний санаатай алах (§ 211)

Хүчирхийлэл дарамтад орсон гэж үзвэл иргэндэй эрх зүйн журмаар хохирогчийг хамгаалах тухай хууль үйлчлэх бөгөөд тус хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар бусдын бие, эрүүл мэнд, эрх чөлөөнд хууль бусаар халдвал шүүх халдлагадаа өртсөн хүний хүснэгтийг үндэслэн цаашинд дахин халдлага үйлдэхээс сэргийлэхдээ зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаа явуулах ба шүүхээс хэрэг үйлдсэн үтгээд тухайн үйлдлийг согтууруулах ундад болон түүнтэй төстэй бодис хэрэглэсэн үедээ буюу хүснэг зоригтоо өөрөө хянах боломжгүй сэтгэл зүйн түр хутсааны эмгэг саатлтай байсан

эсэхээс үл хамааран хохирогчийн орон байранд нэвтрэх, хохирогчийн орон гэрээс тодорхой хэмжээний тойрогт нэвтрэх, хохирогчийн тогтмол байdag өөр тодорхой газарт очих, хохирогчтой холбоо барих, тэр дундаа зайнаас холбоо барих төхөөрөмж ашиглан холбоо барих, хууль ёсны ашиг сонирхол байхаас бусад тохиолдолд хохирогчийтэй уулзахаар оролдох зэргийг хориглосон хугацаатай захирамж гаргахаар хуульчилсан байна.

Шүүгчийн захирамжийг биедүүлэгэй, зөрчсөн тохиолдолд гэм буруутай этгээдэд иэг жил хүртэл хутсааны хорих яа эсхүл мөнгөн тортгуйлийн яланоохоор хуульчилжээ.

Мөн хүүждийг хүмуужсүүлэхээс хүчирхийлэл үйлдэхийг цэвэрэх тухай хууль үйлчилдэг бөгөөд муж усгуудын Цагдаагийн тухай хуулиар бусад харилцааг зохицууллагд байна. Жишиг нь хохирогчтой узлах хоригийг зөрчсөн тохиолдолд хэрэг үйлчлэгийн тусгаарлах гэх мэт харилцааг Цагдаагийн тухай хуулиар зохицуулсан байдаг байна.

ХБНГУ-ын хувьд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн тусгай зохицуулалтгүй бөгөөд хэрэвээ гэр бүлийн хүчирхийлэлд өртөж амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, ашиг сонирхлоор хохирсон тохиолдолд холбогдох гэмт хэрэгтэй адилтган ял, хариушлага хүлээгээд.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийн хамгаалах тогтолцоо маш сайн хуульчлагдсаныг тэмдэглэх хэрэгтэй.

**Дөрөв.** Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилж асуудал

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт, гэмт хэргийн зүйлчилгээний холбоотой шүүхийн практикийг судлах явцад гарсан хуулийн хийдэл, зөрчилдоонийг арилгах түүчиний гадны орнуудын нийтлэг жиниг хандлагад нийцүүлж эрх зүйн зохицуулалтыг өөрчилж боловсронгуй

боловх шаардлагатай байна хэмээн үзэж байна. Үүнд:

1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн объектив заавал байх шинжгүй хууль тогтоогч тухайн үйлдлийг “байига” үйлдсэн байхаар хуульчилсныг практикт янз бүрээр ойлгож хэргийн зүйлчлэлийг хийжээ. Тухайлбал: Албан ёсны зүйлчлэл хийх эрх бүхий субъектүүд “байига” гэх шинжийг гурав ба түүнээс дээш удаагийн үйлдэл, энэ нь цагдаагийн албан ёсны бүртгэлд бүртгэгдсэн байх, нөгөө хэсэг нь тухайн үйлдлийн үргэлжилсэн, амьдралд хэвшиж тогтсон шинж буюу тухайн үйлдэл, эс үйлдэхүйн шинжээр зүйлчлэл хийж байна.

Ийнхүү “байига” гэх ойлголтыг энэ гэмт хэргийн тухайд хасах шаардлагатай байdag зарим хуульчдын санаалыг судлаачийн хувьд дэмжиж байгаа болно. Энэхүү гэмт хэрэг нь Эрүүгийн хуулиар хамгаалагдан хамгийн үзүүцэнтэй эрх ашигт хадлах байдал, хууль тогтоогч энэ гэмт хэрэгт “байига” гэх ойлголтыг заавал байх шинж болгосон нь гэр бүлийн хамаарал бүхий хүмүүсийн амь нас, эрүүл мэнд, эрх чөлөө, өмчлөлийн ашиг сонирхолд тодорхой гэм хор учруулсан тохиолдлыг бүй болгох нөхцөлийг шаардах байгаатай “агаар нэг” мэт ойлголтыг төрүүлж байдаг.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.5 дахь хэсэгт заасан гэмт хэргийн шинжийг харгалzan зөрчлөөс ялган зүйлчлэл хийх боломжтой учраас үйлдлийн давтамж бус шинжээр хуульчилс тухайн зүйлийн диспозицийг тусгах боломжтой.

Өөрөөр хэлбэл үйлдлийн шинж нь тухайн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинжийг тодорхойлно.

2. Гэр бүлийн хүчирхийлэл гэх гэмт хэргийг тусдаа гэмт хэрэг болгон хуульчлах шаардлагатай эсэх асуудалд судлаачид янз бүрийн байр суурьтай байдаг. Нэг хэсэг нь байх ёстой, нөгөө хэсэг нь байх ёсгүй буюу гэр бүлийн хүчирхийллийн хүрээнд үйлдэгээн гардаг гэмт хэргүүдэд хундруулэх нөхцөл болгон хуульчлах нь практикт зүйлчлэл хийхэд хамгийн

ойлгомжтой бөгөөд хүндэрэл бэржшээл гарахгүй гэж үзэгт байна.

Дээрх хоёр ойлголтын хувьд одоогийн хуулийн зохицуулалтыг хэрээн өөрчилж боловсронгуй болгох асуудалд санал, бодлоо илэрхийльэвэл:

а/Хэрвээ гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг бие даасан тусдаа гэмт хэрэг байх ёстой гэж үзэхэд гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрүүдийг бүтгийт тухайн гэмт хэргийн объектив ши нийд хамруулах шаардлагатай. Уг гэмт хэргийн одоогийн хуулийн зохицуулалтад гэр бүлийн хүчирхийллийн зарим хэлбэр хуульчлагдаагүй орхигдсон, хуулийн хийдэл үсгэсэн ял завшуулах боломж олготг байна.

Зарим хуульчдын үзэж буйгаар эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд бие махбодын хүчирхийллийг агуулгаар нь хуульчилж улмаар бэлгийн хүчирхийлэл, сэтгэл санааны хүчирхийллийг орхигдуулсан. Ингээнээр гэр бүлийн хүчирхийллийг 2 сэлбэрээр үйлдэгдэг мэт хайрцааглан ойлж буссад хэлбэрээр үйлдэгдсэн түүний улмаас хөндөгдж байгаа эрх ашиг сонирхлыг гэр бүлийн хүчирхийллийн улмаас бий болсон гэх үзэхгүй байгаа нь гэр бүлийн хүчирхийллийг бүрэн гүйцэтгэх хуульчилж хуулийн хариуллага хүлээлгэх боломжийг бүрдүүлэхгүй байна гэх узлэгээ санал нэг байгаа болно. Иймд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн объектив шинжид дурдсан хүчирхийллийн хэлбэрний хуульчлах шаардлагатай.

б/Дээрх тохиолдлын тухайд хундруулэх нөхцөлл гэр бүлийн хүрээнд үйлдэгэн гарах тодруулбал гэр бүлийн хамаарал бүхий хүнний алах, эрүүл мэндэд хүнд, хүндэвтэр, хөнгөн хохирол учруулах, хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, бэлгийн мөлжлэгт оруулсан, мөрдөн мөшгөсөн, сэтгэл зүйн дарамт учруулсан, албадан хөдөлмөр эрхлүүлсэн, өмч хөрөнгийг нь санаатай устгасан, гэмтээсэн, үргэдүүлсэн, зарж борлуулсан зэргийг хамруулах шаардлагатай гэж үзнэ.

в/Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг бие даасан гэмт хэрэг болгох шаардлагагүй гэж үзвэл гэр бүлийн хүчирхийллийн хүрээнд үйлдэгдэн гарах гэмт хэргүүдийн тодруулбал “тэр бүлийн хүчирхийлээ үйлдэж” эсхүл “тэр бүлийн хамаарал бүхий хүний” –г алах, хүнд, хундзвэр, хөнгөн хохирол учруулах, хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, бэлгийн мөлжлэгт оруулсан, сэтгэл зүйн дарамт учруулсан, мөрдөн мешгөсөн, албадан хөдөлмөр эрхлүүлсэн, өмч хөрөнгийг из санаатай устгасан, гэмтээсэн, үргэдуулсан, зарж борлуулсан зэргийг зөвхөн хүндрүүлэх нөхцөл болгон хуульчлан тогтоох нь гэмт хэргийн зүйлчлэл хийхэд ямар изг ойлгомжгүй байдал уусгүй, хүндэрэл боржизээл тулгарахгүй байх боломжтой.

г/Гэр бүлийн хүчирхийллийн “хохирогчид” хамаарах этгээдийн талаар нэгдсэн ойлголтыг бий болгох шаардлагатай байна. Шүүхийн практикт гэр бүлийн хүчирхийллийн “хохирогчид” хамаарах этгээдийн талаар нэгдсэн ойлголт хөвшиж тогтоогүй буюу хуудын ойлтолт эсрэг тэрэг байна. Гэмт хэргийн хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй “тэр бүийн гишүүд” гэдэгт хамаарч байгаа л бол гэр бүлийн хүчирхийллийн “хохирогч” гэж үзэх нь учир дутгагдлтай. Учир нь

хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй гэр бүлийн гишүүд мөн боловч тухайн гэмт хэргэг үйлдэгдэх шалтгаан, сэдэлт нь хохирогчийн хууль бус, зүй бус үйлдлээс илтгэх шалтгаалсан болох нь тогтоогдсон тухайн тохиолдолд яллагдагч, шүүгээгчийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэж узэхгүй байж үндэслэлтэй юм.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дахь хэсэгт заасан гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөлд “асармжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн” хамааруулсан ёс тэр бүлийн хамааралтай хүн мөн болох эсэх нь эрэлзэлтэй.

#### ДҮГНЭЛТ

Дээр дурдсан саналууд олон улсын практикт нэгэнт тогтсон жишиг, хандлага бөгөөд эдгээрийг аль боломжит хувилбаар Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зохицуулалтуудад нэмэлт, өөрчилж оруулж болох юм. Ингэснээр гэр бүлийн хүрээнд үйлдэгдэн гарсан гэмт хэргийг зөв зүйлчлэх, ойролцоо төрлийн гэмт хэргээс ялагах зэрэг практикт тулгамдах буй асуудал шийдвэрлэх боломжтой төдийгүй хүний эрхийг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн хүнд ял завшуулах явдал гарахгүй байх боломж бүрдүүлнэ хэмээн үзэж байна.

---000---

## ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХЭД ТУЛГАМДАЖ БҮЙАСУУДАЛ



Хэнтий аймаг дахь сүм дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч  
Д.Ганзориг

### ТҮЛХҮҮР ҮГС:

Эрүүгийн хариушлага, хуулийн этгээдэд оногдуулах ял, албадлагын арга хэмжээ, хуулийн этгээд

### ТОВЧЛОЛ:

Монгол Улсын хувьд зах зээлийн нийгмийн харилцаа бүрэн извтэрч, тогтвортой хөгжлийн орчин бий болж чадаагүй 20 гаран жилийн хугацаанд гэмт хөргийн шинэ төрлиүд далд хэлбэрээр оршиж, гэмт хэрэг үйлдэгч субъектийн хүрэс өргөжин, гэмт зам үйлний серөг нөлөөллийг тогтоон барих эрүүгийн эрх зүйн үр ашигтай механизм бүрдүүлэх шаардлагатай болсон төдийгүй, эзүүргийг Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн билээ. Цаашид гэмт хэрэг үйлдэсн хуулийн этгээдэд эрүүгийн хариушлага оногдуулах боломж шийдлийг тодорхойлох, практик тогтоо шаардлагатай.

### УДИРТГАЛ

Сүүлийн үед эрх түйн харилцаанд оролцогч субъектийн хүрэс өргөжин тэлэх, үүргээ хариушлага нь нэмэгдэхийн хирээр хуулийн этгээдэд эрүүгийн хариушлага оногдуулах, түүнийг хэрхэн хэрэгжүүлж шийдлийг улс орнууд эрэлхийлж байгаа билээ.

Бидний мэдэж байгаачлан 1670 оны Францын Ордананс, 1813 оны Боварын хууль цаазын бичиг зэрэг эх сурвалжийн корпораци болон албан төстэй хуулийн этгээдэд эрүүгийн хариушлага хүлээнгэж үндэслэлийг алхлан дэвшүүлсэнээс хойш<sup>1</sup> гэмт хөргийн субъект нь гэмт хэрэг үйлдэсн нь шүүхэйн ноглогдсон хувь хүнээс гадна байгууллагад хамааралтай гэгддэг хүлээн зөвшөөрхөн хандлага бий болжээ.<sup>2</sup>

“Гэмт хөргийн субъект” ба “Хуулийн этгээд” гэсэн хоёр ойлголт хоорондоо салшгүй холбоотой. “Гэмт хөргийн субъект” гэдгийг гэмт хөргийн бүрэлдэхүүний нэг элемент гахээс<sup>3</sup> илүү эрүүгийн хариушлага хүлээх чадвар бүхий этгээд гэж ойлгох явдал баруун Европ, АНУ-д ихэд дэлгэрсэн байдаа.<sup>3</sup> Гэтэл эх газрын эрх зүйн системтэй орнуудын хувьд хувь хүний гэм бурууд үндэслэсэн эрүүгийн хариушлагын зармыг баримталдаг учраас эдгээр улсад хуулийн этгээдэд эрүүгийн хариушлага хүлээлгэх асуудал урт хугацааны туршид шүүмжлэлтэй тулгарсаар байгаа юм.

Хуулийн этгээд нь гэмт хөргийн /эрүүгийн хариушлагын/ субъект байх нехцэл хийгээд ял оногдуулах үндэслэл

<sup>1</sup> Богословский С.О. Очерк истории уголовного законодательства в Европе с начала XVIII-ого века Т.1. Киев. С.24-26.

<sup>2</sup> Никифоров А.С. Юридическое лицо как субъект преступления и уголовной ответственности. М. 2002 С.84.

<sup>3</sup> Simester A.P.Sullivan G.R.Criminal law. Theory and Doctorine. Oxford. Portland 2005 p.275-282.

журмыг 35 орон<sup>4</sup> шууд ба шууд бус байдлаар хуульчлан томъёолжээ. Нийтлэг жишигийн<sup>5</sup> судлан үзвэл хуулийн этгээдэд эрүүгийн хариушлага хүлээлгэвэл зохих гэмт хэрэгт эдийн засгийн гэмт хэрэг, цахим гэмт хэрэг, терроризм, мөнгө угаах, байгаль орчны эсрэг гэмт хэргүүд гол төлөв хамаарч байна.

Зүүн Европын зарим орон Орос, Украина, Белорус, Казакстан болон Монголд хуулийн этгээд гэмт хэргийн субъект байх шинжийг үтгүйсгж ирсэн бөгөөд зөвхөн иргэний эрх зүйн хэрэнд, зарим тохиолдолд захиргааны эрх зүйн хувьд хариушлага хүлээлгэж ирсэн юм.

Сүүлийн хорин жилд постсоциалист орнуудал хуулийн этгээдэд хүзээлж захиргааны хариушлагын хэмжээг нэмэгдүүлэх, зарим тохиолдолд хуулийн этгээдэд хүлээлгэж эрүүгийн хариушлагын нөхцөл боломжийг судалж тооочи, эрүүгийн хуулиндаа нэмэлт өөрчлөлт оруулах замаар эрх зүйн реформын шинжлэгж зорилгоог өөрчлөлтүүд хийгдэж эхлээд байна. Жишээ нь: Унгар 2001 онд, Литва 2000 онд, Польш 2002 онд, Румын 2004 онд, Эстони 1999 онд, Словени 1999 онд тус тус өөрчлөлт, шинчлэлтийг хийснээр элгээр оронд хуулийн этгээдийг гэмт хэргийн субъект гэж тооочи болсон ба эрүүгийн хариушлага хүлээлгэх нөхцөл орчин нэгэнт бурдажээ.

1990 оноос өرنсөн нийгмийн амьдралын бүх талыг хамарсан өөрчлөлт, шинчлэлтийн Монгол Улсын эдийн засгийг зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шийжүүлих, эдийн засгийн харилцааг бөхөөсөнгөй болгохын зүй ёсоор шаардсан билээ. Монгол Улсад зах зээлийн нийгмийн харилцаа бүрэн иштэрч, тогтвортой хөгжлийн орчин бий болж чадаагүй 20 гаран жилийн хугацаанд гэмт хэргийн

шинэ төрлүүд далд хэлбэрээр оршиж, гэмт хэрэг үйлдэгч субъектийн хүрээ өргөжин, гэмт зан үйлний серөг нөлөөллийг тогтоон барих эрүүгийн эрх зүйн үр ашигтай механизм бүрдүүлэл шаардлагатай болсон төдийгүй, энэ үргүйг Монгол Улс нэгдэн орсос олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн.

Хуулийн этгээдэд эрүүгийн хариушлага хүдээлгэх үндэслэл:

Энэ хүрээнд манай улсалд сүүлийн 10 жилд гарсан экологи, газар, санхүү, төсвийн болон эдийн засгийн гэмт хэргийн гаралт, илрүүлэлт болон шүүхээр шийдвэрлэгдсэн байдал дун шинжилгээ хийж, хуулийн этгээд холбогдсон зөрчлийн болон гэмт хэргийн шинжтэй үйлдлийн шалтгаан ихэюүл, бүтэц хандлагыг судалж, 2015 оны Эрүүгийн хуулийн шинчилсэн найруулгад хуулийн этгээдэд эрүүгийн хариушлага хүлээлгэх зохицуулалтыг тусгасан.

Монгол Улсын эрүүгийн эрх зүйгээр хуулийн этгээдэд эрүүгийн хариушлага хүлээлгэх шаардлага нь дараах нөхцөл байдлуудаар тодорхойлогдоно. Үүнд:

1. Хуулийн этгээдээс үйлдэж буй хууль бус үйлдлүүд, гэмт хэргийн тоо ихэсч нийтэй, иргэдэл учруулах хор уршиг, түүний хэмжээ, цар хүрээ улам бүр нэмэгдэж байгаа.

2. Хуулийн этгээдэд хүлээлгэж буй захиргааны хариушлагын арга хэмжээ нь хуулийн этгээдэд үзүүлэх цээрэлт бага, шийтгэлийн үр нөлөө багатай байгаа.

3. Хуулийн этгээд гэмт хэрэг үйлдэсэн тохиолдолд хариушлага хүлээлгэх гэм буруутай тодорхой этгээдийг олж тогтоо, нотлоход хүндэрлэл учирдаг, зарим тохиолдолд тогтоо боломжийг байдаг.

4. Тодорхой хувь этгээдэд хүлээлгэсэн эрүүгийн хариушлага нь тухайн хуулийн этгээдэд цээрэлт үзүүлдэгтүй, хуулийн этгээдээс дахин тийм зөрчил гаргах явдал үргэлжилдэг.

5. Хуулийн этгээдэд эрүүгийн хариушлага хүлээлгэснээр хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн улмаас

<sup>4</sup> Франц /1992/, АНУ, Финлянд /1995/, Англия, Бельгия /1999/, Канада, Хятад /1997/, Португали /2007/, Швейцар /2003/, Даны, Ирланд, Ирак, Иран, Ислам /1998/, Австралия, Алжир /2004/, Ницареми /1976/, Норвеги /1991/, Шотланд /2001/, эзри улсын гадна посткоомиссар оруулдаас: Польш /2002/, Эстон /2003/, Унгар /2001/, Румын /2004/, Хорват /2003/, Словени /1999/ ФАБНУ, Этноп, Таго.

<sup>5</sup> Есанов Г.А. Основы сравнительного уголовного права М., "Эзит" 2007 С.97-104.

учирсан хохирлыг нөхөн төлүүлэж, гэм хорыг арилгах нөхцөл бүрдээз.

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд эрүүгийн хуулийн шинжчилсэн найруултыг баталсан бөгөөд энэ хуульд хуулийн этгээдэд ял оногдуулах гэсэн 9 дутгээр бүлгигүй тусгасан билээ. Хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэл нь дараах болно. Үүнд:

а/ гэмт хэргийн шинжийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргаж хангасан;

б/гэмт хэргийн шинжийг хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан байх явдал гэж тодорхойлсон.

Шийдлийн хувьд хуулийн этгээдэд хариуцлага тооцоходо хуулийн этгээдээс гаргах шийдвэрлийн хэлбэр болох удирдах албан тушаалтын шийдвэр, хамтын шийдвэр зэргийн харгалзан узсэн нь энэ юм. Түүнчлэн тол шинж болох хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэсн бол хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх талаар тусгажээ.

Түүнчлэн Монгол Улсын Эрүүгийн хууль заахдаа хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргаж, зөвшөөрөл очг гэмт хэргийг бусдаар үйлдүүлсэн, эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө өөрийн үйлдэл, эс үйлдэхүйгээр гэмт хэргийг үйлдсэн бол ял оногдуулахаар заасан. Энэ нь ял завших нөхцөл, боломжийг хаясан хэрэг юм.

Хэрэв хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэсн бол тухайн хүнийг ялаас чөлөөлж хуулийн этгээдэд ял оногдуулах бөгөөд энэ үйлдэлд нь өөр гэмт хэргийн шинж байвал тэр үйлдэл, эс үйлдэхүйд ял оногдуулах шийдлийн хувилбарыг сонгосон нь гэм хэргийг үгүйсгэх нөхцөлд хамаарна гэж үзсэн.

Бидний хувьд хуулийн этгээдэд оногдуулах ялыг тортож, эрх хасах, татан буулгах гэсэн гурван төрөлтэй байхад зааж, тортож яланх хэмжээг зөрүүлийн хэмжээнээс дэлгүүр, үр налеөтгийг байхад, эрх хасах ялыг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хягдаарлах. Эсхүл тусгайлан сэргсэн эрх, зөвшөөрлийг хасах хэлбэртэй байхад заасан.

Олон улсын өмнө хүлээсэн үргийн хүрээнд террор үйлдэх, террор үйлдэхэд бэлтгэх хөөр гэмт хэрэгт хуулийн этгээдийг татан буулгах ял оногдуулахаар заасан. Хуулийн этгээдийг татаан буулгасан тохиолдолго хөрөнгө, орлогыг хураан авч гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төхөөд тарцуулж, үлдсэн хөрөнгийг улсын төсөөт шийдвүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэжээр хуулийн зохицуулалт хийсэн байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулиар эдийн засгийн гэмт хэрэг, олон нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг гэх мэт нийт 24 гэмт хэрэгт оногдуулах зохицуулалттай.

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал нь Монгол Улсын төрний эрүүгийн болготын хүрээнд нийгмийн бодит шаардлагар нөхцөлдэж буй шийдвэрлэвэл зохиц нэг асуудал болоод байгаа ба зах зээлийн нийгэмдэх компани хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох, үр налеөт дээшлүүлэх, бизнесийн эс зүйг төлөвшүүлэхэд төдийгүй байгаль орчны хамгаалахад чухал үүргээтий юм.

Үндэстэн дамнаасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенции буюу Палермогийн конвенцион цүхлээсэн Үргийн хүрээнд хуулийн этгээдэд ял оногдуулах боломжийг нэмэгдүүлж үүнийг бодит үр дүнтэй болгохыг Олон улсын сахицгүйн гэмт хэрэгтэй тэмцэх түр хороо (Financial Action Task Force буюу ФАТФ)-ны тусгай бүлэг болох Олон улсын хамтын ажиллагааг хянах бүлэг (International

Cooperation Review Group буюу ICRG)-ээс зөвлөмж болгож, Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог өөрийн хяналтын хоёр дахь шатанд оруулсан билээ.

Хууль хэрэгжих эксленээс хойш хуулийн этгээдэд ял оногдуулсан тохиолдол гараягийг байгаа бөгөөд бидний хувь ямар тохиолдолд хувь хүнээс ялгаж хуулийн этгээдэд эрүүгийн хэрэг үүсгэх, хэрхэн мөрдөн шалгах, хуулийн этгээдийг төлөөлүүлж хэнд ял сонсож буруутахаа зэрэг ажлын туршлага бага байгаа нь тулгамдсан асуудал гэж үзэж байна.

Гэтэл энэ асуудал нь зөвхөн бидний “зовлон” биш бололтой хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах талаар шинэлэг зохицуулалт хийж чадсан бусад улсынхудын хувьд ч хуулийн этгээдийн үйлдсэн хэргийг мөрдэн шалгаж, ял оногдуулж, түүнийг хэрэгжүүлж аргачлал, үр дүнтэй аргуудыг санаал болгож чадаагүй байна. Магадгүй бидний судалж мэдээгүй олон сайн туршлага бий авч үүнийг эх газрын тогтолцоотой орууладад хэрэгжүүлжээ ихээхэн хүндрэлтэй байгаа билээ.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад хуульчилснаар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бөгөөд энэ хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2018 онд 1 хуулийн этгээдийг гэм буруутайд тооцож, ял оногдуулж шийдвэрлэсэн байна.

## ДУГНЭЛТ, САНАЛ

1. Цаашид бидний хувь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар улс орниуд харицлан туршлага судлах, мэргэжилтийн, шинжээчийг солицлох, олон улсын хэмжээнд хуульчдад зориулсан хамтарсан сургалт явуулах зэрэг ўйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгавар хүн, хуулийн этгээдийг гэм буруутайд тооцож, ял шийтгэл оногдуулахаар заасан. Тэгвэл хуулийн

этгээдийг төлөөлсөн хүнд хэрхэн эрүүгийн хариуцлага хүлээлгэх, гэм буруутгийн зарчмыг гэдгийг хэрхэн ойлгож хэрэгжүүлжэх, ЭХХШТХ-ийн 1.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: “... Шүүхийн шийтгэх тогтоол гаргал хүн, хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцожгүй” гэсэн заалт нь эрүүгийн хуулийн өмнө заалттай хэрхэн нийцэх талаар нэгдсэн ойлголтуүг байжээ.

3. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн “6.14 дүгэр зүйлийн 1 дэх заалт /Өршөөл, узучал үзүүлж ялаас чөлөөлөх/ .Гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг өршөөл үзүүлэх тухай хуулиар, эсхүл уччал үзүүлэх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар гэмт хэрэг үйлдсэн хүний эдэлж ялыг бүрэн болон хэсэгчлэн чөлөөлж болно.” Энэ заалт нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг өршөөл үзүүлэх тухай хуулиар эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, эсхүл ялаас чөлөөлж аль нь болох эсхүл бүр хөөлнангас нь чөлөөлж болох эсэх нь ойлгомжгүй байна. 2015 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө үйлдэгдсэн гэмт хэргийн ялагдагчийг өршөөл үзүүлэх тухай 2006, 2010 оны хуульд заасан үндэслэл, журмын дагуу прокуророос эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, хэргиг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх боломжгүй байдалд хүргэж байна.

4. Хуулийн этгээдэд оногдуулсан тортог ялын тухай төлбөрийн чадваргүй, эд хөрөнгө байхгүй, хуулийн этгээдийн тортог ялын төлбөр биелэх боломжгүй хүлээлгэх хариуцлага тодорхойгүй байна. Иймд хуулийн этгээдийн тортог ялын биелэхгүй байгаа төлбөрийг хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хариуцсан эзэн, дарга, захирадл нь тортог ялыг өөрчлөн хариуцлага хүлээлгэх зохицуулалт оруулах хэрэгтэй байна.

5. Зөрчлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ хэрэглэсэн нь тухайн зөрчлийг үйлдсэн хүнийг эрүүгийн хариуцлага, шийтгэл, албадлагын арга хэмжээнээс

чөлөөлөх үндэслэл болохгүй” гэсэн. Энэ заалтын дагуу аж ахуйн илгэж, хувь хүн хоёуланд нь давхар торгууль ногдуулах зохицуулалт байхгүй байна. Тухайлбал зөрчлийн тухай хуулийн 11.21 дутгаар зүйлийн 1 дэх хэсэг “Гаалийн тухай хууль зөрчих” зөрчлийн шинжийг тодорхойлоходоо “Гаалийн тухай хууль, тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариушлага хүлээлгэхээргүй бол хүн, хуулийн этгээдээр

нөхөн төлүүлэж татварын дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна.” гэсэн ба энэ тохиолдолд хүн, хуулийн этгээдийт хоёуланг нь торгох эсэх талаар зохицуулалт байхгүй. Энэ заалтыг хэрэгжүүлжээд хүн, хуулийн этгээдийт хоёуланг нь торгох зохицуулалт Зөрчлийн тухай хуулийн Ерөнхий ангил туссан байна.

---00---

## ХҮН БАРЬЦААЛАХЫН ЭСРЭГ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



ДХИС-ийн УА-ийн УУГБ-ийн профессор,  
цаагдлагийн хурандаа Д.Сундуйсүрэн

### ТҮЛХҮҮР ҮГС:

Эх сурвалж, терроризм, бооцын худалдаа, ёс занчил, барьцаа, хүн барьцаалах гэмт явдал, гэрээ/конвенц/

### ТОВЧЛОЛ:

Түүхэн цаг хугацааны туршид дэлхийн хамтын нийгэмлэг, улс орнууд хүн барьцаалах гэмт явдалтай олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зонхицуулалтаар тэмцэж ирсн бөгөөд иэгдсэн ундастийн улс түмийн хамтын ажиллагаа, хувийн харилцаа, аюулгүй байдлыг хангах, хүн барьцаалахын эсрэг гэрээ хэлэлциэрний харьцуулан судлахыг зорьсон болно.

### УДИРТГАЛ:

Сүүлийн үед дэлхий нийтийн анхаарлыг татаж, ихээхэн айдас тутшүүрийг төрүүлж буй серөг үзэгдэл бол олон улсын шинжлэгийн гэмт хэрэг, тухайлбал алан хядаа үйлдлийн илрээ болсон терроризм, хүн барьцаалах, агаарын тээврийн онгоц барьцаалах явдал ёсч байгаатай холбогдуулан түүнтэй тэмцэжнүү тулд олон улсын гэрээ, хэлэлциэр/конвенц/ байгуулах нь зүй ёсны хэрэгцээ шаардлага юм.

Хүн барьцаалах явдалтай тэмцэж ирсэн олон улсын эрх зүйн акт

Орчин үеийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагаа нь эрүүгийн гэмт хэрэг болон олон улсын шинжлэгийн гэмт хэрэгтэй тэмцэх тэмцлээс бүрдэж байна.

Үрэд нь хууль зүйн шинжлэх ухаан болон практикт “Олон улсын шинжлэгийн гэмт хэрэг”-ийн тухай бүрэн гүйцэд тодорхойлолт байгаатай. Энэ тухай оновчтой тодорхойлолтыг профессор И.И.Карпец өгчээ. Үүнд: “Олон улсын шинжлэгийн гэмт хэрэг гэдэг нь олон улсын гэрээ хэлэлцээрт заасан, нийн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хамаарахгүй гэвч улс хоорондын хувийн харилцаанд халдах, дэлхий нийтийн хамтын ажиллагаа, салбар дүйнэн харилцаа (эдийн засаг, нийтээм, соёл, хөрөнгө гэх мэт) ... -ни хохирол учруулж буй, тогтоосон хэм хэмжээний дагуу шийтгэлтэй, гэрээ хэлэлциэр ёсоор үндэсний эрүүгийн хууль тогтоомждоо хуулылан тогтоосон байх явдал юм”.

И.И.Карпецын үзэж байгаагаар, дээрх гэмт хэргийн олон улсын шинж чанар нь олон улсын хэлэлцээрт заасан, олон улсын харилцааны салбарт хохирол учруулж байгаагаар тодорхойлогдох бөгөөд үндэсний эрүүгийн хууль тогтоомждоо завал тусгаж, шийтгэлийг ногдуулдаг байна.

Энэ гэмт хэргийн олон улсын шинж чанарыг олон улсын харилцааны салбарт хохирол учруулдаг гэхээсээ илүү “гадаадын элемент”-тэй холбоотой үүсдэг, нарийн төвөгтэй эрүүгийн эрх зүйн харилцаа, өөрөөр хэлбэл, гэмт хэргийн субъект нь “гадаадын”, гэмт хэргийн субъект объект нь гадаад орны нутаг дэвсгэр дээр, үйлдэл нь хэд хэдэн хууль эрх зүйг/хоёр ба түүнээ дээш үндэсний болон олон улсын/ зөрчсөн байгаагаар тодорхойлогддог байна.

<sup>1</sup> Карпец И.И.Преступления международного характера. М., 1979. С. 40

Дээр дурдсанас үзэж олон улсын шинжтэй гэмт хэрэг нь олон улсын ба улс үндэстний эрх зүйн журамд халдаж байгаа, төр, олон улсын байгууллага, албан тушаалтан, бие хүн хуулийн этгээд тэдгээрийн ёмч хөрөнгө, амьдралын сайн сайхан, хүний үнэт зүйл, эрх, эрх чөлөөнд нь хор хохирол учруулж байгаа төрийн / улсын/ хууль тогтоомжид заасан, эрх зүй зөрчсөн, эздрээ төвөгтэй, нийгэмд аюултай үйл ажиллагаа /үйлдэл/ гэж үзж болх юм.

**НҮБ-ын Ерөнхий ассамблейн** 1979 оны 12 дугаар сарын 17-нд батлагдсан “Хүн барьцаалахын эсрэг” олон улсын Конвенцод хүн барьцаалах нь олон улсын гэмт хэргийн бие даасан төрөл болохыг анх удаа заажээ.

Урьд нь баталсан олон улсын гэрээ, конвенцуудад боолчлол, албан хядах ажиллагаа, агаарын хөдөл барьцаалах, бусад олон улсын шинжтэй гэмт хэргийг хамааруулсан байна. Тухайлбал; 1926 оны 9 сарын 25-ны өдөр Женев хотод боолчлолтой хөлбоотой Конвенцод гарын үсэг зурсан бөгөөд хожим нь нэмэлт оруулжээ. Энэхүү конвенцын эх сурвалж нь дараах олон улсын актуул:

- 1889-90 оны Брюсселийн бага хурлын ерөнхий акт, энэхүү актанд гарын үсэг зурсан улс орнууд Африкт хийгдэг болын наймааг эцэс төгсгөл болгохыг хатуу мэдэгджээ.

- 1919 оны Сен Жермений конвенц, энэхүү конвенцод гарын үсэг зурсан улс орнууд хуурай газар болон далай тэнгист бүх хэлбэрийн боолчлол, болын наймааг бүрэн устгакав илэрхийлжээ.

- 1924 оны 6 дугаар сарын 12-ны өдөр Үндэстнүүдний Холбооны Зөвлөлөөр томилсон Боолчлолын түр хорооны илтгэл

Сен-Жермений конвенцод гарын үсэг зурсан улсуудас боолчлол, болын худалдааны талаар гаргасан зорилтуудыг дэлхий даяар хэрэгжүүлэх үүднээс Брюсселийн актын дагуу хэрэгжүүлэх ажлыг дуусгавар болгон хэрэгжүүлхийг эрмэлзэн, энэхүү конвенцод тусгагдсан заалтуудаас илүү нарнийчилсан заалт бүхий

хэлэлцээр байгуулах шаардлагатай байгаат үзүүлэх зөвшөөрч, 1926 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр “Боолчлол, боолын худалдааг хорилго тухай” Женевийн конвенци батлагдсан байна.

Энэхүү Конвенцод “Боолчлол гэж өмчлөх эржд хамаарах бүх, эсхүл зарим эрх мэдлийг хүн дээр хэрэгжүүлсэн байдал буюу нөхцлийн ойлгоно”, “боолын худалдааг гэж хүнийг боол болгох зорилгоор олзлох, олих авах буюу эрхэндээ оруулах бүх үйлдэл, боолыг худалдаа буюу солих зорилгоор түүнийг олж авахтай холбогдсон бүх үйлдэл, худалдаа буюу солих зорилгоор олж авсан боолыг худалдаа буюу солих замаар эрхэндээ оруулах бүх үйлдэл, бүхэлдээ боолыг тээвэрлэх, эсхүл худалдаа бүх үйлдэл хамаарна”<sup>2</sup> гэж боолчлол, боолын худалдаа гэгдгийг анх удаа тодорхойлжээ.

Конвенцыг хүлээн зөвшөөрч хэлэлцэн баталсан талуудын хүлээсэн гол үүрэг бол: Боолын худалдааг хоригтох түүхээс урьдчилан сэргийлэх, боолчлолын бүх хэлбэрийг багшино хугацааны бүрмөсөн устахыг чармайх, бололын худалдаа болон боолчлолыг устахын тулд харилцаа бие биедээ дэмжлэг үзүүлэх явдал гэж узжээ.

1956 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр “Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншиг устгах тухай” измэлт конвенц батлагдаж, 1957 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хүчин төгөлдөр болжээ<sup>3</sup>.

Энэхүү конвенцод оролцогч улс бүр, эрх чөлөө бол хүн бүрний төрөлхийн занягтгамал эрх мен гэж үзээд, (Нэгдсэн Үндэстний улс түмэн дүрэмдээ хүн төрөлхтний үзүүлэлтэй, нэр төрд итгэх итгэлийг бататгасныг дурдаж) Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгээс зарлан тунхагласан Хүний эрхийн түгээмэл тунхаглалд боолчлол буюу эрх мэдэлгүй байдалд хэн ч иэрвэгдэх

<sup>2</sup> СССР и международное сотрудничество в области права человека. Документы и материалы МИД СССР. М., 1989. С. 105-106.

<sup>3</sup> Международное сотрудничество государств по борьбе с преступностью: Учебно-методическое пособие. М., 1982. С. 124

ёсгүй бөгөөд боолчлол, боолын худалдааг бүх хэлбэрээр нь хорилно гэж заасныг анхааралдаа авч, Энэхүү Конвенцоор 1926 оны “Боолчлол, боолын худалдааг хорилго тухай” Женевийн конвенцод заасан боолчлол, боолын худалдаа гэсэн тодорхойлолтыг хөндөхгүйгээр зарим ойлголтыг өргөжүүлэн нэмэлт болгож, дараах ёс болон заншлыг бүрэн халах буюу устах шаардлагатай арга хэмжээ авахыг тусгасан байна.

а/ Өрөнд баригдаж боолчлогосон, өөрөөр хэлбэл өртэй хүү өөрийнхөө, эсхүл өөрөөсөө хараат хүний үйлчилгээгээр өрөө төлөх үүргээ биелүүлжтэй холбоотойгоор үссэн барьцааны байдал буюу нехцэл, хэрэв тэрхүү үйлчилгээг зохих ёсбор үзүүлэн үнэлгээ нь уг өрний төлөөсөнд тооцогдогчай, эсхүл тэрхүү хөдөлмөрийн шинж чанар, үргэлжлэх хутацаа нь тодорхой бус бол, ...

с/ Дараах үйлдлийг зөвшөөрсөн аливаа ёс, заншил:

а) эмэгтэй хүнийг мөнгө болон биет эд зүйлийн оройд төлөх болзолжийгоор өөрийнхөө нь зугээс татгалзах эрхгүйгээр түүний эцэг, эх асран хамгаалагч, гэр бүл, эсхүл бусад хүн, эсхүл бүлэг хүмүүсээс эхнэр болгож өгөхгүй алласан эсхүл өгсөн.

б) эмэгтэй нөхөр, түүний гэр бүл, эсхүл овгийнхон нь тухайн эмэгтэйг өөр хүнд үзүүлээд зүйлсний оронд буюу бусад хэлбэрээр шилжүүлэх өгөх эрх залдэг байх.

с) нехрийт нь нас барахад бэлбэсэи эхнэрийт бусад өвлүүлэн өгөх.

д) 18 нас хүрээгүй болон бага наасны хүүхдүүдийг ашиглах буюу тэдний хөдөлмөрийт мелжих зорилгоор эзгэж эхийнх нь аль нээ, эсхүл хоёул, эсхүл асран хамгаалагч нь тэднийг шан харамжтай буюу харамжгүйгээр бусад өтдөг аливаа ёс буюу заншил<sup>4</sup>.

Анхны эрх зүйн баримт болох 1937 оны “Терроризмаас урьжсан сэргийлж болон ял оногдуулах тухай” Женевийн конвенциг

<sup>4</sup> Олон улсын гэртэй, албаны шүүрхийн эзлэгэл, УБ., 2015 оны, 306 дэх тал.

“хүн барьцаалах” гэсэн нэр томьёог анх эхэн иэрлэн заажээ. Энэ конвенци оршил болон 29 зүйлтэй, терроризмын үйлдлийн объектыг бүрэн дүүрэн, өргөн хүрээтэй тодорхойлжээ. Конвенци олон улсын алан хядах явдал /терроризм-/ын ойлголтыг томьёолсон, терроризмтай тэмцэх механизмыг боловсруулсан, үндэсний болон олон улсын түвшинд хэрэглэгдэх журам, үйл ажиллагаа Конвенциэд элсэн орех процедуруюудыг тогтоосон юм. Харин улс тэр ба хууль зүйн шалтгаанаар хүчин төвлөрөөр болоогүй гэвч олон улсын эрх зүйн эсрэг шинжтэй гэмт хэрэг ба олон улсын алан хядах ажиллагааг буруушааж байсан нь одоо ч ач холбогдоо алдаагүй байна.

Энэ нь сүүлийн эхийн төрөлхтний аюулгүй байдал, дэлхий нийтийн эсрэг гэмт хэргийн тухай хууль, эрх зүйн баримт бичийн төсөл боловсруулахад ашиглах сурье нь болсон гэж үзүү үндэстэй юм. Түүчинчлан агаарын хөлгийт барьцаалахын зэрэгцээ хүн барьцаалах, олон улсын хамгаалалтанд байдаг хүн, дипломат төлөөлөгчийн халдашгүй байдал, харилцаанд хүч хэрэглэн халдах явдал терроризмын төрлүүдийн нэг юм<sup>5</sup>.

Иргэний нисэх хүчин, олон улсын харилцааны эсрэг агаарын хөлгийн бүхээгт үйлдэгдэх буй гэмт хэргийн тоо өвч байгаатай холбогдуулан улс орнууд 1963 онд “Агаарын хөлгийн бүхээгт үйлдэсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай” Конвенцийг Токно хотио батгалаа гаргасан байна.

Энэ Конвенциоо агаарын хөлөг, түүний дотор байгаа хүмүүс, эд хөрөнгө, түүнчлэн агаарын хөлгийн дотоод сахилга, дэг журамд аюул учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг тодорхойлжээ.

Энэ гэмт хэргийг үйлдэхээр завдсан, үйлдэсэн гэх үндэслэл байвал агаарын хөлгийн дарга, агаарын хөлөг, түүнд байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг хамгаалах, нисэх багийн гишүүд болон зорчигчийн

<sup>5</sup> Советский Ежегодник международного права. М., 1989. С. 124

дэмжлэгийг авах, гэмт этгээдийн эрх чөлөөг нь хягаарлах, саатулах, агаарын хөлгөөс буулгах, эрх бүхий байгууллагад шилжүүлэх, зэрэг болоцтоотой бүхий л арга хэмжээг авахыг тусгажээ.

Конвенцын 11 зүйлийн 1 дэх хэсэгт: “Агаарын хөлгийн бүхээгт байгаа этгээд хүч хэрэглэн, эсхүл хүч хэрэглэхээр заналхийн нислэгт буй агаарын хөлгийн удирдлагагд хууль бусаар саад учруулах, удирдлагыг булаан авах буюу хууль бус бусад үйлдэл буюу үйлдэжийг завдсан тохиолдолд хэлэлцэн тохирогч улсууд агаарын хөлгийн удирдлагыг түүний хууль ёсны даргад эгүүлэн егэх буюу түүний хянaltaанд байлгахад шаардлагатай бүхий л арга хэмжээ авна”<sup>6</sup> гэжээ. Харилсан тохирогч улс орнууд дээрх арга хэмжээг авахын зэрэгцээ сэжигтэн этгээдийг шилжүүлэн авч, албадан саатуулан, цагдан хорхж, эруутгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахаар тодорхой зохицуулсан байна.

1970 онд Гаагийн “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай” конвенцыг батлагдсан. Хэлэлцэн тохирогч улс бүр “агаарын хөлгийг хууль бусаар булаа” үйлдэл гаргасан тухайн этгээдэд хүнд яланогдуулах үүрэг хүлээсэн.

Мөн 1971 онд Монреалийн “Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай” конвенц батлагдсан.

Конвенцын 7 дугаар зүйлд: Нутаг дэвсгэр дээр нь сэжигтэн этгээд илрэч тогтоогочсон хэлэлцэн тохирогч улс түүнийг шилжүүлэн өгөхгүй байвал гэмт хэрэг түүний нутаг дэвсгэр дээр гарсан эсэхээс үл хамааран яллуулхаараа өөрийн эрх бүхий байгууллагад шилжүүлнэ. Тэрхүү эрх бүхий байгууллага нь тухайн улсын хуульд заасны дагуу иоцтой шинж агуулсан ердийн хэрэгтэй адил журмаар шийдвэрлэнэ” гэж заажээ.

Ийм байдлаар хэлэлтийн батлагдсан олон улсын конвенц нь иргэний нисэх хүчиний эсрэг үйлдэж буй гэмт хэргийн ангилалд хамаарч буй нөхцөл байдлыг арилгахын тулд бие биендээ дэмжилт үзүүлэх, зохих ёсны харнушлагын зарчим бусад арга хэмжээг хэрэглүүлж, олон улсын терроризмын аюултгээр төрөл буюу хамгийн тутгээж энд гэмт хэрэгтэй тэмцэжэд улс орны хамтын ажиллагааны эрх зүйн үзүүлжийг бурдуулжээ.

Гэвч олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг, нисэх буудалд үйлдэгдэж буй хүч хэрэглэсэн явдлыг таслан зогсоо асуудал олон улсын эрх зүйн зохицуулалтгүй үйлдээн байна. Тиймээс “Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай” Монреаль хотноо 1971 оны 9 дугаар сарын 23-ны өдөр үйлдээн Конвенцийн олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүч хэрэглэсэн хууль бус үйлдлийг хориглох тухай нэмэлт протокол 1988 оны 2 дугаар сарын 24-ийн өдөр баталж, 1989 оны 8 дугаар сарын 6-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

Энэхүү нэмэлт протоколд “Оролцогч улсууд олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүмүүсийн аюулгүй байдалд аюул занал учруулж буй, учруулж болзошгүй, эсхүл здгэр нисэх буудлын аюулгүй ажиллагаанд саад учруулж буй хүч хэрэглэсэн хууль бус үйлдлүүд нь эдгээр нисэх буудлын аюултууд ажиллагаанд итгэх дэлхийн ари түмний итгэлний бууруулж, бүх улсын хувьд иргэний нисэхийг аюулгүй, журамтай удирдахад саад болж байгаа гэж үзök, ийм гэмт хэрэг үйлдэх нь олон улсын хамтын нийгмэлгүйг нийтгэж түгшэж байгаа гэж үзэн, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлж болон шийтгэхийн тулд түүштэй арга хэмжээ авах шаардлагатай болсныг хэлэлцэн тохирсон тухай” заажээ. Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүс түүний дотор дипломат төлөөлжидийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлж болон шийтгэх тухай конвенциг НҮБ-ын Ерөхийн ассамблей 1973 оны 12 дугаар сарын 14-ны

<sup>6</sup> Олон улсын гэрээ, хөтөлбөрчийн эмхтгэл, УБ., 2015 он, 306 дахь таа.

өдөр баталж, 1977 оны 2 дугаар сарын 20-ний өдөр хүчин төгөлдөр болсон.

Энэ конвенцод “тусгай хамгаалалт”, “сэжигтэн этгээд” /тухайн гэмт этгээд/ гэсэн ойлголтыг гарган тавьж, олон улсын хамгаалалтанд буй хүн гэдгийг тодорхойлсон. Конвенцын 4-11 дүгээр зүйлд тогтоосон хэм хэмжээ, үндэсн зарчмын хурээнд олон улсын алан хядах ажиллагаагаа үйлдэж буй этгээдэд ял шийгтийг оногдуулж байх зарчмыг хангаха, тэдгээртэй холбоотой зүйлүүд хамаарсан байна.

1973 оны Конвенциг нэгтгэн дүгнэж үзвэл 1937, 1971 оны конвенцийн олон зүйл заалтыг ашиглласан байна.

1975 онд Европын зөвлөлийн оролцогч улсын Хууль зүйн сайд нарын Европын хороо олон улсад хүч хэрэглэсэн яз бүрийн хэлбэрийн гэмт явдалтай холбоотой асуудлуудыг судлан үзж, энэ асуудлаар Конвенцийн төслийн боловсруулах саадаа дэвшүүлсэн байна. 1976 оны арван нэгдүгээр сарын 10 өдөр Европын Холбооны Сайд нарын зөвлөл терроризмтай гэмцж тухай Европын конвенцийн баримтыг хүзүүн авч, 1977 оны нэгдүгээр сард баталсанад уг баримт 1978 оны 8 дугаар сарын 4 өдөр хүчин төгөлдөр үйлийлж эхэлсэн. 16 зүйл бүхий энэ баримт бичиг нь олон улсын терроризмтай гэмцж үйл ажиллагаанд улс хоорондын хамтын ажиллагаанаа талаар байгуулсан бусад гэрээ хэлэлцэрийн дунд онцгой байр суурь эзлэдэг.

Террорист хүчирхийлэл, үйлдлийн өргөн хүрээг тодорхойлсон нь Конвенцийн онцлог юм. Тэдгээрт иргэний агаарын эсрэг, нисэх хөлгийн бухээгт үйлдсэн гэмт хэргүүд, олон улсын хэмжээнд хамгаалуулах эрхтэй этгээдийн эрүүл мэнд, эрч чөлөөнд халдсан явдал, хүн барьцаалах эскул санаандгүй байдлаар хүний эрх, эрх чөлөөнд халдах түүчинлэн бусадаа аюул учруулах тэсээр дэлбэрэх зэвсэг хэрэгсэл ашиглах явдал камаарааар зохицуулсан байна. Уг Конвенцийн dedere, aut judicare гэх зарчимд тулгуурласан, түүничэн хэрэгтний шилжүүлэн огөх үйл ажиллагаа нь террорист акт үйлдсэн этгээдүүд ял

шийгээлээс зайлсхийхээс урьдчилан сэргийлж чадсан үр дүнтэй хэрэгсэл болсон байна.

Хүн барьцаалах явдалтай тэмцэх тухай дээр дурдагдсан конвенцийндаас гадна дайны үед эдгэр гэмт хэрэг үйлдэхийг хориглосон конвенцийндууд байжээ.

1949 онд Женевийн олон улсын 4 конвенцийн батлагдсан. Үүнэд: “Дайны талбарт байгаа зэвсэгт хүчиний шархтан, евчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай” Конвенц, “Зэвсэгт хүчиний бүрэлдхүүнээс сүйрээн хөлөг онгоцноос хохирсон этгээд, евчтөн, шархтаны нөхцөл байдлыг сайжруулах тухай” Конвенц, “Олзлогдсон цэргийг харж хандах тухай” Конвенц, “Дайны үед иргэний хүн амыг хамгаалах тухай” Конвенцийндууд юм. 1977 онд эдгэрээр конвенцийндууд измэлт протокол батлагдсан.

Тухайн цаг үед хүннүүг газар сайгүй барьж, хорьж, алхаар өрүү шүүлт тулгах, ташуурдаж яллах, гэмтэй бэргэл учруулах, хүний эрхэм чанарыг доромжлох, хүний барьцаанд авах, зоих эсны шийдвэрлгүйгээр хоморголон яллаж байсан, эдгэр гэмт үйлдлийн бүх төрлүүд нь харгис хөргүүл, бусдыг басамжлан доромжилсон хандлагатай байв.

1949 оны Женевийн конвенцийндууд болон 1977 онд баталсан Нэмэлт протокол баримтууд байлдаж буй талууд олзлогдсан, далайд онгоцны сүйрэлд нэрвэргдсэн, шархадсан, евчтөн зэргийн хумууст хандах хүмүүнүүгээс хэм хэмжээг тусгасан байна. Дээрх олон улсын акт баримтад тусгах зааснаар хүн барьцаалах хүнд ноцтой гэмт хэрэг үйлдэхийг хориглосон байгаа нь чухал ач холбогдолтой юм. Хүн барьцаанд олзлон авах үйлдэл олон улсын зарим эрх зүйн баримт бичигт<sup>1</sup> олон улсын гэмт хэрэгт тооцогдож байгаа боловч практикдээр энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээнүүд хангалтгүй байгаа нь илт харагддаг. Олон улсын төвшийнд хүн барьцаалах үйлдлийг бие даасан гэмт хэрэгт тооцоо, түүнтэй тэмцэжд чиглэсэн

<sup>1</sup> Женевские конвенции о защите жертв войны. М., 1954. С. 12

<sup>2</sup> Женевские конвенции 1949 года и Дополнительные протоколы к ним 1977 года; Европейская конвенция 1976 года

нэй яаралтай арга хэмжээг боловсруулан батлахад хүргэсэн эмгэнэлтэй явдал бол 1972 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр Мюнхене ХХ Олимпийн наадмын үед гарсан “Хар есдүгээр сар” гэх, экстремист бүлгийн гишүүд тамирчдыг барьцаалсан хэрэг юм.

“Террористууд барьцааны хүмүүстэй хамт арабын аль ньтг улс руу хамт нисэх онгоц гаргаж өгөхийг шаардсан. Террористууд, ХБНГУ-ын цагдаагийн байгууллага иар зөвшлийлд хүрснийн дараа террористууд болон барьцааны хүмүүсийн Мюнхен хотоос 25 км байршил Фюрстенфельдрүүкэд дэх нисэх буудал руу хоёр вертолёт оногооцроо хүргэсэн, тэдгээрийг тэнд “Боинг” онгоц хүлээж байв. Вертолётт оноги газардахад отолтой байсан цагдаагийн мэргэн буучид террористуудын зүг гол нээв. Буудалцааны үед террористууд барьцааны хүмүүс, вертолётын изг нисгэгч мөн цагдааг бөмбөг дэлбэлэн амийг нь хөнөөжээ. Энэ ажиллагданы дунд 16 хүн амия алдсан ба тэднээс 11 нь олимпиини тэмцээнд оролцож байсан тамирчид байв. Бавари мужийн Дотоод хэргийн сайд отолт зохион байгуулсан шалтгаанаа тайлбарлаадаа нисэх будаад ирэнгүүт нь барьцааны хүмүүсийг алж болзошгүй гэж Германы албаны хүмүүс болгоомжилж байсан учир тэдгээрийг онгоцанд суухаас нь өмнө цагдаа нар аврахыг оролцсон гэжээ<sup>10</sup>.

Энэ гэмт хэрэг гарсантай холбогдуулан НҮБ-ийн гишүүн орны хувьд ХБНГУ Хүн барьцаалах үйлдлэлтэй тэмцэх Конвенц санаачлан боловсруулсан. НҮБ-аас ХБНГУ-ын энэхүү санаачилгыг дэмжсэн бөгөөд Еронхий Ассамблейн 31/103 дугаар баримт бичгийн дагуу 1976 оны арванхоёрдугаар сарын 15 өдөр Хүн барьцаалах үйлдлэлтэй тэмцэх олон улсын конвенц боловсруулах Тусгай хороог байгуулсан юм.

Уг хороог байгуулсан нь НҮБ-ийн гишүүн орнууд хүн барьцаалах асуудалд хэр сэйтэл зөвнүүж буйг харуулжээ. Олон тооны эмгэнэлт үйл явдал гарч байсан ч тэдгээр

<sup>10</sup> Советский спорт. 1972. 7 септ.

харгис үйлдлийг зохион байгуулагчдын эсрэг олон улсын хэмжээнд ижн яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байгааг харуулсан юм.

Улс төрийн зорилгоор хүн барьцаалах гэмт үйлдэл ямар ч гэм бууруутгүй хүмүүсийн амь насанд заналхийлж, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулан, төр засгийн хүчийг супруулж буй үйлдлийн эсрэг тухайн улс орны зүгээс хүмүүнээг ёссыг дагаж хууль зөрчин арга хэмжээ авахад хүргж байна.

Аль ч орны дотоодын хууль тогтоомжкоор хүний амь хөөнөх, агаарын хөлгийг эзлэн авч барьцаалах, хүүхэд хүлтэйлах, хүний эр чөлөөг хууль бусаар хасах, дээрэмдэх зэрэг хэргүүд нь хүнд ноцойг тообогдол, хатуу шийтгэлтэй гэмт хэрэг юм. Хүн барьцаалах нь мөн адил олон улсын эрх зүйлээр байж болшгүй гэмт хэрэг, ихэнх тохиолдолд үндэсний эрүүгийн эрх зүйлээр хангаптуй зохицуулагдсан байдал, ялангуяа нэг улс оронд хүн барьцаалах, амийг нь хороосон этгээд өөр улс орноос орлоголт одлг явлыг таслан зогсоо шаардлагатай байгааг Канадын төлөөлөгч Вонг онцлон тэмдэглэжээ.<sup>10</sup>

Хүн бүр Хүний эрхийн түгээмэл тунхаглалд зассан амьд явах, эрх чөлөөтгий байх, хувийн аюулгүй байдлаа хамгаалах эрхтэй гэсэн зарчмыг баримтлах шаардлагатай. Хүн барьцаалах явдал нь гэм бууруутгүй хүмүүсийн амь насанд заналхийлсэн гэмт үйлдэл тул түүнтэй тэмцэхгүй нэг ч улс орон байх боломжгүй юм.

ХБНГУ, Францын төлөөлөгчийн конвенцын төслийн үндэс нь “ял оиоо эсвэл хүлээлтэн өг” гэсэн зарчмын юм. Олон улсын хэмжээнд үр дагавар үүсгэдэг хүн барьцаалах явдал нь хүмүүнлэгийн эрх зүй зөрчөөд зогсохгүй хүний эрхийг зөрчиж, улс хоорондын найрсаг харилцааг бусниуудаг. Конвенцыг боловсруулах үед гэм бууруутгүй золиос болж болзошгүй хүмүүсийн аюулгүй байдлын тухай асуудал голлогох байр сууринт эзлэх

<sup>10</sup> ООН. Генеральная Ассамблея. 5-е заседание. Специальный комитет. 5 августа 1977 г. А/АС. 188/5. С. 6.

ёстий гэдгийг бүгд хүлээн зөвшөөрсөн. Мөн түүчилэн, барьцааны хүн гэдэг ойлголтыг урьдчилсан тодорхойлох шаардлагатай эсэх талаар хэлэлцсэн. Олон хумүүсийн дэмжлэгийт авсан боловч Италийн төлөөлөгчдийн үзэж байгаагаар, барьцааны хүн гэсэн ойлголтыг урьдчилан тодорхойлох шаардлага байхгүй, учир нь золиос бологчийн тодорхойлоулт нь гэмт хэргийн тодорхойлоултосоо автоматаар урган гарч байгаа тухай илэрхийлсэн байдал. Тусгай хороо гурван удаа чуулган хийж /1977, 1978, 1979 он/ ажлын явцад 35 орны төлөөлөгчид конвенцын үндсэн зүйл заалтуудыг хэлэлцсэн байна.

1979 оны 12 сарын 17-ны өдөр Нью-Йорк хотод НҮБ-ын Ерөнхий Ассабедийн 34 дүгээр чуулганаар 34/146 дугаар тогтолцогт баталж, Хүн барьцаалын авахын эсрэг олон улсын конвенциод гарын үсэг зурснаар, хэрэгжүүлэх нөхцөл боломжийг нээж өгсөн.

Конвениц нь удиртгал ба 20 зүйлэс бүрдсэн. Удиртгалыг конвенциод оролцогч улс орнууд Нээгдсэн үндэстний ард түмнүүд хоорондын хамтын ажиллагаа, наирсаг харилцаа, аюултүй байдал, олон улсын энэ тайвныг хангахад чиглэгдсэн НҮБ-ын дүрмийн зорилго, зарчмыг дэмжихийг оншилон дурдсан. НҮБ-ын дүрэм болон олон улсын эрх зүйн зарчмын тухай тунхаглалд ард түмнүүдийн тэги эрх, тусгаар тогтнох зарчмыг бататгасан. Удиртгальд мөн энэхүү конвенциод оролцогч орнууд хүний эрхийн түгээмэл тунхаглал, иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактад заасан хүн бүр амьт явах, эрх чөлөөтэй байх, аюулгүй байх эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн, мөн хүн барьцаанд авах нь олон улсын хамтын нийгэмлэгийн санааг ихээхэн тутгээсэн гэмт хэрэг гэж үзэж байгааг тул нэй бол эрүүгийн журмаар яллах эсчүүл шилжүүлэх өгөвлөх зохицыг заасан. Хүн барьцаанд авах бүх үйлдлийг олон улсын терроризмын илрэл гэж үзэн гэдгээрээс урьдчилан сэргийлэх, тэдээрийг яллах болон шийтгэх талаар үр иөлөөтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг хэлэлцэн толирсон байна. Хүн барьцаанд

авахын эсрэг Олон улсын Конвенцын 1 дүгээр зүйлд: “Турав дахь этгээдээр, тухайлбал улс, засгийн газар хоорондын олон улсын байгууллага, хувь хүн, хуулийн этгээд, эсхүл бүлэг этгээдээр аливаа үйлдэл гүйцэтгүүлэх буюу гүйцэтгэхээс татгалзуулалт зорилгоор өөр нэг хүн (цаашид “барьцааны хүн” гэж)-ийн суллах шууд буюу шууд бус болзол болгон тавьж түүнийт олзлоо буюу саатуулах, амийг нь хөнөөх, бие махбодод нь гэмтэл учруулах, эсхүл үргэлжлүүлэн саатуулахаар заналхийдэх бий аливаа этгээдийн энэхүү конвенцын хүрээнд хүн барьцаалах гэмт хэрэг үйлдсэн гэж” үзэхээр тодорхойлжээ. Түүчилэн “аливаа этгээд”:

а) хүн барьцаалах үйлдэл хийхний завдсан

б) хүн барьцаалах үйлдэл хийсэн буюу чингэхийг завдсан этгээдийн гэмт хэрээт хамтран оролцисон бол”... гэмт хэрэг үйлдсэн гэж үзэхээр, оролцогч улс бүр дээрх гэмт хэргүүдийн ноцтой шинжийг хяргалзан зохих шийтгэл ногдуулахаар заасан байна. Мөн гэмт хэрэгтэн нутаг дэвсгэрт нь хүн барьцаалсан бол оролцогч тухайн улс барьцааны хүний байдлыг хөнгөвчлөх, тухайлбал, түүнийг суллах, сулласны дараа шаардлагатай тохиолдолд уг улсаас гарахад нь тусламж дэмжлэг үзүүлэх, гэмт этгээдийн хүн барьцаалж байж олж авсан аливаа зүйл оролцогч улсын мэдэлд орсон бол тухайн оролцогч угдээ түүний түргэн хугацаанд барьцааны хүн буюу тэдээрийн эрх бүхий болгободх байгууллагад буцааж өгөх, оролцогч улс нь нутаг дэвсгэрт нь олж тогтоосон сэжигтэнг шилжүүлэгээгүй болгэмт хэрэг нутаг дэвсгэрт нь үйлдэгдсэн эсэхээс үл хамаарч уг хэрэгт тухайн улсын хууль тогтоомжийн дагуу барьцаан шийтгэх ажиллагаа явуулахдаа шударга хамдах өөрийн эрх бүхий байгууллагад яллуулахаар шилжүүлэх, шийдвэрээ ноцтой шинж бүхий ердийн гэмт хэргийг шийдвэрлэгдгийн адиллаар гаргаж байхаар зохицуулжээ.

Дайид хэлмэгдэгдснийг хамгаалах тухай 1949 оны Женевийн конвенциид буюу тэдгээрийн нэмэлт протоколуудыг

хүн барьцаалах тодорхой үйлдлийн хувьд хэрэглэдэг бөгөөд энэхүү конвенцод оролцогч улсууд дээрх коивенцуудын дагуу хүн барьцаалсан этгээдний яллах буюу шилжүүлэн өгөх үүрэг хүлээсний хэрээр 1977 оны 1 дүгээр протоколын 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу улсууд найрсагаар харилцах, хамтран ажиллах талаарх олон улсын эрх зүйн зарчмын тухай тунхаглалд дурдсан өөртөө засан тохиох эрхээ хэрэгжүүлэх үүднээс колонийн дарлал, харин эзлэн түрэмгийлэл, арсын үзэлт дэглэмийн эсрэг хийж буй ард түмнүүдийн тэмцлээс үүдсэн зэвсэгт мөргөлдөөн зэрэг 1949 оны Женевийн конвенциуд болон тэдгээрийн протоколуудад заасан зэвсэгт мөргөлдөөний үед хүн барьцаалах үйлдлийн хувьд энэхүү конвенциг хэрэглэхгүй, гэмт хэргийн нэг улсын нутаг дэвсгэрт үйлдсэн бөгөөд барьцаанд байгаа хүн болон сэжигтэй этгээд хоёул тухайн улсын харьат, түүнчлэн сэжигтэн этгээдийг тухайн улсын нутаг дэвсгэрт олж тогтоогоон тохондолд энэхүү конвенциг хэрэглэхгүй байхаар тус тус тогтоосон байна.

Гишүүн орнууд Хүн барьцаанд авахын эсрэг Олон улсын конвенцод гарын үсэг зурсан явдал түүх, улс төр болон хууль эрх зүйн чухал ач холбогдолтойг тэмдэглэх нь зүйтэй. Монгол улс Хүн барьцаалахын эсрэг олон улсын Конвенцонд 1992 оны б дугаар сарын 9-нд нэгдэн орсон байна.

### ДҮГНЭЛТ

Хүн барьцаалах гэмт хэрэг нь олон улсын терроризмын нэг хэлбэр, мөн дэлхийн хамтын нийгэмлэг, улс орнуудын хоорондох харилцаанд (олон улсын харилцааг тогтвортгүй болгодог) хохирол учруулдаг олон улсын бие даасан гэмт хэрэг гэж үзэхээр байна.

Түүхэн олон улсын гэрээ, конвенциудад боолчлол, алан хядах ажиллагаа, агаарын хөлөг барьцаалах, бусад олон улсын шинжтэй гэмт хэргийг

хамаараулан зохицуулсан байна. Хүн барьцаалах гэмт хэргийн иżн эртийн хэлбэрийг боолчлол гэж үзэх үндэстэй юм.

1926, 1956 онд конвенцоор боолын худалдааг хориглох түүнээс урьдчилан сэргийлэх, боолчлолын бүх хэлбэрийг богино хугацаанд бүр мөсөн устахыг чармайх, боолын худалдаа болон боолчлолыг устахын тулд харилсан бие биенээ дэмжилгээ үзүүлэх явдал гэж үзэх.

1963 онд “Агаарын хөлгийг бүхээлт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай” Конвенцоор агаарын хөлөг, түүний дотор байгаа хүмүүс, эд хөрөнгө, түүнчлэн агаарын хөлгийн дотоод сахилга, дэг жүрэмд аюул учруулсан, учруулах болзошгүй үйлдэл, агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг тодорхойлсон байна.

1970 онд Гаагийн “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай” конвенцоор “агаарын хөлгийг хууль бусаар булаах” үйлдэл гаргасан тухай этгээдэд хүнд ял оногдуулахаар зохицуулсан байна.

1971 онд Монреалийн “Иргэний нисэкийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай” конвенцоор иргэний нисэх хүчиний эсрэг үйлдэж буй гэмт хэргийн ангилалд хамаарч буй нөхцөл байдлын арилгахын тулд бие биенээ дэмжилгээ үзүүлэх, зохих ёсны харинушлагын зарчмын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх, олон улсын терроризмын аюултай төрөл буюу хамгийн түгээмэл энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд улс орны хамтын ажиллагааны эрх зүйн үндсний бүрдүүлжээ.

Гэвч олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг, нисэх буудалд үйлдэгджэй буй хүч хэрэглэсэн явдлыг таслан зогсоо асуудал олон улсын эрх зүйн зохицуулалтгүй үйлдсэн учир 1971 оны Конвенцын олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүч хэрэглэсэн хууль бус үйлдлийг хориглох тухай нэмэлт протоколыг баталж, 1989 оны 8 дугаар сарын 6-ны өдөр хучин төгөлдөр болсон байна.

Нэмэлт протоколоор оролцогч улсууд олои улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүмүүсийн аюулгүй байдалд аюул занал учруулж буй, учруулж болзошгүй, нисэх буудлын аюулгүй ажиллагаанд саад учруулж буй хүч хэрэглэсэн хууль бус үйлдлүүд, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэхийн тулд тутуштай арга хэмжээ авахаар тогтжээ.

1977 оны “Олон улсын хамгаалалтад байdag хүмүүс түүний дотор дипломат төлөөлөгчийн зэрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэх тухай” конвенцод тогтоосон хэм хэмжээ, үндсэн зарчмын хүрээнд олон улсын алдай хядаа ажиллагаа үйлдэж буй этгээдэд ял шийтгэл ногоонд улж байх зарчмыг хангах, тэдгээртэй холбоотой зүйлүүд хамаарсан байна.

1949 оны Женевын конвенцууд болон 1977 онд баталсан Нэмэлт протокол баримтууд байдалд буй талууд олзлогдсон, далайд онгоцны сүйрэлд нэрвэгдсэн, шархадсан, эвчтэн зэргийн хүмүүст хандах хүмүүнлэг ёсны хэм хэмжээг тусгасан байна. Дээрх олон улсын акт баримтад тусгаж зааснаар хүн барьцаалах хүнд иоцтой гэмт хэрэг үйлдэхийг хориглосон байгаа нь чухал ач холбогдолтой юм.

1979 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Хүн барьцаанд авахын зэрэг олон улсын Конвенцод хүн барьцаалах гэмт хэргийн шинжийг анх удаа бие даасан гэмт хэрэгт тооцоохор тодорхойлж, ангилсан

бөгөөд ноцтой шинжийг нь харгалzan зохих шийтгэл ногдуулах зэргээр оролцогч улс орнууд үүрэг хүлээж, харилцан туслаадаа үзүүлэхээр тогтсон үндсэн баримт бичиг юм. Уг конвенцын дутагдалтай тал нь гэмт хэргийн субъектыг тодорхойлох асуудалд зөвхөн хувь хүн (этгээдүүд) гэж тодорхойлсон, зарим тохиолдолд хүн барьцаанд авах актыг зохион байгуулан гүйцэтгэхээр оролцож буй улс, засгийн УҮРэг ролийг тодорхойлоогүй явдал юм.

#### Ном зүй

1.Карпец И.И.Преступления международного характера. М., 1979.

2.СССР и международное сотрудничество в области прав человека. Документы и материалы МИД СССР. М., 1989.

3.Международное сотрудничество государств по борьбе с преступностью: Учебно-методическое пособие. М., 1982.

4.Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл. УБ., 2015.

5.Советский Ежегодник международного права. М., 1989.

6.Женевские конвенции о защите жертв войны. М., 1954.

7.Женевские конвенции 1949 года и Дополнительные протоколы к ним 1977 года; Европейская конвенция 1976 года.

8. Советский спорт. 1972.

9.ООН.Генеральная Ассамблея. 5-е заседание. Специальный комитет. 5 августа 1977.

---00---

## ЭРҮҮГИЙН ПРОЦЕСС ТУРГЭВЧИЛСЭН АЖИЛЛАГААНЫ МӨН ЧАНАРЫН ТАЛААРХ РОМЫН ЭРХ ЗҮЙН ҮНЭТ ЗҮЙЛС



УЕПГ-ын туслах прокурор,  
мониторингийн халтсийн дарга  
Б.Бат-Орших

### ТҮЛХҮҮР ҮГС:

Ромын эрх зүй, Ромын нэрг хуульчид, целинтийн процесс, Ромын эрх зүйн үнэт зүйлс, эрүүгийн процесс, тургэвчилсэн ажиллагаа, хялбаршуулсан ажиллагаа, дегисакийн, екстраординарийн процесс, инквизици процессы, эрх зүйн рецепции

### ТОВЧЛОЛ:

Дэлхий дахини бичмэл хууль тогтоомжийн түүх нь Ромын эрх зүйтээс эхлэлтэй бөгөөд эдүгээ хууль зүйн шинжлэх ухаанд нэвтрч хэрэглэгдэж буй ихэнх нэр томъёо нь латин хэллэг, ойлголтын утга, агуулгатай нийцдэг.

Ромын эрх зүйг ихэвчлэн иргэний эрх зүйн судлагдахуун талаас нь авч үзсээр ирсэн боловч ХХI зуун гарснаас хойш эрүүгийн эрх зүй, процессын эрх зүй талаас нь судлах, үнэт зүйлийн нь илрэхийлэх хандлага нэлээд түгээмэл илрэх болсон билээ. Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллээрээ эрүүгийн процессын тэр тусмаа хэргийг тургэвчлэн шийдвэрлэх ажиллагааны зарим арга хэлбэр, шинж, мөн чанарын талаарх Ромын хуульчид, нэрг

сэтгэгчдийн үзэл баримтлал, тэдгээрийн онолын үндэслэлийг судлан тодорхойлох оролдлого хийсэн ба Ромын эрх зүйн эх сурвалж, хууль тогтоомжид тухайн процессын зарим онцлогийг хэрхэн тусгаж байсныг харуулахыг зорив.

Түүчилэн Ромын эрх зүй дэх хууль зүйн латин хэлэг, иэр томъёоны эрүүгийн процесст холбогдох ойлголтын мөн чанар, агуулгыг тодорхойлж, Ромын эрх зүйн үнэт зүйлс болон талаас тайлбарлах явдлыг үндэслэл бүхий дүгнэлтийн хамт нэлрхийлэв.

### УДИРТГАЛ

Эрүүгийн процессын зорилго, зарчмын, мөн чанарыг авч үзэхийн өмнө тухайн процессын хэв маяг, тогтолцоо болон тэдгээрийн онолын суурь үзэл баримтлал хаанаас эхэлэлтэй ямар шалтгаан, шаардлагаар гарч ирснийг дурдах нь чухал ач холбогдолтой.

“...Эрүүгийн процесс нь тодорхой ўе шаттайгаар, хэлбэршүүлсэн журмын дагуу хэрэгжих зүй тогтолцойт чухамхуу Ромын эрх зүйгээс уламжлан авсан билээ...”<sup>1</sup>

Академич С.Нарангэрэл: “...Ромын эрх зүй нь эртний нэлээд хөгжингүй эрх зүйн тогтолцоо ...ийнгийн сонгодог эрх зүй.”<sup>2</sup> Гэж тэмдэлэсэн бол академич Ж.Амарсанаа “...МЭӨ II зууны эцсээр Квант Муций Сиевола гэдэг ирээдэгч Ромын эрх зүйн анхны томъёоллыг бүтээсэн. Ромын эрх зүй нь ... эрх зүйн албанаа салбар болон харьцуулсан эрх зүйг ойлгох цагаан толгой, хууль зүйн хэл, эрх зүйн сэтгэлгээний заах аргын оньсон

<sup>1</sup> Эрүүгийн процессын тулгамсан асуудлыг харьцуулсан судлах нь (хамтын бүтээл), Уб., 2018 он, б дахь тал.

<sup>2</sup> С.Нарангэрэл, Монголын эрх зүйн их толь бичигт IV хувьсаа, Уб., 2018 он, 356 дахь тал.

түлхүүр.”<sup>3</sup> гэж тодорхойлжээ.

Ромын эрх зүй судлаач, гадаадын цөөнгүй эрдэмтдийн үзэж байгаагаа бол “Ромын эрх зүй нь бичмэл төрөлжсөн хуулийн анхны үлгэр загварыг тодорхойлоход түүхэн үүрэг гүйцэтгэсэн ба иргэний хууль, материаллаг эрх зүйг бүтээх, хөгжүүлэхэд төдийгүй процессын эрх зүйн тогтолцоог бүрдүүлж төлөвшүүлэхэд шийдвэрэлж наелс үзүүлжээ.”<sup>4</sup>

Эрүүгийн процесс бол хууль зөрчсөн аливаа үйлдэл, үйл ажиллагаа гэмт хэрэг мөн эсэхийг шалган тогтооход чиглэгдсэн эрх зүйн үйл явц мөн тул энэ нь эрх зүйн хамгаалалтын нэг чухал бурзилжүүн хэсэг болдог. Нийгмийн харилцааг гэмт халдлагаас хамгаалах нь эрх зүйн изи чухал зорилго болохыг Ромын эрх зүйг бүтээгч, нэрт сэргэгчид тэмдэглэхийн сацуу угаасаа эрх зүй нь зөвхөн хэм кэмжээний байгаа байдлаараа мөн чанар нь хязгаарлаждахгүй түүнийг хэрэгжүүлэх, хэрэлгэх замаар агуулга нь тодорхойлогох учиртайт дурдсан нь цөөнгүй.

Ромын эрх зүйн сонгодог хөгжлийн оргил үед (МЭӨI-МЭНН зуун) тухайн тэр, нийгмэд үтгэгдэн хүлээн зөвшөөрөгджэг гарч ирсэй Ромын нэргт хуулийн<sup>5</sup> эрх зүйн зорилго, зарчим, мөн чанарын талаар хэлж тэмдэглэсэн зүйлүүд нь Институти, Дигест, Кодекс, Новеллы зэрэг хуулынислэл сурвалжууд төдийгүй өөрсдийн бүтээлд тодорхой тусгагдан нь бий.

Хэдийгээр Ромын эрх зүйн тогтолцоонд хувийн эрх зүй зонхилох байр суурьтай байсан боловч процессын эрх зүйн зорилго, зарчим, зохицуулалтын талаар багагүй өв соёл, уламжлалыг үлдээснийн үгүйсгэх аргагүй.

“...Эрх зүйн уг гарвал, мөн чанар нь зөв зохиистой шударга байх үйлийг дэмжиж, хамгаалах, харин зохицгүй шударга бус үйлийг хорилго, хязгаарлахад оршино.

<sup>3</sup> Д.Балсарайлан, Ромын эрх зүй, Уб., 2000 он, 7-8 дахь тал.

<sup>4</sup> Borkowski A and du Plessis Textbook on Roman law, Oxford 2005, Barry Nicholas An Introduction to Roman law, Oxford 2008.

<sup>5</sup> Ромын хуульчил - Jurista, Judicacum, Римские юристы, Lawyers of Roman Law – Ромын хуулын тайлбарлаг завлогог агаар таларх ярийг Ромын төрөөс итгэвшилгэсн эрх зүйн мэдэх, чадаар бүүний хүмүүс.

“Jus est norma Resti, et quicquid est contra portam Resti est injuria” гэсэн үзэл санааг Дигестийн I дүгээр дэвтрийн 1-д тодорхойлон дэлгэрүүлж бичсэн байна. Ер нь материаллаг болон процессын эрх зүйн аль алианд нь шударга зохиистой байх явдлыг буюут сайн үйлийн эрхэм дээд зориг эрмээлэл болохыг Цельз, Ульпиан, Павла нарын номдолд олонтоо тусгагдан байдгийт харж болно.

Жицээ нь Ромын нэргт хуулияа Павла: “...Сайн сайхан, чин шударга гэж үзэж буй тэр зүйл хэнд ашигтай, хэнд тустай байна, тэр бүхэн зохиистой, тэлгээрний нь хуулиар хорилго биш, харин хуулиар зөвшөөрөх ёстой.” Цельз нь “Шударга үйлийг шударга бусаас зааглан ялгахад хуулийн, эрхзүйн журам хэрээтэй...” гэж тэмдэглэжээ.<sup>6</sup>

Дигестийн I дүгээр дэвтрийн 10-р зүйл: “...Шүүх бол хэн бүхэнд хуулиар олгогдсон эрхийг зөв залдуулэх гэсэн байнгын хувиршгүй хүсэл зориг мөн ...Бусдад хохирол учруулахгүй, тухайн хүнд шууд хамарагдах зүйлийг тухайн хүнд нь харинцуулах...” тухай өгүүлжээ.<sup>7</sup> Энэ нь нэг талаас эрх зүйн харилцааны нэг субъект өөрийн харинцуагаа ухамсарлах, Үргүйнхээ дагуу бусдад хохирол учруулсан бол түүнийгээ харинцаа, нөгөө талаас бусдад хохирол учруулахгүйтэр шударга үйл хийх эрхийг нь шүүх хүлээн зөвшөөрөх гэсэн агуулга илрхийлэгдэж байна.

Ромын хуульчдын үзэл, сургаалд эрх зүй нь зохицуулах хорилго гэсэн зорилго, чиг үүргээс гадна хамгаалах нь түүний нэг салшгүй хэсэг мөн болохыг нэг бус удаа дурдсан нь бий. Хаана хамгаалалт тогтооно тэнд эрх зүй нь зорилгоо хангаж байдал. (Ibi jus ibi remedium). Энэ нь шүүхийн үйл хэрээт илүү тод тусгагдах ёстой гэж үзэх нь нийтлэг байв.<sup>8</sup>

Ромын сонгодог эрх зүйн хөгжлийн оргил үеийн нэргт төлөөлөгч Ульпиан

<sup>6</sup> Schulz F. Classical Roman Law, Oxford 1951, p 68-69.

<sup>7</sup> К.И.Батыр, Е.В.Поликарпова, Хрестоматия по всей общей истории государства и права, Том I. Юрист.М., 1996, с 133.

<sup>8</sup> З.М.Чермыловский. Лекции по Римскому Частному праву. М., 1991 с 71.

анх удаа “Хувийн эрх зүй ба ийтийн эрх зүй” (*Jus publicum, jus privatum*) гэж ангилсан байдаг. Тухайн цаг үедээ нийтийн эрх зүйт өнөөгийн ойлголт шиг яг нарийн тодорхойж чадаагүй, зөвхөн хувь хүний ашиг сонирхолтой холбоотой хуулиас ялгаатайгаар магистратын эрх мэдэл, терийн шашин шүтэгзээр зэрэг олон нийтэд хамааралтай хуульд хэрэглэх төдий байжээ.<sup>9</sup> Эрүүгийн эрх зүй нь иргэний эрх зүйтээс ялгарахгүй байсанас хулгай хийх, бусдыг зодох, бусдыг дээрэмдэх зэрэг хувь хүнтэй холбогдсон гэмт үйлийг иргэнний эрх зүйн үргийн эрхийн зөрчилд тооцож байлаа.

### ҮНДСЭН ХЭСГЭГ

Доминатын эзэнт улсын үесэс гэмт хэргийг хөнгөн хүнд гэж зааглах болсон ба янлангуяа хөнгөн хэргийг газар дээр нь иэт мөсөн шийдэх (“*Celerit ad processus*”), ингэхдээгээрчлэх этгээд тодорхой мэдгэдсэн, хэргээг хүлээсэн, хохирагч нь нэхэмжлэлээ гаргасан байхыг заавал шаардлаг айжээ.<sup>10</sup>

Түүнээс гадна “*Forum*” буюу хэрэг зарыг шийдэх талбай, газрыг урьдчилан зааж өгч, претор болон шүүхийн орлогцоотой шууд шийдвэрлэх процедурыг тогтоож байв.

Хуулийг төрөөс тогтоосон позитив хэм хэмжээ гэж ойлгох төсөөллийг ромын эрх зүйчид анхлан гаргаж ирсэн боловч мөн чанар, агуулгаараа эрх зүй нь жам ёсны шинжтэй, шударга ёс, тэгш эрх, эрх чөлөөт байдлыг хамтаалсан хамгийн зохистой хүсэл зориг, нийгэмд зөв зүйтэй, хохиролгүй, ал тустай бүхний хэмжүүр болж эрх зүй үйлчлэх учиртай гэж номлож ирсэн нь тутгээмэл. Жишээ нь Юлиан: “... Шударга байх жам ёсны эрх зүйн утга агуулгад харшилж байвал тэгж гарсан хуулийг бил дага мөрдөх албагүй, тэгж хэрэгжих уйлийг ч зөвшөөрх албагүй...” Гэж хэлсэн нь бий.<sup>11</sup>

<sup>9</sup> Петер Штайн, Европын түүхэн дэх Ромын эрх зүй /Орч. Янжкова/, УБ, 2016 он, 26 дахь тал.

<sup>10</sup> D.Dauble, *Forms of Roman law*, Oxford 1956, p 84-85.

<sup>11</sup> A. Watson, *The Spirit of Roman law*. G.A University of Georgia press, 1995, p 79.

Модестиний хэлсэн үгэнд “Хууль нь хоригийжсан сацуу зөвшөөрөх, хязгаарлахын сацуу дэмжих, шийдвэрлэхийн сацуу шийдвэрлэхээс татгалзах, яллахын сацуу эс яллах зорилго, үүргийг зөв тогтоож байх ёстой” гэсэн байдал.<sup>12</sup>

Марцианы бичсэнчилэн “..Хууль нь ухаант хүмүүсийн хэлэлцэж зөвшилцж гаргасан, нийтиг ашиг сонирхлоор тохиролцсон хэлэлцээрийн үр дун учраас түүнийг өөрчилж шинэчилж болохос гадна зөвчийн тохиролцсон бүхэл хэрэв хон нэгэндээ хохиролгүй бол түүнийг хуулиар зөвшөөрх хамгаалах ёстой.” гэжээ.<sup>13</sup>

МЭ II зууны үед Ромын хуулианд дунд Прокульяний болон Сабиняны хөөр дэг сургууль буюу ургал бий болсон байдал. Сабиняны үзл, баримтлалаар бол хуулийн логик болон утга учирыг орхиж байгаад ч болтугай хувь хүний хэрэг дээр тохирсон процессын шийдэл олохыг эрэлхийлж байсан ба хуулийн бичвэрдиг ижил утгатай, давхардсан, шуд холбогдолгүй гэх мэт хэт догматик заалт, нормд шууд автагдлыг эзэр хуулийн ерөнхий зарчмын, мөн чанарт нийцүүлж, тэдгээртэй уялдуулж, зарим хэрэг, маргааныг шийдэх боломжтой, эн бүхийг хуулиар угтгисгэж болохгүй гэж тайлбарлаж байжээ.<sup>14</sup> Энэ нь утгаа хуулийг төсөөтэй хэрэглэх, хэргийг хялбаршуулж шийдэх, шүүх прецедент тогтоог үндэслэлийг гаргах зэрэг үзл санааны анхны үр үндэс нь болж өгчээ. Харин Прокульян болохкоор хуулийн бичвэрт зассан норм, хэм хэмжээг яг үт, үсэгчлэн хатуу чанд ойлгож мөрдөх ёстой гэж үзсэн билээ.

Сабиняны дэг сургуулийн нэг төлөөлөгч Масуриус Сабиниус нь эд хөрөнгийн хулгай, бусдад гэмтэл хохирол учруулах, залилан мэлхэх, бусдын өмч хөрөнгийг эвдэж сүйтгэх, хүний өмч хөрөнгийг ашиглан завших зэрэг гэмт үйллийн буруу үйллүүдийг иргэнний эрх

<sup>12</sup> H.J.Wolff, *Roman law: An Historical Introduction*. Norman. Oklahoma, 1951, p 107.

<sup>13</sup> F.Schulz, *Classical Roman law*, Oxford, 1976, p 34.

<sup>14</sup> Петер Штайн, Европын түүхэн дэх Ромын эрх зүй /Орч. Янжкова/, УБ, 2016 он, 21-22 дахь тал.

түйн зөрчилтэй адилтгах нөхцөл, зарчмын дагуу тохиролцоо зөвшлилж шийдвэрлэх боломжийг хуулиар зөвшөөрөх ёстой гэж үзжээ байв.<sup>15</sup> Өөрөөр хэлбэр, хохирогч ба яллах тал нь нэхэмжилгэх ба хариуцагчийн байр сууриннаас хэрэгээ шийдвэрлүүлэх нь зүйтэй гэдэг үзэл бодлоготой байжээ.

Ромын эрх зүйд эрүүгийн процессын арга хэлбэр, зохицуулалтын онцлогийн талаар харьцангуй бага өв үлдсэн боловч тухайн процессын агуултуг тодорхойлоход ач холбогдол бүхий зарчмын шинжлэтийг томъёолол болон уг үйл явцын үе шатыг гарган илэрхийлсэн зүйл цөөнгүй байсан нь түүхэнд үлджээ. Юуны өмнө эрүүгийн процессын түүхэн хөгжилд хүчтэй нөлөөлсөн зарим зарчмын агуулга бүхий томъёолыг Ромын эрх зүйчийн тодорхойлсон байдлаар тоймлон илэрхийлбэл:

- “*Consensus facit jus*” – Зөвшин тохиролцсон бүхэн эрх зүйт бий болгоно.

(Хэлэлцэж тохирсон л бол тэрхүү процесс нь эрх зүйт нийцсэн, хуулиар хориглоогүй, хуулиар зөвшөөрөгжсөн байх ёстой)

- “*Pro et contra*” – Эсвэл тийм, эсвэл угүй. Зөвшөөрөн, эсвэл татгадзана.

(Эсвэл шиййтэнэ, эсвэл шийтгэхгүй)

- “*Consuetudo est altera lex*” – Хэвшиж тогтсон заншил, зан үйл бүхэн эрх зүйн хамгийн оновчтой зохицуулалт

(Хэвшигүүлж уламжлал болгон тогтоосон бүхнийг хуулиар зөвшөөрөх ёстой)

- “*Consuetudo neque injuria oriti, neque tolli potest*” – Уламжлагдаж тогтсон ёс журам, зан заншил нь элдэв буруу зуришлыг эндэх замаар үүсч тогтдог

(Хуулиар шууд зохицуулах боломжгүй зарим хэрэг тохиолдлыг ёс заншилны болон жишгийн журмаар тогтоог боломжтой)

- “*In dubio pro*” – Эргэлзээтэй үед яллагдагчийн талд ашигтайгаар шийдвэрлэх

(Шалгасан боловч нотлогдохгүй бол яласа чөлөөлөх ба ялыг хөнгөрүүлнэ.)

- “*Poena pytius molliendaes quam exasperanda sunt*” – Ял нь цээрлүүлэх залжаахад биш, харин зайлшгүй шаардлагад орших ба гэмт зан үйлийг номхтон намдаах, зөвтөн төловшүүлэхэд чиглэгдэнэ.

(Ял нь зөвхөн хорх, цаазлахаас илүү эзээс олсон одон сонголттой, үр дүнтэй байх ёстой)

- “*Scientia utrinque par pares contrahentes facit*” – Сэргэлдэн маргалдагч нэг тал нь негээ талынхаа байранд өөрийтөө тавьж, эсрэг талынхаа хүсэл зориг ашиг сонирхлын ойлгож мэдэх нь зөвшилцэн тохиролцоо процесст хүргэнэ.

(Тохиролцоо, зөвшлилж замаар тэрээ хэлцэл хийхэд юуны өмнө тухайн харилцаанд оролцогч талууд харилцан биеийнхээ хүсэл, санаа зорилгыг урьдчилан мэдэж, ойлголцын тухайн процессын үндсэн нөхцөл)

- “*Contracta sunt servanta*” – Нэгэнт хэлэлцэж тохирсон л бол шууд биелүүл

- “*Qui non negat fatetur*” – Хэн үгүйсгэж чадахгүй байна, тэр зөвшөөрөн гэсэн үг

- “*Contractus legem ex conventione accipiunt*” – Гэрээ, хэлшийн эрх зүйн үндэслэл нь зөвшилцэн

(Зөвшилцэн л бол гэрээ, зөвшилцэж чадаагүй бол гэрээ биш)

- “*Contractus ex turpi cause, vel contra bonos moros nullus est*” – Хэрэв нэг тал нь өөрийн хүсэл зоригтой тулган дур зоргоороо буюу ёс зүйг зөрчиж гэрээ, хэлшигийг хийхэд хүрвэл тэр бол эрх зүйд харш бөгөөд юу ч биш юм.

(Гэрээ, хэлцэй бол талуудын хүсэл зоригийн тэнцвэртгэй, адил тэгш байдлын илэрхийлэл байх ёстой)

- “*Contra veritatem lex nonquam aliquid permitit*” – Шударга бус ямар ч үйлдлийг хуулиар зөвшөөрч болохгүй

(Шударга, зүй ёсны зүйлийг хуулиар зөвшөөрөх ёстой)

<sup>15</sup> В.А.Савильев, Римское частное право М., 1995, с.97.

Дээр дурдсан латин хэл дээрх эрх зүйн томъёолол, тэдгээрийн угийн утта болон агууллын тайлбарууд нь Ромын эрх зүйн эх сурвалжкууд болон бүтээлүүдэд цөөнгүй тусгагдах ирсн<sup>16</sup> байх бөгөөд эрүүгийн процесст одоо ч түгээмэл хэрэглэгддэг "Шүүгч" (Judge), "Өмгөөлөгч" (Attornati), "Гэмт хэрэг" (Crimen), "Мөрдөн байцаалт" (Inquistio adere), "Гомдол" (Actio), "Хохирогч" (Victima), "Хэргийн тохиолдол" (Casus), "Хууль" (Lex, Lege, Codex), "Шүүх хуралдаан" (In iudem), "Мөрдөн байцаагч" (quaester), "Хэргийн нөхцөл байдал" (Factum), "Гэрч" (Tescice), "Шүүхийн өмнөх шат" (In iure), "шүүхийн шат" (In iudicem), "Шүүхийн байцаалт" (comportotium), "Барьцаа" (Pignoraitia), "Зөвшиндөх" (Consensuism), , "Шүүхийн онцгой байцаан шийтгэх ажиллагаа" (Extra ordinem cognitionis), "Түргэвчилсэн процесс ажиллагаа" (Centrale agere processus) гэх мэт иэр томъёо. нь тэдээр ойлголтыг анхлан бий болж тайлбарласан гэлгээрээ танин мэдэхүүн чухал ач холбогдолтой юм.

Латин нэр томъёо, латин хууль зүйн хэллэгүүд нь иэг талаас ялангуяа эрүүгийн процесс дахь тулгуур ойлголтыг сонгодог агуулгаар нь танин мэдх, хэрэглэх талаасаа ач холбогдолтой төдийгүй өнөө хир идэвхтэй хэрэллэгдэж байгаа учраас тэдгээрийн мөн чанарыг гүнзгий судлах, эрх зүйн суурь зарчмуудыг ойлгох, хэрэглэхд онолын чухал үндэслэл болсоор байна. МЭӨ 451-450 онд бичигдэж гарсан Ромын эрх зүйн анхны түүхэн эх сурвалж болох "12 таблицын хууль (The twelve tables)-ийн 1 дүгээр хүснэгтийн 6, 7 дугаар зүйлд эрүүгийн процессын түргэвчилж шийдвэрлэхтэй холбоотой чухал заалт тусгагсан байдаг.

Энэ хуулийн 1 дүгээр таблицын 6-р зүйлд: "When the parties agree on the matter the magistrate shall announce it". "Процесст оролцогч талууд чухам юун

дээр тохиолцоонд хүрсн байна, чухамхүү түүнийгээ л заргаа мэдүүлэх шуух хурал дээр ижээмжлэг" гэсн нь бий.<sup>17</sup> Уг хуулийн 7 дугаар зүйл: "Хэрэв заргалдагч талууд тохиолцсон зөвшилцөөнд хүрч чадахгүй бол ут заргыг шийдвэрлжийн тулд форум болон комициун дээр үд лундаас өмнө цуглараг. Ингэд оролцогч талууд эзлэжээрөөрсдийн хэрэгтийн хамгаалаг" гэж бичигдээж. Хэдийгээр энэхүү заалт нь хувийн эрх зүйл шууд хамааралтай мэт боловч тухайн түүхэн шаг үед хүнд биш хэргийн ихэнх нь иргэний эрх зүйн хэрэг, маргааныг шийдвэрлэх нөхцөл, зарчмын арга хэлбэртэй адил төстэйгээр шийдвэрлэгдэж байсан тэр эрүүгийн процесст хамааралгүй гэж угтыгэх аргагүй юм.

Түүнчлэн Ромын 12 хүснэгтийн хуулийн 8 дугаар хүснэгтийн 2 дугаар зүйл: "Хэрэв хэн нэгэн этгээд бусдын эд эрхтэнг эмчэж эрэмдэг болгочижоод хохирогчтой эвлээржүй бол түүнийт өөрийн нь мөн адил эрэмдэг болго" гэж дурдажээ. Хэдийгээр яллах процессын "Taleonis" системийн зарчмын илт туслаалаа олон гэж харх болок боловч эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээд ямар ч тохиолдолд хохирогчтой зөвшин тохиолцоо, эвлэрэн хэлэлцэж шаардлагатай гэсэн санаа агуулагдаж байна. Үүнээс гадна хэллэлэн зөвшинцүүлэх процесст гэрчийг хөндлөнгөөс оролцуулах болон түүний хариушлагын тухай заасан нь анхаарал татах байна. Тухайлбал хүснэгтийн хуулийн 8-р хүснэгтийн 22-р зүйлд "Хэрэв хэн нэгэн хүн хэлэлцээ хийжэд гэрч буюу жинийгээр оролцсон мөртлөө дараа нь түүнийгээ гэрчлэхээс татгалзваал тэрээр шударга ёсноос гажсанд тооцогдох, гэрч байх эрхээ алдаг" гэжээ.<sup>18</sup>

Ромын эрх зүйн сонгодог болон түүний дараах хөгжлийн үед эрүүгийн процессын зорилго, агуулга, үе шатыг тодорхойлох оролдлого хийдэж байсанас гадна эрүүгийн процессын зөвшилцлийн зарим шинж, арга хэлбэрийн талаар эрх

<sup>16</sup> O.F.Robinson. The Sources of Roman law. London. 1997, Хрестоматия по всеобщей истории государства и права. Том 1, Древний Рим. N., 1996, D.Johnston The Roman legislation Oxford. 1988. "Хууль зүйн нормын судалгаа, хэрэгж" сэдэвт улсын хэмжээний эрэлт шинжилгээний хурлын эмзэгтийн, Уб., 2015 он, 107 дахь тал.

<sup>17</sup> E.H.Wurtington, Remains of old latin III. Circa 450 B.C Roman law. W.1978. p.71.Х.Сэлэнг, Ромын эрх зүйл.(12 хүснэгтийн хууль), Уб., 2019 он, 126 дахь тал.

<sup>18</sup> X.Сэлэнг, Ромын эрх зүйл.(12 хүснэгтийн хууль), Уб., 2019 он, 134 дахь тал.

зүйн үндэслэлийг тусгасан нь хожмын түүхэнд Ром-Германы эрх зүйн төдийгүй Франц, Орос болон Англи-Америкийн эрх зүйн бүлийн орнуудад анхны үлгэр загвар болсон ба үзэл баримтлалын хувьд анхны үзэл, төсөөллийг бий болгоход чухал түлхэц үзүүлжээ.

Доктор, профессор Д. Баатархайхан бичихдээ: "...Ромын сонгодог эрх зүйн хөгжлийн эхэн үед эрүүгийн процесс нь иргэний процесстой хамтдаа түүнээс бүрэн ялгарж гарваагүй түүхэн цаг үед шүүхийн процессын нэгдэлмэл тогтолцооноос улбаалж, хэдийгээр эхэн дунд үедээ голчлон иргэний хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэжээ илүү хамааралтай байсан боловч цаашдын хөгжлийн явцад зөрчлөөс зарим гэмт хэрэг ялгаран гарсан буюу нийтийн эрх зүйн зөрчлийн дийлийн нь төрийн эсрэг гэмт хэрэгт тооцогдох болсон эргээс үүдэн эрүүгийн процессын түүх 4 уе шатыг дамжин хөгжсон.

I үе шат: *Legis actio adere processus* (Легисакции процесс).

II үе шат: *Formulas adere processus* (Формулир процесс),

III үе шат: *Extra ordinem cognito processus* (Экстра ординарни процесс),

IV үе шат: *Inquisitio adere processus* (Инквизицији процесс) гэж ангилна..." гэж лурласаа ба үе шат бүрний онцлог, мөн чанарыг ялган тайлбарласан байна.<sup>19</sup> Оросын судлаач, профессор А.И.Косрев дээрх 4 үе шатыг эрүүгийн процесст хамааралтайг тэмдэглэсэн ба Легисакции процесс нь мээлжлэшний агуулыг илрэхийлж байсан тухай өгүүлжээ. Тэрээр элгээр 4 хэс магац хожмын түүхэн дэх Ром-Германы болон Англо-Саксоны эрх зүйн бүлийн шүүхийн процесс хөгжин тэлэвшигэд нөлөөлсний эрх зүйн рецепшийн мөн чанартай холбон авч үзжээ.<sup>20</sup>

Ромын эрх зүйн судлаач, доктор, профессор Х.Сэлэнгэ 2019 онд хэвлүүлсэн

<sup>19</sup> Д.Баатархайхан, Эрүүгийн процессын эрх түй /Ерөнхий вийш/, №6, 2014 он, 15-16 дахь тал.

<sup>20</sup> А.И.Косрев, Римское частное право. ЮниТи. М., 1998, с 193-199, с 245-249.

"Ромын эрх зүй: Нийтийн болон хувийн эрх зүй, процесс" номын б 2 дахь хэсэгт эрүүгийн процессын асуудлыг тухайлан ялган авч үзэж бичжээ. Тэрээр: "...МЭӨ II зунаас өмнө эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тусгай журам байгаагүй... Магистрат эрүүгийн хэргийг мөрдэн шалгаад өөрийн үзэмжээр шийдвэрлэж байсан... Харин ах дүү Грактын шинтгэлээр шүүхийн байнгын комисс (5 хүнтэй) байгуулсан ба энэ комисс байцаан шийтгэх ажиллагаа явуулж байсан тухай дурдажээ.<sup>21</sup> Түүчлэн, эрүүгийн процессын хэлбэрүүд нэлээд онцлогтой байсныг 5 үндсийн хэлбэрээр тухайлан тодруулж авч үзэн байна. Үүнд:

1) Магистратын процесс: ...Цэргийн гэмт хэрэг, гадаад иргэн, болоны үйлдэсн гэмт хэргийг Эдил буюу магистратын түшмэл дангаараа хянан шийддэг.

2) Ардын хурлын процесс: Ихэнхдээ цаазын ялтай онц хунд гэмт хэрэг болон давж заалдах хэргийг магистратын бүрэлдэхүүнтэйгээр шийддэг.

3) Хувийн зөрчлийн шинжтэй хэргийн процесс: Претор дангаараа шийдэх ба иргэний процессоос ялгагдаж байсангүй.

4) Тангарагтны шүүхийн процесс: Шүүхийн магистрат, преторийн бүрэлдхүүн бүхий хурлаас албан тушаалын болон нийтийн ашиг сонирхлын эсрэг хунд гэмт хэргийг хянан шийддэг.

5) Нутгийн захирагааны шүүхийн процесс: Мужийн магистрат өөрийн эрх мэдлийн хүрээнд хамаарах хэргийг (жижиг, ердийн) хянан шийдвэрлэж байсан тухай биччээ.<sup>22</sup>

Монгол, Орос хэл дээр гарсан Ромын эрх зүйн судалгааны голлох бүтээлүүдийг нарийчилан харьцуулж судлаж үзэжээ нийхнэдээ мөрдэн байцаалтын болон шүүхийн процесс бүрэн ялгарч чадаагүйг дээр иргэний хэрэг, эрүүгийн хэргийг нэлээд тохнолдолд өнөөгийн түвшинд

<sup>21</sup> Х.Сагниг, Ромын тэр түй (12 хүчинчтэйн хууль). УБ., 2019 он, 61 дахь тал.

<sup>22</sup> Мон гэнд, 62 дахь тал.

оилгогод шиг бүрэн ялгаж зааглах хандлага бий болоогүй байжээ.<sup>23</sup>

Энэхүү тухайн үеийн өвөрмөц онцлог байдлаас үзүүл хувь хүний үйлдсэн зарим гэмт хэргийг хянан шийдвэрлэх процесс нь үндсэндээ иргэний процессын нөхцөл, үе шаттад адиин төсөөтэй хэрэглэгдэх байжээ.

Судлаачдын үзэж байгаагаар иргэний процессоор эрүүтийн зарим хэргийт шийдэхээс өөр аргагүй байдал нь тэрхүү хувь хүний эсрэг гэмт хэрэг (criminal privata) нь хохирог ба хариуцагч буруутны хооронд хохирол, төлбөр, гэмтэл, үр дагаврыг арилгаж болохоор тохиорлох боломжтой гэж үзэж байсанд оршино.<sup>24</sup> Хувь хүний эсрэг гэмт хэргийн төрлүүдэд:

- Хулгайн гэмт хэрэг;
- Дээрмийн гэмт хэрэг;
- Залилан;
- Бусад хүний биед гэмтэл учруулах

гэх мэт.

Доктор, профессор Д.Баярсайхан "...Хувь хүний эсрэг гэмт хэрэг нь Ромын эрх зүйд хоёрдмолов шинжтэй байсан. Эрүү, иргэний эрх зүйн алт алниаар нь зохицуудагджад байсантай холбоотой..." гэж бичижээ.<sup>25</sup> Ромын эрх зүй дэх эрүү, иргэний процесс нь ихэнхдээ нэгдмэл ўйл явцыг илрхийлж байсан боловч хүнд иштэй зарим хэргийт (хүн алах, галдан шатаах, бослого уймын гарах, төрийн эсрэг хуйвалдаан гэх мэт) эрүүтийн процессын тусгай нөхцөл, журмаар хянан шийдвэрлэх байв.

Доктор Х.Сэлэнгийн тэмдэглэснээр "...Сонгуулийн хаант засгийн үед эзэн хаан өөрөө биечлэн зарим гэмт хэргийг бие даан шийдвэрлэх болсон. Үүнийг онцгой хянан шийдвэрлэх ажиллагаа гэдэг." гэж дурдсан ба Ромын эрүүгийн процесст эрүүдэн шүүлтийг хэрэглэх байсан тухай өгүүлжээ.<sup>26</sup>

<sup>23</sup> Д.Баярсайхан, Ромын эрх зүй, Уб., 2000 он, Х.Слониг, Ромын эрх зүй, Уб., 2001 он В.А.Савельев Римское частное право М., 1995, А.И.Косарев Римское частное право М., 1998.

<sup>24</sup> R.C.Gbenegan, An Historical Introduction to Private law Cambridge University Press, 1992, p 106.

<sup>25</sup> Д.Баярсайхан, Ромын эрх зүй, Уб., 2000 он, 83 дахь тал.

<sup>26</sup> Х.Сэлэнгиг, Ромын эрх зүй, Уб., 2001 он, 62 дахь тал.

"*Legis actio ader process*"-ийн тухайд авч үзвэл хохирогч-нэхэмжлэгчийн гомдол, шаардлагаар нэхэмжлэгч ба хариуцагчийн хооронд маргаан, мэгтгэлээн үүсгэхийн хүлээн зөвшөөрч, магистрат дээр баталгаажуулж үндэслэл, нотлох баримтыг мэгтэлцүүлэн шалгаж үнзлэх замаар хянан шийдвэрлэж байснаараа онцлог томаа. Энэ ажиллагаа нь *In iure ba II iudicem* гэсэн хөөр үечилгэлтэйгээр явагддат. Энийн үечилгээр (*In iure* нэхэмжлэгч буюу хохирогч тухийн хэргийн талбар үндэслэл, баримтаа нотлох замаар буруутан буюу хариуцагчтай мэгтэлэлж, претор болон шүүхийн ордооцоо үйгээр хэргийг шийдвэрлэх нөхцөлүүдийг тохиирно. Ингээдээ преторийн ажиллан зохицуулагчар байгуулах бөгөөд шүүхийн эсийн шийдвэртэл талууд асуудлыг шийдвэрлүүлж хүснэгтэй байгаагаа илрхийлж андгай тайгаралг тавих, эд юмс барьцаалах зэрэгээр уг процесст оролцно.<sup>27</sup>

*In iudicem* буюу II үечилэлд шүүхийлж ажиллагаа хамаарах талуудын хүснэгт гаргаснаас хойш 30 хоногийн дотор явагдах журам. Шүүх хурлыг товлосон өөр нь хийж, талуудын тайлбарыг сонсож, засгийж, хэлэлцэн нотлох барынгыг нягтлан үнзэж, шүүх эсийн шийдвэрлийг гаргасан. Энэхүү шийдвэр гармагчад эсийн шийдвэр болох ба давж заалдах, шийдвэрлийг өөрчлөх тухай ойлголт байхгүй.

"*Per formulas adere process*"-ийн хувьд өмнөх легисакацийн процессын зарим шинжтэй төстэй боловч хөөр үечилэлтэй явагдах зааглалттай. Эхлээд претор нь хохирогчийн буюу нэхэмжлэгчийн гомдол, шаардлагыг хүлээн авч хууль зүйн үндэслэл, нотлох баримтыг хянан шалгайд ажт буюу formula гаргана. Формулярийн акт гаргахын өмнө талуудыг дуудаж, мэдүүлгийг нь гаргуулж тайлбарын сондог. Тухайн преторын үйлдсэн формулярийн акт нь "Intentio, exceptio, conditatio, demonstratio, adiudicatio" гэсэн нөхцөл бүхий хэсгүүдтэй байх тухай дурдажээ.<sup>28</sup>

<sup>27</sup> Д.Баярсайхан, Ромын эрх зүй, Уб., 2000 он, 150 дахь тал.

<sup>28</sup> Институции Гал. Книга 4. 4.39. Хрестоматия по всеобщей истории со государства и дрода том1. Юристы М., 1996, с 122.

Хэдийгээр иргэний хэргийн маргаанд хамааралтай боловч өмчийн хулгай, хувь хүний үйлдсэн хүнд биш гэмт хэргийг шийдэхэд тухайн процессын зарчим, нехцел, онцлогийг харгалзаж байсан.<sup>29</sup>

Ялангуяа хохирогчийн төдийгүй карнузагч этгээдийн үндэслэл бүхий эсэргүүшийн агуулыг (excerptio) тусгахын хамт хэргийг шүүхэд шилжүүлэхэд тухайн хэргийг хэрхэн шийдвэрлэх тухай зааварчилга бүхий саналыг өгч байсныг (comdefinatio) дурдах нь зүйтэй. Формуляри процессын хоёр дахь үеийлдэл шүүх хэргийг хүлээж аваад преторийн формула буюу акттай танилцаж, тухайн хэргийн материалын хүрээнд хэлэлцүүдэж шийдвэрлэн.

Ромын эзэнт улсын үед өмнөх үеийн процессын училзлийг алга болгох, эзэн хааны ашиг сонирхол, бодлогод нийцүүлж хэргийг шүүгч нар өөрсдөө үүсгэн, шалгаж, эзийн шийдвэрийг өөрсдөө гаргаж байв (Extra ordinem).

Түүнчлэн шүүхийн бус журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны хэлбэрүүд (Interdictio, cognitio) нэвтрэч байнаас гадна эрүүгийн хэрэг, иргэний хэргийг эрс зааглах шаардлага бил болсонтой холбоотойгоор Inquisitio adere processus буюу Инквизици процессын хэлбэр анхлан гарын ирсний тэмдэглэх хэрэгтэй. Энэ үес эрүүгийн процесс иргэний процессоос зааглагдан ялгарах болсон ба өмнөх үед хохирогчийн хүсээн зориг, ашиг сонирхолд үзүүлж нийцүүлж, нэхэмжлэгчийн гомдлоор хэргийг үсгэж, мэтгэлцүүлсэн байлаараа шийддэг байсныг өөрчилж, мөрдөн байцаалтыг шүүхийн санаачилгатайгаар томилогдсон эрх бүхий түшмэл квестр (quivestrus) хэрэгжүүлэх ба яллагдагч, гэрч болон бичиг баримтын нотолого зэргийг зайлшгүй харгалзан шалгадаг болсон.<sup>30</sup>

Мөрхөн байцаалт ба шүүхийн гэсэн нарийн заагласан үе шат байхгүй боловч уг ажиллагааны чиг үүргээ нь ялгагдах байсан байна. Квесстрийн мөрдэж дуусгасан хэргэгт

шүүх тусдаа процесс явуулж, хэргийг эзслэн шийддэг болсон ажээ.

“... Инквизици бол тухайн цаг үед (эдүгээс 1900 шахам жилийн өмнө) эрүүгийн процессын бүрдлийн сүүлчийн хэлбрэшил болж гарч иржээд тэр үеийн зорилго, зорилт мён чайар нь XIX зуунь дунд үесэ Баруун Европт хэвшин төлөвшүүсэн инквизицийн системийн агуулга, зарчмытай тэр бүр тохирдоггүй. Гэхдээ ерөнхий, тулгуур зарчим, үзэл баримтлалын үүдээс авч үзвэл орчин цагийн эх газрын тогтолцообын эрүүгийн процессын үр хөврөл, үндэс нь болсон...”<sup>31</sup> гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй юм.

Ромын хууль зүйн латин хэллэгт “Cententes” гэдэг нь “шүүд хүргэх, хурдтайгаар тэмүүлэх” гэсэн утгатай ба “Centent adere processus” гэх ойлголтыг Ромын эрх зүйчид (Сабиннус, Юлиус) үзэл төсөөллийн түвшинд дэвшиүүлж байсан нь онол-гносеологи талаасаа танин мэдхүйн ач холбогдолтой юм. Ромын эрх зүйн бүхий л түүхэнд эрх зүйн процессын хэргэлзэнд сэжилтэн этгээд бусад илчилгэн хэргээ шууд хүлээх, эсхүл өөрөө өөрийгөө илчилэн гэм буруутгаа хүлээн зөвшөөрсөн нэхцэлд иżn даруй буюу газар дээр нь хойшшууллахгүй шийдэх гэсэн агуулыг илрхинийдэг байжээ. Тухайн түүхэн цаг үед уг процесс хэдийгээр өргөн тархсан хэлбэрээр хэвшээгүй боловч уг ажиллагааны хуульлагдсан процедурын хэв маягийг анхлан тогтоож туршсан түүхэн ач холбогдолтой билээ.

Судалгааны ажлын зарим үр дүнг тоймлон дүгнэвэл:

1) Ромын эрх зүй бол матерналлаг иргэний эрх зүйгээр хязгаарлагдахгүй, эрүүгийн процессын зорилго, зарчим, болон түргэвчилсэн буюу зөвшин тохиролцоо замаар шийдвэрлэх ажиллагааны анхны үзэл төсөөлөл, эрх зүйн зохицуулалтын хэв маягийг анхлан тогтоох байнаараа онол, практикийн үзэлж баршгүй ач холбогдолтой. Энэ нь эрүүгийн процессын эрх зүй чухал өв улдаж, үзт зүйлэ болж,

<sup>29</sup> Н.А. Покровский История римского права М., 1918, с 91.

<sup>30</sup> A. Jolowicz. Historical Introduction into the study of Roman Law W., 1965, p 81-82.

<sup>31</sup> Д.Баярсайхан, Эрүүгийн процессын эрх зүй, Ерөнхий вигн., Уб., 2014 он, 172 дахь тал.

цаашнд байнга судлагдааэр байх болно.

2) Ромын эрх зүйн хөгжлийн эжэн, дунд, сонгодог хөгжлийн ихэнх цаг үед эрүүгийн хэрэг, иргэний хөгжийг хамтад нь нэгдмэл нэг процессын эрх зүйн тогтолцоонд оруулж, хуулычлан зохицуулж байсан нь анхаарал татсаар байна. Эрүүгийн хүнд биш, жижиг хэрэг, тэр тусмаа ёмчийн хулгай дээрэм, заплан, хувь хүний бие, эрхтэнг гэмтээх зэрэг гэмт үйлдлийг гол төлөв иргэний процессын нөхцөл, зарчмын дагуу эхлээд тохиролцох, эвлэрэх, зөвшилцэх зэрэгээр шийдвэрлэж байсан нь эрүүгийн процессын хөгжилд шийдвэрлэх нөлөө үзүүлжээ.

3) Эрүүгийн хөгжийг түргэвчилсэн буюу хялбаршуулсан журмаар шийдвэрлэх ажиллагааны онолын болон эрх зүйн анхны үндэслэл нь Ромын эрх зүйтээс эхлэлтэй гэж үзж байна.

4) Эрүүгийн процессын хөгжийг түргэвчлэн шийдвэрлэх ажиллагааны зарим арга хэлбэр, шинж, мөн чанарын талаарх Ромын хуулычнд нэрт сэтгэгчдийн

үзэл баримтлал, тэдгээрийн онолын үндэслэлнийг нарийвчлан судалж, шинжлэх нь онол практикийн чухал ач холбогдолтой байна.

5) Ромын эрх зүйн нүүчин, эрүүгийн процессыг үзэл зүйлсийг Герман, Франц, АНУ, Англи, Австраи, Швейцарь, Орос зэрэг өндөр хөгжилтэй улс орнууд хэрхэн хүлээн авч, эрх зүйн рецепцийн түвшинд судлан хөгжүүлэх улс орнууд хэрхэн хүлээн авч үзж онол, баримтлал, хандлагаа өөрчлөн шинэчлэх шаардлагаа өсөн ишмэгдсээр байна.

Цаашдаа Ромын эрх зүйн өв уламжлалыг гүнзгайруулж судлах, тэр тусмаа Ромын иргэн, эрүүгийн процессын үзэл зүйлсийг Герман, Франц, АНУ, Англи, Австраи, Швейцарь, Орос зэрэг өндөр хөгжилтэй улс орнууд хэрхэн хүлээн авч, эрх зүйн рецепцийн түвшинд судлан хөгжүүлэх ярсныг зайлшгүй авч үзж онол, баримтлал, хандлагаа өөрчлөн шинэчлэх шаардлагаа өсөн нэмэгдсээр байна.

---00---

## СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООГ ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ



МУИС-ийн ХЭС-ийн доктор.....  
С.Номынбаясгалан

### I. Оршил

Сонгуулийн тогтолцооны хэрэгжилтийн үйл явцад тухайн улс орны засаглал, засаглалын хэлбэр чухал учир холбогдолтой. Гүн ухааны сэргэлээрний сонгодог сударт засаглахуй хэмээхүйн утрыг “Засаглалаар хөтөлж, хууль цаазваар цэгцэвээс эзлэг ард гэм ял үйлдээс зайлсхийх боловч гэмшигийн сэргэлэл эс термүй. Ес сургаараа хөтөлж, ёслолоор цэгцэвээс эзлэг ардал гэмшигийн ичинигүйрэхүйн сэргэл төрөх төдийгүй, эрхшиб эрхшээн дагамуй.” хэмээн тэмдэглэсэн байна.<sup>1</sup> Нийтийн эзгэх хариушлагын (Social accountability) үүдиэс засаглалыг “шийдвэр гарах болон шийдвэрийг хэрэгжүүлэх үйл явц” хэмээн тодорхойлох нь бий (UN, 2017).<sup>2</sup> Энэ ч үүдиэс улс орны хэрэгт бүх түвшинд улгардахыг засаглал гэж томъёолж болох юм.

Тэгвэл академич С.Нарангэрэл өөрийн бүтээлдээ “Чингис хайн ердөө л хоёр сонгуулийн хугацаанд төрийн эрх барсысан бол хийж бүтээснээс чухам юут нь амжуулах байсан бол. Агуу их үйл хэрэг бүтээхийн тулд хүмүүн өөрийгөө зээн хэмээн мэдрэн наасаараа хүчин зүтгэдэг жамтай ажгуу. Эрхэмбэрт бүхэл бүтэн амьдралаа зориулсан ч багадна. Баруунхыны ардчиллыг дууриасан монгол төрийн залгамж чанар алдагдаж, сонгуулийн эрх мэдэлэр дамжуулан менгэ, эл хөрөнгө олох гэсэн хоноши сэргэлгээтийг хүмүүсээр дүүрэн төр дамжуурахад хүрч байна.” гэж шүүмжлэн бичсэн байх нь бий.<sup>3</sup>

Ардчилсан төр – улс сонгуулиар байгуулагддаг. Ард түмнээс сонгогдон байгуулсан байгууллагад хүлээлгээн эрх мэдэл нэг талаас сонгуулийн утга учирь тодорхойлдог.<sup>4</sup> Сонгуулийн ардчилсан шинж чанар, нийгэм – улс төрийн үр өгөөж, гүйцэтгэх үүрэг нь түүнийг зохицуулан тодорхойлох эрх зүйн зохицуулалтаас багагүй шалтгаална. Эрх зүйн зохицуулалтын улс төрийн агуулга, утга учир нь нийгмийн ямар булгийн, эсхүл улс төрийн ямар хүчиний төлөөлгчийт хэнээр, хэрхэн, яж сонгуулат вэ, түүнийг яж хуульчлаа баталгаажуулах вэ гэдэгт оршино. Төрийн засаглалын эрх мэдэл ард түмнүүдийн байж ард түмнээс эх үүсэлтэй байдгийн хувьд сонгууль нь мөн ард оны хүсэл зориг, эрх ашгийн илрхийлэл, хэрэгжилт байх ёстой гэж

<sup>1</sup> Күнн, Шүүгчилгээнийгүйз, (Орууласан: Чимшидэл М.), УБ., 2004 он, 27 дахь тал.

<sup>2</sup> Энэ тодорхойлолт “шийдвэр нь зөв” байх гэхээстэй илүү шийдвэр гаргах, хэрэгжүүлэх үйл явц боломжтой хэмжээнд салж бийгээг түүлчилж гэхэг агуулгаар, мөрөр хубилга, шийдвэр гаргах үйл явц нь зөв байх гээж тайлбарласан гүйцүүлж. Гүмснэгчтэй Т., нар. Нийгмийн эзгэх хариушлагын үндсэн ойлголт, (Гарын албаны 1), УБ., 2017 он, 33-34 дахь тал.

<sup>3</sup> Нарангурда С., Хуулийн амин сүнс буюу Чингис хайн монголчууд, (Измэс засварласан гурав дахь хувь), УБ., 2018 он, 142 дахь тал.

<sup>4</sup> Эндрю Рейнольдс, Бин Райли, Эндрю Эланс, Сонгуулийн тогтолцооны бүтээх зорилсон байгуулалт // Electoral System Design: The New International IDEA Handbook, (Орууласан: Батбаяр Г.), УБ., 2010 он, 14 дахь тал <http://forum.mn/forum/2019/ElectoralSystem.pdf?fbclid=IwAR0B72O-yml5P-SWT3SThTRkGvzbfbTfXo-B-X-WVjz5UGYc68DfITwqzXO> (Last visited in 2019.06.08.) (Цавшил: Эндрю Рейнольдс, Бин Райли, Эндрю Эланс, дурсансан бүтгүүн) гэж тохиолдо. С.Н.

үздэг.<sup>5</sup> Үүнийг сонгуулийн эрх зүйн зохицуулалтын тулгуур гэж үзэж болох юм. Чухамдаа сонгуулийн ямар асуудлыг үндсэн хуулийн түвшинд, ямар асуудлыг эрхийн бусад актуудад тусгах вэ гэдэг асуудлыг ихэвчлэн нарийвчлан авч үзэх хэрэгтэй байна. Жишээлбэл, Үндсэн хуульд сонгуулийн тухай асуудлыг ямар хэмжээнд тусгах нь тухайн улс орны сонгуулийн менежментд илтгэж олон нийтийн итгэлийн түвшингээс ихэвчлийн хамаардаг. Учир нь Үндсэн хуульд сонгуулийн үйл ажиллагааны зарчмын чанартай үндсэн асуудлыг тодорхойлох хандлагыг зонхицлог. Энэ нь сонгуулийн хэм хэмжээг эрх баригч намаас зөрчих эсхүл гүйвуулахаас сэргийтээд чухал ач холбогдолтой утраас үндсэн хуулийн иэр хүнд, тодорхой байдал зэрэг нь сонгуульд оролцогчдын итгэлийг бэхжүүлнэ гэх үздэг.<sup>6</sup>

Сонгуулийн тогтолцооны тодорхой хэлбэрүүдийг сонгох явцад анхаарч харгалзах зарим асуудлын талаар судлаачид “сонгуулийн явцын согог” нь сонгуулийн тогтолцооны хэлбэртээ байна уу эсвэл тогтолцоог хэрэгжүүлэх арга механизмаадаа байна уу гэдэг нь маргаантай байна. Сонгуулийн тогтолцооны нэг хувилбарыг сонгож авсан хэрээс түүний онцлогтой холбогдсон тусгай зарчмын ул тоосорлон будлантуулах, уг хэлбэрээс гарч болох зарим зохистой хувилбарыг гүйцэд ашиглаж чадахгүй бол тухайн тогтолцоо үр дүнгээ өгөхгүй нь ойлгомжтой. Иймд сонгуулийн тогтолцооны ямар ч хэлбэрнийг сонгож авсан ч гэсэн юуны өмнө түүнээс

<sup>5</sup> Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Философи, социологи, эрхийн хурzzын, Монгол Улс дахь сонгууль, сонгуулийн шинг тогтолцоо: Улс төр судалалын шинжлэгээ, (Редактор Жамбал А.), УБ, 2000 он, 27–28 дахь тал (Цавшил “Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Философи, социологи, эрхийн хурzzын, дурслан бүтээл” гэж товчилно. С.Н.)

<sup>6</sup> Алан Уолл, Эндрю Эллис, Эйман Альб, Карл У Дундас, Жордан Рукамбэ, Сара Стено, Сонгуулийн Менежментийн Хувилбаррудуу: ПДАА, (Арчилал, сонгуульд дэмжилж үзүүлэх олон улсын институтийн гармын албан), УБ., 60 дахь тал [https://catalog.npm.edu.mn/cgi-bin/koha/opac-search.pl?/id=\(i&q=%D1%8A%D0%BE%D0%B2%D0%BD%D1%83%D1%83%D0%BB%D1%8C&off-set=0&sort\\_by=relevance\\_desc](https://catalog.npm.edu.mn/cgi-bin/koha/opac-search.pl?/id=(i&q=%D1%8A%D0%BE%D0%B2%D0%BD%D1%83%D1%83%D0%BB%D1%8C&off-set=0&sort_by=relevance_desc) (Last visited in 2019.06.08.), (Цавшил “Алан Уолл, Эндрю Эллис, Эйман Альб, Карл У Дундас, Жордан Рукамбэ, Сара Стено, дурслан бүтээл” гэж товчилно. С.Н.)

гарч болох зарим серөг үр дагаврыг арилгахад чиглэсэн арга механизмыг гүйцэд бүрдүүлж, зохистой ашиглахад анхаарах нь иэн чухал байна гэж үзсэн байна.<sup>7</sup> Гэвч энэжүү асуудал нь иэн төвөгтэй олон талт шинжтэй болохоор түүнийг гүйцэд томъёолж, бүрэн хэрэгжүүлжээд бэрхшээлтэй зүйл цөөнтүү.

Сонгуулийн арчилсан тогтолцооны хэлбэр бүхэн улс төрийн амьдралын хүрээнд өөр өөрсдийн өвөрмөц үр дагаврыг бий болгодог бөгөөд сонгуулийн системийг сонгож авах нь цэвэр техникийн шийдвэр биш (Сонгуулийн ямар тогтолцоог системийг сонгох вэ гэдэг нь аливаа арчилсан орны улс төрийн институцийн хувьд хамгийн чухал шийдвэрийн нэгд тооцогддог). Энэ нь улс төрийн системийн ажиллагаанд зэрэг болоод серөг үр дагавартай байж болно.<sup>8</sup> Иймээс сонгуулийн тогтолцооны шийдвэр гаргахад алт тогтолцоо хамгийн рүү дүнтэй вэ гэдэгт үзүүлэлт дүгнэлт огехийн өмнө улс төрийн тодорхой ямар нехцэл байдалд алиш шалгуур нь хамгийн чухал вэ гэдгийг нарийвчлан судалж тогтоох хэрэгтэй гэж үзэх нь бий.<sup>9</sup>

Ер нь сонгуулийн ямар системийг хэрэглэх нь илүү ашигтай вэ гэсэн асуултын хариу, тэр дундаа сонгууль тойрсон маргаан нь эсийн эзэст төрийн эрх барих дээд байгууллагад сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн хэний эрх ашиг, ашиг сонирхлыг илрүхийлэх вэ гэдэгт тулж очдог. Нийт улс эх орны юу (тодруулбал аливаа асуудалд үндэсний язгуур эрх ашигийн ҮҮДЭСЭУ, нийтийн эрх ашигийн үзүүлэс хандах уу), эсвэл сонгогчдын тойргийнх уу гэсэн асуултууд байнга тавигддаг түгээмэл асуудал юм. Энэ ч утгаараа дурдсан асуудлын учир холбогдлыг ашиг сонирхлын болон тоглоомын (Game theory)

<sup>7</sup> Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Философи, социологи, эрхийн хурzzын дурслан бүтээл, 13 дахь тал

<sup>8</sup> Лоуренс Денук., Ричард Ницми., Пиппа Норрис., Ариаднаалуудын харьцуулалт: Сонгууль ба санаа огналт гэлбээ төвийн, (Орнуулсан Монх-Эрэлэг Д.), УБ., 2008 он, УБ., 37 дахь тал. (Цавшил “Лоуренс Денук., Ричард Ницми., Пиппа Норрис., дурслан бүтээл” гэж товчилно. С.Н.)

<sup>9</sup> Эндрю Реймоньес, Бен Райлли, Эндрю Запис, дурслан бүтээл, 11 дахь тал.

онолуудын үүднээс авч үзэж болох юм.

Ардчиллын хөгжлийн дээд хэлбэр болохынхувьд сонгууль нь аливаардчилсан улсын амьдралд чухал үүрэг гүйцэтгэх төрийн эрх мэдлийн төлөөлгөгчийн институтийн бурялдах үйл явцын түлхүүр болдог.<sup>10</sup> Сонгуулийн эцсийн зорилт нь хэн засаглалыг тогтоох явдал юм.<sup>11</sup> Энэ ч үүднээс ардчилсан ийнхэмд төрийн эрх мэдлийн хүлээн зөвшөөрөгдхөн чанар нь хууль ёсны дагуу ардчилсан сонгуулнаар төрийн тогтолцоого бүрдүүлэх замаар эхэлнэ гэж үзлэг.<sup>12</sup> Төрийн эрх мэдлийн тодорхой шаардлага хангасан субъект хэрэгжүүлэх ёстой. Ийнхүү тусгай шаардлага тавьдаг нь төрийн эрх мэдлийн хүлээн зөвшөөрөгдхөн чанараас шууд урган гардаг. Нөгөө талаас эрх мэлдэл бас серег талын агуулж байлагдучраас тодорхой шаардлага, хориглолтыг хуулнаар тогтоодог онцлогтой.<sup>13</sup> Учир нь сонгууль явуулж байгаагийн философи утга нь Засгийн газрыг байгуулахад бэрхшээлгүй байх, намын линдерүүдийн санаа зоригийн давамгайлын хэзгээрдэх зэргээс илүүд авч үзэх зүйл – сонгочг олон түмний санаа зоригийн илрэхийлийн илүү тусгасны сонгох явдал мён. Үтгээр сонгуулийн шударга чанарыг хэмжиж болох юм.<sup>14</sup>

Монгол Улсын Үндсэн хууль<sup>15</sup> сонгуулийн тогтолцооны талаар тухайлсан зохицуулалт байхгүй. Иймд сонгуулийн тогтолцоо 1992 оноос хойш хэд хэдэн

удаа өөрчлөгдж үрсэн байдал.<sup>16</sup> Энэ нь сонгуулийн хууль ихээхэн тогтвортгий, сонгууль болгоны дараа өөрчлөгдэх байсныг харуулж байна. Энэ талаарх судалгаанд “Олон улсын байгууллагас гаргасан зөвлөмжийн<sup>17</sup> дагуу нэгэнт сонгосон сонгуулийн тогтолцоог Үндсэн хуульдаа шууд тусгаж байж гэмээн парламентад олонх болсон нам бүр эн тэргүүд сонгуулийн хуулиар оролддогийг ээс болгоно. Эс тэгвээс тухайн Улсын Их Хуралд олонх болсон улс төрийн нам бүр өөртөө алж ашигтай гэж үзсэн хувийнбарыг сонгож, сонгуулийн хуулиараа оролдсон байх хэвээр болно.” гэсэн дүгнэлтийг хийсэн байна.<sup>18</sup> Үүнийт бас Монгол Улсын Үндсэн хуулийн цэсийн 2016 оны 04 дугаар сарын 22-ны өдрийн 05 дугаар дүгнэлтийг холбон авч үздэг. Энэ нь бүр даамжирч Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “тогтолцоо” гэсэн нэмэлт оруулах тесдийн боловсруулах үндэслэл, шаардлага бүхий асуудал болсон байна.<sup>19</sup> Энэ тухай олон ийтийн мэдээллийн хэрэгслүүдэд “Сонгуулийн тогтолцоо, намуудын

<sup>16</sup> Тухайбайж, Олонхын тогтолцооны хувийнбаруудын дотор 1992 онд олон мандаттай тойрот, 1996, 2000, 2004 онд ног мандаттай тогийнх зохион байгуулалтыг ашигласан бол 2008 онд эргэж олон мандаттай тойрот шийжсан. 2011 онд сонгуулийн шинэ хууль батлагдаж, олонхын ба хувь тэнцүүлэх системийн 48:28 гэсэн харшиа бүлэг колимог тогтолцоос иштэрүүлсэн. Улсын Их Хуралын 76 сургуулийн 48-д наамудын нэр лавшигчид тойрот өрсөлдсөн, үлдэчин 28 сургууд улс төрийн наам судалж ажлын түүдлийн хэмжээнд ийн саналын 5 хувийн авсан байхтар зассан Улсын Их Хуралын 2016 они сонгуульд ч. Сонгуулийн тухай хуулийн дагуу пропорционалан буюу хосолсон тогтолцоогоор авагдах байсан. Гээд ийн тогтолцоо Үндсэн хууль зөрчж байна гэсэн Үндсэн хуулийн цэсийн (МУХЦ), дутгын №05/2016.04.22/ шийдвэр гарсан тул Сонгуулийн тухай хуулийн орчмын Улсын Их Хуралын 2016 они сонгуулийн нэг мандаттай тойрот бүхий мэвсрэлтийн тогтолцоогоор ишүүлсэн. Энхбаяр Ч. нар. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэргэжлийн байдалд хийсн дун шинжилгээ, УБ., 2016 он, 136 дэх тал.

<sup>17</sup> “Compilation of Venice Commission Opinions Concerning Constitutional and Legal Provisions for the Protection of Local Self-Government” (European Commission for Democracy Through Law (Venice Commission)), 2015 он, 13, Дам цэвэр.

<sup>18</sup> Энхбаяр Ч., нар. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэргэжлийн байдалд хийсн дун шинжилгээ, УБ., 2016 он, 137 дэх тал.

<sup>19</sup> Монгол Улсын Үндсэн хууль оруулах нэмэлт, аюулжилжийн төслийн тайлбар, (Монгол Улсын Их Хурал), УБ., 2017 он, 68 дэх тал.

<sup>10</sup> Улсын хуулийн эрх зүйн тутамдасан асуудал, (Онол, врга түй, хэргэжжэл), УБ., 2017 он, 253 дэх тал.

<sup>11</sup> Лоуренс Денук, Ричард Нигеми, Пинка Норрис, дурдсан бүтэлж, 58 дэх тал.

<sup>12</sup> Луизандорик Н., Төрийн онол // Theory of State, (Нийж засварласан хөф дэвсээ хэмийн), УБ., 2005 он, 58 дэх тал. (Цваша Н.Луизандорик Н., дурдсан бүтэлж” гэж төвлөнлио. С.Н.)

<sup>13</sup> Луизандорик Н., дурдсан бүтэлж, 58 дэх тал

<sup>14</sup> Луизандорик Н., Төр, эрх түйн сүтэлгүүлийн хэсгийн чиг хандлага // The state and legal thoughts (Trends and Developments) УБ., 2002 он, 159 дэх тал.

<sup>15</sup> Төрийн мэдээлээний зынхүүгээл, УБ., 1992 он, №1 дутгаарт шийтгэжсан

төлөвшилд санаа зовох цаг ирсэн”<sup>20</sup>, “Сонгуулийн тогтолцоу ямар парламентыг төрүүлдэг вэ”<sup>21</sup>, “Сонгуулийн тогтолцоог сонгуулийн хуулиар зохицуулахыг 270 мянган иргэний 210 мянга нь дэмжсэн”<sup>22</sup>, “Сонгуулийн тогтолцоог Үндсэн хуульд бичихгүй, Улсын Их Хурал хуулиар тогтооно”<sup>23</sup> гэээрэг нийтлэлүүд цөөнгүй.

Сонгуулийн тогтолцоог өөрчлөх асуудал хөндөгдөхөд улс төрийн намууд их ач холбогдол өгдгийн учир нь сонгуулийн тогтолцооны сонголт нь улс төрийн намуудад шууд нөлөөлөхүйцүүр үр дагавартай гэж үздэг. Улс төрийн намууд сонгуулийн тогтолцоог өөрчилсөнөөр ардчиллыг хэрэгжүүлэх тоглоомыг дурмийг зохиох боломжтой болно.<sup>24</sup> Сонгуулийн тогтолцоо зөрт, сөөр талтай хэмээн нэрлээд түүнийгээ улс төрийн “хөзор тоглох” шалтаг, шалтгаан болгожээ. Энэ нь өдгөө дэлхий дахини үзэгдэл болсон байна. Эрх баригчид өөр өөрдөө ашигтай, тоглож дасан тогтолцоог өдгөө сонгодог нь бараг нууц биш болжээ.<sup>25</sup>

Өөр үзээр хэлбэл, Сонгуулийн тогтолцоог өөрчилэх нь хэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгдох, аль нам төрийн эрх мэдлийг гартаа авахыг шийдвэрлэх чухал хүчин зүйл болно. Улс төрийн намын түйлийн зорилго нь улс төрийн эрх мэдлийг аваха, шийдвэр гаргах түвшинд ажиллах, төрийн удирдах зорилтыг агуулдаг. Намуудын дотоод эв нэгдэл, сахилга батал ч сонгуулийн тогтолцоо нөлөө үзүүлнэ.<sup>26</sup> Тэээд ч төрийн эрх барих дээд байгууллага, албан тушаалтын сонгуул явуулах журам буюу сонгуулийн журам нь үндсэн хуулийн

<sup>20</sup> <https://news.zinda.mn/2513> (Last visited in 2019.06.08.)

<sup>21</sup> <https://newspress.mn/v1/p/news/10430> (Last visited in 2019.06.08.)

<sup>22</sup> <http://eagle.mn/r/60455> (Last visited in 2019.06.08.)

<sup>23</sup> <http://www.inews.mn/a/8372> (Last visited in 2019.06.08.)

<sup>24</sup> Гангаабаттар Д., Үндсэн хуулийн эрх зүй: Төрийн байгуулал, зарчмын, үзээ баримтлаг // Constitutional law: State structure, principles and policies. УБ., 2019 он. 196 дэх тал. (Цахилд “Гангаабаттар Д., дурсасан бүтээгдэг” гэж тохиолно. С.Н.)

<sup>25</sup> Луцендорж Н., Тэр, эрх зүйн структурний хөгжлийн чиг хандлага // The state and legal thoughts (Trends and Development) УБ., 2002 он. 159 дэх тал

<sup>26</sup> Эндрю Рейнольдс, Бэн Райлли, Эндрю Эллис, дурсасан бүтээгдээ, 8 дэх тал.

хэм хэмжээгээр тодорхойлогдоно.<sup>27</sup> Энэ нь хууль тогтоомжоор багталгаажсан байх бөгөөд сонгуул явуулах бодит, объектив үндэслэл юм. Харин сонгуульд оролцогчид сонгох, сонгогдох эрхээр хангагдсан байхыг сонгуулийн эрх зүйн субъектийг үндэслэл гэж тодорхойлдог.<sup>28</sup> Монгол Улсын Үндсэн хуульд заасан үндэслэлийн дагуу Улсын Их Хурлын Ерөнхийдүүдийн Иргэдийн Төлөөлгэгчийн Хурлын тус тус сонгуулийн тухай хуулиар бэхжүүлэн зохицуулсан. Энэ Үндсэн дээр сонгуулийн эрх зүйн харилцаа ҮСЭЖ хэрэгжих<sup>29</sup> бөгөөд Улсын Их Хурлын сонгууль нь Монгол Улсын иргээд засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэх үндсэн дээр хууль тогтоох байгууллагыг өөрсдийн төлөөлгэгчдөөр бүрдүүлж үндсэн арга гэж үздэг.<sup>30</sup> Тиймээс үүгээр зөвхөн Улсын Их Хурлын гишүүнийг сонгох асуудлыг объект<sup>31</sup> болгон эргэцүүлэн авч үзжийт оролдоо.

## II. Монгол Улс дахь сонгуулийн тогтолцооны үндсэн асуудлыг хөндсөн нь

Өмнө дурдсан “Сонгуулийн эрх зүйн үндэслэл” гэсэн ойлголтоос гадна “сонгуулийн тогтолцоо/систем/” гэсэн томъёолол бий. Үүнээс гадна “сонгуулийн тогтолцоо”, “сонгуулийн хэлбэр” хэмээх хөөр ойлголтын онцлогийг ляган үздэгтүй, тэдээрийн харилцан хамаарал, нөлөөллийн тухайд буруу зөрүү ойлгодог гэж үзсэн

<sup>27</sup> Үндсэн хуулийн эрх зүйн тulgamsan асуудал. (Онон, агаар зүй, хэрэгжилт). УБ., 2017 он. 254 дэх тал. (Цахилд “Үндсэн хуулийн эрх зүйн тulgamsan асуудал, дурсасан бүтээг” гэж тохиолно. С.Н.)

<sup>28</sup> Монгол Улсын Шинжилгээ ухвалин академи. Философи, социологи, эрхийн хөрөнгөй, дурсасан бүтээг, 41 дэх тал

<sup>29</sup> Чимэд Б., Үндсэн хуулийн мэдээлэл, УБ., 2008 он 218 дэх тал.

<sup>30</sup> Монгол Улсын улс төр, залын засаг, нийгэм: тогтолцоо ба болгодог. (Үйлдвэрийн зэвлэлийн гишүүд, домогчдын, иргээдэд зориуулсан гарын вагаг), УБ., 2013 он. 22 дэх тал.

<sup>31</sup> Сонгуулийн тухай хуулийн 120 дутгаар түүлжиллийн 120.1 дэх эхэлжт “Улсын Их Хурлын сонгууль нь Монголын ара түмэн засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэх үндсэн хэр төрийн эрх барих дээр байгууллагыг өөрийндөө төлөөлгэгчдөөр буруулжасан арга мен” гэж зохицуулсан (2015.12.25). Жанцан Н., Үндсэн хуулийн эрх зүй, (Схем дүүснэгт), УБ., 2018 он, 44 дэх тал. (Цахилд “Жанцан Н., дурсасан бүтээг” гэж тохиолно. С.Н.)

байдаг.<sup>32</sup> Энэхүү нэр томъёоны талаар урьд нь төв өгүүлж байсан<sup>33</sup> тул дахин нуршин дурдахыг илүү гэж үзлээ. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчилэлт оруулах төслийн тайлбар “Сонгуулийн тогтолцоо буюу санал хураах тогтолцоо гэдэг нь сонгогч тодорхой хувилбааудаас өөрийн сонголтыг хийхтэй холбогдсон харилцаа юм. Сонгуулийн тогтолцоо нь санал хураах, санал тоолох, эсийн дунг нэгтгэн тооцох дүрэм жуурмыг өөртөө агуулна” гэж тэмдэглэсэн байна.<sup>34</sup>

Хууль зүйн шинжлэх ухааны ном зохиол “сонгуулийн систем” хэмээх нэр томъёо гол төлөв өргөн ба явцуу утгаар хэрэглэгдэг бөгөөд Монгол Улсын хувьд хууль тогтоох, улс төр, нийгмийн аль ч хүрээнд уг нэр томъёог чухам аль утгаар нь хэрэглэж байгааг үл харгалзан “сонгуулийн тогтолцоо” гэх нэшил өрөнхийдөө тогтсон байна.<sup>35</sup> Энэ байдал нь тухайн нэр томъёогоор илрөхийлж гэж буй узэл санааг илт бүдгэрүүлж, эсэвл өөр олон салдаа утгатай болгоц эзрэг эрдэлтэй байж болох юм. Өөр үзээр хэлбэл, хэл шинжлэлийн үүдээс “үг болгон утгатай, утга болгон агуулатай” хэмээн хэлэлцид. Дээрх байдлыг задлан авч үзэвл, сонгуулийн систем гэснээр томъёог өргөн утгаар хэрэглэх үед сонгуулийн тогтолцоо гэж ирлэх нь зохилтой ба хэрэв явцуу утгаар хэрэглэхээр бол сонгуулийн үр дунг тооцох арга буюу манцад хувваарилах арга гэж ирэлж хэвших нь зүйтэй<sup>36</sup> гэсэн уг изр томъёоны агууллыг багтаамжийг тодорхойлсон тайлбарыг харгалzan үзэх нийгмийн зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүссээд байна.

<sup>32</sup> Монгол Улс дахь Үндсэн хуулийн процессын тulgамдсан асуудал. Хууль тогтоох, сонгуулийн болон төслийн процесс, (Эрдэм шинжлэгүүний баг хурлын шилтгэлийн эмзэгтэй), УБ., 2013 он, 90 дэх тал.

<sup>33</sup> Номынбаяслалын С., Сонгуулийн тогтолцоог тодорхойлох эргийн асуудал, Хууль дээдэлхэс ёс сэлтүүл, УБ., 2019 он, №11(71), 68–69 дэх тал (Цамшил “Номынбаяслалын С., дурслав бүтээс” гэх тохижуулсан. С.И.)

<sup>34</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн оруулах нэмэлт, өөрчилэлтийн төслийн тайлбар, (Монгол Улсын Их Хурал), УБ., 2017 он, 129 дэх тал.

<sup>35</sup> Үндсэн хуулийн эрг зүйн тulgамдсан асуудал, дурласан бүтээс, 253 дэх тал.

<sup>36</sup> Үндсэн хуулийн эрг зүйн тulgамдсан асуудал, дурласан бүтээс, 254 дэх тал.

Жишээлбэл, мажоритар, пропорционал, холимог сонгуулийг гол төлөв ялгаа бүхий сонгуулийн тогтолцоо хэмээн оноон ирлэх нь хэвшиж тогтсон зүйл юм. Гэвч үзэх хэрэгтээ талгэрэйг сонгуулийн тогтолцоо гэхээсээ илүү сонгуулийн бие даасан хэлбэрүүд хэмээн оноон томъёолблол оновчтой байна<sup>37</sup> гэсэн саналыг зарим судлаач гаргасан байдаг.

Сонгуулийн тогтолцооны эхлэл нь терний эрх мээл, иргэдийн сонгох, сонгогдох эрх бөгөөд түүний хангах, хамгаалах, тохируулах эрг зүйн хэмжээ, обийлож баримтлах, мөрдхөн ухамсар, хэрэглэх практикний сонгуулийн “эрх зүйн тогтолцоо” гэж тодорхойлжээ.<sup>38</sup> Монгол Улсын Үндсэн хуулиар нэгэнт сонгуулийн тогтолцоог шууд толорхойлоогүй учраас сонгуулийн ямар тогтолцоотой байхыг Улсын Их Хурал шийдвэрлэх бүрэн эрхтэй<sup>39</sup> гэж үзэх хандлага зонхицдог. Энэ нь нэг талаас, Монгол Улс дахь сонгуулийн тогтолцоо, түүний агуулгыг Улсын Их Хурал Үндсэн хуульд заасан хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд хэрхэн, ямар арга хэлбэрээр тодорхойлох болох<sup>40</sup> өөрийнх нь эрх хэмжээнийн асуудалд холбогдох юм.

Нэгөө талаас, “... хувь тэнцүүлэх элемент бүхий сонгуулийн холимог хэлбэрийг Улсын Их Хурлын сонгуульд хэрэглэх талаар санал хураахад уг санал гишүүдийн олонхын дэмжлэг авч чадаагүй. Үзүүлэсүүжээд, Улсын Их Хурлын сонгуулийг хувь тэнцүүлсэн хэлбэрээр явуулах боломжийг Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрөөгүй гэж үзэх үндэслэлтэй байна. Энэхүү үзэл баримтлалын дагуу дээрх зохицуулалтыг тусгаж, аль нэг намд бус нэр дэвшигч иргэнд өөрт нь саналаа

<sup>37</sup> Монгол Улс дахь Үндсэн хуулийн процессын тulgамдсан асуудал. Хууль тогтоох, сонгуулийн болон төслийн процесс, (Эрдэм шинжлэгүүний баг хурлын шилтгэлийн эмзэгтэй), УБ., 2013 он, 91 дэх тал.

<sup>38</sup> Чимиджийн Б., Сонгуулийн тогтолцоонаа ара түмэн, түүний Үндсэн хууль буруутай юу?!, Үндсэн хуульт бене толовшиг цувралын IV, УБ., 2011 он, 49–50 дэх тал. (Цамшил “Чимиджийн Б., дурсласан бүтээс” гэх тохижуулсан. С.Н.)

<sup>39</sup> Монголын О., Монгол Улсын Үндсэн хуулийн сонгуулийн холимог тогтолцоог бориглоогүй // The Constitution of Mongolia does not prohibit mixed election system, Эрх зүйн сэлтүүл, УБ., 2016 он, №2 (34), 23 дэх тал.

<sup>40</sup> Номынбаяслалын С., дурсласан бүтээс, 73 дэх тал.

өгөх замаар Улсын Их Хурлын гишүүнийг сонгог агуулгаар хуульчилсан байна. Улсын Их Хурлын гишүүнийг шууд сонгож зарчим нь Улсын Их Хурлын гишүүнийг ямар нэг байгууллага, засаг захирагаа, нутаг дэвсгэрийн нэгжээр дамжуулан дам сонгохгүйгээр, сонгогч саналаа аливаа этгээдээр төлөөлүүлэхгүйгээр өөрөө биечлэн, шууд гарган сонтохыг ойлгоно. Иймээс Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргээдээс Улсын Их Хурлын гишүүнийг шууд сонгож эрхэд хязгаарлалт хийх боломжтүй” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдгүйзэр зүйлийн 2 дахь эсгийн албан ёсны тайлбар бий.<sup>41</sup>

Сонгуулийн тогтолцоо, түүний үзэл баримтлал, зарчим (онцлог) нь тухайн улс орны нийгэм, эдийн засаг, ялангуяа улс төрийн дэглэм, төр ёсны түүхэн уламжлалаас ихээхэн шалтгаалдаг учраас нийгмийн байгуулал, улс төрийн дэглэм өөрчлөгдхөх сонгуулийн тогтолцоо ч өөрчлөгддөг гэж үздэг.<sup>42</sup> Сонгуулийн тогтолцоо бүр өөрийн гэсэн улс төр, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлын асуудалтай. Тиймээс сонгуулийн тогтолцоо нь сонгууль явуулах хүрээ, сонгогчдын бүртгэлийн үйл явц, сонгогчдын боловсрол, мэдээллийн шаардлага, санал өгөх хуудсын загвар, санал өгөх өдрийн тоо, дахин сонгууль явуулах шаардлага бүхий л асуудалд нөлөө үзүүлдэг.<sup>43</sup>

<sup>41</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн ижиний 2016 оны 04 дугаар сарын 22-ны өдрийн “Сонгуулийн хувийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дахь заалт, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсгийн Үндсэн хуулийн холбогдуулж бий”<sup>44</sup> 05 дугаар дүгнүүтийн үүрэгээс авав. Номийнбаатарлан С., Үндсэн хуулийн мэргэжлийн: Монгол Улсын Үндсэн хуулийн ижиний шийдвэрийн лавлах бичиг, (эмзэгэл), Уб., 2018 он.

<sup>42</sup> Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Философи, социологи, тэжиний хургалд, дурсдан бүтээг, 51 дахь тал.

<sup>43</sup> Жишээлбүл, Жижиг тойрот баримжаалсан сонгуулийн тогтолцоо хургуулж нөхцөл тобром нь бүрээр саналын хуудас болгтуух, сонгогчдын бүртгэх ажиллагааг нарийн ниймжийн явуулж, албан залжсан мухлах ажиллагаанас урьчмын сэргийлэх чадахи бий болгох учраас ортөө нийтийг байж болох юм. Ногоо талаар олон сонгогчтой сонгуулийн тойротгасан тохool нь бүрэн, ийндоо ортогтгийн тогтолцоо ичтүүрүүлж шаардлагыг гардас тогснуулж үйл явцыг ил төхөөжтэй удирахад хүчирдэгтийн байж болгоц тээвэр, засхрэгнээс бусад зардах ондор байж болзошгүй юм. Албан Уолл, Эндрю Эллис, Эймэн Айуб, Карл У. Дуллас, Жорам Руамбл, Сара Стено, Сонгуулийн мөнөжжентийн кувалбарууд: IDEA, (Арчишилаа, сонгуульд алжилж үзүүлж олон улсын институтийн гарын аллагы), Уб., 297 дахь тал.

Энэ талаар өөрсдийн байр сууриа тодорхой язгийхэлсэн суплаачид цөөнгүй.<sup>45</sup> Харин сонгогчийн (иргээий) гарын авлагад “Сонгууль зохион байгуулса, санал авах, дун гаргах, парламентын судал хувьзарилж олон янзын арга, дүрэм байдаа. Эдгээрийн нийлбэр цэгчиг сонгуулийн тогтолцоо буюу систем гэдэг. Олонхиийн саналаар буюу мажоритар систем хувь тэнцүү төлөөллийн буюу пропорционал систем, гэсэн үндсэн хоёр хэлбээ бий. Мажоритар систем нь дотроо хоёр төрөл байдал. 1/ Ердийн олонхиын буюу мажоритар систем. Нэр дэвшигч сонгуульд эзлэхэн тулд тухайн тойротг санал өгсөн сонгогчдын 50%+1 санал авсан байх ёстой. Эхний шатанд нэр дэвшигчдийн хэн нь ч ердийн олонхиын санал авч чадаагүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигч хоёр дахь шатны сонгуульд өрслөлдөг. 2/ Харьцаангуй олонхиын санал авсан нэр дэвшигч ялсанд тооцогдох систем. Нэр дэвшигч өрслөлдөгжесөө харьцаангуй олон санал авсан байвал саналын тоо 50% хурсэн эсэхийг үл харгалзан түүнийг ялсанд тооцогд. Сонгууль нэг шаттайгаар явагдах тул нэр дэвшигч цөөн санал авсан ч хамгийн олон санал авсан тохонддойд парламентийн гишүүн болж болиж олгодог талтай. Мажоритар системээр явагдаж буй тохонддойд сонгуулийн нрцээс хамаарж “Ирц ондер сонгууль”, эсхүл “Ирц бага сонгууль” гэсэн үр дагавар гарч болох юм.” гэж Тэмдээгээсэн байна.<sup>46</sup> Харин Үндсэн хуулийн эрх зүйг схемчилсэн гарын авлагад “Сонгуулийн тогтолцоо гэж сонгуулийн бэлтгэл ажиллагагаа болои сонгууль явуулах ажиллагатай холбоотой нийгмийн харилцааны нэгдлийг ойлгоно.” Гэж тодорхойлжээ.<sup>47</sup>

Хамгийн энгийнээр хэлэхэд “сонгуулийн тогтолцоо” нь аливаа сонгуульд иргэдийн өгсөн саналыг нам,

<sup>44</sup> Товуусүрэн Ц., Үндсэн хуудас ойлгохуй (Үндсэн хуулийн холбогдуулсан тайлбар), Уб., 2017 он, 77–78 дахь тал. (Classica “Товуусүрэн Ц. дурссан бүтээг” гэж точижилсно. С.Н.)

<sup>45</sup> Отгончимэг А., Сонгогчийн гарын аллагы, Уб., 2017 он, 14–15 дахь тал. [http://gec.gov.mn/for\\_elected/555/556](http://gec.gov.mn/for_elected/555/556) (Last visited in 2019.06.08.)

<sup>46</sup> Жанлан Н., дурсасан бүтээг, Уб., 2018 он, 44 дахь тал.

нэр дэвшигчдийн авах суудлын тоонд шилжүүлэх арга замыг хэлдэг. Үүнийг тодорхойлдог гол хувьсагчид нь сонгуулийн тогтолцооны хувилбар, суудал хуваарилах томъёо (олонхын, хувь тэнцүүлсэн, холимог эсвэл өөр ямар тогтолцоо ашиглаж байгаа, суудлын хуваарилалтыг ямар математик томъёо ашиглан тооцоолох гэх мэт), саналын хуудасны бүтэц (сонгочгүй нам эсвэл изр дэвшигчийн алиинд санал өгч байна, зөвхөн ирг сонголт хийх үү эсвэл хэд хэдэн сонголт хийх боломжийт ю), сонгуулийн тойргийн цар хүрээ (тухайн тойрог хэдэн сонгогчтой байгаагаар биш, тойиргос хууль тогтоох байгууллагад хэдэн төлөөлөгч сонгогдох байгаагаар илрэхийлгэдэн) зэрэг юм.<sup>47</sup> Энэ утгаараа, Сонгуулийн ямар тогтолцоогоон сонгосноос хамаарч сонгогчид улс төрийн наамд санал өгөх эсвэл нэр дэвшигчид саналдаа өгөх, сонгогчдын саналыг ямар аргачалааар парламентын суудал хуваарилах, сонгуулийн тойргийг хэрхэн тогтоох, тойрог бүрээс хэдэн төлөөлөгч сонгох гээд олон асуудал тодорхой болдог гэж үздэг.<sup>48</sup>

Тиймээс сонгуулийн эрх зүйн тохируулагч үүрэг, тухайн үед хэрэглэсэн тогтолцооны үр нөлөө хэр зэрэг байна вэ?<sup>49</sup> гэдэг нь эсний дунд уг үйл явцад сонгогчид хэр зэрэг санаа тавьж оролцсон, тухайн сонгуулийн үр дунд иргэдийн сэтгэл ханамж ямар түвшинд байна вэ? гэдээр илрэдэг. Өөрөөр хэлбэл, иргэдийн оролцо бол сонгуулийн эрх зүй, тогтолцооны үр дүнгийн гол шалгuur гэж үздэг.<sup>50</sup> Сонгуулийн тогтолцооны төвлөвшилтийн өөр ирг чухал асуудал нь сонгуулийн зохон байгуулалт юм.<sup>51</sup> Мөн түүзэчин сонгуулийн тогтолцооны ач холбогдлыг орхигдуулж болохгүй.<sup>52</sup> Учир нь ард түмнээс сонгогдон байгуулагдсан

<sup>47</sup> Эндрю Рейнивэлс, Бири Райли, Эндрю Эзлис, дурслан бутгэл, 7 дахь тал.

<sup>48</sup> Гангаабаттар Д., дурслан бутгэл, 195–196 дахь тал.

<sup>49</sup> Чимэгэл Б., дурслан бутгэл, 44 дахь тал.

<sup>50</sup> <http://www.ecr.gov.mn/details/887> (Last visited in 2019.06.08.)

<sup>51</sup> Жамшижүүлэбэ, Сонгуулийн тогтолцоо нь засгийн газрын хөгжлийн бургуулж хувь албан тогтолцоогийт. Гангаабаттар Д., Улсын хуулийн эрх зүй. Төрийн байгуулал, зарчмын, узсл баримгалын // Constitutional law: State structure, principles and policies, Уб., 2019 он, 197 дахь тал.

хууль тогтоох байгууллага нь засгийн газрыг бүрдүүлэхэд төдийгүй засгийн газрын бодлогод үзүүлэх нөлөө ихтэй. Иймд еронхийд нь тэмдэглэхэд, дурдан буй энэ бух зүйлүүд сонгуулийн тогтолцоо хэмээн ойлголтын агуулгад багтдаг. Энэ эргэцүүлийн хүрээнд сонгуулийн тогтолцоо чухамхуу энхжуу утгаар нь илүүгэй хөндлөө. Ийнхүү сонгуулийн тогтолцооны суурь асуудал болох уг иэр томьёог ямар агуулгаар тодорхойлж, хэрхэн ойлгон хэрэглэж буй байдлаас гарч байгаа серэг үр дагаврыг эргэцүүлэв.

**Сонгуулийн тогтолцооны сонголт, харгалzan үзэх болдит нөхцөлүүдийн тухайд**

Сонгуудийн тогтолцооны хэлбэрний сонгож хэрэгжүүлж нь төвөтгэй нарийн үйл яви. Үүний учир нь сонгуулийн тодорхой нэг тогтолцоог сонгохын өмнө тухайн тогтолцооны тусгай оншлог, түүнд нийцисэн улс төрийн өвөрмөц болдит орчин, нөхцлийн бурдлал, гарах үр дагаврын шинж байдал зэрэг цогц олон хүчин зүйлийг урьдчилан нарийн тооцож үзэх шаардлагатай холбон үздэг.<sup>52</sup>

Сонгуулийн тогтолцооны тусгай онолын үүднээс алнаас сонгуулийн ардчилсан тогтолцооны хэлбэр нь сонгуулийн үйл явцын объект, субъектын харилцан үйлчлэл тэлдээрэйн төлөвшилтийн өвөрмөц онцлогийн нөхцөлдсөн дараах тодорхой нөхцел, хүчин зүйлтэй холбоотой. Үүнд: нэгд, төрийн засаглалын хэлбэрний онцлог тэлдээрэйн өвөрмөц шинж төлөв; хоёрт, улс төрийн нам, наамын системийн бурдэлт төлөвшилтийн онцлог; гурват, лидер, хошуучлагчын тодролт, бойжилтын онцлог; дөрөвт, сонгогч олон түмэн, улс төрийн хамсал болон сөйлийн есөлт төлөвшилтийн шинж хандлага эзргийг хамруулаан үзэж болно гэж тэмдэглэсэн.<sup>53</sup>

**Сонгуулийн тогтолцооны дагнасан**

<sup>52</sup> Монгол Улсын Шинжлэх ухвалин академи, Философи, социологи, зураан хүрээлэн, дурслан бутгэл, 120 дахь тал.

<sup>53</sup> Монгол Улсын Шинжлэх ухвалин академи, Философи, социологи, зураан хүрээлэн, дурслан бутгэл, 121–122 дахь тал.

бүтээлд ““Сонгуулийн систем” гэсэн ойлголтыг вөр явцуу утгаар хэрэглэхэд сонгуулийн үр дүнг тооцдог хоёр үндсэн аргачлал болох мажоритар буюу олонхиын санал, пропорционал буюу хувь тэнцүүлэх аргачлалыг хамт хэрэглэсэн нөхцөлд сонгуулийн “холимог систем” гэсэн ойлголт буй болдог” гэж дурдсан байна.<sup>54</sup> Судалгаанд “Сонгуулийн эрх зүйн тогтолцооны дээр нэрлэсэн зарчмууд нь сонгуулийн санал тооцоо, судал хуваарилыг аргын 2 зарчмыг дамгаар ий болон хослон /холимогоор/ хэрэглэхэд саад болохгүй” гэж дүгнэсэн бий.<sup>55</sup> Сонгуулийн тогтолцоо нь олонхиын саналаар сонгох / мажоритар, хувь тэнцүүлэх төлөөллийн журамаар сонгох /пропорционал/, холимог<sup>56</sup> гэсэн терелтэй<sup>57</sup> бөгөөд энэ эргэцүүлэлт тэдгээрийн нэг бүрчлэн авч үзэхийг зориогүй билээ.

Сонгуулийн эрх зүйн буюу тусгай зарчмууд ёсоор ардчилсан сонгуул нь бүх нийтийн, тэгш, саналаар нууцаар гаргах үндсэн дээр явагдана. Эдгээр зарчмууд сонгогчдын эрх, эрх чөлөө, сонгуулийн үйл явцыг тодорхойлон зааж зохицуулсан хэм хэмжээ, чиг баримтлалтууд болно.<sup>58</sup> Монгол Улсын Үндэсний хуульд Улсын Их Хурлын гишүүнүүд Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно гээд сонгуулийн үндсэн гурван зарчмыг тусгасан байна. Тиймээс сонгуулийн үндсэн зарчмуудыг хүлээн зөвшөөрч, дагаж мөрдсөн үед л

<sup>54</sup> Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Философи, социологи, эрхийн хуралдаан, дурдсан бүтээл, 41 дахь тал.

<sup>55</sup> Чимид Б., дурдсан бүтээл, 51 дахь тал.

<sup>56</sup> Сонгуулийн холимог тогтолцоо нь олонхиын систем болон хувь тэнцүүлж системийн давуу талуудын изгтийг гэсэн оролдлагод тулгууралагаа. Холимог сонгуулийн тогтолцооны сонгуулийн үндсэн хоёр систем эзрэгшиг оршиж байдаг. Холимог сонгуулийн системийн үндсэн хоёр хувьтобар бай. Үүнээс Кувь тэнцүүлж системийн дагуу судал хуваарилыг авч нь олонхиын системийн дагуу явлагасан тойрогт ишвар үр дүн гарсан хамаралттай бол холимог мандаттай хувь тэнцүүлж систем гэж ирэлдэг. Харин хувь тэнцүүлж болон олонхиын системийг тус тусдаа салангыг байдалар хэрэгзэн сонгууль явуулж тогтолцогаар паралель систем (parallel system) гэж ирэлдэг. Гангбаатар Д., дурдсан бүтээл, 205 дахь тал.

<sup>57</sup> Жанцан Н., дурдсан бүтээл, 44 дахь тал.

<sup>58</sup> Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Философи, социологи, эрхийн хуралдаан, дурдсан бүтээл, 24 дахь тал.

сонгуулийн утга агуулга жинхэнэ ёсоор хэрэгжих боломж нээгддэг. Эдгээр зарчмыг тураангуйлан чөлөөт, шударга сонгуулийн зарчим ч гэж ирэлдэг.<sup>59</sup> Сонгуулийн зарчмууд харицсан уялдаатай байж, хэрэгждэг. Ийм учраас сонгуулийг нууц санал хураалтаар явуулах нь сонгот эрх, эрх чөлөөг хамгаалахад чухал зарчим гэж үздэг.<sup>60</sup>

Сонгох, сонгогдох эрх нь иргэд төрийг удирдахад оролцох хууль зүйн үндсэн хэлбэр гэж үздэг. Энэ нь сонгуулийн наасанд хурсэн цргэн төрийн байгууллагыг сонгож бүрдүүлэхэд бисчилэн оролжж сонгох, эдгээр байгууллагын бүрлэлжүүнд вөрөөс орж сонгогдох гэсэн хоёр хэсгээс бүрдэг цогцолбор эрх. Сонгох, сонгогдох эрх төрийн удирдлагын мөн чанар, онцлогуудтай уялдан нийт яргэлэд үүсч бий болшгүй, төрөөс хууль тогтоомжид тодорхойлсон тусгай болзол хангаж байж уг эрхийг эзлэлдэг<sup>61</sup> онцлогтой. Сонгох, сонгогдох эрх сонгуулийн тогтолцооны уг сурвалж болохыг үтгүйсэх аргагүй.

### Сонгуулийн тогтолцоо сонгуулийн зарчмын үндэслэлгэсэн нь

Монгол Улсын сонгуулийн тогтолцоо гэдэг нь Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхийлөгч, орон нутгийн хурлын төлөөлөгчдийг сонгох журам юм. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Сонгуулийн тухай хуулиар Улсын Их Хурлын, Ерөнхийлөгчийн, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулыгээ холбоотай хариццааг тогтоон хуулиасаа байдаг.<sup>62</sup> Монгол Улсын сонгуулийн тогтолцооны үндсэн хуулийн эрх зүйн зарчмуудыг дараахаа байдлаар авч үзсэн байдаг. Үүнд: Сонгууль бүх нийтийн байх, сонгуулийн тэгш эрхийн, сонгуулийн шууд байх, саналаа нууцаар гаргах, сонгууль тогтмол, зэлжжит байх, сонгууль чөлөөт бөгөөд сайн дурын

<sup>59</sup> Гангбаатар Д., дурдсан бүтээл, 191 дахь тал.

<sup>60</sup> Гангбаатар Д., дурдсан бүтээл, 195 дахь тал.

<sup>61</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томъёоны дагылга, УБ., 1993 он, 37 дахь тал.

<sup>62</sup> Үндсэн хуулийн эрх зүйн тузгын дасгалдан асуудал, дурдсан бүтээл, 253 дахь тал.

байх зарчмууд болно.<sup>63</sup>

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтаар Улсын Их Хурлын гишүүнийг сонгох сонгуулийн зарчмыг бүх нийтийн, чөлөөтэй, шууд сонгог эрхийн үндэс гэж тогтоосон байна.<sup>64</sup> Сонгуулийн үндсэн зарчмын тухай хууль тогтоомжид “Сонгуулийн тогтолцоо нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр санаалаа нууцаар гаргаж сонгох эрхийг хангахад үндэслэнэ.” гэж зохицуулж байсан.<sup>65</sup> Энэ бол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоог бүрдүүлэгч гол зарчим, журам, гишүүний бүрэн эрхийн хутсааг гол шалтгур болгон тодорхойлсон үндэслэл юм. Үүнийт Үндсэн хуулийн эрх зүйд бол сонгуульд иргэдийн оролцооны зарчим гэж иэрлэж нь бий. Өөрөөр хэлбэл, Үндсэн хууль Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоог иргэдийн сонгох эрхийн зарчмыг үндэслэн тодорхойлсон гэж үздэг.<sup>66</sup>

Сонгуулийн тухай хууль тогтоомжтой холбоотой эрх зүйн магадлал шиндвэрлэсэн Үндсэн хуулийн цээний шийдвэр сонгуулийн эрх зүйн эх сурвалж<sup>67</sup> болохоос гадна холбогдох хууль тогтоомждоо нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрнэг тусгасх ёстой. Энэ нь сонгуулийн үйл ажиллагаа олон улсын гэрээ, хэлэлцээрт харшигийн байгаа тохондолд энд байдлыг эрх зүйн талаас шүүмжлэх үндэстэй гэж үздэг.<sup>68</sup> Мөн “Сонгуулийн тогтолцооны талаар шийдвэр гаргажад олон улсын пакт, гэрээ хэлэлцээр, холбогдох бусад олон

улсын эрх зүйн актуудыг харгалzan үзэх зайншгүй шаардлага өнөө үед бий болсон” гэж онцолжог.<sup>69</sup>

Энд онцлон дурдахад, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцний 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 05 дугаар дугизлэл (МУҮХЦ, дүгнэлт 05№/2016.04.22.) сонгуулийн мажкортар тогтолцоог баримжаалах урьдч нөхцөл болсон тедийгүй Сонгуулийн тухай хуулиас хувь тэнцүүлсэн /пропорционал/ буюу “Улсын Их Хурлын . . . гишүүнийг хувь тэнцүүлэх сонгуулиар . . . сонтоно” гэсэн сонгуулийн холимог тогтолцоонд холбогдох эрх зохицуулалтыг хүчингүй болгох хууль зүйн үндэслэлээг бүрдүүлж, өөрчлөгдсөн байна.<sup>70</sup> Энэ нь шаашлаад Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дахь хэсэгт “тогтолцоо” гэсэн нэмэлт оруулах байдалд хүргэх бодит нөхцөл мөн эсэжийг эргэцүүлэх шалтгаан болж болоюм. Учир нь сонгуулийн тогтолцоог дагваар нь салган авч үзүүгийг бай нь чухал. Тэдээрэйн зохиомж бүтэц, үзүүлэх нөлөө нь Үндсэн хууль болоод бусад хүчин зүйлэс ихээхэн хамааралтай гэж үздэг.<sup>71</sup>

Сонгуулийн тогтолцоог боловсруулах үйл явцат холбоотойгоор тавигдаж хендэх ёстой чухал асуудлудыг орхигдуулж болохгүй гэж үздэг. Үүнд: Сонгуулийн тогтолцоог өөрчлөх санааг хэн улс төрийн хэлэлцэх асуудал болгон дэвшүүлж байна вэ, тогтолцоо шинээр буюу нэмэлт, өөрчлөлт оруулан шинчилж боловсруулах Үүргийг хэн, ямар үйл явцаар дамжуулан хүлээж байна вэ, нэмэлт, өөрчлөлт оруулахад улс төр, эрх зүйн хүрээнд

<sup>63</sup> Эндрю Рейнольдс, Бэн Райлли, Эндрю Эллис, дурссан бүтэц, 20 дахь тал.

<sup>64</sup> Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар нүйлийн 7.1 дахь хэсэгт “Сонгууль нь олонхишиг /мажкортар/ тогтолцоотой бийн” гэж өөрчлон найруулж зохицуулсан байна. Энэ хуулийн 120 дутаар зүйлийн 120.2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын сонгуулиар Улсын Их Хурлын 76 гишүүнийн тус бүр ньг мандатыг 76 төвтээс сонирго” гэсэн нэмэлтийн оруулсан байна. Харин энэ зүйлийн 120.4 дахь хэсэгт “Улсын Их Хурлын 48-ас наягийн тогтолцоогийн 26 төвтээс сонирго” гэсэнд хүчингүй болгосон байна. (<http://www.legalinfo.mn/law/details/351?lawid=351> [Last visited in 2019.06.08.]

<sup>65</sup> Сонгуулийн тогтолцоо бол төрийн тогтолцоо, залгийн эрх мэдээлэл хурьс яж бүрийн болохыг, дургум процессийн карийнн үзүүдээвшигийн нийлмэл бүтцийн зөвлөн нэгжийн хэсэг гэж кийгж болно. Эндрю Рейнольдс, Бэн Райлли, Эндрю Эллис, дурссан бүтэц, 10 дахь тал.

<sup>66</sup> Жамшид Н., дурссан бүтэц, 45 дахь тал.

<sup>67</sup> Товуусүрэн Ц., дурссан бүтэц, 76 дахь тал.

<sup>68</sup> Монгол Улсын Их Хурлас 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр батлагдсан, күннүүг болсодоо тооцогдсон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль /Шинжчинстгэний нариуулга/-ийн 5 дугаар түймрээ (<https://www.legalinfo.mn/law/details/351?lawid=351> [Last visited in 2019.06.08.]

<sup>69</sup> Чамшид Б., Улсын хуулийн эзлэлт, Уб., 2008 он, 218 дахь тал.

<sup>70</sup> Жамшид Н., дурссан бүтэц, 45 дахь тал.

<sup>71</sup> Алан Уолл., Эндрю Эллис., Эймэн Альб., Карл У Дундас., Жорам Рукамба., Сарв Стено., дурссан бүтэц, 60 дахь тал.

ямар механизмууд үйлчлэх вэ, ийнхүү нэмэлт, өөрчлөлт оруулсан тогтолцоог нийтээр хүлээн зөвшөөрүүлжээд ямар үйл ажиллагаа шаардлагатай вэ, хэрэв шийдвэр хүрсэн бол түүний хэрхэн хэрэгжүүлж вэ гэсэн асуултууд юм.

Зарим бүтээлд “Сонгуулийн тухай үндсэн заалтуудыг үндсэн хуулиndaа тусгаж оруулсан улс орны тоо осен нэмэгдэж байна. Энэ нь сонгуулийн байгууллагын эрх зүйн байдал, үндсэн хуулиар тогтоосон үйл ажиллагааны зарчмыг зэрэгт өөрчлөлт оруулахад түвэргтэй болгосон юм. Үндсэн хууль, түүний заалтуудад өөрчлөлт оруулахын туда хууль тогтоох байгууллагын дийлэнх олонхын саналыг авах, эсвэл санал асуулгаар явуулах шаардлагатай болдог. Үндсэн хуульд сонгуулийн үндсэн зарчмуудыг тусгаснаар эрх баригч намд өөрөө ашигтай хувилбараа сонгуулийт холбоотой заалтуудад өөрчлөлт оруулахад нь саад тогтор болдгоороо серег хүчинийхэнд сонгуулийн тухай заалтууд илүү хамгаалагдсан гэж ойлгогддог.”<sup>72</sup> Хэмээн тэмдэглэжээ.

Парламентийн сонгуулийн тухайд Үндсэн хуулийн дурдсан зүйл, заалтыг сонгуулийн тогтолцооны тухай биш харин түүний үндэс болсон сонгуулийн эрх зүйн үндсэн зарчмыг тодорхойлсон заалт гэж үздэг. Гэтэл үүний сонгуулийн тогтолцоо гэх олон эрэмбийн ойлголтын нэг хувилбар болох сонготчдын саналыг дүгнэж, гишүүний (мандат) суудал хуваарилах арга болсон “мажоритар”, “пропорционал” тогтолцогтой хутгас ойлгож байна гэсэн шүүмж цөөнгүй.<sup>73</sup> Сонгууль бол утгаа шууд ардчиллын гол хэлбэр учраас сонгуулийн

<sup>72</sup> Алан Үолл., Эндрю Элис., Эймэн Альб., Каар У.Дунцас., Жорам Рукамбэ., Сара Стено., дурдсан бүтээл, Уб., 61 дж тал.

<sup>73</sup> Энэ онцлог гэмдэглэхэд, Шинэ Үндсэн хуул 1992 оны 02 лутгар сарын 12 -иц хүчин төгөлдөр болж мөрдсөн дор Хөвсгөлт хуульд эвслий дагуу Үлсийн Багийн Хурал Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай шинэ хуул гаргаж, сонгуулийн эрхийн зарчмыг, тогтолцоо, үйл ашын журмыг шинэ нөхцөл анхлан тодорхойлсөн байна. Энэ хуулиар санал тооочаа, манцал (суудал) куваарилса аргын хувь олонхиных буюу мажоритар тогтолцооны харьцааныг олонхиных хувилбарыг тодорхойжих хэрэгжээр ирснэй байна. Чимид Б., Сонгуулийн тогтолцооийн арл түмсн, түүний Үндсэн хууль буруутай юу?, Үндсэн хуульт ёсны төловшийн цувралын IV, Уб., 2011 он, 39 дж тал.

аль ч тогтолцоог хэрэглэсэн сонготчдын шүүд оролцоог хангах үндсэн зорилгоос гажиж болохгүй гэж үздэг.<sup>74</sup> Иймд Үлсээн хуульд бийжүүлсэн<sup>75</sup> зарчмыг Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны үндсэн зарчмыг гэж ойлгох нь зөв байх болов уу. Иймийн учир Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны шинэ байдлыг түүний үндсэн зарчмуудын агуулгаар авч үзж нь зүйтэй.<sup>76</sup>

### III. Дүгнэлт

Эцэст нь тэмдэглэжээд, Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурлыг сонгог тогтолцоог өөрчлөх эсэх талаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн хэлэлцэж буй энд сонгуулийн тогтолцооны тухай бодож эргэцүүлсний Үндсэн дээр цөөн хэдэн саналыг гаргаж байна. Үүнд:

1/ Сонгуулийн систем гэсэн нэр томъёог өргөн утгаар нь хэрэглэх үед “сонгуулийн тогтолцоо” гэж нээрэн хэвшийн нь зүйтэй болов уу, харин явшуу утгаар хэрэглэх тохиолдолд сонгуулийн үр дүнг тооцох арга буюу мандат хуваарилас арга гэж ялгай зааглаж ут изр томъёоны агуулгын багтаамжаас /хэрэглэж байгаа хүрээний/ нь хамааран тодорхойлж болох юм. Ийнхүү дурдан буй нэр томъёог сонтон хэрэглэхдээ хэлбэр талаас нь бус харин агуулга талаасаа эрх зүйн зохицуулалт бүхий зарчмын шинжтэй хөшүүрэг Үгүйлэгдэж байна. Үүнээс улбаалан улс төрийн (тогтвортгий) иөхцөл байдал нь сонгуулийн тогтолцоог тодорхойлох боломжийн нөхцөлдүүлсэн байна.

2/ Сонгуулийн тогтолцоо улс тэр, эрх зүйн шинэ чиг хандлага, хүн ам зүй болон бусад эрэлт хэрэгцээг зохицтой хангаж байхын тулд тодорхой цаг хугацаа

<sup>74</sup> Чимид Б., дурдсан бүтээл, 59 дж тал.

<sup>75</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн Хоригийн нийгдэгэр зүйдээ “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрхийн бүхийн иргэл нийтэрээ, чөвлөтэй, шүүд сонгох эрхийн үндсэн дээр саналыа нууцар гаргаж, дөрвөн жилийн хугацаагтар сонгото” гэж эмсан.

<sup>76</sup> Номынбаатын С., дурдсан бүтээл, 72 даль тал.

өнгөрөхөд тухайн нөхцөл байдалд зохион өөрчлөгджэй байх нь зайлшгүй. Ийнхүү сонгуулийн тогтолцооны ямар ч хэлбэрийг сонгон хэрэгжүүлж болохыг үгүйсгэж болохгүй. Гагцхүү Үндсэн хууль, гүүний (МУҮХЦ, дүгнэлт 05№/2016.04.22.) тайлбараар нэгэnt баримжаалж авсан сонгуулийн тогтолцоогоо зүгшрүүлж хэлбэршүүлэх (сонгуулийн тогтолцоог урьд өмнөж жишгийг отг харгалзахгүйгээр эсхүл үгүйсгэж, шинээр боловсруулах нь эрсдэлтэйг үгүйсгэх аргагүй) үүднээс тодорхой цаг хугацааны турш хэрэглэж, яаран солихыг оролдох ийхэр зохистойг зргэцүүлэх хэрэгтэй байна. Энэ нь улс орны улс төрийн тогтвортой байдал (Үндсэн хуулийн тогтвортой байдал) болоод ийтийн ашиг сонирхолт төдийлөн нийцэхгүй байж болох юм.

3/ Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин изгдүгээр зүйлийн 4 дахь хэсэгт “тогтолцоо” гэсэн нэмэлт оруулах болсон нь Монгол Улсын сонгуулийн тогтолцоо уламжлагдах шийцүүлгэдэх хандлагар бус харин шинчлэгдэн уламжлагдах байгааг харуулж байна (Сонгуулийн тогтолцоо нь аливаа улсын тэр застийн уйл ажиллагаанд нөлөөтэй түйлн чухал институции бөгөөд хамгийн дээд эх хууль болох Үндсэн хуульд энэ талаар албан ёсоор заадаггүй байсан уламжлалтай. Гэвч сүүлийн үед энэ нь өөрчлөгджэж эхэлсэн гэж үздэг).<sup>77</sup>

4/ Сонгуулийн тогтолцоог ийнхүү удаа өөрчлөх болсон нэг шалтгаан нь

<sup>77</sup> Эндрю Рейнольдс, Бэн Райлли, Эндрю Эллис, дурссан бүтээл, 28 дахь тал.

тухайн тогтолцооны үзүүлж болох зэрэг, серөг нөлөө, давуу болон сул талыг сайтар судалж, улс орныхоо нийгэм, эзийн засаг, улс төрийн нөхцөл байдал болоод хөгжлийн төлөвт тохируулан зохистой сонгох хийх асуудалдаа бодитой хандаж чадаагүйтэй холбоотой байж болох юм. Иймд сонгуулийн тогтолцоонд өөрчлөлт оруулах эсэх асуудлыг улс орны хөгжлийг урагшуулах тогтвортой, ард түмний хүсэл зоригийг бүрэн илэрхийлсэн тэр засаг Улсын Их Хурал/ бүрэлдэх нөхцөлийг хангасан, урт хугацаанд тогтвортой хэрэгжих шийдвэрлэл хүрнэ гэж бодож байна.

#### IV. Ном зүй

1. Чимнэл Б., Сонгуулийн тогтолцоонд ард түмзи, түүний Үндсэн хууль буруутай юу?, Үндсэн хуульт ёсны төлөвшийн цуврал IV, Уб., 2011 он.

2. Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал, (Онол, арга зүй, хэрэгжилт), Уб., 2017 он.

3. Монгол Улсын Шинжлэх ухааны академи, Философи, социологи, эрхийн хүрээлэн, Монгол Улс дахь сонгууль, сонгуулийн шинэ тогтолцоо: Улс төр судалалын шинжилгээ, (Редактор: Жамбал А.), Уб., 2000 он.

4. Эндрю Рейнольдс, Бэн Райлли, Эндрю Эллис, Сонгуулийн тогтолцооны бүтэц зохион байгуулалт // Electoral System Design: The New International IDEA Handbook, (Орчуулсан: Батбаар Г.), Уб., 2010 он.

## ҮНДСЭН ХУУЛЬ ДАХЬ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРЧИМ



**МУИС-ийн ХЭС-ийн магистрант**  
Л.Загдэа

### НЭГ. Удиртгал

Монгол Улсын Үндсэн хуулийн<sup>1</sup> 17 дугаар зүйлийн 1.3-т Монгол Улсын иргэн шударга, хүчилгээ ёсыг эрхэмлэн “хуулиар ногдуулсан албан татвар төлөх” үндсэн үзүүлэгтэй болохыг хуульчилсан бөгөөд татвар нь төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрнийг бурдлуулж эдийн засгийн арга болдог. Татварын өрөхийн хууль<sup>2</sup> 20 гаруй төрлийн татвар хүчин төгөлдөр мөрдөгдж байна. Иргэд бүх татварыг изгэн зэрэг төлдөггүй, татварын ачаалал хүн бүрт өөр өөр байдал учир татварыг шударгаар тэгш хувиарлах шаардлага тавигддаг<sup>3</sup> бөгөөд Үндсэн хуулийн датуу татвар хурааснаар хувь этгээдийн санхүүгийн чадавхад шууд сергээр нөлөөлдөг хэдий ч энэхүү төрийн оролцоо нь эрх зүйт төрийн зарчим, хүний үндсэн эрх болох өмчлөх

эрх, болон ажил мэргэжилээ чөлөөтгийн сонгох эрх, аж ахуй эрхийг эрхийн хүрээнд байх бөгөөд татварын дарамтыг хүн бүрт тэгш байхаар зохицуулдаг.<sup>4</sup> Үндсэн хуульд заасан эдгэр зарчмуул нь иргэн, аж ахуйн нэгжийн орлогод ногдуулж буй татвараар дамжин болдит байдалд хэрэгждэг учир цаашид орлогын албан татварын ойлголтод үндэслэн энэхүү өгүүллийг бичих бөгөөд АНУ-д энэхүү зарчим ямар байдлаар хэрэгждэг болох, татварын талаарх онолын хувьд зөрүүтэй ямар байр суурь байдал болохыг энэхүү өгүүллийн хүрээнд бичих болно.

### 1.1 Орлогын албан татварын зарчим Үндсэн хуульд тусгагдсан байдал

Аливаа төр нийт иргэдээс хандаж нийгэм, эдийн засгийн бодлогын хүрээнд олон талт чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд үүнд хүрэлцэхүйц санхүүгийн эх үүсвэрийн бий болгох шаардлага тулгардаг. Учир нь санхүү төсвийн систем нь улсын санхүүгийн неөц баялаг болох төсвийн болон төсвийн бус сангүүдэг бурдлуулж харилцаа агуулдаг. Энэ систем нь улсын эдийн засгийн үр дүнтэй хөгжлийг хангах, төр нийгмийн болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэхэд зорилготой. Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэгч санхүү төсвийн системийн “гол амин судас” гэж нэрлэгддэг чухал зүйл нь татвар юм.<sup>5</sup>

1991 оноос өмнө Монгол Улсад тусдаа бие даасан татварын зохион байгуулалтын бүтцийг байгаагүй бөгөөд татварын хууль эрх зүйн үндсийг бүрдүүлэхээ тухайн хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр тогтоол, дүрэм заавар гаргай мөрдүүлж байв. Монгол Улсын хувьд 1990 оноос ардчилсан нийгмийн байгуулалтыг сонгж, төвлөрсөн төвлөвлөгөөт здийн засгас зах зээлийн здийн засгийн харилцаанд

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн Хууль, Төрийн мэдээлэл №1, УБ., 1992 он.

<sup>2</sup> Татварын өрөхийн хууль, Төрийн мэдээлэл №2, УБ., 2008 он.

<sup>3</sup> П.Одгэрэл, Татварын эрх зүйн өрөхийн аяги, УБ., 2017 он, 14 дахь тал.

<sup>4</sup> Монгол тэнц. 30 дахь тал.

<sup>5</sup> Монгол Улсын албан татварын эрх зүй. Татварын өрөхийн газар, УБ., 2009 он, 12 дахь тал.

шилжсэнээр татварын өнөөгийн тогтолцооны суурь тавигдсан<sup>6</sup> гэж үздэг байна.

Татвар болон татварын систем зөвхөн төсвийн орлогын эх үүсвэр төдийгүй зах зээлийн эдийн засгийн хамгийн чухал бүтцийн элемент<sup>7</sup> учраас Монгол улсад зах зээлийн эдийн засгийн харилцааг извтрүүлэх үндэсн арга хэмжээний нэг нь орчин үеийн татварыг бий болгон төлөвшүүлэх шаардлагыг байсан бөгөөд тус шаардлагын хүрээнд 1992 оны 12-р сард татварын багц хууль гэсэн 5 хууль бэлгэгдсаныар татварын эрх зүйн өнөөгийн тогтолцооны суурь тавигдсан билээ. Түүнээс хойш нийгэм, эдийн засгийн хэрэгтэй, хөгжлийн шаардлагаар татварын хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, шийцчлэх ажлууд хийдэж ирсэн төдийгүй шинээлэл, өөрчлөлт өнөөдөр ч яригдааэр байна. Татвар нь зөвхөн хуулиар тогтоогдох учир хууль эрх зүйн нэг салбар эрх зүй юм.<sup>8</sup>

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” хэмээн хуульчилсан байгаа нь татварын эрх зүй дэх эрх тэгш байх зарчмын үндэс гэж үзж болохоор байна. Хуулийн өмнө эрх тэгш байхыг түнхгэлснаар татварын байгууллагаас татварын хуулийг хүн бүрт ашиг тэгш хэрэглэхийг баталгаажуулсан байна.<sup>9</sup> Энэхүү зарчим нь татварын эрх зүйд хувь этгээдийн эдийн засгийн ялгаатай чадваа бүрт ялгаатай татварын ачаалал иржийг ойлгоно. Нийтээрээ адил тэгш байх зарчмын бол агуулгаараа төрийн тэгш хувваарилалтын суурин хэм хэмжээ бөгөөд адил тэгш этгээдүүдэд адилаар хандах, адил тэгш бус этгээдүүдэд адил бусаар хандах үр дагаврыг бий болгоно. Татварын эрх зүйд адил тэгш байх гэдэгт хувь этгээдийн эдийн засгийн ялгаатай чадваа бүрт ялгаатай татварын ачаалал

ирихийг ойлгоно. Чадавхад үндэслэлэх зарчим нь тухайн этгээдийн төлөх чадварт үндэслэн татвар ногдуулах явдал юм. Чадавхад үндэслэх зарчим нь татварын хувьд хэрэгтэй эсэх талаар эдийн засгийн онолд маргаантай байдаг<sup>10</sup> байна.

Үндэсн хууль дахь татварын эрх зүйн зарчмын ТЕХ-аар дамжин хэрэгждэг бөгөөд тус хуульд татварыг шууд ба шууд бус татвар нь хоорондоо татварыг ногдуулах арга зүйгээрээ ялгагдана.<sup>11</sup> Шууд татварыг хувь хүн, хуулийн этгээдийн орлого, ашгийн хэмжээ болон эд хөрөнгөтэй шууд хамааралтайгаар тогтоогдоно.<sup>12</sup> Шууд татварыг хувь хүний орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар хамаардаг. Энд дурдагдаж буй шууд татварын төрөл болох хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын албан татвар нь эрх тэгш байх, чадавхад үндэслэх зарчмын ийнцисэн байх ёстой нь эндээс харагдаж байна. Өөрөөр хэлбэл Үндсэн хууль дахь татварын эрх зүйн зарчим нь орлогын албан татвараар дамжин хэрэгждэг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 1.3-т Монгол Улсын иргэн шударга, хүнээг ёсыг эрхэмлэн “хуулиар ногдуулсан албан татвар төлөх” үндсэн үүрэгтэй болохыг хуулийн заалтын агуулга нь 25 дугаар зүйлийн 1.7 дахь заалтад “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний болдого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлэйн тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах” оншгий бүрэн эрхийн олгосон агуулга юм. Үндсэн хуулиинд тусгагдсан эрх зүйн ерөнхий зарчмуудыг татвар ногдуулах, хураах үйл ажиллагаанд зайлшгүй мөрдлөгө болтох ёстой байдал. Үндсэн хуулийн дагуу татварын байгууллагын бүхий л үйл ажиллагаа “хууль ёсны дагуу” байх ёстой.

<sup>6</sup> Г.Алтанзаваа, Татвар, УБ., 2015 он. 32 дахь тал

<sup>7</sup> Монгол Улсын ийн татварын эрх түй. Татварын сронийг газар, УБ., 2009 он, 12 дахь тал.

<sup>8</sup> Татварын эрх зүйн сронийг анги. П.Одгэрэл, УБ., 2017 он, 3 дахь тал.

<sup>9</sup> Ман тэнд. 50 дахь тал.

<sup>10</sup> П.Одгэрэл, Татварын эрх зүйн сронийг анги. УБ., 2017 он, 51 дахь тал.

<sup>11</sup> ТЕХ-ийн 5.3 дахь заалт.

<sup>12</sup> П.Одгэрэл, Татварын эрх зүйн сронийг анги, УБ., 2017 он, 19 дахь тал.

<sup>13</sup> ТЕХ-ийн 5.4 дахь заалт.

Өөрөөр хэлбэл татварын байгууллага “хууль дээдлэх” болон “хуульд үндэслэлж” зарчмыг бүхий л үйл ажиллагаандaa мөрдлөгөө болгохыг шаарддаг. Иймд Үндсэн хуулийн зохицуулалт нь татварын эрх зүйн эх сурвалжаар дамжин бодит амьдралт татвар төлөгчдөд хэрэглэгдэж байдаг.<sup>14</sup>

Монгол улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 1.3 дахь заалт, Татварын ерөнхий хуулийн<sup>15</sup> 18 дугаар зүйлийн 18.1 дахь заалтад заасан эрх зүйн зохицуулалтын хүрээнд Монгол улс нь олон улсад иерлэгдэж заиншанаар self-assessment буюу “tatvar төлөгч нь өөрөө татвараа ногдуулан төлөх” зарчмыг мөрддөг. Энэ зарчмын хүрээнд татвар төлөгч нь татварын хуулийн дагуу өөрдөө татвар ногдуулах орлого, татвар ногдох зүйлсээ ногдуулах татвар төлөгчөөр бүртгүүлэх, татвараа тооцоолох, төлөх, түүнийгээ бүртгэж тайллагнах ажлуудыг хуулийн хүрээнд хэрэгжүүлжийг үзүүр болгогд. Өөрөөр хэлбэл энэ нь иргэд орлогoo сайн дураараа мэдүүлэх, татвараа сайн дураараа төлөөгүй тохижолдол холбогдох хуульд заасан хариушлага хүлээх механизмулчилдэг.

Одоо хүчин төгөөдөр үйлчилж буй TEX-ийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооноо” гэж заасан бөгөөд тус хуулийн 8.2-т “Энэ хуулийн 8.4-8.6-д зааснаас бусад татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал тогтооноо” гэж зааснаар УИХ нь Засгийн газар, аймаг нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд татварын хувь, хэмжээ тогтоо онцгой эрхийг шилжүүлсэн байна. Мөн 2020 оны 01 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх шиннэчлэн найруулсан TEX-ийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор

Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооноо” гэж мөн л адил УИХ-ын онцгой эрхийг бусад субъектэд шилжүүлж байна. Утгаа УИХ-ын онцгой бүрэн эрх, гээд нь бусад шилжүүлж үл болох буюу гагшүү өөрөө шийдвэг гүйцэтгэх эрх үргийг шийдвэгдэг бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэх үндсэн үүргийнхээ ёсоор ямар ч асуудлыг шийдвэрлэх<sup>16</sup> уүрэгтэй хэдий ч энэжүү онцгой бүрэн эрхийг TEX-аар бусад этээдэд шилжүүлжээ.

Дээрхээс дүгнэвэл Монгол Улсын Үндсэн хуульд татварын эрх зүйд баримталдаг үндсэн зарчим болох тэгш байдлын болоод чадавхд үндэслэж зарчмууд бүрэн тусгагласан байна. Эдгээр зарчим нь TEX-аар дамжин Монгол улс нь олон улсад иерлэгдэж заиншанаар self-assessment буюу “tatvar төлөгч нь өөрөө татвараа ногдуулан төлөх” байдлар хэрэгждэг бөгөөд зарим төрийн татварын хувь хэмжээг тогтоох, татвар ногдуулах эрхийг засаг захиргааны нэгжид нь шилжүүлсэн байна. Нэгдмэл улсын Үндсэн хуульд туссан эдгээр зарчмууд нь төрийн байгууламжийн хувьд холбооны улс болох АНУ-д ямар байдлаар хэрэгждэг болохыг дараагийн хэсэгт авч узье.

## ХОЁР. АНУ-ЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

### 2.1 АНУ-ын орлогын албан татварын тухай

АНУ-ын орлогын албан татварын тогтолцоо нь түүхийн он удаан жилийн яваад эрс өөрчлөгдсөөр ирсэн. Анх орлогын албан татвар гэж байгаагүй бөгөөд шинэ татварыг ихэвчлэн дайныг үеэр төсвийн орлогыг бүрдүүлэх гол эх сурвалж болгон гаргагдаг байсан. Шинээр бий болгосон татварыг тухайн дайныг дуусах хүртэл хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлжэг

<sup>14</sup> Татварын эрх зүйн ерөнхий ангк. П.Одгэрэл, Уб., 2017 он, 65 дахь тал.

<sup>15</sup> Татварын ерөнхий хууль, Төрийн мэдээлэл №22, 2008 он.

<sup>16</sup> Б.Чимид, Үндсэн хуулийн мэдэлж, Уб., 2008 он, 200 дахь тал.

байжээ.<sup>17</sup> 1862 онд гарсан иргэний дайнаас үзүүлэлтгээр Конгресс соос анх удаа орчин үеийн орлогын албан татварын үндэс суурийг тавьсан гэж хэлж болохоор орлогын албан татварын тухай хуулийг баталсан байна. Иргэний дайны үед 600-10,000 долларын орлоготой иргэн 3 хувийн татвар төлдөг байсан бол 10,000 доллараас дээш орлоготой иргэл илүү өндөр татвар төлдөг байжээ. Энэхүү хууль баглагдсан гарснаар 1866 он гэхэд орлогын албан татвараас тус үндэстэн сүүлийн 90 жилийн түүхэнд хамгийн өндөр буюу 310 сая доллар төсөвт төвлөрүүлсэн бөгөөд 1911 оныг хүртэл дахин ийм өндөр хэмжээнд очиж чадаагүй юм.<sup>18</sup>

1862 оны хуулиар улсын орлогыг цутглуулалт албыг байгуулж, тус албаны албан хаагчдад татвар ногдуулах, татвар хураах, татварын хууль тогтооможийг эд хөрөнгө, орлогод нь нийцүүлэн хураан авах, мөн хяналт тавих эрхийг олгосон нь өнөөдөрийг хүртэл хэвээр мөрөгдж байна.<sup>19</sup> 1862 оны АНУ-ын Конгресс татвар бүрдүүлэлтийн асуудалдаа дахин анхаарал хандуулж тамхи, нэмрэл спиртэд татварын хяналт тавьж ирсэн байна. Энэхүү шийдвэр нь багино хугацаанд буюу 1894, 1895 онуудад лур дундгийн байжээ. Ингээд энэхүү шийдвэр хэрэгжжих байсан сүүлийн жилүүдэд АНУ-ын Дээд шүүхээс орлогын албан татвар нь Үндэсэн хуульд нийцэгүй гэж үзэн хүчингүй болгосон юм.

Харин 1913 онд АНУ-ын Үндэсэн хуульд оруулсан 16 дугаар нэмэлт өөрчлөлтөөр<sup>20</sup> орлогын албан татварыг АНУ-ын татварын тогтолцоонд бүрэн

суултаж өгсөн гэхэд болно.<sup>21</sup> Энэхүү нэмэлт өөрчлөлт нь Конгресс орлогын албан татварыг ногдуулах эрх мэдлийг өгсөн бөгөөд ингэснээр хувь хүн болон аж ахуйн изгжуудийн орлогод татвар ногдуулах хууль гарах үндэслэл болсон байна. АНУ-д анх удаа 1918 оны санхүүгийн жилд жилний дотоодын ордого нь тэрбум долларыг давсан бөгөөд 1929 он гэхэд 5,4 тэрбум доллар болж өссөн байна. Дэлхийн 2 дугаар дайн эхлэхтэй зэрэгцэн иргэдний ажийн эрхлэлт нэмэгдэж, үүнийг дагад татварын орлого 7,3 тэрбум долларт хүрчээ. Энэхүү орлогын албан татвар нь стандартад нийцсэн хууль болсон<sup>22</sup> байна.

Өнөөдрийн байдлаар АНУ нь олон шатлал бүхий орлогын албан татварын системтэй бөгөөд энэ нь татварын холбооны, мужуулсын, зарим тохиолдолд орон нутгийн засаг захирагаа татвар ногдуулдаг систем юм. Холбооны болон муж улсын орлогын татвар нь татварын орлогод ногдуулж байгаа татварын хувь хэмжэээрээ ижил эскул орлогос хамааран өөр өөр ч байдал.<sup>23</sup> Холбооны татварын хувь хэмжээ нь тухайн муж улсад ногдуулж буй татварын хэмжээнээс ялгаатай байж болдог бөгөөд өнөөдрийн байдлаар АНУ-ын Аляска, Флорида, Невада, Өмнөд Дакота, Техас, Вашингтон болон Вайоминг зэрэг муж улсад орлогын албан татвар отт байдагтаг. Нью Хэмпшири, Теннесси гэсэн мужууд зөвхөн цалингас олсон орлогод татвар ногдуулдаг. Теннесси муж нь 2022 он гэхэд тус татварыг хүчингүй болгоохор ажиллаж байна.<sup>24</sup> Бусад бүх муж улсын хувьд муж улсын бие даасан шүүд татварын системийг ашиглаж байна. Тус систем нь орлогын бүх түвшинд иżг ижил хувь хэмжэээр татвар ногдуулдаг систем юм. 2019 оноос эхлэн

<sup>17</sup> US income tax history, Taxation <https://www.efile.com/tax-history-and-the-tax-code/>

<sup>18</sup> The Income Tax Amendment: Most Thought It Was a Great Idea in 1913 on. <https://www.cfr-usa.org/bill-of-rights-in-action/bria-11-3-b-the-income-tax-amendment-most-thought-it-was-a-great-idea-in-1913.html?fbclid=IwAR2RZFAxyfMdgnjKeB8HVxlg5eT7YKUz2Lfiobd4zYMrYnpoXhFBbl0Jk>

<sup>19</sup> US income tax history, Taxation <https://www.efile.com/tax-history-and-the-tax-code/>

<sup>20</sup> АНУ-ын Үндэсэн хуулийн 16 дугаар нэмэлт өөрчлөлтийн хийхэд “Фермерс Лаги & Траст компанийн ‘срэгт’ Нийлжүүлжийн кэрх” чухал наалуу үзүүлсэн байдал.

<sup>21</sup> Wealth tax's legality Depends on What 'direct' Means <https://www.bloomberg.com/opinion/articles/2019-01-30/elizabeth-warrens-health-tax-is-probably-constitutional>

<sup>22</sup> Valuation Law (Bewertungsgesetz), version of February 1, 1991 (current version available at <http://bundesrechtfabrik.de/bundesrecht/bewg/index.html>).

<sup>23</sup> All States Handbook, 2010 Edition, RIA Thomson, ISBN 978-0-7811-0415-9 (RIA)

<sup>24</sup> State Income Tax vs. Federal Income Tax: What's the Difference? <https://www.investopedia.com/ask/answers/060515/what-differences-between-state-income-tax-and-federal-income-tax.asp>

Хойд Каролина (5.499%), Массачусетс (5.10%), Юта (5%), Колорадо (4.63%), Минчиган (4.25%) Иллинойс (3.75%), Идиана (3.23%) , Пенсильвани (3.07%) гэсэн 8 муж улс энзхүү системийг ашиглаж эхлээд байна.<sup>25</sup>

Гучин гурван муж улс татварын дэвшилтэг тогтолцооны дагуу татварын орлогыг илүү өндөр түвшинд төвлөрүүлж байна. Энэ арга нь холбооны албан татварын тогтолцооны нийтлэг байдаг. Хавай муж 2019 оны байдлаар 12 төрлийн татварын төрлөтэй байгаа бол Каизас муж ердөө 2 төрлийн татвар ногдуулж байна. Харин Калифорния мужийн хувьд 1 сая долларас дээш орлогод 13,3 хувь, Хавай 11 хувийн татвар ногдуулж байгаа нь нийт муж улсынхон хувьд хамгийн өндөр татварын хувь хэмжээтэй мужид тооцогдох байна. Харин Хойд Дакота муж 2,9 хувь, Аризона муж 4,54 хувийн татвар ногдуулж байгаа нь хамгийн бага хувь хэмжээ юм.<sup>26</sup> Холбооны улсын хувьд тухайн муж улсад татвар төлслийн дараах хувь хэмжээнээс тооцдог бөгөөд энэ нь зарим муж улсын хувь хэмжээнээс хамаагүй өндөр байдаг. Холбооны татварын хэмжээ нь 2018 онд 10-37 хувийн хооронд хэлбэрэлж байв. Зарим мужийн хувьд мужийн орлогын албан татвар ногдуулсны дараах орлогоос төлдөг бол зарим муж нь нийт орлогоос татвар төлөх байдлаар хэрэгжиж байна.<sup>27</sup>

Харин АНУ-ын томоохон улс төрийн намуудын татварын талаарх баримталдаг бодлого нь ялгаатай байдаг. Тухайлбал, Ардчилсан нам нийтийн эрх ашигийн төлөө авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг санхүүжүүлэхийн тулд татвар нэмдэг бол Бүгд найрамдах нам томоохон бизнес эрхэлгэчдэй болон чинээлэг иргэдэл илүү ашиг хүртээхийн тулд татварын хувь хэмжээт бууруулах бодлого баримталдаг

байна.<sup>28</sup> Бүгд найрамдах намын хувьд “Засгийн газар гагтхүү үндэснүү чиг үүргээ хэрэгжүүлэх үүднээс татвар хураадаг байх ёстой буюу нийгмийн гэрэээр хүлээсэн үүргээ бичлүүлж, улс орны дэд бүтэц, үндэсний агуулгүй байдлын хангах, иргэдийг гэмт кэрэгтийн хамгаалахад татварын орлого зарцуулагч ёстой гэж үзэл. Харин Ардчилсан намын хувьд татварын болголгоо нь татварын хувь хэмжээт нэмсэн тохиолдола эргээд бизнесийн салбарыг заавал дэмжих ёстой гэж үзэл. Энэ ч үүднээс намын мөрийн хотөлбөртөө ажлын байрыг измэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг бий болгон гэж заасан байдал.

Үндсэндээ Ардчилсан намынхан дунд давхаргын татварын бууруулахыг уриалдаг яж. Энгийнээр хэлбэл томоохон корпорациудаа бодон чинээлэг иргэд Бүгд найрамдах намын татварын бодлогоос илүү ашиг хүртэх бол Ардчилсан намын татварын бодлогоос жижиг бизнес эрхэлгэчид, дундаж давхаргын иргэд илүү ашиг хүртэээр байна.<sup>29</sup> Эдгээр намуудын баримталж буй татварын бодлогоос либертари үзэлтийн, тэр ч бүү хэл Либертари намын баримталдаг бодлого нь тэс өөр билээ. 1989 оны АНУ-ын ерөнхийлгэгийн сонгуульд Либертари намаас нэр дэвшсэн Дэвид Бэргландин тухай үед бичсэн ном болон бусад эх сурвалжаас либертари үзэлтийн татварын талаар ямар бодлого баримталгийг товч дурдья.

Либертари үзэлтийн татварыг хулгай гэж үзэл. Америк хүн бүрийн олонс орлогын тодорхой хэсгийг Татварын албанад шилжүүлж байх хуулийн Конгресс баталжээ. Үүнийг эс биелүүлбээс гэмт хэрэгтэн болно. Татвар төлөөгүй хувийн хөрөнгийг Татварын алба хураан авдал.<sup>30</sup> Төр өөрөө юу ч үйлдвэрлэлж бутгэдэгтгүй. Төрийн хүмүүс татвар гэж нэрлэсэн

<sup>25</sup> “State Individual Income Taxes” (PDF). taxadmin.org. Archived (PDF) from the original on 28 December 2016. Retrieved 1 May 2018.

<sup>26</sup> State Income tax vs. Federal Income Tax: What’s the Difference? <https://www.investopedia.com/ask/answers/060515/what-difference-between-state-income-tax-and-federal-income-tax.asp>

<sup>27</sup> CCH State Tax Handbook 2018, page 254, et seq.

<sup>28</sup> Republicans vs. Democrats on Taxes: What’s the Difference? <https://www.investopedia.com/articles/economics/09/us-parties-republican-democrat-taxes.asp>

<sup>29</sup> Republicans vs. Democrats on Taxes: What’s the Difference? <https://www.investopedia.com/articles/economics/09/us-parties-republican-democrat-taxes.asp>

<sup>30</sup> Дэвид Бэргланц, Нэгэн хичэолд баатасан либертэр үзл, УБ, 2006 он. 20 дахь тал.

санхүүгийн хүчирхийлээр биднээс мөнгө авдаг<sup>31</sup> хэмээн үзэж байна. Өөрөөр хэлбэл “татвар бол хулгай” гэдэг нь либертарийн үзлийн түгээмэл хэрэглэгддэг уриа юм.<sup>32</sup> Либертарийн үзэлтийн татвар бол хулгай гэдгийг дараах 3 үндэслэлийг гол болгон тайлбарладаг байна. Тухайлбал,

Нэгдүгээрт, Тэр засгийн зүгээс татвар бол хулгай биш, учир нь иргэд татвараа төлөхийг зөвшөөрсөн. Учир нь засгийн газар болоод иргэн хоорондын хийсн нийгмийн гэрээнд дагуу хүлээж буй уүрэг гэж үздэг. Иргэд засгийн газрын хамгаалалтын хариуд татвар төлөх, хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг зөвшөөрсөн<sup>33</sup> гэдэг бол либертарийн үзэлтийн татвар болоод Засгийн газрын хооронд байгуулсан ямар ч гэрээ байхгүй. Засгийн газраас ийм санал тавьдагтүй, ийм гэрээнд ямар ч иргэн гарын үсэг зураагүй. Үнэн хэрээтээ засгийн газар иргэдийг төрийн үйлчилгээг ашигладаг эсэхээс үл хамааран татвар төлөхийг албандааг.<sup>34</sup> Нийгмийн гэрээ гадэг бол хүмүүс төрийн хяналтан дор байж, журамлагдсан нийтгэмд амьдарч байгаагийнхаа төлөөс болгож татвар төхөөрөөстэй гэсэн үндэслэлийн нэг хээг болж байдал<sup>35</sup> хэмээн сорог аргумент гаргаж өөрсдийн аргументийг хамгаалж байна.

Хоёрдугаарт, Тэр нь хулгайч болж чадалгатгүй, учир нь тэр нь өмчийн эрхийг хуулиар тодорхойлдог. Татварт төлж буй таны мөнгө биш бөгөөд, энэ бол Засгийн газрын мөнгө юм<sup>36</sup> хэмээн засгийн газрын зүгээс тайлбарлахад либертарийн үзэлтийн Засгийн газарт хуулиас үл хамааран

<sup>31</sup> Мөн тэдээ 26 дахь тал.

<sup>32</sup> Is Taxation Theft?

[https://www.libertarianism.org/columns/is-taxation-theft?fbclid=IwAR2zMY1IEKDzDz2ayCsqyr4jxvdYD-mn3eu1\\_H\\_PVN83Ce1W7VpbRn5c](https://www.libertarianism.org/columns/is-taxation-theft?fbclid=IwAR2zMY1IEKDzDz2ayCsqyr4jxvdYD-mn3eu1_H_PVN83Ce1W7VpbRn5c)

<sup>33</sup> See John Locke, *Second Treatise of Government*, ed. C.B. Macpherson (Indianapolis, Ind.: Hackett, 1980; originally published 1690), esp. section 120-1.

<sup>34</sup> Is Taxation Theft?

[https://www.libertarianism.org/columns/is-taxation-theft?fbclid=IwAR2zMY1IEKDzDz2ayCsqyr4jxvdYD-mn3eu1\\_H\\_PVN83Ce1W7VpbRn5c](https://www.libertarianism.org/columns/is-taxation-theft?fbclid=IwAR2zMY1IEKDzDz2ayCsqyr4jxvdYD-mn3eu1_H_PVN83Ce1W7VpbRn5c)

<sup>35</sup> Дэшил Биржанд, Нийгэн хичээлд багтвасан либертарийн үзэл. үб., 2006 он. 21 дахь тал.

<sup>36</sup> See Liam Murphy and Thomas Nagel, *The Myth of Ownership: Taxes and Justice* (Oxford: Oxford University Press, 2002), p. 58.

анхнаасаас үл хөдлөх хөрөнгийн эрх байхгүй. Энгийн угзэр хэлэх юм бол ямар ч хүн өөрнийн хөдөлмөрөөр бий болгосон, бусад хүнтэй тайван, шударга замаар наймаалцаж авсан, эсвэл бэлгэнд авсан зүйлээ эзэмшиж эрхтэй.<sup>37</sup>

Гуравдугаарт, Татвар бол нийгмийн дэг журмыг хангахын тулд төрд төлж буй үнэ юм. Хэрэв татвар байхгүй бол тэр засаг нутган унаж, нийгмийн дэг журам сүйрч, та ямар ч мөнгөгүй байх болно. Харин либертарийн үзэлтийн хувьд үүний эсрэг өөрсдийн үзлийг батлахдаа “Би чамд буу тулгаж байгаад чамаас 20 доллар авч, хариуд нь чамд өөрнийн номоо бүлээлээ гэж бодьё. Намайг бугуаа буулгамагч чи намайг хулгайч хэмээн дудаж, өөрнийн мөнгийг буцаан өгөхийг шаардана. Харин харинуд нь би хулгайч биш шүү дээ, би мөнгөний хариуд өөрнийн үнэтгийн номоо өгсөн гэж хэлнэ. Яг үнэндээ чи номыг маань асуух биш, мөнгөө л авахыг хүснэ. Учир нь би чиний мөнгийг чиний хүслээс гадуур авсандаа л байгаа юм”<sup>38</sup> гэж мэтээр тайлбарладаг байна. Энэ мэтчилэн татварын талаар олон ургалж үзэл байгаа нь тухайн улс орны татварын эрх зүйн тогтолцоо хөгжихед чухал нөвлөгөй гэж үзэж байна.

## 2.2 АНУ-ын Үндсэн хуулийн 16 дугаар нэмэлт өөрчлөлт<sup>39</sup>

АНУ-ын Дээд шүүхээс 1895 онд шийдвэрлэсэн “Фармерс Леюи & Траст компанийн эсрэг Поллок”-ийн хэрэгт хүү, ногдол ашиг, түрээсийн орлогод ногдуулж байгаа холбоны татвар нь АНУ-ын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийг зөрчсон гэж шийдвэрлэсэн. 1913 онд батлагдсан Үндсэн хуулийн Арванзургадугаар Нэмэлтээр<sup>40</sup>

<sup>37</sup> Дэвид Бэркли, Нийгэн хичээлд багтвасан либертарийн үзэл, үб., 2006 он. 29 дахь тал.

<sup>38</sup> Is Taxation Theft?

[https://www.libertarianism.org/columns/is-taxation-theft?fbclid=IwAR2zMY1IEKDzDz2ayCsqyr4jxvdYD-mn3eu1\\_H\\_PVN83Ce1W7VpbRn5c](https://www.libertarianism.org/columns/is-taxation-theft?fbclid=IwAR2zMY1IEKDzDz2ayCsqyr4jxvdYD-mn3eu1_H_PVN83Ce1W7VpbRn5c)

<sup>39</sup> Pollock v. Farmers Loan & Trust Co., 157 U.S. 429 (1895) <https://constitutionallawreporter.com/2016/02/02/pollock-v-farmers-loan-trust-co-federal-income-tax-violated-constitution/>

<sup>40</sup> АНУ-ын Үндсэн хуулийн 16 дугаар нэмэлт өөрчлөлт: “Конгресс бүх төрлийн орлогыг Муж усуудын хооронаа хувцаслахгүйгээр, хүн амын болон бусад тохиолгыг үл хяргалзан татвар нуудлах, кураах цэргийг. <https://constitution.findlaw.com/amendment16.html>

орлогыг албан татварыг хүн амын тоонд хувь тэнцүүлэн ногдуулах шаардлагыг хүчингүй болгосон байна.

Ийнхүү хүчингүй болоход “Фармерс Леүн & Траст компанийн эсрэг Поллокийн маргаан чухал нөлөө үзүүлсэн байдал 1894 оны Орлогын албан татварын хуулийн дагуу 4,000 амдоллараас дээш алниваа “орлого, ашиг”-т 2 хувийн татварыг таван жилийн хугацаанд ногдуулахаар болжээ. Хуульд заасан шаардлагыг биелүүлэхээр Фармерс Леүн & Траст компани хувьцаа эзэмшигчидээ татвар төлөх болсон, мөн Сангийн яаманд компани хэнд орлого шилжүүлсэн тухай мэдэгдэнэ гэдгээ мэдээджээ. Компанийн хувьцаа эзэмшигч Чарлес нь Поллок Фармерс Леүн & Траст компанийг орлогын албан татвар төлөхгүй байх, орлогоо хэнд төлсөн талаарх мэдээллийг Сангийн яаманд хүргүүлэхгүй байхыг даалгасан нэхэмжлэлийн шаардлага гаргажээ. Дээд шүүхийн эмне тулгарсан анхдагч асуудал бол тухайн татвар нь Үндсэн хуулийн дагуу хувь тэнцүүлэн ногдуулах “шууд албан татвар”-т тооцогдох татвар мөн эсэхийг тогтоох байлаа. Арван зургадгаар Нэмэлт баталдаахас эмне АНУ-ын Үндсэн хуульд бүх шууд албан татварыг муж бүрийн хүн амд хувь тэнцүүлэн ногдуулахаар заасан. 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу: “Төлөөлгөгчийн тоо болон шууд Албан татварыг энэ Холбоонд багтсан тусгаар Муж улсуудын дунд харьцаагаар хувь тэнцүүлэн ногдууна/ хуваарилна.....”

Түүнчлэн 1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт: “Аливаа гувчуур, эсхүл бусад шууд Албан татварыг хүн амын тооплого буюу дахин тооцоглын дагуу тэдэнд харгалзан хувь тэнцүүлэн ногдуулахаас бусад байдлаар ногдуулж үл болно.” гэж заасан байсан бол Арванзургадгаар Нэмэлтээр шууд албан татвар /хөрөнгийн орлогын татвар гэх мэт/-ыг хувь тэнцүүлэн ногдуулахаа болсон. Тус нэмэлтэд зааснаар “Конгресс бүх төрлийн орлогыг эх үүсвэрний нь харгалзахгүйгээр, мөн Муж улсуудын хооронд харьцуулж хуваарилахгүйгээр, хүн амын болон бусад

тооплогыг үл харгалзан татвар ногдуулах, хураах эрхтэй.” гэж тодорхой заажээ.

АНУ-ын Дээд шүүх 5-4 харьцаагаар Орлогын албан татварын тухай хууль нь Үндсэн хууль зөрчсөн байна гэж шийдвэрлэсэн. Тэрээр орлогын албан татвар нь муж улсуудын дунд зохих харьцаагаар хувь тэнцүүлэн хуваарилгаагүй шууд албан татвар байна гэж үзжээ. Дээд шүүхийн Даргагалч шүүгч Меливилл Фулзэр олонхийн өмнөөс дараах шийдвэрийн бичжээ. Тэрээр: 1894 оны хуулийн 27-37 зүйлд заасны дагуу ногдуулах албан татвар нь Үндсэн хуулийн узлэ санаанаас үзжээд үл хөдлөх эд хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгийн орлогод хамаарч байгаа шууд албан татвар юм. Тиймээс төлөөлгөгчийн харьцаагаар хувь тэнцүүлэн ногдуулахгүйгээр зохицуулсан эдгээр зүйл заалт нь үндсэн хууль зөрчсөн, хүчин төгөлдөр бус байна.

Дээрх шийдвэрийг гаргахад шүүгчийн олонх нь “шууд албан татвар” гэх ойлголтыг тодорхойлохын тулд Үндсэн хуулийт бүтээгчид, эдийн засагчдын ашигласан баримт бичиг болон Дээд шүүхийн өмнөх шийдвэрүүдийг судалж, дараахь дүгнэлтийг өгчээ: Ерөнхийдөө, татварыг анхлан төлсөн этгээд тухайн татварыг бусад этгээдэд шилжүүлжэх боломжтой бүх албан татварыг шууд бус албан татварт тооцдог; гэхдээ үл хөдлөх эд хөрөнгө эсхүл хувийн эд хөрөнгө, эсхүл тухайн эд хөрөнгөс олсон орлогод ногдуулж байгаа татвар бол шууд албан татварт тооцогдоно. Хэдийгээр харьцаагаар хувь тэнцүүлж нь амаргүй ажил гэгдгийг хүлээн зөвшөөрсөн ч Дээд шүүх энэхүү шаардлага нь “шууд албан татвар авах бүрэн эрхийг они чухал нөхцөл хэрэгжүүлэхээр хязгаарлах, хуримтлагдсан эд хөрөнгөд “шууд тоо тогтоох” халдаахас урьдчилан сэргийлэх” зорилготой байсан гэж дүгнэсэн бол дараах шүүгчид эсрэг санал өгч, тус бүрийн тайлбарыг бичиж байжээ. Тухайлбал:

Дээд шүүхийн шүүгч Жон Маршалл Харлан, Ховелл Эдмундс Жаксон, Эдвард Дуглас Вайт болон Хэнри Биллингс Браун

нар эсрэг санал гаргасан байна. Шүүгч Вайт маргаадаа: Манай үндэстэн оршин тогтосны дараа, засгийн газар гадны дайн байлдаануудын зовлон зүдгүүр, аймшигт иргэний тэмцэл хөдөлгөөнүүдийг тэсвэрлэн туулж, хүн ард нь нэгдэж хүчирхэг болсноос хойш 100 гаруй жилийн дараа энэ шүүх урт удаан няцаагдаж угүйсгэгдсэн, түүнчлэн засгийн газрын татвар ногдуулах салшгүй бүрэн эрхийт угүйсгээн Үндсэн хуулийн онол руу эргэж харах цаг болсон<sup>41</sup>. Шүүгч Харлан тайлбартаа: Тус шүүх Конгрессийг хувийн эд хөрөнгөд, эсхүл үл хөдлөх эд хөрөнгийн түрэсийн орлого, эсхүл хувийн эд хөрөнгө үүнд хөрөнгө оруулалт, хувьцаа, бонд болон бүх төрлийн хөрөнгө оруулалтыг оролцуулан/-ийн орлогод Муж улсуудын хүн амьн тоонд харьнуулан хувь тэнцүүлэн ногдуулахаас өөр замаар татвар, хураамж ногдуулж болохгүй гэж шийдвэрлэж байгаа нь үзүүлээ /Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтүйгээр – Конгрессын хоёр танхимын гуравны хоёр, Муж улсуудын дөрөвний гурвины санаалаар/ тухайн эд хөрөнгө болон орлого нь үндэсний засгийн газрын дэмжилт хэзээ ч хувь нэмэр оруулахгүй гэж шийдвэж байгаа эзрэг юм.

Дээд шүүхийн шүүгчдийн дээрх маргаан нь үндсэндээ орлогын албан татвар нь Үндсэн хуульд нийцсэн эсэж, эсхүл Үндсэн хуулийн бус татвар уу гэсэн маргааныг шийдсэн томоохон шийдвэр

юм.<sup>42</sup>

## ГУРАВ. ДУГНЭЛТ

Дээрхэс дүгнэвэл Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 1.3 дахь заалт, 25 дугаар зүйлийн 1.7 дахь заалтуудад татварын эрх зүйд баримталаад үндсэн зарчмын болох тэгш байдлын болоод чадавхд үндэслэх зарчмууд үзэл баримталаа олсон байна. Эдгээр зарчмын нь TEx-аар дамжин self-assessment буюу “tatvar telegch ny eehee tatvaraa ногдуulam teloх” байдлаар хэрэгжин байна. Терийн байгууламжийн хувьд нэгдмэл улсын хувьд холбооны улсын татварын эрх зүйн тогтолцоотой зарим талаар нжил төстэй байна.

АНУ нь енөөдрийн байдлаар олон шатлалт татварын системтэй улс болсон бөгөөд Холбооны татвар, муж улсын татвар болоод орон нутгийн засаг захирагааны зүтгээс татвар ногдуулж байгаатай нь манай улсын татварын тогтолцоо зарим талаараа төстий. Тус улсын татварын бодлогыг эрх барж байгаа нам нь тодорхойлдог бөгөөд эдгээр намуудын татварын талаар баримтлах болдогоос хамаарч нийгмийн аль давхаргад илүү үр өгөөжтэй байх нь тодорхойлгдог байна. Татварын тэгш байдлын зарчмын нь АНУ-ын Үндсэн хуулийн 16 дугаар нэмэлт өөрчлөлтөөр тухайн улсын татварын тогтолцоонд суусан гэж үзэж болохор байна.

<sup>41</sup> Are income taxes Unconstitutional or Illegal?

<https://www.cfile.com/trivolous-arguments-against-tax-and-why-taxation-is-wrong-illegal-unconstitutional-unfair-if-below-lwARIm3cbTa-hb5iaxxXKBkc9Pds5yx0C5WGY4y-CU18YcfI0-x7H3z1s5X6Q>

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ИРГЭНИЙ НЭХЭМЖЛЭЛИЙГ ШАЛГАН ТОГТООХ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ БҮЙ ПРАКТИК**



**Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн багш M. Vanzhigmaa**

**ТОВЧЛОЛ:**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагaan дахь иргэний нэхэмжлэлийн хэрэглээ болон түүний холбогдох хуулийн байгууллагаас шалган тогтоох, хянан шийдвэрлэсэн шийдвэрлийн хэрэгжилтийг хангаж буй онол, практикийг судлан харьцуулж тулгамдаж байгаа нөхцөл байдлыг илэрхийлэхийг зорилоо.

Төр, иргэн хоёр харилсан үүрэг хүлээх шаардлага зүй ёсоор тавигдсан ёнөө уед төрөөс иргэнийнхээ өмнө хүлээх үүрэг, хариуцлага ондурсаж, төрийн зүгээс иргэдийнхээ зөрчигдсөн эрхийн хамгаалах механизмын хэрэгжилтийг баталгаатай хангах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг үзнэн бодитой тогтоож, арилгах буюу нөхөн төлүүлэх асуудал нь нэн тулгамдаж буй асуудлуудын иэг юм.

Учир нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо хохирогч, иргэний нэхэмжлэгч нөхөн төлүүлж чадахгүй байгаа практикт нийтлэг болжээ. Харин энэ нь хэрэг бүртгэх, мөрдөн шалгах эрх бүхий байгууллага, прокурор, шүүхийн ўйл ажиллагаанаас хамаарч байна уу? эсхүл хохирлын нэхэмжлэлийг шийдвэрлэх буй төрийн

байгууллагын боллого, өнөөдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн зохицуулалттай холбоотой байна уу? гэлэний нарийвчлалын судлахад хүргэж байна.

ҮЕПГ-ын Сургалт, судалгааны төвөөс эрхлэн гаргасан “Судалтны эмхэтгэл Г” бүтээлийн холбогдох судалгаанаас онцлог узвэрлэх нөхөн төлөлтийн 36.9 хувь ийн мөрдөн байцаалтын шатанд, 27.2 хувь ийн прокурорын хяналтын шатанд, 29.6 хувь нь шүүхийн шатанд, 9.9 хувь нь иргэний журмаар нэхэмжлэхээр шийдвэрлэжсан бол 2.5 хувь нь хохирол огт барагдуулаагүй байна.

Манай улсад гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, нөхөн төдөх ажиллагааг хууль тогтоомжид үндэслэн гурван үе шатаар хэрэгжүүлдэг. Үүнд:

нэгдүгээрт, хэрэг бүртгэх мөрдөн байцаах буюу шүүхийн өмнөх шатанд прокурор, цагдаагийн байгууллага;

хоёрдугаарт, шүүхээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатанд шүүхийн байгууллага,

гурваандаарт шүүхийн шийдвэр, тогтоогүй гүйцэтгэх болои ял шийтгэх, зэвлэлний дараах шатанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зэрэг субъектүүд тус тус хэрэгжүүлдэг тогтолцоотой байна.

Практик туршлагаас хараад гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэлт нь мөрдөн шалгах ажиллагааны явцад дараах нийтлэг дутагдал байна.

- Иргэний нэхэмжлэгч, хариуцагчийг тухай бүрд нь тогтоохгүй орхих;

- Яллагдагч, шүүгдэгч нарын болон иргэний хариуцагчийн хөрөнгийг олж илрүүлэх, шаардлагатай уед наар алдахгүй битүүмжлэх, нэхэмжлэлийг іангаж арга

хэмжээ хангалттай авадахгүй байх болон орхиос;

• Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэр хэмжээг эрх бүхий байгууллагыг, мэргэжлийн хүмүүсийн үзүүлээнд тулгуурлах, нарийвилан тогтоолшүйгээр зөвхөн иргэний нэхэмжлэгч, хохирогч нарын үзүүлэгт үндэслэн тогтоо;

• Гэмт хэрэгтэй холбогдон гараагүй материаллаг бус зардлыг хохиролд хамааруулах;

• Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн хохирол хүлээсэн этгээд болон иргэний нэхэмжлэгчид, шүүхийн хэлэлцүүлэг хүртэлх мөрдөн шалгах ажиллагааны алч уу шатанд иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг тайлбарлаж өгөхгүй орхигдуулах;

• Нэхэмжлэл гаргаагүй тохиолдолд прокурор өөрийн санаачилгээр хохирол хүлээсэн этгээдийн эрхийг хамгаалах арга хэмжээ авдагтуу зэрэг дутгасан гаргаж байгааг судалгаанд сууринсан албан дүтнэлт хийсэн байна.

ЦЕГ-ийн Мэдээлэл судалгааны төвийн танилишуулга<sup>1</sup> үзвэл 2018 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн 36220 гэмт хэрэг гарсан, гэмт хэргийн хадаллагад 33566 иргэн, 57 байгууллагыг хэрэгтэй төрөлж хохирсноо 20997,7 сая төгрөгийн хохирол учирсны 16,8 хувийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн байна. Албан ёсны статистикиас зөвхөн хохирлын хэмжээ, нөхөн төлөгдсөн хохирлын хэмжээг тусгасан нь судалгааны сэдвийн хүрээнд иж бүрэн дүгнэлтийн хийх хангалттай мэдээллийг харуулахгүй байх бөгөөд мэдээллийн төрөл хэт өрөнхий гаргийг харуулж байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн хэргүүдийг шалгаж шийдвэрлэх явцад хэлэн иргэн, хуулийн этгээд жмар хэмжээний, ямар төрлийн хохирол учирсан мөн нөхөн төлүүлжээр нэхэмжлэл гаргасан эст, хэдийн хэмжээний иххэмжлэлийг хүлгэн авахаас татгалзсан,

хэмжээн нэхэмжлэгч ямар шалтгааны улмаас нэхэмжлэлээсээ татгалзсан, шүүхийн хэмжээн хэрэгт нэхэмжлэлдний асуудлыг хэрхэн шийдвэрлэгдсэн, шүүхээр шийдвэрлэгдсэн хэмжээн хэрэгт иргэний нэхэмжлэлүүдийн асуудлыг хэрхэн шийдвэрлэгдсэн гэх зэрэг олон төрлийн тоо баримтуудыг нэгтгээг гаргах, дун шинжилгээ хийх боломж албан ёсоор бүрдээгүй байна. Учир нь 2017 оноос мөрдгэж эхэлсэн шинэ Эрүүтийн хууль баглагдаас өмнө эрүүтийн хэргийн хохирогч бүрнүүг иргэний нэхэмжлэгчээр давхар бүртгэж, мэдүүлэг авдаг байсан. ЦЕГ-дас гаргадаг статистик мэдээ нь нарнийчилсан байдлаар төрөлжих гардагтүй байна. Бид цаашид гэмт хэргийн талварх статистик мэдээний төрөлжүүлэлтийг өргөжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Харин төв, орон нутгийн прокурорын газрууд 2012 оны байдлаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргүүдээс хэрэг бүртгэлтийн 6219, мөрдөн байцаалтын 7544 хэргийг түүвэрлэн судалгаа<sup>2</sup> явуулжээ. Хэрэг бүртгэлтийн шатанд 5214 иргэн, хуулийн этгээдийн төлөөлгөчийг хохирогчоор тогтоогоод мөн шууд иргэний нэхэмжлэгчээр шууд тогтоосон байна. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд гэмт үйлдлийн замаар олсон орлоготоо, эд зүйл гэгдгийг мэдэлгүй шударгаар олж аваад хохирсон иргэн, хуулийн этгээдийн тогтоогод мөн шууд иргэний нэхэмжлэгчээр тогтоосон байна. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд учирсан хохирлын барагдуулах, түүнчлэн бусдын өмчлөлийн эд хөрөнгөд өөр этгээд хохирол учруулсан уед, тухайлбал зам тээврийн ослын уед тээврийн хэрэгслийн өмчлөгчид учруулсан хохирол нь гэмт хэргийн бүрзэлэхүүнгүй боловч тухайн тээврийн хэрэгслийн өмчлөгчид учирсан эд хөрөнгийн хохирлыг барагдуулах зэрэг тохиолдуудад хохирогчоор тогтоолгүй зөвхөн иргэний нэхэмжлэгчээр тогтоосон байна.

Ихэнх тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаач нар иргэн хуулийн этгээдэд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгуулах талаар нэхэмжлэл

<sup>1</sup> Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тумай Монгол Улсын Дэх шүүхийн тогтоо. // Төрийн мэдээлэл. 2000. № 201.

<sup>2</sup> Цагланын Ерөнхий газрын мэдүүлэл судалгааны төвийн танилишуулга. <http://police.gov.mn/>

гаргах эрхтэй болохыг амаар тайлбарлан өгч хохирогчоор байцасан тэмдэглэд тусган бэлжүүлэх, иргэний нэхэмжилэл гаргасан тохноодолд ихээмжлэл гаргаж байгаа үндэслэл, шалтгаан, үүийн дүн, түүнийт нотолсон баримтуудыг хэргийн материалд хавсаргах зэргээр иргэний нэхэмжилэлийг хангах ажиллагаануудыг хийнсэн байна.

Иргэний нэхэмжилэлийг хангах зорилгоор ЭХХШ хуулийн 23, 24 дугээр зүйлд заасан хүний бие, тээврийн хэрэгслэл, ачаа тээшинд үзлэг хийх, хуулийн этгээд, иргэний эд зүйл, эд хөрөнгө, мөнгө агуулсан байр савыг битүүмжлэх, хэрэгт ач холбогдол бүхий эд зүйл, мөнгийг түр хугацаагаар хураан авах, Иргэн албан тушаалтнаас тайлбар авах зэрэг хойшлуулшигийг ажиллагааг 169 удаа, эд хөрөнгө захиран зарцуулах эрхийг хязгаарлах арга хэмжээг 142 удаа, эд зүйл хураан авах болон ихэжлэгийг 784 удаа, эд хөрөнгө битүүмжлийн арга хэмжээг 106 удаа, бусад арга хэмжээг 125 удаа тус тус авч хэрэгжүүлжээ<sup>4</sup>.

ЭХХШ ажиллагааны оролцогчдоос иргэний нэхэмжилэлтэй холбогдуулан прокурорын газруудад хэрэг бүртгэлийн хийнхийн 106, удаа бусад арга хэмжээг 125 удаа арга хэмжээ авч хэрэгжүүлжээ. Эрүүгийн хавтаст хэргийн материалд гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд хохирол учирсан бол тэдэнд нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг нь тайлбарлаж өгсөн эсэх нь тодорхойгүй 299 орчим, хохирогчийн байцаахаа үед гэмт хэргийн улмаас хохирол учирсан талаар мэдүүлсээр байтал нэхэмжилэлийн шаардлагыг гаргах эсэх талаар, нэхэмжлэх зүйл нь юу байгаа эсэх талаар асуулт тавигүй 355 зөрчил тус тус илэрсэн байна. Хохирогчоос гаргасан иргэний нэхэмжилэгтэй холбогдуулж нотлох баримт цутгуулах, бэлжүүлэх ажиллагааг хийгээгүй 86 зөрчил, иргэний нэхэмжилэлийг хангах талаар огт арга хэмжээ аваагүй 41 зөрчил мөн илрчээ<sup>5</sup>.

<sup>4</sup> "Судалгааны эмхэтгэл-1", УҮПГазрын сургалт, судалгааны төв, Уб... 2019 он, 180 дахь тал.

<sup>5</sup> Мөн тэнд.

132 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Гэрлэгчид эвлэрж боломжтуй буюу гэрлэгчийн хэмээн нэгний байнгын хүчирхийлэл дарамтас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ийцотой аюул, хор уршиг учирч болгошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүгч энэ хуулийн 132.1-б зассан арга хэмжээг авалгүйгээр гэрлэгчийг "пушалж болно" гэж заажээ. Тэгвэл энэ заалтыг тадлан шинжилгээг гэр бүлийн хүчирхийлэл гэдэг нь байнгын тогтмол үйлдэгдэх шинжлэй, гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэндэд ийцотой аюул хор уршиг учирсан байхыг шаардаж байна. Өөрөөр хэлбэл, алгадах гар хүрж зэрэг хөнгөн зэргийн асуудал нь гэр бүлийн хүчирхийлэлд орохгүй болох нь. Тэгээд ч гэр бүлийн хүчирхийлэл гэдэг зүйл нотлох баримттай үйлэгддэг ўу? Гэр бүлийн хүчирхийлэлд нотлох баримт шаардаж болох юм ўу? Үү нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцээ тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1."гэр бүлийн хүчирхийлэл" гэж энэ хуулийн 3 дугаар зүйлд зассан этгээд энэ хуулийн үйлчилэлд хамаарах хүний сэргэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрч чөлөө, бие махбодол халдсан үйлээл, эс үйлдэжүйг ойлгоно гэж заасан буюу гэр бүлийн хүчирхийлэл нь сэргэл санааны, эдийн засгийн, бэлгийн, бие махбодийн гэсэн хэлбэртэй байдал талаар туслажээ. Гэтэл дээрх залалтад зөвхөн биенийн хүчирхийллийг ойлгоод байх шиг. Энэ талаар шүүхүүд төдийлон сайн анхаарахгүй байгаагийн улмаас зарим шүүх хүчирхийллийн талаар цагдаа, эмнэлэгт хандсан бичиг бүхий нотлох баримтыг шаардаж байхад зарим шүүх гараар бичсэн өргөдлийг хүлээж авсны дараа нөхцөл байдлыг тодорхойлж байна. Угтаа бол дээрх зүйл залалтуудыг уялдуулж тайлбарлавал нэг л удаа гар хүрэх, эсхүл байнгийн таастаж хардах, мөрдөх, санхүүгийн хязгаарлагдмал байдал оруулах зэрэг нийтлэг нөхцөлүүд нь гэр бүлийн хүчирхийлэлд орох юм. Тэгээд шүүхүүд хянан шийдвэрлэж тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.1 дэх хэсэгт

заасан заалтыг голчлон барьж эвлэрүүлэх арга хэмжээг авсаар байгаа нь гэр бүлийн хүчирхийлийн хохирогчдыг аюултай нөхцөл байдалд оруулж байна.

Эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэж байгаа нийт өргөдлийн 30-40 хувийг гэр бүлийн эрх зүйн маргаан зээлж байх бөгөөд нэгээнт өргөлгүүтээ цүшүүлахаар шийдвчихсүйн гэр бүлийт эвлэрүүлэхэд эвлэрүүлэн зуучлагчийн ур чадварын асуудал өндөрөөр тавигддаг. Эвлэрүүлэн зуучалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд Эвлэрүүлэн зуучлагчид дээд болсоворлойд, эвлэрүүлэн зуучлагчийн сургалтанд хамрагдсан байх гэсэн шаардлагыг л тавьжээ. Гэтэл эвлэрүүлэн зуучалын ажиллагаа явуулахад зайлшгүй хуулийн мэдлэг шаардах нь дараах байдлаар батгагдана. Жишээ нь иргэний эрх зүйн чадамж, гуравдагч этгээдийн хууль ёсны ашиг сонирхол, хүсэл зоригийн илрхийлэл, иргэний эрх зүйн хэлцэл, гэрээ хүчин төгөлдөр байх, итгэмжлэл гэх мэт эрх зүйн ойлголтууд нь эвлэрүүлэн зуучлал явуулахад зайлшгүй мэдлэг байх шаардлагатай анхан шатны нэр томъёонууд юм. Эрх зүйчээс өөр эмч, багш, наиглэн болдог гэх мэт мэргэжилтийн тус нэр томъёог ойлгох у? Эвлэрүүлэн зуучалын сургалтаар хуулийн сургуульд 4,5 жил үзлэг эрх зүйн мэдлэг болон хууль хэрэглээг эзэмшиүүлэх боломжтой юу?

Негеө талаас эвлэрүүлэн зуучлалын гэрээг шүүгч баталгаажуулж захирамжаараа баталж буй нь эвлэрийн гэрээг хуульд нийцсэн байлыг шаардаж буй баталгаа боловч эвлэрүүлэн зуучлагчийг эрх зүйч мэргэжилтэй байхыг шаардахгүй байх нь зөв үү? Эвлэрүүлэн зуучлагчийг хуулийн дагуу ажилана, хууль зөрчвөл тийм хариушлагын оногдуулна гэсэн заалт байхгүй боловч холбогдох хуулийг бодит байдалтай уялдуулаан анализ хийвэл заавал эрх зүйч мэргэжилтийн байхыг шаардаж байна. Мөн эвлэрүүлэн зуучлагчийн ур чадварт ямар ч шаардлагыг хуульд туслаагүй. Гэтэл эвлэрүүлэн зуучлалд хандаж байгаа маргааны гуравны нэг нь гэр бүлийн эрх зүйн маргаан байdag. Гэр бүл гэдэг бол нийгмийн бүрдүүлдэг хамгийн

жижиг, хамгийн хэврэг нэгж. Хагарсан аяга эвлэдэггүйтэй адил холдсон сэргэлийн нийлүүлэхэд эвлэрүүлэн зуучлагчийн ур чадвар ихээр шаарддаг. Хэдийгээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд тогтсон жишиг байхгүй боловч эвлэрүүлэн зуучлагч зорилгоо тодорхойлж түүнд нийцсэн процессыг хэрхэн явуулахаас шалтгаалан олон төрлийн арга барил байж болно. Жиншээлбэл харилцан яриаг дэмжих хэлбэрийт эвлэрүүлэн зуучлал (facilitative mediation), асуудлыг шийдвэрхэдэх хэлбэрийн эвлэрүүлэн зуучлал (problem-solving mediation), эмчилгээний хэлбэрийн эвлэрүүлэн зуучлал (therapeutic mediation)... Энэ хэс мааг нь эвлэрүүлэн зуучлал нь тохиролцоонд хүржийн төлеөх маргаан шийдвэрлэг явц боловч тохиролцоонд хүргээс илүүтэйгээр талууд хоорондоо зохицтой харилцаа үүсгэх тэдний бодол санаа нь өөрчлөгдөх нь илүү чухал гэж үзлэг.<sup>3</sup>

Өөрөөр хэлбэл, эвлэрүүлээ зуучлагч нь маргалдагч талууд, маргааны төрөл, нөхцөн байдлаас хамаарч эвлэрийн ямар артыг хэрэглэх вэ? Ямар арга замаар талуудыг эвлэрүүлэх вэ? зэрэг сонголтуудыг хийх болдог. Гэр бүл цүшүүлах маргааны үед эвлэрүүлэн зуучлагч талуудыг эвлэрүүлэжийг эрмэлзэхээс илүүтэйгээр маргаан болж байгаа гол асуудал юунд байгааг тодруулах, бие биедээ тунирхсан гомдсон сэргэлийн ний болгох, гэр бүлийн аз жаргалтай үе, танилцсан, дурласан, хайлласан меч зэрэг наандин мөчүүдийг нь сэргээн сануулж, сэргэлийг нь хөдөлгөх зэрэг аргуудыг хэрэглэх шаардлагатай болдог. Иймд арга зүйн хувьд эвлэрүүлэн зуучлагчид бусдыг таньж мэдэх, харилцааны зөв аргыг олж сонгох сэргэл судлаачийн ур чадвар зайлшгүй хэрэг болдог.

**Дүгнэлт:** Шүүгч хэргийг хуулийн дагуу шүүхийн шатанд өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэдэг бол эвлэрүүлэн зуучлагч иргэл хооронд үүссэн тодорхой төрлийн маргааныг эвийн журмаар, сайн

<sup>3</sup> Нийн шүнэ, Орчин үсийн инйтим дэх бие даан калзилжин явцыг дээмжих хэлбэрийн эвлэрүүлэн түүчлэл лекц

дүрүн үнисэн дээр, шүүгчээс өмнөх шатанд, талуудаар оөрсдөөр нь шийдвэрлүүлжээд дэмжилж үзүүлгүүрээ олон талин ур чадвар шаардлагын онцлог бүхий ажиллагаа юм. Өөроор хэлбэл, шүүгч, эвлэрүүлжин зуучлагч 2 ажил чиг үүрэг зорилгын хувьд хэрэг маргааныг шийдвэрлэж; шийдвэрлэх нехэлний бий болголгоороо ашиглхан байдал. Гагшхүү шийдвэрлэх арга нь өөр юм. Харин үр дүн ач холбогдлын хувьд эвлэрүүлжин зуучлагч ажлаа сайн хийх тусам нргэд хоорондын харилцаа зөвлөрч, шүүхийн ачаалал буурна. Мэдэж шинэхэн тогтолцоог хэдэн жилийн хугацаанд нутагшуулна гэдэг амаргүй зүйл. Гэхдээ бил баагахан туршилага дээрээ тулгуурлан үйл ажиллагаагаа улам чанаржуулах, эвлэрүүлжин зуучлагчдаа чадваржуулах, энэ ажиллагааг олон нийтэрээ дэмжих шаардлагатай байна. Тухайлбан:

1. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг олон нийтэд сургалтын ажиллагааг зогсолтгүйгээр явуулах. Эвлэрүүлэн зуучлалд хандах иргэдийг нэмэгдүүлэх, иргэдийн итгэлийг төрүүлэх зорилгоор өмгөөлгүйчидийг эвлэрүүлэн зуучлахын сургалтанд хамруулах мөн өмгөөлгүйчид иргэдээд эвлэрүүлэн зуучлахын талаар мэдээлэл олгож, санаал болгох үргийг хуульчлах, мэдээлэл лавлагaa нэхэмжлэл авахдаа эвлэрүүлэн зуучлалд хандах талаар санаал болгох байх, шүүгчийн туслах, шүүгч нар талуудыг эвлэрэх боломжтой гэж үзвэл нэхэмжлэл болон иргэнийн хэргийг эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлдэг практик бий болгох;

2. Гэр бүл болгоныг эвлэрүүлнэ гэж түйлишрах асуудлыг болимоор байна. Нэгэнт арваан хэдэн жил тусдаа амьдарчихсан тусдаа гар бүл хүүхдэгтэй болчихсон гэр бүлүүдийг заавал эвлэрүүлэн зуучлалд ханд гэж тулгах нь хийсвэр амьдралтай уялдаагүй зарчмын мотсанагдана. Харин ч гэр бүл болгон эвлэрүүлэн зуучлааар орохгүй эвлэрэх боломж бүхий гэр бүл нь хандаад эхэлбэл эвлэрүүлэн зуучлагчийн алжлын бүтээмжийг дэвшүүлүүлэх юм. Тэгхээр бид гэр бүлүүдийг ялгаа заагтайгаар эвлэрүүлэн зуучлалд ханддаг боломжийг

хуульдаа оруулах хэрэгтэй байна. Япон улсын Иргэний хэрэг эвлэрүүлжин түүчлэх тухай хуулийн 13-р түйлд Эвлэрүүлжин түүчлэх ажиллагааг явуулахгүй байж 13.1 Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөл нь тухайн хэргийн шинж чанар нь эвлэрүүлжин түүчлэхад тохиромжгүй тохиолдолд, эсвэл зохиц зүй бус зорилгоор эвлэрүүлжин түүчлүүлах нэхэмжлэл гаргасан нь тогтоогдон тохиолдолд, эвлэрүүлжин түүчлэх ажиллагааг явуулахгүйгээр хэргийг хааж болно.<sup>6</sup> гэж заасанчлан Монгол Улсын Эвлэрлийн тухай хуульд маргааны талуд эвлэрэх боломжтой нөхцөл байдлаа нотлох баримтаа гаргасан эсхүл эвлэрүүлжин зуучлагч эвлэрүүлжин түүчлэхад тохиромжгүй маргаан гэж үзэж үзүүлэлтээ гаргасан бол шүүхэд шууд хандах эрхийг олгосон заалт оруулах нь зүй юм. Мөн ч шүүг заавал үрдичлан шийдвэрлэх шатаар дамжгэсэн шаардлагтаа тавихгүйгээр эвлэрэх боломжгүйгээ илрэхийлсэн гэрээлт цүшүүлах нэхэмжлэлийг хүлээж аваад үнэлэлт дүгнэлт өгсний үндсэн дээр түдгэлзүүлж эвлэрэх хугацаа өгөх үү?<sup>7</sup> эсхүл гэрээлтийн цүшлэх уу? гэсэн шийдвэрээ гаргаж болно. Хэрвээ нийм боломж бүрдээд ийм байдлаар ажиллаж чадвал иргэдийн бүхимдал багасаж, эвлэрүүлжин зуучлагчийн ачаалал багасах боломжтой:

3. Шүүхийн шатанд гэр бүлийн хүчирхийлийн шинжтэй гэр бүлийн гэрээлт цүшлэх нэхэмжлэлийг хүлээн авахдаа аливаа шааралдаа, цензор, холбогдох нотлох баримтыг шаардаж шалтаг заан буцаахгүй байхад анхаарах хэрэгтэй байна. Учир нь гэрээлт цүшүүлахаар эвлэрүүлэн зуучлал болон шүүхэд хандсанаар тухайн гэр бүлийн харилцаа улам хүрицдэж аюултай нөхцөл бий болох боломжтой болохыг ойлгох хэрэгтэй. Эвлэрүүлэн зуучлагчид ажиллах хугацаанд өргөдлөө өгчихөө ...нөхөр хэрүүл хийгээд загнаад байна, би айгаад байна өргөдлөө буцаагаад авьяя...” гэх эзгрээр хандаж байсан тохиолдол нийлээд

<sup>6</sup> Ш.Оюунхансүүлжин дэх эвлэрүүлжин зуучлагчидын онцлог, шүүгчийн практик, анхаарал асуудал Шүүлэргэ сийн хөмжүүр, 2012.09 сар №7-007.

байсан учраас энэ асуудлыг зайлшгүй анхаарах нь зүйтгэй болоод байна;

4. Нэгэнт бий бичихсон, тогтчихсон энэ тогтолцоогоо цаашид улам сайжруулж чанаржуулахын тулд бил эвлэрүүлэн зуучлагчил тавих шаардлага, ур чадварыг ондөржүүлэх шаардлагатай байна. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа гэх энэ нэр томъёог цэвэр нуруун дээрээ үүрч явва хүмүүс бол эвлэрүүлэн зуучлагч нар л байдал. Бид эвлэрүүлэн зуучлагч нараа чанаржуулж чадваржуулсаар нргэдийн итгэх итгэл ишмэгдэнэ. Мөн ч эвлэрүүлэх ажиллагааны бүтээмж дээшлэх үр дүнтэй. Тиймээс эвлэрүүлэн зуучалын тухай хуульд эвлэрүүлэх зуучлагчийн эрх зүйч мэргэжилтэй байх шаардлага оруулах мөн эвлэрүүлэн зуучлагчид нь өөрийн үр чадварыг нэмэгдүүлэх аливаа төрлийн сургалтанд /сэтгэл судал, харилцаа

хандлага гэх мэт/ улирал бүр хамрагдаж кредит цаг хангаж байхыг холбогдох журмаар зохицуулж тогтмол сургалтанд хамруулж чадваржуулах шаардлагатай байна. Нөгөө талаас эвлэрүүлэн зуучлах гэх энэ ажиллагааг зөвхөн эвлэрүүлэн зуучлагчидоожөгсөннүүчир дутагдалтай байна. Үнээр л гэрлэлтээ цүшлүулах гэж буй гэр бүлд эвлэрүүлэх бухий л төрлийн арга хэмжээ авах юм бол зөвхөн эвлэрүүлэн зуучлагч ч биш нийгмийн ажилтан, гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн, сэргэл зүйч нарын хамтарсан баг тухайн гэр бүлтэй ажиллаж болно. Мөн ч төрөөс гэр бүлнүйг дэмжих чиг үүргээ төрлийн бус байгууллагуудад сиљкуулж санхүүжүүлж болно. Ингэснээр гэр бүлний гишүүдтэй, нөхөртэй, эхиртгэй, хүүхэдтэй тус бүрчлэн ажилласнаар тухайн гэр бүлний асуудлыг шийдвэрлэхэд томоохон дэмжлэг болдох боломжтой байна.

--00--

## ЗАХИРГААНЫ ГЭРЭЭНИЙ МАРГААНЫ ХЭРГИЙН ХАРЬЯАЛАЛ



**МУИС-ийн ХЭС-ийн мэгистрант  
Г.Уранаага**

### ТҮЛХҮҮР ҮГС:

Захиргааны гэрээ, Хэргийн харьяалал, Захиргааны өрөнхий хууль, Захиргааны хэрг хянан шийдвэрлэх тухай хууль, Арбитр

### ТОВЧЛОЛ:

Төрийн үйл ажиллагааны нэг хэлбэр болох захиргааны гэрээний хэрэглээ, харьяалын талаар маргаантай асуудлууд үүсч, улмаар энэ төрийн маргааныг хянан шийдвэрлэх харьяаллын асуудал хуульч, шүүгч нарын иżn тэргүүний анхаарч судлах асуудал болж байгаа тул “захиргааны хэргийн шүүх нь үндсэн хуулийн шүүхэд харьяалуулсангаа бусад бүхий л нийтийн эрх зүйн маргааныг харьялан шийднэ” гэсэн зарчим, онон ойлголтыг дэмжих байр сууринасаа энхүү сэдвээр өгүүлэл бинчихийг зорив.

### УДИРТГАЛ

Төр хүн хоёрт нэгэн зэрэг хууль даргалан захирч байгаагаараа энэ хоёртг хувийн /иргэний/ эрх зүйн харилцаанд эн тэнцүү эрхтэй субъект болгож байгаа билээ<sup>1</sup> хэмээн гавьяат хуулын Бяравгийн Чимид нэгэнтээ тэмдэглэсэн байдал.

<sup>1</sup> Чимид Б., Төрийн засах ёс, УБ., 2018 он, 18 дахь тал.

Сошиалист дэглэмийг халж, зах зээлийн арчилсан нийгмд үүдлийн Үндсэн хуулиа баталсан бидний хувьд “захиргааны гэрээ”-г захиргааны үйл ажиллагааны ирг хэлбэр болгон сонгож хэрэглэх болсон. Энэ талаар доцтор П.Одгэрэл бүтээлдээ<sup>2</sup> “1992 оны шинэ Үндсэн хууль баглагдан дараах уес хууль тогтоомжийг захиргааны гэрээний шин практик үүсч хөгжих болсны зэрэццээ манай эрх зүйн тогтолцоо эх газрын бүлд шилжих эхлэнээр захиргааны гэрээ өргөжих иżn чухал нөхцөл бүрэлдсэн. Улсын Их Хурлаас 2002 онд Захиргааны хэргээ хянан шийдвэрлэх тухай хууль баглагдан 2004 онд шинээр захиргааны төрлийсөн шүүх байгуулагдсаныа Монгол Улсын орчин үеийн захиргааны эрх зүй нь эх газрын эрх зүйн бүлийн захиргааны эрх зүйн сонгодог онолыг баримжалаан хөгжжих байгаа иль захиргааны гэрээний асуудал дөхөм үзүүлж байна” гэжээ. Энэ мэтчилийн суултуйн 20-оод жилийн хугацаанд захиргааны эрх зүйн эрдэмтэн судлаачид энэ чиглэлээр бүтээл тууривсан ийн дорвitoй алхам болсои бөгөөд эх хал дээрх судалгааны анхдагч эх сурвалж болж байна.

2015 онд Захиргааны өрөнхий хууль болон Захиргааны хэрг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль баглагдаж, мөрдөгдхөөс өмнө захиргааны гэрээний маргааныг иргэний хэргийн шүүх харьялан шийдвэрлэхээс гадна арбитраар харьяалуулан иргэний хэрг хянан шийдвэрлэх журмаар хэргийг шийдвэрлүүлдэг байсан практик бидэвд бий. Харин одоо үед захиргааны гэрээг бие даасан институтын нь хувьд хүлээн зөвшөөрч тусдаа бүлэг болгон хуульчилсан<sup>3</sup> хэдий ч захиргааны гэрээтийн холбоотой маргааныг захиргааны хэргийн шүүх дагнаж шийдвэрлэнэ гэж шууд дүгнэх

<sup>1</sup> П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн өрөнхий аюу, УБ., 2008 он, 229 дэх тал.

<sup>2</sup> Захиргааны өрөнхий хууль, 2015 он.

нь учир дутагдалтай хөвээр байна. Учир нь захиргааны гэрээ гэдэг “соигодог” ойлголтын хүрээнд байгуулагдсан захиргааны гэрээнээс гадна холимог шинжтэй гэрээнүүд практикт байгуулагдаж байгааг тооцож үзэх асуудал тулгарч байна.

Зах зээлийн харилцаа нь захиргааны чиг үүргийг дан гаанц захиран тушаах бус, сонгон хэрэлтэх уян хатан бусад арга хэлбэрээр түүний дотор түншлэлийн харилцааны механизмыг өргөнөөр хэрэгжүүлжийн зайлшигийг ихцелдүүлж, түншлэлийн үндэснэ арга замын нэг нь уг харилцааг захиргааны гэрээгээр зохицуулах явдал мөн<sup>4</sup> хэмээн хулээн зөвшөөрсөн боловч өдгөө хүртэл захиргааны гэрээг байгуулж, үйл ажиллагааны хэлбэр<sup>5</sup> болгон сонгот ажилладаг төрийн эрх бүхий ёлбан тушаалтнууд, тэдгээртэй гэрээ байгуулан ажиллаж байгаа хувийн хөвшийн төлөөлөгч наарт захиргааны гэрээний талаар ойлголт дутмаг байгаа нь ажиглагддаг. Тухайлбал, төрийн байгууллага хуульд заасны дагуу үйл ажиллагаанд захиргааны гэрээг сонгон хэрэглэж байгаа атласаа гэрээний мөн чанарыг үл харгалзан хувийн хэвшилийн байгууллагатай ажил гүйцэтгэж гэрээ байгуулсан мэтээр хувийн байгууллагыг ажил гүйцэтгэж мэтээр хандаж, гэрээний тал тэжээс илүү харьяанд нь байгаа алба, хэлтэс мэтээр ойлгодог гэхэд хилдэхгүй биз.

Үүнтэй холбоотойгоор төрийн үйл ажиллагааны нэг хэлбэр болох захиргааны гэрээний хэрэглээ, харьяаллын талаар маргаантай асуудлууд үүсч, улмаар энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэх харьяаллын асуудал хуулийн шүүгч нарын нэн тэргүүний анхаарч судлах асуудал болж байгаа тул “захиргааны хэргийн шүүх нь үндэснэ хуулийн шүүхэд харьяалуулсанас бусад бүхий л нийтийн эрх зүйн маргааныг харьялан шийдэй” гэсэн зарчим, онол ойлголтыг “дэмжих байр суурь”-аас энэхүү сэдвээр өгүү лэл бичихийг зорив.

<sup>4</sup> Олонцэд Н. Бахиргааны гэртүүний эрх түүн зохицуулалтыг төслийшүүдэх нь, 2006 он, -4 дэд тал.

<sup>5</sup> Loening, Stengel нар 1884-1886 онд хамгийн чухал шүүгчийн бүтэцүүдэд захиргааны актын хожуултараар ийнхийн эрх түүн гаргын бол захиргааны үйл ажиллагааны нэг хэлбэр” гэв үзснэй билдээ.

### Захиргааны гэрээний маргааны хэргийн харьяаллын асуудал

Хэргийн харьяалал гэж тухайн маргаан ямар байгууллагаар шийдвэрлэдэхийг тодорхойлдог, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бол шүүх уг асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй эсэхний тогтоодог ойлголт юм. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлд иргэний хэрэг шийдвэрлэх еренхий харьяалын шүүхэд энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан нэхэмжлэлтэй маргаан шийдвэрлэдэхийг зааснаас гадна шүүх болон арбитрын харьяаллыг зааглах тухай тусгасан байна. Харин иргэний хэрэг хянан шийдвэрлэх еренхий харьяаллын шүүх болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх дагнаас шүүхэд хамаараас асуудлын хүрээг заагласан зохицуулалт уг зүйлд тусгагдаагүй хэдий ч энэ асуудал нь шүүхийн биш харин хэргийн харьяалалд хамаарах болно.<sup>6</sup>

Манай улс Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг 2002 онд баталж, 2004 онд мөрдөж эхэлсэн бөгөөд мөн онд захиргааны хэргийн дагнаас шүүх байгуулган даруй 15 жилийн нүүрийг үзэж. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилтыг иргэн, хуулийн этгээдээс захиргааны актыг хууль бус гэж үзэж, зөрчигдсөн эрхээ хамгаалуулхаар гаргасан гомдол, нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх болон уул захиргааны хэргийн захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино<sup>7</sup> гэж хуулычилж багнаасаас үзэвлэж захиргааны гэрээний маргаан нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрлэх маргааны харьяаллаас гадуур орхигдсон байжээ гэж дүгнэхэд болохоор байна.

Гэхдээ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “захиргааны байгууллага” гэж нийтийн ашиг сонирхлыг илрэхийлэн

<sup>6</sup> Улсын дээд шүүхийн тогтолц, Иргэний зарим хэргийн харьяалал захиргааны хэргийн зарынвалас залган ялагх тухай, 2007 он.

<sup>7</sup> Захиргааны хэрэг хянан инийдээрэлж тухай хууль, I дүгээр зүйлийн 1.1 дэд хэснэгт.

засагласан шийдвэр гаргадаг, төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв болон орон нутгийн бүх байгууллага, түүчилэн Засгийн газрын байгууллагын зарим үргийг төлөөлөн гүйцэтгэдэг Засгийн газрын бус байгууллага, хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр бусдыг захирамжилсан шийдвэр гаргаж, нийтлэг үйлчилгээ үзүүлдэг сургууль, эмнэлэг, холбоо, харилцаа, эрчим хүчиний зэрэг байгууллагын захирагаа, нутгийн өөрөө удирдах ёсны болон шашны байгууллага зэрэг нийтийн эрх зүйн субъект болох байгууллагыг хэлнэ гэж тодорхойлоходоо Засгийн газрын байгууллагын зарим үргийг төлөөлөн гүйцэтгэдэг Засгийн газрын бус байгууллага, хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр бусдыг захирамжилсан шийдвэр гаргаж, нийтлэг үйлчилгээ үзүүлдэг байгууллагыг захирагааны байгууллагад хамаарулсан нь тухайн үед “Захирагааны гэрээ”-ний үндсэн дээр захирагааны байгууллага үйл ажиллагаа явуулдаг тухай, өөрөөр хэлбэр, захирагааны байгууллага болон нийтийн эрх зүйн гэрээний харилсан хамаарлыг тодорхойжсон шинэлэг зонхицуулалт болсон байдал. Энэ нь 1993 онд батлагдсан Засгийн газрын тухай хуулийн 19 дутгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үргүйт холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлын бүрэн буюу хэсэгчилэн санхүүжүүлж болно” хэмээн захирагааны байгууллага үйл ажиллагаандaa “гэрээ байгуулах хэлбэр”-ийг сонгот боломжийг нэмэгдүүлж өгсөн хуулийн заалтаас эхлэлтэй байж болох ч зарим талаараа захирагааны эрх зүйн судлаач, эрдэмтдийн судалгаа, шинжилгээний үр өгөөж гэж судлаачийн хувьд ойгогод.

Улмаар 2015 онд батлагдсан Захирагааны өрөнхий хуульд “захирагааны гэрээ” гэсэн нэр томъёог албан ёсоор хуулийнхаас өмнө холбогдох хуулиудад

захирагааны уйл ажиллагааны зарим хэлбэрийг “захирагааны гэрээ” байгуулж замаар хэрэгжүүлж талаар хуулийнисан. Гэвч ийнхүү албан ёсоор хуулийнлагахаас өмнө бодит байдал дээр нийгэмд захирагааны гэрээтийг холбогтой сарилщаа үүсч, өөрчлөгдж, дуусг авар болж тасралтгүй гнижин хэлээгээй оршин байсан бөгөөд захирагааны гэрээний маргааны захирагааны шүүхээр харьялдуулан шийдвэрлэх хандлага төлөвшиж байсан иргэний хэргийн шүүхийн шийдвэрт судалгаа, дун шинжилгээ хийх явцад илрүүлсэн юм.

Иргэний хэргийн шүүхийн маргааны<sup>4</sup> баатар хувийг эзлэх захирагааны гэрээтийг холбогтой маргаануудаас жишээ болгон татаж, захирагааны гэрээний талаар нарийвчилсан зохицуулалт бидэнд хэрэцээтэй байсан талаар тайлбарлах гж оролцдээ.

**1. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхны шатны шүүхийн шүүгчийн 2016 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 2716 дугаар захирамжилж тухай:** “Дэл трейд” ХХК-аас Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Тээврийн газарт холбогдуулан “Нийслэлний Тээврийн газрын 2013 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 1328 тоот гэрээ цуцалсыг мэдэгдэх тухай актыг хүчингүй болтуулах, нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэн гүйцэтгэх 2012 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн туслах шугамын, 2012 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн буухна шугамын гэрээнүүдээс учирсан хохиролд 138 075 036 төгрөг гаргуулах” шаардлага бүхий нээмжлэл гаргасан байна.

Шүүхээс хэрэг хэлэлцэх явцад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 117 дугаар зүйлд заасан үндэслэл тогтоогдох байх тул хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх нь зүйтэй гэж үсээн. Учир нь, ... нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэн гүйцэтгэх 2 төрлийн гэрээний агуулга, зорилгоос үзэхэд здээр гэрээ нь нийтийн эрх зүйн харилцааны

<sup>4</sup> <http://shuuukh.mn>

шинжийг агуулсан гүйцэтглийн гэрээний үндсэн дээр үүссэн маргаан гэж үзэхээр байна. Гэрээний нэг тал болох хариуцагч Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг болох Нийслэлийн Тээврийн газар нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11-т заасан субъект гэж үзнэ. Нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэн гүйцэтгэх 2 төрлийн гэрээг захиргааны байгууллагас нийтийн эрх эүйн хүрээнд эрх зүйн харилцаа үүсгэх, өөрчилж дуусгавар болох эрх зүйн хэмжээнд нийцүүлэн хийгдсэн гэрээ юм гэж дутгэнэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлд заасны дагуу хэргийн харьялал зөрчсөн тохиолдолд нэхэмжлэлийн хүлээн авахаас татгалзана гэх заасныг үндэслэн хэргийг хэрэгсхгүй болгосон байна.

**2. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 101ПШ20162519 дүгээр шийдвэрлийн тухай:** “Рич голден буулс здууэши” ХХК-ас Монгол Улсын Засгийн газарт холбогдуулан “Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 354 дүгээр тогтоолыг хүчингүй болгуулах” шаардлага бүхий нэхэмжлэл гаргасан байна.

“Рич голден буулс здууэши” ХХК нь Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн “Концессын гэрээ байгуулах эрх олго тухай” 49 дүгээр тогтоолыг үндэслэн “Бага сургууль, цэцэрлэгтийн цогцолбор төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ”-г Монгол Улсын Засгийн газраас эрх олж авсан эрх бүхий этгээд болох Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатартай байгуулсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн “Концессын гэрээ цушил тухай” 354 дугаар тогтоолоор “Рич голден буулс здууэши” ХХК-тай байгуулсан концессын гэрээг цушихыг Хөрөнгө оруулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэг С.Жавхланбаатарт даалгаж, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 2

дугаар сарын 09-ний өдрийн “Концессын гэрээ байгуулах эрх олго тухай” 49 дүгээр тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэжээ.

“Рич голден буулс здууэши” ХХК нь шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээ “... 2015 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар концес эзэмшигч “Рич голден буулс здууэши” ХХК-д мэдэгдлгүйээр концессын гэрээг цушилж концессын эрхийг “Топ Интернэшил Иженеринг Монголия” ХХК-д ширжүүсэв нь Иргэний хуулийн 204 дүгээр зүйлийн 204.1-д аль нэг тал нь гэрээнээс татгалзах бол энэ тухай нөгөө талдаа мэдэгдэнэ гэж заасныг зөрчсөн. Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 354 дүгээр тогтооб концессын гэрээний 1.16-д заасний дагуу гэрээг цушихыг Хөрөнгө оруулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Жавхланбаатарт даалгасан байдал бөгөөд гэрээний 1.16 дахь заалт гэрээний 1.13.2-т заасан үргээ гүйцэтгэгүй бол гэрээг цуших асуудлыг ... шийдвэрлэн гэж заасан байдаг. Гэтэл гэрээний 1.13 дахь хэсэгт 1.13.2 гэсэн заалт байхгүй. Засгийн газар 354 дүгээр тогтоолыг гаргахдаа гэрээнд заагдаагүй үндэслэлээр гэрээг цушилсан үндэслэлтүй тогтоол гаргасан ...” гэж тайлбарлажээ.

Хариуцагч Монгол Улсын Засгийн газар нь нэхэмжлэгчийн шүүхэд гаргасан нэхэмжлэлийн татгалзаж буй үндэслэлээ “... концес эзэмшигч нь төслийн эхийн эзлжийн санхүүжилтийн 30 хувьтай тэнцэх 18 сая ам.долларыг Монгол Улсын али нэг арилжаанаа банкин дахь өөрний дансанд концессын гэрээнд гарын үсэг зурснаас хойш 1 (нэг) сарын дотор байршиулах үүргэгээ боловч энэ үүргээ билүүлэлгүй. Гэрээ хүчин төгөлдөр болоогүй байгаа нехцэлдэд гэрээнээс татгалзах тухай нөгөө талдаа мэлэглэх ёстой байсан гэж тайлбарлах нь үндэслэлтүй. Нэхэмжлэгч тал эрх бүхий этгээдэд гаргаж өгсөн бичигтээ гэрээний 1.13.2 гэсэн заалт байдаг гэдгээ хүлээн зөвшөөрсөн. Гэрээн дээр техникийн алдааны улмаас 1.13.2 гэж бичигдээгүй нь төдийлөн ач холбогдолтой

гэж узсгүй байна ...” гэж тайлбарласан байна.

Шүх хэргийт шнийдвэрлэждээ “Концессын тухай хуулийн 3.1.3-т “концессын гэрээ” гэж концессыг хэрэгжүүлжээр эрх бүхий этгээд, концесс эзэмшигч нарын хооронд бичгээр байгуулсан гэрээг”, 3.1.4-т “концесс эзэмшигч” гэж энэ хуульд заасан журмын дагуу концесс авсан Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд, түүний иэтгэлийг”, 3.1.7-д “эрх бүхий этгээд” гэж төрийн өмчийн концессын зүйлийн хувьд концессын асуудлаар эрхэлсэн төрийн захирагааны байгууллагыг, орон нутгийн өмчийн концессын зүйлийн хувьд аймаагийнслэлийн Засаг даргыг” хэлнэ гэж тус тус тодорхойлжээ. Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д зааснаар Засгийн газар нь концессын асуудлаар төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтыг батлах, концесс олгох шийдвэр гаргаж, концессын гэрээ байгуулах эрхийг энэ хуулийн 6.2-т заасан байгууллагад олгох, концессын тухай хууль тогтоомжийн хэрэгжлийн талаар Улсын Их Хурлын Эдийн засгийн байнтлын хороонд жил бүр мэдээлэх, хууль тогтоомжийд заасан бүсэд бүрэн эрхийг хэрэгжүүлжээр заасан бөгөөд харин Засгийн газарт концессын гэрээг цушлах бүрэн эрхийг хуулиар олгоогүй байна.

Концессын гэрээг цушлах бүрэн эрх нь Концессын тухай хуулийн 3.1.7-д заасан эрх бүхий этгээдэд хамаарах бөгөөд эрх бүхий этгээдийн бүрэн эрх нь мөн хуулийн 19 дутгээр зүйлийн 19.1-д зааснаар Засгийн газраас гэрээ байгуулах зөвшөөрөл олгогдоноор хэрэгжих юм. Хариуцагч Монгол Улсын Засгийн газар нь 2015 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн “Концессын гэрээг цушлах тухай” 354 дугаар тогтоолыг гаргахдаа Концессын тухай хуулийн 24 дутгээр зүйлийн 24.2.3-т “концесс эзэмшигч концессын гэрээгээр хүлээсэн үргээ гүйцэтгэгүй буюу зохих ёсоор гүйцэтгэгүй нь гэрээнд зааснаар гэрээг цушлах үндэслэл болсон” гэсэн заалтыг үндэслэл болгосон ба хуульд зааснаар тухайн нөхцөл байдал бий болсон

тохижолдолд гэрээг цушлах эрхийг мөн хуулийн 24 дутгээр зүйлийн 24.2-т заасан эрх бүхий этгээд хэрэгжүүлжээр байна. Өөрөөр хэлбэл, Концессын хуульд гэрээ цушлах эрхийг гэрээний нэг тал болох эрх бүхий этгээд хэрэгжүүлжээр заасан байхад Монгол Улсын Засгийн газар нь хуулиар олгогдоогүй бүрэн эрхийг хэрэгжүүлж, эрх бүхий этгээдийн өмнөөс концессын гэрээг цушласан шийдвэр гаргасан нь хууль үндэслэлгүй байна” гэж дүгнэх, ижэмжилэлийг хангаж Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн “Концессын гэрээг цушлах тухай” 354 дутгээр тогтоолыг хүчингүй болгожээ.

3. Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 989 дутгээр магадлалын тухай: Дээрх шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч хариуцагч болон гуравдагч этгээдээс давж заалдах шатны шүүхээс шүүхийн шийдвэр хууль -ынши бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангагүй байна гэж үзээд шийдвэрийг хүчингүй болгож, ижэмжилэлийг хэрэгсжгүй болгосон.

Ингэждээ “Монгол Улсын Засгийн газар нь Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т “концесс олгох шийдвэр гаргах, концессын гэрээ байгуулах эрхийг эрх бүхий байгууллагад олгох бүрэн эрхтэй” тул концессын гэрээ цушлах шийдвэр гаргасан нь хуульд нийцжээ. Дээрх концессын гэрээ нь Иргэний хуулийн 189 дутгээр зүйлийн 189.1 дэх хэсэгт заасан гэрээ чөлөөтэй байгуулах, түүний агуултыг өөрсдөө тодорхойлохоор зохицуулсантай нийцсэн бөгөөд ут гэрээний үүрэгтэй холбоотой маргааныг шийдвэрлэхдээ мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт зааснаар нарийвчлан зохицуулсан буюу Концессын тухай хуулийн заалтыг хэрэглэх байтал шүхх Иргэний хуулийн 204 дутгээр зүйлийн 204.1 дэх хэсэгт заасан гэрээнээс татгалзах журам үйлчилэх гэж дүгнэсэн нь буруу болгээ. Талууд гэрээний 1.13-т заасан нөхцөл хангагдсан эсэх талаар

хамтран дутгылт гаргаснаа гэрээ хүчин төгөлдөр болохоор тохирсон байдаг бөгөөд ихээмжлэгч өөрийн зүгээс гүйцэтгэвэл зохих үүргээ зохих ёсоор биелүүлсэн нь хэрэгт авагдсан баримтаар тогтоогдсонгүй.

Талуудын байгуулсан гэрээний 1.16 дахь хэсэгт гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөл хангалаагүй тохиолдолаа эрх бүхий этгээд гэрээг цулаах эсэх асуудлыг Застийн газарт тавьж шийдвэрлүүлнэ гэж Концессии тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.3 дахь хэсэгт заасан, концесс зэмшигч концессийн гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэгүй буюу зохих ёсоор гүйцэтгэгүй нь гэрээнд зааснаар гэрээ цулаах үндэслэл бүрдсэн тул Монгол Улсын Засгийн газар эрх хэмжээнийн эз хүрэнд хуульын заасан үндэслэл зааж концессийн гэрээг цулаахыг Хөрөнгө оруулалтын газар даалгак шийдвэрлэснийг зөв гэж үзүүлэх эзэмшиг дутгыссын байна.

Ийнхүү маанай улсад 2015 онд батлагдсан Захиргааны срөнхий хууль 2016 оны 7 дугаар сард мөрдөгдөж эхлэх хүртэл “гэрээ” гэдэг ойлголтыг нийтлэг байдлаар иргэний эрх зүйн асуудал гэж ойлгож, шийдвэрлэх ирсэн бөгөөд “захиргааны гэрээ”-ийн талаар тодорхой зохицуулалт, шалтуур хараахан хуулиялгагаагүй, гагцхүү онолын түвшинид изгасан ойлголтод хүрээхэр чармайж байсан. Иймд захиргааны хэргийн шүүх харьялан шийдвэрлэхгүй маргааны нэг болж орхигдсон захиргааны гэрээний маргаан шүүхийн хяналтаас гадуур үлдэх аюултай байсан учир иргэний хэргийн шүүх гэрээний зохицуулалтыг шүүхчийн дотоод итгэл үзүүмшил, хуулын үндэслэл зарчим, эрх зүйн эх сурвалжийн эрэмбэ дараалал зэрэгт үндэслэн шийдвэрлэсэн нь шүүх хэрэг хялан шийдвэрлэх бүрэн эрхээ хэрэгжүүлсэн хэрэг юм.

Негоотгэгүүр захиргааны хэргийн дагисан шүүхтэй атлаа захиргааны эрх зүйн бие даасан судлгадаахуун болох захиргааны гэрээний талаарх ойлголт, зохицуулалтыг орхиждуулснаас захиргааны байгууллага болон хувийн хшилийн байгуулсан гэрээний агуулга, зорилгыг

үнэлж, нийтийн эрх зүйн харилцааны шинжийг агуулсан гэрээний маргаан гэж дутгыж “Гэрээний нэг тал болох харинуучи Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг болох Нийслэлийн Тээврийн тавар нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11-т заасан субъект гэж үзүүлэх эзэмшиг хэргийг хэрэгжүүлж болгосон нь мөн л нийтийн эрх зүйн маргааныг хувийн эрх зүйн маргаанаас ялгах гэсэн зохицтийн оролдлого мөн.

Шинээр батлагдан мөрдөгдөж буй Захиргааны срөнхий хуульд захиргааны гэрээ гэх ойлголтыг тусгай бүлэг болгон “Захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчилж, эсхүл дуусгавар болгохоор захиргааны гэрээг эрх зүйн хэмжээнд нийтийн байгуулж болно”<sup>9</sup> гээд териин алба, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах болон бусад захиргааны эрх зүйн харилцаанд, захиргааны байгууллагаа өөрийн зарим чиг үүрэг, эрх мэдлийг бусад этгээдэд шийлжүүлэх харилцаанд, дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг бий болгох, тогтвортой ашиглахтай холбогдсон харилцаанд, концессийн харилцаанд болон хуульд өөрөөр заасан бусад харилцаанд захиргааны гэрээг хэрэгжэж болохоор заасан.

Хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор “Эрх зүйн боловсрол” академи болон Ханис-Зайдэлийн сангаас гаргасан Захиргааны срөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, судалгааны тайлан<sup>10</sup>-д захиргааны гэрээний тухай ойлголт, зохицуулалтыг өөрчлөх, хүчингүй болгох шаардлагатай эсэхийг дүгнэлт хийхээд “ЗЕХ хэрэгжих эхэлсэнээс хойшах байгуулсан гэрээнд ЗЕХ-ийн холбогдох заалтыг үндэслэгүй, захиргааны байгууллага тэгш эрхийн харилцаа /иргэнэй эрх зүйн харилцаа/ эсхүл нийтийн эрх зүйн харилцаанд захиргааны гэрээ байгуулж байгаа эсэх тухай төрөлжүүлэгүй,

<sup>9</sup> Захиргааны срөнхий хууль, 52 дутгавар зүйлийн 52.1 дахь клэшт.

<sup>10</sup> “Эрх зүйн боловсрол” академи Ханис-Зайдэлийн сан, Захиргааны срөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, судалгааны тайлан, УБ, 2018 он.

мөн ЗЕХ-тай холбогдуулан байгуулсан гэрээний загварт өөрчлөлт ороогүйт харвал захирагааны гэрээний тухай ойлголт хэвшээгүй, тухайн салбарын хууль болон өмнө нь хэрэгжүүлж ирсэн туршлагаар дээрх харилцаа үргэлжилж байна. Захирагааны гэрээтэй холбоотой маргаан шүүхийн практикт цөөн боловч гарч байна. Одоогоор дийлэнх маргаан шүүхийн шатанд эцэслэн шийдвэрлэгдээгүй буй тул дүгнэлт хийх боломжтүй байна. ... ЗЕХ-ийн захирагааны гэрээний зохицуулалтыг практикт хийгдэж буй гэрээнд хэрэглэхийг захирагааны байгууллагуудад таниулах хэрэгээ шаардлага тулгамдах байна. ЗЕХ-ийн захирагааны гэрээтэй холбогдох зохицуулалтад зайлшгүй нэмэлт, өөрчлөлт оруулах хүчиннүүг болгох шаардлагагүй байна”<sup>11</sup> гэсэн нь дээр дурдсан “өдгөө хүргэл захирагааны гэрээг байгуулж, үйл ажиллагааны хэлбэр болгон сонгон ажилладаг төрний эрх бүхий албан тушаалтууд, тэдээргээ гэрээ байгуулан ажиллаж байгаа хувийн хэвшлийн төлөөлөгч иарт захирагааны гэрээний талаар ойлголт дутмаг байгаа нь ажиллагддаг” гэх судлаачний таамгийн батгатгажээ.

Зарим судлаачдын узүүг байгаагаар захирагааны гэрээний нэг төрөл болох Концессын гэрээ нь хэдийгээр нийтийн эрх зүйн хууль тогтоомжоор зохицуулагдах харилцаа мөн боловс Захирагааны гэрээ: Концессын гэрээ буюу түүнээс узүүс маргааныг хянан шийдвэрлэх харьяаллын асуудал нилтгэлд<sup>12</sup> захирагааны гэрээний төрөл болох Концессын гэрээний маргааны харьяаллыг тодорхойлоодо зөвхөн Концессын гэрээний талаар маргааны харьяаллыг онцолбол хуульд зааснаар Концессын гэрээний талуудын хооронд үүссэн аливаа маргааныг гэрээгээр харилцаан тохиролцсон аргаар шийдвэрлэн хэмээн заасан байна. Гэрээгээр харилцаан тохиролцсон аргын талаар тодруулбал, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай

<sup>11</sup> “Эрх зүйн боловсрол” академик Хансис-Зайделийн сан, Захирагааны ерөнхий күүлийн хэрэгжлийн үр дагварыг хийсэн чиглэл, судлаачны тайлбар, УБ, 2018 он, 262 дахь тал.

<sup>12</sup> Сүнжид Д., Баармын Н., Захирагааны гэрээ: Концессын гэрээ буюу түүнээс үзүүс маргааныг хянан шийдвэрлэх харьяаллын асуудал, УБ, 2016 он.

хуулийн 13.2-т зааснаар Монгол Улсын олон улсын гэрээнд заасан буюу зохиц хэлэлцэн тохиролцсон бол иргэн, хуудийн этгээдийн хооронд үүссэн маргааныт арбитр шийдвэрлэнэ. Тиймээс Концессын гэрээний талууд арбитраар маргаана шийдвэрлүүлэхээр харьцаан тохиролцож боломжтой байхаа. 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгвэлжүйлчилж эхэлсэн Захирагааны ерөнхий хуулиар захирагааны гэрээг анх удаа хуулиар тодорхойлж зохицуулсан. Тиймээс Концессын тухай хуулийн гэрээний маргааны харьяаллын зохицуулалт ба Захирагааны ерөнхий хуулийн гэрээний маргааны харьяаллын зохицуулалтын хүрээнд Концессын гэрээний маргааны харьяаллыг хэрхэн тодорхойлох талаар “Захирагааны ерөнхий хуулийн 52.1, 52.2 ба Захирагааны хэрэг шүү хад хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн зохицуулалтас Концессын гэрээ нь захирагааны гэрээ байх боломжтой бялгэд түүнээс үүссэн маргаан нь Захирагааны хэргийн шүүхэд харьяалгахаар байна. Концессын гэрээнд талууд хэрэв арбитраар маргаана шийдвэрлүүлэхээр заасан тохиолдолд л маргааны харьяалыг нь талуудын харилцаан тохиролцсон уг аргазар тодорхойлогдоно. Хэрэв Концессын гэрээ байгуулагч талууд гэрээндээ арбитраар маргаан хянан шийдвэрлэхүүлэхээр сонгоогүй тохиолдолд уг гэрээний маргааныг хянан шийдвэрлэх субъект нь Монгол Улсын захирагааны шүүх болно. Талууд сонгосон тохиолдолд маргааны арбитрын журмаар шийдвэрлүүлж боломжтой бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмын нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сууринлна”<sup>13</sup> гээсээ.

Дээрх байдлаар захирагааны гэрээний маргааны шүүхийн харьяаллын асуудлыг эрдэмтэн, судлаачид өөр өөрийн судалгааг үндэслэн яэн бүрээр тодорхойлж байгаа нь “Захирагааны гэрээ”-ний маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар нэг мөр ойлголтой болохыг зорьж буй хэлбэр мөн.

<sup>13</sup> Сүнжид Д., Захирагааны гэрээ: Концессын гэрээ буюу түүнээс үзүүс маргааныг хянан шийдвэрлэх харьяаллын асуудал, УБ, 2016 он.

Иргэн, хуулийн этгээдийн захиргааны хэргийн шүүхэд хандан гаргасан нэхэмжлэлийн шаардлага нь дан ганц захиргааны акт (жишээ нь тусгай зөвшөөрөл олгосон) төдийгүй түүний “урьдач нөхцөл” эскул “үйлчлэлийг хадгалах нөхцөл” болсон захиргааны гэрээзэр хослуулсан зохицуулагдсан үйл ажиллагааг хянуулах тухай бол өнөөгийн хуулний зохицуулалтаар ч захиргааны хэргийн шүүх цогцоор нь хамтатан шийдвэрлэх нь илүү зохижтой мэт. Түүчинчлэн Захиргааны хэргийн шүүхээр хянгадах буй маргаан бүхий захиргааны актын хууль зүйн үндэслэлийг хянахад “захиргааны гэрээ” нотлох баримтав ашиглагдах тохиолдол нилээд элбэг байдал. Зарим гадаад орны туршилагаас үзвэл нийтийн эрх зүй дэх захиргааны гэрээ захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгддэг тохиолдол байна. Жишээ нь Лативийн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нийтийн эрх зүйн гэрээ хуульд харшилсан, зөрчсөн гэсэн үндэслэлээр нэхэмжлэл гаргах эрхтэй байдгийг тодорхойлж, эн дагуу шүүх уг гэрээг хууль буу болгохыг зарласан угтатай шийдвэр гаргаж болдог байна.<sup>14</sup>

Манай улс эрх зүйн эх газрын бүлд хамаардаг бөгөөд эх газрын эрх зүй тогтолцоотой хөгжингүй улсын гол төлөөлгөч болох ХБНГУ-ын практикт захиргааны гэрээгээр зохицуулж буй үйл ажиллагаанд шүүхийн зэрэгцээ хуулний болон мэргэжлийн хяналтын байгууллагууд хяналт тавьдаг. Эрх зүйн бодит шаардлагыг зөрчсөн эсвэл нийтийн ашиг сонирхлын серөг тал дээр үндэслэгдэж буюу аливаа хяналтын гадна оршиж захиргааны гэрээнүүдийн хувьд маргаантай нөхцөл байдал бий болдог. Учир нь түүний эрх зүйн зөрчил эсвэл хүчингүй болгох нөхцөл тодорхой бус байдал бөгөөд ямар тохиолдола хуулийн би мэргэжлийн хяналтын байгууллагудын хяналтад хамрах боломжтой вэ гэдгийг тодруулах шаардлагатай болдог.<sup>15</sup> ХБНГУ-д захиргааны гэрээг байгуулахад гэрээний

<sup>14</sup> Ц.Цогт, Хэвлэхүүгийн эмчилгээн 2017-2018, №6., 2018 он.

<sup>15</sup> Олдгарын П., Закиргааны гэрээний эрх түүн зохицуулалтын төвлөвшүүлэх нь, Уб., 2006 он, 88 дэх тал.

ядаж нэг тал нь хуульд заасан захиргааны эрх зүйн үндэслэлтэй байхыг шаарддаг. Өөрөөр хэлбэл, гэрээний изг тал болох хуулнар тусгайлан эрх олгогдсон захиргаа би нөгөө тал болох бие даасан хувь этгээд гэсэн эрх зүйн хоёр өөр систем гэрээний хэлбэрээр харилцаан тохиолцон хамтран ажиллах нөхцөл байдлыг бий болгодог. Иймд захиргааны гэрээний зохицуулалт нь өөрийн гэсэн систем тогтолцоу ба нийтийн эрх зүйн суурь зохицуулалтанд тохиорсан байх ёстой болдог. Захиргааны этгээдүүдийн хооронд эсвэл захиргааны этгээд ба хувийн эрх зүйн субъектын хооронд байгуулсан хувийн эрх зүйн бус захиргааны гэрээтэй холбоотой маргаан нь захиргааны эрх зүйн замаар хянан шийдвэрлэгддэг. Захиргааны гэрээ өөрөө захиргааны эрх зүйн нэгэн институт учир түүнтэй холбогдон гарсан албанаа нэхэмжлэл нь захиргааны процессын хуулийн 40 дагуу захиргааны шүүхээр хянан шийдвэрлэгддэг байна.<sup>16</sup>

## ДҮГНЭЛТ

Захиргааны гэрээний талаарх ойлголт, практик хэрэгжилт, тулгамдааж буй асуудлын талаар судалж үзсэндэй үзэсгээд захиргааны гэрээний талаарх ойлголт, зохицуулалт хангалийтай сайн хуульчлагдсан гэсэн дүгнэлтэд хүрч байна. Харин албанаа хуулийн хэрэгжилтийн асуудал хамгийн хүнд сэдэв байдгийн хувьд захиргааны гэрээг үйл ажиллагаанд ашиглаж байгаа байгууллагуудыг захиргааны гэрээний талаар нэгдсэн ойлголтой болгох, хуульд заасан шаардлагыг хансасан захиргааны гэрээний стандарт загварыг нэвтрүүлэх зэрэг ажлуудыг хийх хэрэгээг шаардлагаа үүсээд байгаа төдийгүй хууль хэрэгжээд бодигаа хугацаа өнгөрч байгаа учир маргааныг шийдвэрлэхэд ямар асуудал үүсч байгаа талаар ирээдүйд практик дун шинжилгээ хийх нь хуулын, судлаачдын үндсэн үүргэ мөн биз ээ.

Ингээдээ захиргааны гэрээ нь захиргааны эрх зүйн нэг судлалдахуун болохын хувьд төдийгүй зохицуулалт зүйл, зохицуулалт хэм хэмжээ нь нийтийн эрх

<sup>16</sup> Олдгарын П., Закиргааны гэрээний эрх түүн зохицуулалтын төвлөвшүүлэх нь, Уб., 2006 он, 89 дэх тал.

зүйн (үндсэн хуулний эрх зүйд хамаарахас бусад) асуудал мөн болохыг дүгнэх шалгуур аргачлалыг тогтоож өгөх нь зүйтгэй гэж үзэж байна.

Түүнчлэн захирагааны гэрээний онцлогийг харгалзан үзэж, захирагааны гэрээнд иргэний хуулийн зохицуулалтыг нөхөн тохируулж хэрэглэх асуудлыг Захирагааны ерөнхий хуульд зохицуулсан учир захирагааны гэрээний маргааныг хянан шийдвэрлэхдэд анхаарах асуудалд харьяаллын олон сонголт гарч ирх байгааг гэрээний зохицуулалтын хүрээ, зорилтыг харгалзан үзэж, маргааны зүйлийг зөв тодорхойлсны үндсэн дээр шийдвэрлэх нь ач холбогдолтой байна. Гэвч хэрэггүй харьялан шийдвэрлэх байгууллагын<sup>17</sup> шинж чанар, шийдвэр болелгэдэхтэй холбоотой зохицуулалт, тухайблал Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 11 дутгээр зүйлийн 11.1-д “Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрлийг иргэн, хуулийн этгээд засалв биелүүлнэ” гэх засалтыг захирагааны байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлэхдээ Захирагааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дутгаар зүйлийн 12.2-т “Захирагааны хэргийн шүүхийн шийдвэрлийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа холбогдох захирагааны байгууллага, хуудийн этгээд, албан тушаалтан, хүн засалв биелүүлэх үүрэгтэй бөгөөд сайн дураар биелүүлэгээй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэн” гэх зохицуулалт адил мөрдөх эсэх, ялангуяа захирагааны байгууллага, албан тушаалтан нь иргэний болоод арбитрын шийдвэрлийг биелүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын маргаантай асуудал тулгарч болохыг урьдчилан тооцоолих шаардлагатайг орхигдуулж болохгүй юм.

Судлаачийн хувьд нийтийн эрх зүйн маргаан, тэр дундаа захирагааны гэрээний маргааны хэргийн харьяалал дээрх нөхцөл байдалтай хамааралтайгаар “захирагааны шүүх”-ээр хянан шийдвэрлэгдэх нь илүү зохицжийт гэж үзэг ба Захирагааны ерөнхий хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу Иргэний хуульд заасан гэрээний

суурь зохицуулалт нэгэн адил үйлчлэх, түүнийг нөхөн тохируулж хэрэглэхдээ цийтийн эрх зүйн зарчмын тайлбаруудаа захирагааны үйл ажиллагаа болон захирагааны гэрээнд тохира байгаа эсэйийг нягтлан шалтаж тохируудаа хэрэглэж боломж нь “захирагааны шүүх”-д илүү давамгай гэдэг нь зргэлзэгүй.

### Ном зүй

#### Монгол ёх сурвалж:

1.Чимиджийн Б., Төрийн засак ёс, Улаанбаатар хот, 2018 он  
2.“Эрх зүйн боловсрол” академи Ханис-Занделийн сан, Захирагааны сөрөнхий хуулийн хэрэгжилтийн үр дааварт хийсэн үзүүлэлт, судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2018 он

3.Монголын Хуульчдын холбоо, Захирагааны эрх зүйн хорооноос хэвлүүлсэн Хэлэлцүүлгийн эмхэтгэл 2017-2018, Улаанбаатар хот, 2018 он

4.Сүнжид Д., Баярмаа Н., Захирагааны гэрээ: Концессиин гэрээ буюу түүнээс үүсжж маргааныг хянан шийдвэрлэх харьяаллын асуудал, Улаанбаатар хот, 2016 он

5.Одгэрэл П., Захирагааны гэрээний эрх зүйн зохицуулалтыг төлөвшүүлж нь, 2006 он

#### Гадаад ёх сурвалж:

<https://germanlawarchive.iuscomp.org/?p=289>

Administrative Procedure Act (Verwaltungsverfahrensgesetz, VwVfG)

### Хууль тогтоомж:

1.Захирагааны ерөнхий хууль, 2015 он  
2.Захирагааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2015 он

3. Захирагааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он  
4.Монгол Улсын Засгийн газрын тухай, 1993 он

5.Засгийн газрын тухай хууль, Улаанбаатар хот, Улсын дээд шүүхийн тогтоол, Иргэний зарим хэргийн харьяаллыг захирагааны хэргийн харьяалаас зааглан ялгах тухай, 2007 он

### Цахим ёх сурвалж:

<http://legaldata.mn/buteel/pdf?id=214>

<sup>17</sup> “Байгууллага” гэмэгт шүүх болон арбитрыг хамааруулсан болго.

## ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ



Хуулын А. Тувшинтсэг

### ТҮЛХҮҮР ҮГС:

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, газар эзэмших эрх, ашиглах эрхийн изгэж, газар эзэмших эрх, ашиглах эрх

### ТОВЧЛОЛ:

Тус судалгаагаар гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж Монгол Улсын хуулийн этгээд мөн боловч яагаад газар эзэмших эрхтэй бус ашиглах эрхтэй байгаад талаар тодруулж, тайлбарласан бөгөөд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж газар ашиглах эрхтэй гэж судлаачийн зүгээс судалгааны дүгнэлтэд үндэслэн дүгнэсэн болно. Газрын тухай хуулийн зохицуулалт, хуулийн узэл баримтлаасаас дүгнисн үзэж Газрын харилцаа үндэсний өв уламжлал, тусгаар тогтолцоны узэл санаанд уламжлагдан боловсруулагддаг бөгөөд энэ үүднээс Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь газрыг ашиглах эрхтэйгээр эдлэх боломжтой болох нь харагдаж байна.

Шүүхийн практикт гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг газар эзэмших эрхгүй өөрөөр хэлбэл, Монгол Улсын аж ахуйн нэгж биш гэж шийдвэрлэсэн хэд хэдэн тохиолдол гарсан. Мөн Гадаадын хөрөнгө оруулалттай аж

ахуйн нэгж эзэмших эрхтэй газрыг Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас шилжүүлэн авах эрхтгүй байгаа талаар газрын тухай хуульд тусгасны нэг мөр ойлгож, тайлбарлах шаардлага үүсч байгаа болно. Энэхүү өгүүлэлд гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн онцлог, газар эзэмших, ашиглах эрхийн ялгаа, газрын тухай хуульд тусгассан субъектийн эрхийн ялгамжийн онцлог, шүүхийн практикийг хөндөж, тайлбарласан болно.

### Нэг. Газар эзэмших эрхтэй холбоотой асуудал

#### 1.1 Газрын эрх зүйн харилцааны субъектийн ойлголт, хамрах хүрээ:

Газрын хууль тогтоомжид заасан эрх эдэлж, үүрэг билүүлж газрын эрх зүйн харилцаанд оролцогчдыг газрын эрх зүйн субъект гээц. Субъект нь газрын эрх зүйн харилцааг тодорхойлон тогтоох, үүсгж, өөрчлөх, дуусгавар болгох, тодорхой эрх эдэлж, үүрэг билүүлэн уг харилцаанд оролцож газар өмчлөх, эзэмших, ашиглах, хамгаалах зэрэг эрх зүйн янз бүрнийн байдалтай холбоотой байдаг<sup>1</sup>. Энэ нь тухайн субъектийн газрын эрхийн чадвараас хамаарна. Зарим субъект газрыг өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг зэрэг эдэлж байхад зарим нь эзэмших, ашиглах эрхийг хамтад нь буюу дангаар эдэлдэг. Ингэж ялгамжтай байдаа тогтооши шалтгаан нь улс орны онцлог, хүн амын уламжлал, газрын эрх зүйн суурин зарчмуудтай холбоотой. Газрыг Монгол Улсын арван найман насанд хүрсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, сууши өмчлөгчдийн холбоо, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улсын болон олон улсын байгууллага, гадаад улсын хуулийн этгээд эзэмшиж, ашиглах эрхтэй. Дээрх субъектүүд газар

<sup>1</sup> Т.Сингээрж. Монгол Улсын газрын эрх зүй, УБ., 2002 он, 38 дахь тал.

эзэмшиж, ашиглах, эрх зүйн харилцаанд оролцогчид байна. Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн газар эзэмшиж, ашиглах эрх нь гадаадын иргэн, харьяалалгүй хүй, аж ахуйн нэгжийн эзлэх эрхээс ялгамжтайгаар тусгагдсан. Харин газрын зүй зохицтой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх талаар аль ч субъектийн хүлээг үүрэг үндсэндээс нийтлэг байна<sup>2</sup>.

Газрын эрх зүйн харилцааны субъектүүдийн дотор “Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж” нь изэхэн онцлогтой субъект байдаг. Монгол Улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлний 38.1-т “Газар эзэмших эрхийг гэрчилгээг хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр бусад шилжүүлэх, барьцаалж болно. Эрхийн гэрчилгээг бусад шилжүүлэх, барьцаалах үйл ажиллагаа нь зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд явагдана” гэж заасан байна. Тус зохицуулалтаар газар эзэмших эрхийг олж авсан этгээд газар эзэмших эрхийн гэрчилгээг зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлэхээр зохицуулжээ. Харин практикт гадаадын хөрөнгө оруулалттай компанийд газар эзэмших эрхийн шилжүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэхээд газрын тухай хуулийн б дугаар зүйлийн 6.3 болон 44 дутгээр зүйлийг үндэслэл болгон газар эзэмших бус ашиглах эрхтэй байна гэж шийдвэрлэж байна. Хэдийгээр гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд Монгол Улсын аж ахуйн нэгж мөн боловч газрыг эзэмших бус ашиглах эрхтэй гэж шүүх шийдвэрлэж байгааг хуульд тайлбар хийж замаар тайлбарлая.

1.2. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн ойлголт (Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь Монгол Улсын аж ахуйн нэгж үү эсхүл гадаадын аж ахуйн нэгж үү?)

Юун түрүүнд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн ойлголтыг

тодорхойлох шаардлагатай. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хэмээх ойлголтыг Монгол Улсын хөрөнгө оруулалтын тухай хуулийн<sup>3</sup> З лутгаар зүйлийн 3.1.5-д “Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулгасан хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийт гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 мянган америк доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуйн нэгжийг” хэлиэ гэж тодорхойсон байна. Дээрх зохицуулалтын дагуу гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь (1) Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулгасан байх (2) хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийт гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа (3) гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 мянган америк доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх гэсэн гурван шинжийг агуулж байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн “Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулгасан байх” гэсэн шинж нь Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийт Монгол Улсын аж ахуйн нэгж болох нэхцэлийг бурдруулж байдаг. Учир нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгууллагдаж, бүртгэгдэх нь Монгол Улсын хуулийн этгээдийн үндсэн шинж байдагтай холбоотой. Хүчингүй болсон Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн<sup>4</sup> 11 дутгээр зүйлийн 11.2-т “Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь бүртгүүлсэн өдрөөсөө эхлэн Монгол Улсын хуулийн этгээд болох бөгөөд үйл ажиллагаагаа Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу явуулна.” гэж тодорхой зохицуулсан байсан. Харин хүчин төгөлдөр мөрдөгджэвэй Хөрөнгө оруулалтын тухай хуулийн

<sup>2</sup> О.Амархүү, Монгол Улсын орчин цагийн экологийн эрх зүй, УБ, 2009 он, 345 дахь тал.

<sup>3</sup> Газрын тухай хууль, 2002 он, Төрийн мэдээлэл эмхтгэл №27.

<sup>4</sup> Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013 он, Төрийн мэдээлэл эмхтгэл №41.

<sup>5</sup> Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013 он, Төрийн мэдээлэл эмхтгэл №41.

гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг Монгол Улсын хуулийн этгээд болох талаар тодорхой зохицуулаатай байдал.

Дээрх асуудалтай холбоотойгоор шүүхийн практикийг судлан үзжээд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг Монгол Улсын хуулийн этгээд мөн гэмшийдээрэлж байгаа хэд хэдэн шийдвэр, магадлал, тогтоол байх боловч нөгөө талаар Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг Монгол Улсын хуулийн этгээд биш гэмшийдээрэлж бий шүүхийн практик байна. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг Монгол Улсын хуулийн этгээд мөн эсхүл биш гэмшийс хамаараад Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж газар эзэмшигс эрхтэй субъект байх уу эсхүл газар ашиглаж эрхтэй субъект байх уу гэдэгт хариулт өгөх боломжтой болох юм.

**Хоёр. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн газар эзэмшиг, ашиглах эрх ба Үндсэн хуулийн үзэл баримтлал**

### 2.1 Үндсэн хуулийн үзэл баримтлал

Үндсэн хуулийн, газрын талаарх үзэл баримтлалаас үзжээд нэгд, байгалийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох газар, түүний хэвллийн бусад баялагийг онцгойлон үзэж, гагчихуу Монгол Улсын арийн түмний мэдэл, терийн хамгаалалтанд байлагх эрх зүйн оншгийн журамтай болгосон, Хоёрт, тус улсын иргэнд өмчлүүлсизээс бусад газар, мөн газрын хэвллийн бусад баялаг терийн өмчлөх эрхийн объект болохыг хуулиялан тодорхойлсон, Гуравт, бэлчээр, нийтийн эдэлбэрлийн ба улсын тусгай хэрэгцээнийнхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлжэй. Үндсэн хуулийн хэмжээнд анх удаа зөвшөөрсөн. Дорөвт, иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах, бэлзгэлэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалтгүй хүний өмчлөлд шилжүүлэх, түүчинийн терийн эрх, бүхий байгууллагын зөвшөөрлигүй гээр буудад эзэмшиүүлэх, ашиглуулахыг хориглохоср эрх зүйн

байдлыг нь тодорхой хязгаартайгаар тоогосон, Тавт, төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөн олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд байгаль хамгвалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглалт хураан авах, Зургаа, төрөөс гадаадын нргэн, хуулийн этгээд, харьсалалтгүй хүнд газрыг телбер, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, жуurmaар ашиглуулж болох эрх зүйн үндэслэлтийг бий болгожээ<sup>6</sup>.

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн газар эзэмшиг, ашиглах эрхийн асуудалтай холбогдуулан Үндсэн хуулийн үзэл баримтлал, бусад хуулийн уялдаа болгаргод тодруулах шаардлага байна. Газар бол Монгол Улсын түүхээд хууль ёсоор хувийн өмчийн эд зүйл байгаагүй онцлогтой<sup>7</sup>. Энэ нь Монголчуудын аж амьдралын үндсэн хэв маяг нь бэлчээрийн малажахуйн байнсантай их төлөв холбоотой<sup>8</sup>. Түүнээс гадна эрс тэс уур амьстгалтай байгаль цаг уурьин нөхцөл байдлууд ч нөлөөлсон. Орчин үед нийгмийн хөгжлийн зүй тогтолцыг дагалдан хүн амын хотжих, суурьших процесст явагдаж уламжлалт нүүдлийн соёл иргэншилжин хамт суурин соёл иргэншил зэрэгцэн хөгжих болсон бодит амьдралд Монгол Улсын иргэнд

<sup>6</sup> Т.Сэнгдорж. Газран харилцааны эрх зүйн зохицуулалт. УБ., 1997 он. 17-18 дахь тал.

<sup>7</sup> Н.Луундэлзорж. Монголчуудын өмчлөх эрхийн үзэл стяглэгдэхийн уламжлал, шинчилэл. УБ., 2004 он. Шинийн түүхийн зүйн шинжилгээний ухадны онол, арга зүй, мэдүүлэл, 57-58 дахь тал. О.Амархүү “Монгол Улсын газар өмчлөх эрхийн уламжлал, шинчилгэлийн асуудал” УБ., 2005 он. Шинийн түүхийн зүйн шинжилгээний ухадны онол, арга зүй, мэдүүлэл 2005/1-2), 33-34 дахь тал.

“Азийн үйлдвэрлэгчийн аргын онцлогийн хамадч ази-порно дахин шиг оруулад албаны эрхийн стяглэгээ нь европ дахин шиг хөгжөөнүү учраас хувийн өмчийн тулгуурлан хөгжлийн эрхийн бусад институтууд ч удаан хөгжсөн, хөгжим хөгжжэж эхлийн билэг. Монголчуул түүхэндээ газар нутгийн хүн амын өмчилдөгтүй байсан нь итгэдүүрт төвөөс зутгах хувийн сааруулж торийн нэгдэлийн байдлыг хагалдах шаардлагыг, хөбөрдүүгээр нэудийн мэл аж ахуйн технологи нь газар нутгийн өмчилүүгтэйн зэрэг бодижийн явулахыг нөхцөлдүүлжүүлж гэх зүйл болно. Негтоо тайланс хөгжлийн бүтцийн урьжмын давшиг ч нүүдэлжлийн амьдралын нөхцөлбүүлэлтийн лайвт”

<sup>8</sup> Г.Совд нар. Монгол Улсын үндсэн хуулийн тайлбар, УБ., 2000 он, 47 дахь тал.

газар омчлүүлэх шаардлагыг бий болгов.<sup>9</sup> Дээрх нөхцөл шаардлагын дагуу шинэ Үндсэн хуулийн төслийг боловсруулах явцад газрыг өмчлөх харилцааг хэрхэн зохицуулж, тусгах вэ, газрыг зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж өмчлөх үү гэсэн асуудал хэлэлцэгдсэн байdag. Энэ талаар Үндсэн хуулийн эхийг баригч Б.Чимид багш “төслийн тавдугаар зүйл Монгол Улс эдний застгийн бие даасан бодлиг явуулах тухай дурдсан нь улсын тусгаар тогтолцоны гол баталгааны нэг нь эдийн застгийн тусгаар тогтнол мөн байдагтай их холбоотой. Эдний застгийн бие даасан байдлын хуульчлаыг эрмэлзэхээс өмчийн бүх зүйлсийн дотроос газар өмчлөх асуудлыг онцгойлж үзсэн байна. Төсөлд “Газар, түүний хувьлий ...гагсхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гээд “газрыг зөвхөн Монгол Улсын иргээд өмчлүүлж болно” гэсэн учиртай. Энэ хөөр заалт хоорондоо ямар нэг зөрчилгүйн дээр тусгаар тогтиол, иргээдийн эрх хөөрьн аль алийтай нь бас зах зээлнийн харилцаанд орохтой тус тус холбоотой<sup>10</sup>.“ гэж дурдсан байдал.

Газар өмчлөх харилцааны талаарх Үндсэн хуульд тусгагдсан үзэл баримтал нь газрын тухай хуульд тусгагдсан газар, эзэмших, ашиглах харилцааны суурь болж байдал. Учир нь газар эзэмших, ашиглах харилцаан нь газар өмчлөх харилцаанд сууринлан үүсдэг онцлогтой юм. Энэ талаар Үндсэн хуулийн эхийг баригч Бираагийн Чимид багш “Үндсэн хуулийн үзэл баримтлал” бүтээлдээ: “Монгол Улсын иргэн газар нутгийнхаа эзэн юм бол нэгээхэн хэсэг эзлэлбэрийт өмчилж болох, ийнхүү өмчилсөнөөр “нийтийн”, “үнэгүй” зүйлнийг эзэнгэх, хамгаалж дээдлэх нь сайжрах бус уу. Газар өмчлөх эрхийг зөвхөн Монгол Улсын харьяатаар хязгаарласан нь даруй тусгаар тогтнолоо бодсон хэрэг. Нэгэнт ингэж хязгаарласан болохоор өмчилсөн газраа арилжиж,

<sup>9</sup> Г.Соид нар. Монгол Улсын үндсэн хуулийн тайлбар, Уб., 2000 он, 47 дахь тал.

<sup>10</sup> Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг асуудал, Хүний эрх, шүүх эрх мэдэл, нутгийн удирдлагы, Уб., 2017 он, 37 дахь тал.

худалдах, бэлтгэлж буюу хуулийн хэлээр “захиран зарцуулж” өмчлөгчийн “түйлийн эрх” нь зөвхөн Монгол Улсын иргээд хоорондын харилцаа байхаас бус гадаадын элемент эхийн брохгүй гэсэн утга агуулж буй. Даширамд хлблэл, ирээнт гадаадын хөрөнгө оруулыяа, хамтын хөрөнгө оруулсан үйлдвэр солтгийг байгуулж ажиллуульяа гэж байгаа учир гадаадын хийнгээд харьяалалгүй иргээдээ газрыг боломжийн түгээсэлх зэрэгжрээ мэдээж улсын хараа, хянгалттайгээр эзэмшүүлж, эзлүүлж болио байх. Энэ бол эмчигүүнээ хуялданаа гэсэн уг биш!”. Гэж тодорхойжсон байдал. Үндсэн хуулийн үзэл баримтлалаас харалд газрыг зөвхөн Монгол Улсын иргээ өмчлөх байдлаар зохицуулсан зорилго нь Монгол Улсын тусгаар тогтнол, газар бол улсын үндэс, энэ үүднээс Монгол Улсын иргээд зөвхөн өмчилжээ гэх үзэл баримтлалтai холбоотой байна. Харин газар эзэмших, ашиглах харилцааг газрын тухай хуулиар нарийвчлан зохицуулсан бөгөөд дараагийн бүлгүүдэд энэ талаар тодорхой тайлбарлалаа.

## 2.2 Газрын тухай хууль ба газар эзэмших, ашиглах эрх

Энэхүү бүлэгт газрын тухай хуульд тусгагдсан газар эзэмших, ашиглах эрхийн ялгаа, газрын тухай хуулийн үндсэн зарчмын болон газар эзэмших эрхийн уялдаа холбоо, үзэл хандлага, болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн ижгэж газар эзэмших эрхийтую эхслэх ашиглах эрхтэй юу гэдгийг тодруулан тайлбарлалаа.

### 2.2.1 Газар эзэмших эрх-гаарын эрх зүйн үндсэн зарчмытай холбогдох нь

Газарын эрх зүйд удирдлагыг болгох үндэслэлүүд болох үндсэн зарчмуудыг тогтоон авч үздэг. Газар нь улс орны тусгаар тогтнол, аж амьдралын үндэс болж байдал учир улс бур газрын харилцаатай холбоотой үндсэн суурь зарчмуудыг тогтоодог байна. Манай улсын хувьд газар нь ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байх; газрыг төрөөс өмчлөх;

<sup>11</sup> Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг асуудал, Хүний эрх, шүүх эрх мэдэл, нутгийн удирдлагы, Уб., 2017 он, 37 дахь тал.

газрыг тодорхой зориулалтаар эзэмшүүлж ашиглуулах; газрыг үз төлбөргүй эзэмшүүлж ашиглуулах; газрыг зүй зохицтой, бүрэн дүүрэн, үр ашигтай здлэх зэрэг зарчмууд нь газрын эрх зүйн үндсэн зарчим болно. Дээрх зарчмууд нь газар эзэмших эрхтэй хэрхэн холбогдох талаар тайлбарлаг. Газрыг өмнөх тогтолцооны үед тодорхойгүй хугацаагаар зөвхөн Монгол Улсын иргэн, хуулийн этгээд эзэмшиж ашиглаж байсан бол зах зээлийн нийгэмд шилжсэнээр гадаадын иргэн, хуулийн этгээдэд газрыг ашиглах эрхтэйгэр олгох боломжтой болсон юм. Гадаад улсын хуулийн этгээдэд газрыг ашиглуулах болсноор гадаад улсын аж ахуйн нэгж манай улсад өөрийн салбар иżгijt байгуулаи уйл ажиллагаагаа тогтвортой явуулах, газрыг зөв зүйтэй ашиглах эрхтэй болсон. Харин газрын тухай хуулиар ягаад зөвхөн Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд газар эзэмших эрхийн олгох болсон бэ гэдэг нь газрын эрх зүйн үндсэн зарчмаас улбаатай<sup>12</sup> гэж тайлбарлаж болно. Учир нь газар ард түүний мэдэл, төрийн хамгаалтад байх, газрын эрх зүйн зарчмын дагуу Газрын тухай хуульд газар эзэмшиж байгаа этгээд газрыг бусад шилжүүлэх, барьцаалах эрхтэй байхар тусгаж, харин газар ашиглаж байгаа этгээд газрыг бусад шилжүүлэх, барьцаалах эрхгүй байхаар ялгамжтай тусгасан.

### 2.2.2 Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн иżgijt газар эзэмших эрхтэй эсэх

Хууль тогтоомжийн уламжлалаас үзэжд ихэвчлэн газар здлэх, газар эдлэбэр, газар эдлэбэрээг гэсн ойлголтыг хэрэглэж байсан бөгөөд 1920-нод оны нутаг болчээрэйг эдлэх дүрэм, 1942, 1971 оны газар эдлэбэрийн хуулиуд ч газрыг эзлэхэрлэх чиглэлээр гарч байв<sup>13</sup>. Харин газрын тухай шинэ хуулиар газар эзэмших, газар ашиглах гэсн ойлголтыг хэрэглэж, Газрын тухай хууль нэр томъёоны үүднээс түүнд тодорхойлолт өгсөн байдал. Үүнээс

<sup>12</sup> Газрын тухай зүйн үндсэн зарчмууд нь газрын талаарх Үндсэн хуулийн зүйл баримтлагын агуулж байдаг.

<sup>13</sup> Т.Сингэвэрх. Газрын харилишни тухай зүйн зохицуулалт. Уб., 1997 он, 56 дээль тал.

үзэжд, Газрын шинэ хууль батлагдахаас өмнө хэрэглэгдж байсан газар эдлэбэрийн харилцаа нь газрыг эзэмших гэсэн ойлголтыг агуулахаас илүү газар ашиглах ойлголтыг илэрхийлж байсан. Учир нь газар эдлэбэрийн харилцаанд газрын үр шинийг хүртэжд л зориулж ашиглаж байсан болохоос бус газрыг бусад шилжүүлэх, барьцаалах эрхийг агуулж байгаагүй нь харагддаг. Харин Газрын тухай шинэ хуулиар газар эзэмших ойлголтыг илүү тодорхой болгож өгсөн байдал.

Өнөө үед газар ашиглалтын уламжлалт хэлбэрээ хадгалагдахын зэрэгцээ зах зээлийн харилцаанд шилжих байгаатай холбоотойгоор газар ашиглалтын шинэ субъект, зориулалт хэлбэрүүдийг бий болж байна. Үүний илрэл нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж газар ашиглах тухай ойлголт юм. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн газар ашиглах эрхийт Газрын шинэ хуулиар тогтоох өгсөн бөгөөд газар ашиглаж өөрийн үйл ажиллагаагаа бусад аж ахуйн иżgijt явлалт боломжийг олгосон.

Газрын тухай хуульд газрыг эзэмших болон ашиглах эрхтэй яг нийцүүлэн эзэмших (гэрээ байгуулсан этгээд газраа зөвхөн өөрөө ашиглах эрхтэй, бусад барьцаалах, шилжүүлэх эрхтэй), ашиглах (гэрээ байгуулсан этгээд газраа зөвхөн өөрөө ашиглах эрхтэй, бусад шилжүүлэх эрхгүй) хоёр төрлийн гэрээг хууличсан байна. Энэхүү хоёр эрхийн гол ялгаа нь газрыг эзэмших эрхтэй этгээд газрыг бусад шилжүүлэх болон барьцаалах эрхүүдийг захирагааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр хэрэгжүүлэх боломжтой байдал бол газар ашиглах эрхтэй этгээд газрыг шилжүүлэх, барьцаалах эрхгүй ээр газрыг зориулалтын дагуу зөвхөн ашиглах эрхийг л эзлэх байдгаараа ялгаатай. Газар эзэмшүүлэх харилцаа нь зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүхий субъектүүд эдлэхээр хязгааралттай тогтоогдсон байдал онцлогтой. Харин өноо цагт тулгарч байгаа асуудал нь Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж Монгол Улсын хуулийн этгээд бөгөөд газрын

тухай хуулиар газар эзэмшиг боломжтой харагдаж байгаа боловч тусгайлсан газар ашиглах зохицуулалтад Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг газар ашиглах боломжтой гэж тусгасан нь асуудал үүсгэх байна. Тодруулбал:

Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т “Газар эзэмшиг эрхийн гэрчилгээг зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгоно”, 31 дүгээр зүйлийн 31.1-т “Газар эзэмшиг хүснэгт гаргагч нь Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байна”, 38 дугаар зүйлийн 38.1-т “Газар эзэмшиг эрхийн гэрчилгээг хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр бусад шилжүүлж, барьцаалах болно. Эрхийн гэрчилгээг бусад шилжүүлж, барьцаалах үйл ажиллагаа нь зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд явагдана” гэж зааснаас хараахад Газрын тухай хуулиар зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмшиг эрхийг здэлнэ. Энэхүү эрх нь газар эзэмшиг эрхийг шилжүүлж зохицуулалтад мөн адил хэрэглэгдээц.

Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д “Газар эзэмшиг эрхийн гэрчилгээ” гэж энэ хуулийн дагуу гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харьяалалгүй хүний газар ашиглах эрхийг баталгаажуулсан баримт бичгийг; 6 дугаар зүйлийн 6.3-т “Гадаад улс олон улсын байгууллага, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харьяалалгүй хүний тодорхой зориулалт хугацаа, болзول, гэрээний үндэснээ дээр хувь тогтоомжийн дагуу газар ашиглагч байж болно”, 44 дүгээр зүйлийн 44.5-д “Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн изгжид энэ хуулийн дагуу газрыг тусгай зориулалт, хугацаа, болзолтойгоор ашиглуулах бөгөөд уг хугацаат Засгийн газар тогтооно.” гэж зааснаас үзэхэд Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь хэдийгээр Монгол Улсын хуулийн этгээд боловч

газрыг зөвхөн ашиглах эрхтэй байхаар газрын тухай хуульд тусгасан байна. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн изгж, байгууллага гэсэн итг томбоны хөрөнгө оруулалтны тухай хуулиар тодорхойлогдсон бусад хуулийн этгээдэй харьцуулан үзэж ошилж бүхий хуулийн этгээд. Хууль тогтоогчийн хүсэл зоригийн үүднээс тайбардавал гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн изгж нь хөрөнгө оруулагч дангаараа болон бусад хөрөнгө оруулагчтай хамтран аж ахуйн изгж байгуулах; хөрөнгө оруулагч хувьцаа, ердийн бичиг, бусад төрдийн үнэт цаасыг худалдаан авах; компанийг нэгтгэх, нийтийн замаар хөрөнгө оруулалт хийж, концес, бүтээгдхүүн хуввах, маркетинг, менежментийн болон бусад гэрээ байгуулах; санхүүгийн түрээс /лизинг/-ийн болон франчайзийн хэлбэрэйн хөрөнгө оруулалт хийж замаар байгуулагдаг бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт авч буй компанийг гэлэг үүднээс нь газрыг Монгол Улсын иргэн, аж ахуйн изгжтэй нэгэн алийн байлаараа эзэмшигүүлж бус, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, аж ахуйн изгжтэй алияар ашиглуулах эрхийг эзлүүлэх хувилбарыг сонгосон гэж тайлбарлаж болохкоор байна.

Газрын тухай хуулийн зохицуулалт, хуулийн үзэл баримтлалаас дутгэн үзэхэд Газрын харилцаа үндэсний өв уламжлал, тусгаар тогтолцын үзэл санаанд уламжлгадаа боловсруулагдаг бөгөөд энэ үүднээс Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь газрыг ашиглах эрхтэйгээр эзлэх боломжтой болох нь харагдаж байна. Хэдийгээр Монгол Улсын хуулийн этгээдээр бүртгэгдэж, байгуулагдсан аж ахуйн изгж болоч газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь газрыг эзэмшиг бус ашиглах талаар тодорхой тусгасан байна.

**Гурав. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн изгжийн газар ашиглагч эрх ба шүүхийн практик**

Мөн Үндэснээ хуулийн үзэл баримтлалыг нарийвчлан тусгасан газрын

тухай хуулиас үзэхэд системчлэлийн хувьд газар эзэмших эрхийт Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж здлэх, харин газар ашиглах эрхийг гадаадын аж ахуйн нэгж, иргэн, харьвалалтгүй хүн здлэхээр зохицуулсан харагдана. Гэтэл газрын тухай хуульд гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд газар эзэмших, ашиглах эрхүүдийг сонгон аль нэгийг здлэх боломжтой байхаар тусгагдсан нь асуудал үүсгэж, шүүх хуулийг хэрэглэхэд төвөгтэй байдал үүсгэж байгаа юм. Шүүхийн зүгээс тус асуудалд хэрхэн хандаж, үзлэлт дүгнэлт өгч байгааг харгшаяа.

Нийслэл дэх захирагааны хэргийн анхан шатны шүүх 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр гаргасан 85 тоот шийдвэрлийнхээ Үндэслэл хэсэгтээ:

“Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д “Газар эзэмших эрхийн гэрчилгээг хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр бусдад шилжүүлж барьцаалж болно. Эрхийн гэрчилгээг бусдад шилжкуулж, барьцаалах үйл ажиллагаа зөвхөн Монгол Улсын иргэн аж ахуйн нэгж, байгууллагын хооронд явагдана”, 38.3-т “Эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай хүснэгтийг тухайн шатны Засаг дарга хүлээн авч, дараах зүйлүүдийг тодруулна”<sup>11</sup>, 38.3.3-т “Эрхийн гэрчилгээг шилжүүлэн авч байгаа этгээд нь ут эрхийн гэрчилгээг эзэмшиж эрхтэй эсэх” гэж тус тус зааснаас үзвэл газар эзэмшиж буй аж ахуй нэгж нь зөвхөн Монгол Улсын аж ахуйн нэгжид эрхийн гэрчилгээг шилжкуулж эрхтэй бөгөөд эрхийн гэрчилгээг шилжүүлэн авч байгаа этгээд буюу “И” ХХК-нас газар эзэмших эрхийг ашиглах зориулалтаар өөрчлөн эрхийн гэрчилгээг шилжүүлэн авах эрхтэй эсэхийг Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга 2012 оны 227 дугаар захирамжийг гаргахдаа тодруулаагүй байна. Ихээмжлэгч “Э” ХХК нь 100 хувь гадаадын хөрөнгө оруулалттай компанийар үүсгээс байгуулгасан болох нь компанийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, Оюуны өмч, Улсын бүртгэлийн газраас ирүүлсэн компанийн дэлгэрэнгүй лавлагaa зэргээр нотлогдож байх бөгөөд 2014 оны 11 дүгээр сарын 03-

ны өдөр Монгол Улсын иргэн Т 100 хувийн үүсгэн байгуулагчаар бүртгэгдэж, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр авчээ. Эдгээр баримтаас үзвэл ихээмжлэгч “Э” ХХК нь 2012 оид талаадын хөрөнгө оруулалттай компани байхдаа бусдын эзэмшиж буй газар эзэмших эрхийн гэрчилгээг ашиглах зориулалтаар өөрчлөн шилжүүлэн авсан нь хууль бус байна<sup>14</sup> гэжээ.

Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүх 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр гаргасан 221/МА2017/0260 тоот магадлалынхаяа Хяналал хэсэгтээ:

“Хариуцагч Сонгинохайрхан дүүргийн засаг дарга нь 2012 оны 227 дугаар захирамжаар 100 хувийн хөрөнгө оруулалттай хуулийн этгээд болох “Э” ХХК-нд “И” ХХК –ийн 50.0 м.кв газар ашиглах эрхийг шилжүүлэн авч байгаа этгээдийн эрх зүйн байдлыг тодруулаагүй буюу газар ашиглах эрхийг шилжүүлэн авах эрхтэй эсэхийг нягтлан шалгалгүйгээр газар эзэмших эрхийг ашиглах эрх болгон шилжүүлж шийдвэрлэсэн нь Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д “Газар эзэмших эрхийн гэрчилгээ хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр бусдад шилжүүлж, барьцаалж болно. Эрхийн гэрчилгээг бусдад шилжкуулж, барьцаалах үйл ажиллагаа нь зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд явагдана” гэж заасныг зөрчсөн байна. Иймээс Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2013 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн маргаан бүхий 341 дүгээр захирамжаар ихээмжлэгч “Э” газар ашиглах эрхийг хүчингүй болж шийдвэрлэсэн нь Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д “Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн шийдвэр, ...газрын тухай хууль тогтоомж, ...зөрчсөн бол уг ...албан тушаалтан өөрөө буюу түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан эсхүл шүүх уг хууль бус шийдвэрлийг хүчингүй болгож, таслан зогсоон” гэж заасантай нийцсэн, тус шийдвэрийн улмаас ихээмжлэгчийн

<sup>11</sup> Нийслэл дэх захирагааны хэргийн шатны шатны шүүх 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр гаргасан K5 тоот шийдвэр

“Газар ашиглах хууль ёсны эрх зөрчигдсөн гэж үзэх” үндэслэлгүй байна. Анхан шатны шүүх Газрын тухай хуулийн “газар эзэмших эрхийг гэрчилгээг шилжүүлэхтэй” холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ нь “газар ашиглах тухай хүснэгт гаргах, түүнийг хянах шийдвэрлэх, газар ашиглах гэрээний агуулгыг тогтоох, түүнийг байгуулах”-д баримтлах журамд хамрагдаагүй гэж зөв дүгнэсэн байна. Өөрөөр хэлбэл, газрын тухай хуульд газар ашиглах эрх нь газар эзэмших эрхийг шилжүүлэх замаар ашиглах эрх үүсэх боломжтой байхаар хуульчлаагүй байна<sup>15</sup>. Гэжээ.

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх 2017 оны 06 дугаар сарын 12-ны өдөр гаргасан 227 тоот тогтоолынхоо Хяналын хэсэгтээ:

“Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3, 1-5-д зааснаар гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшик байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 мянган amerik доллар буюу түүнтэй тээвэрхийн төгрөгөөс дээш байх аж ахуйн нэгжийг хэлнэ. Хуулийн энхүү тодорхойллоос үзвэл гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан бүртгэгдсэн Монгол Улсын аж ахуйн нэгж. Иймд газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д заасан Монгол Улсын аж ахуйн нэгж гэдэгт гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь хууль зүйн ойлголтын хувьдаа хамаарахаар байна. Харин газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 44 дүгээр зүйлийн агуулгаас үзвэл гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь газар ашиглах эрхтэй юм. Газрын тухай хуульд заасан

“газар эзэмших” болон “газар ашиглах” эрхийн гол ялгаа нь газар эзэмшигч нь уг эрхээ бусдал шилжүүлэх болон барьцаалах боломжтой байдлаа бол газар ашиглачийн хувьд ийм эрх байдалтгүй. Энхүү Маргааны хувьд “Инжир” ХХК газар эзэмших эрхээ шилжүүлэх хүснэгт гаргасан нь тээвэр Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн заасан эрхээ хэрэгжүүлсэн байх бөгөөд түүнийг хязгаарлах хууль зүйн үндэслэлтэй байхгүй байна. Ийм ч учир хариуцагч түүнийг хүлээн зөвшөөрөш шилжүүлэхээ Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-3-ийн дагуу икэмжлэгч нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж чир газар түүнд эзэмшиг бус харин ашиглах, эрэ олон, ашиглах эрхийн гэрчилгээ өгч, гэрээ байгуулсаныг ТЭХЭРГИЙН I дүгээр хавтас, 56, 58 дахь тал/ хууль зөрчсөн гэж үзэх үндэслэлтгүй. Иймээс “эзэмших эрхийгэшигч лах эрх болгон шилжүүлсэн нь Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3.2 дахь заалтыг зөрчсөн” гэж анхан болон давх заалдах шатны шүүхийн дүгнэлт буруу байна. Харин Газрын тухай хуулийн агуулгаар ашиглах эрхийт авсан нэхэмжлэгч нь уг эрхээ бусдал шилжүүлэх боломжгүй<sup>16</sup>. Гэжээ.

Дээд шүүхийн шийдвэрээс дүгнэн үзэхэд Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан Монгол Улсын хуулийн этгээд гэгдгийг дурдсан байх боловч газрын тухай хуульд заасан нарийвчилсан зохицуулалтын дагуу буюу Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага газрыг эзэмшиг бус ашиглах эрхтэй гэж шийдвэрлэжээ. Үчир нь хуулийн системчилн тайлбарлахдаа нарийвчилсан хууль тогтоомж болох газрын тухай хуулийт удирдлага болгож шийдвэрлэсэн байна.

#### Нэгдсэн дүгнэлт:

Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд нь Монгол Улсын хуулийн

<sup>15</sup> Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүх 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр гаргасан 221/МА2017/0260 тоот магадлал.

<sup>16</sup> Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх 2017 оны 06 дугаар сарын 12-ны өдөр гаргасан 227 тоот тогтоол.

этгээд мөн боловч үндсэн хуулийн үзэл баримтлал, Монгол Улсын газрын эрх зүйн уламжлал, зан заншлын үүдиээс гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд газрыг ашиглах боломжтойгоор эрхийт нь олгож Газрын тухай хуулиар зохицуулжээ. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага гэсэн иэр томъёо нь хөрөнгө оруулалтын тухай хуулиар тодорхойлогдсон бусад хуулийн этгээдтэй харьцуулан үзэхэд онцлог бүхий хуулийн этгээд. Хууль тогтоогчийн хүсэл зоригийн үүдиээс тайлбарлавал гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь хөрөнгө оруулагч дагнаараа болон бусад хөрөнгө оруулагчтай хамтран аж ахуйн нэгж байгуулах; хөрөнгө оруулагч хувьцаа, ерийн бичиг, бусад төрлийн нүэн цаасыг худалдан авах; компанийг нэгтгэх, нийлүүлэх замаар хөрөнгө оруулалт хийх; концес, бүтээгдэхүүн куваах, маркетинг, менежментийн болон бусад гэрээ байгуулах; санхүүгийн түрээс /лизинг/-ийн болон франчайзийн хэлбэрийн хөрөнгө оруулалт хийх замаар байгуулалтадаг бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт аял буй компани гэлгэ үүдиээс нь газрыг Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжтэй нэгэн адил байдаараа эзэмшүүлж бус, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, аж ахуйн иэгжтэй алилгаар ашиглуулах эрхийг элдүүлэх хувилбарыг сонгосон гэж тайлбарлаж болохоор байна.

Газрын тухай хуулийн зохицуулалт, хуулийн үзэл баримтлалаас дүгнэн үзэхэд Газрын харилцаа үидэсний өв уламжлал, тусгаар тогтолцын үзэл санаанд уламжлагдан боловсруулагдаг бөгөөд энэ үүдиээс Гадаадын хөрөнгө оруулалттай аж

ахуйн нэгж нь газрыг ашиглах эрхтэйгээр эдлэх боломжтой болох нь харагдаж байна. Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд нь газар ашиглах эрхийг эдлэснээр өөрийн компанийн үйл ажиллагааг тогтвортой, тасралтгүй явуулах боломжтой байхаас гадна хуулийн этгээдийн тэр дундас аж ахуйн нэгжийн өмчийн эрхийг эдлэх юм. Газар эзэмших эрхийг бус газар ашиглах эрхийг эдлэснээр газрын бусдад шилжүүдэх, барьцаалах эрхийг эдлэх боломжгүй болох сул талтай байдаг. Өөрөөр хэлбээ өмчийн эрхийн нэг суурь эрх болох бусдад шилжүүлэх, барьцаалах эрхийг газар ашиглах эрхтэй этгээд эдлэх боломжтой байдлаар зохицуулсан бөгөөд зөвхөн газрыг зориулалтын дагуу ашиглах эрхийг л эдлэх юм. Газар ашиглах эрхийг эдлэж буй этгээд газрыг гэрээнд заасан зориулалт, хуташаанд ашиглаж газрын үр шимийн хүртэж байгаа нь газар эзэмших эрхтэй адил байна. Гэхдээ газрыг бусдад барьцаалах шилжүүлэх боломжгүй болсноор өмчөө захиран зарцуулах хязгаарлагдмал эрхийг эдлэх боломжгүй болох сул талтай байдаг. Хууль тогтоогч гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, аж ахуйн нэгжийн зөвхөн газрыг ашиглах эрхтэй байдлаар зохицуулсан зорилго нь Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн нэг дэх хэсэгт заасан “Монгол Улсад газар, түүний хэвлэй, ой, ус, амьтан ургамал болон байгалийн бусад баялаг гагхуу ард түмний мээлэл, төрийн хамгаалалтад байна” гэсэн зохицуулалтын дагуу Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийг гадаадын этгээд бусдад шилжүүлэхгүй, барьцаалахгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн гэж үзж, дүгнэж болохоор байна.

---000---

## ИРГЭНИЙ ХУУЛЬ ДАХЬ МЭДЭЭ ТАРААХ ҮЙЛДЭЛ БОЛОН ТАЙЛБАР, САНАЛ, ШҮҮМЖЛЭЛ ЗЭРГИЙГ ЯЛГАХ НЬ



**МУИС-ийн ХЭС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш Р.Пүрэвбаатар**

### ТҮЛХҮҮР ҮГС:

Мэдээ, санал, зохицтой шүүмжлэл, олжманы шалгур, хам сэдэв

### ТОВЧЛОЛ:

Энэхүү судалгаагаар Монгол Улсын Иргэний хуулийн хүрээнд тайлбар, санал, шүүмжлэл болон мэдээ тараах үйлдлийг хэрхэн ялгах вэ гэсэн асуултад хариулт өгөхийг зорих бөгөөд үүний тулд шүүхийн шийдвэрүүд төдийгүй Америкийн Нэгдсэн Улс болон Япон улс дахь энэ асуудлын талаарх онол, хууль зүйн тайлбарын талаар харьцуулсан эрх зүйн судалгааг хийсэн болио.

### I. УДИРТГАЛ

Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалсан эрх зүйн тодорхой зохицуулалт анхлан 1963 оны Иргэний хуульд тусгагдсан байдал. Тус хуульд бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан “мэдээ” тараасан этгээд түүнийхээ үзэн зөвийг нотолж чадахгүй бол хариушлага хүлээлгэхээр заажээ. Энэхүү зохицуулалтын үндсэн агуулга одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж

буй 2002 оны Иргэний хуулинд я тусгагдсан гэж дүгнэж болно<sup>1</sup>. Өөрөөр хэлбэл, Иргэний хуулийн 21-р зүйлийн 21.2 болон 511-р зүйлийн агуулгаас үүнийг тодорхой харж болох юм.

Харин энэхүү өгүүллийн судалгааны гол цэг нь дээр дурдсан Иргэний хуулийн 21-р зүйл болон 511-р зүйл дэх “мэдээ” гэх нэхцэл болно. Өөрөөр хэлбэл, уг “мэдээ (орос. сведения)” гэх ойлголтыг хэрхэн тайлбарлах ёстой вэ, түүний бусад ойлголтоос хэрхэн ялгаж тайлбарлах вэ гэсэн асуултад тодорхой хариулт өгөхийг зорхи юм. Яагаад гэвэл бил өвр хэн изгээн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах шинжтэй мэдээг тараандаа гэдэг нь зөвхөн ямар изгээн бодитой болсон үйл явдал (өргөн уттаараа факт)-ын талаараа бусдад тараах үйлдлийг илрхийлдээ үү. эсхүл тайлбар, санал, шүүмжлэл зэрэг субъектив үзүүлэлтийн шинжтэй ойлголтыг ч мөн адил өөртөө багтаад ойлголт уу гэсэн асуулт зайлшигүй урган гарах болно.

Энэхүү асуултад хариулт өгөх зорилгоор тус өгүүллээр иргэний хуулийн зохицуулалт төдийгүй шүүхийн шийдвэрийн агуулгыг судлан узэж, харьцуулсан эрх зүйн судалгаагаар дамжуулан өөрийн орны иргэний хуулийн зохицуулалтыг тайлбарлахад тодорхой хувилбарыг дэвшүүлэхийг зорьсон болно. Мэдээж хэргээ тус өгүүллээр өөрнийн тавьсан асуултанд бүрэн дүүрэн хариулт өгөх боломжтүй боловч, цаашид тус асуудлыг илүү нарийвчлан судлахад өөрийн эх сурвалжийн чиг үүргээ зохих хэмжээнд гүйцэтгэнэ хэмээн найдж байна.

<sup>1</sup> Энэ талвар дэлгэрнүүд судалгааг R.Пүрэвбаатар “Монгол Улсын Иргэний хуулиуд дахь нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийн талвар зохицуулсаны хэмжээнд харьцуулсан эрх зүйн үзүүлэлт дүгнэх нь” Хууль доодлах ёс, УБ., 2018 оны, 83 дахь тал.

## II. ҮНДСЭН ХЭСЭГ

### 1. ИРГЭНИЙ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ТҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ

#### 1.1. ИРГЭНИЙ ХУУЛИЙГ ТАЙЛБАРЛАХ ОРОЛДЛОГО

Энэ хэсэгт юун түрүүнд тус судалгааны гол объект болох Иргэний хуулийн 21-р зүйлийн 21.2 дахь хэсэг болон 511-р зүйлийн агуулгыг түүхчилсэн байдлаар болон харьцуулсан эрх зүйн үүднээс (боссоо харьцуулалт) тайлбарлах замаар эдгээр зохицуулалт дахь “мэдээ” гэх нөхцлийн агуулгыг тодорхой болгохыг оролдох бөгөөд үүний дараагаар системийн тайлбар хийх замаар эдгээр зохицуулалтын чиг үүргийг тодорхой болгохыг зорих болно.

Иргэний хуулийн 21-р зүйлийн 21.2 дахь хэсгийг түүхчилсэн байдлаар судлан авч үзвэл 1994 оны Иргэний хуулийн шинэчилсэн наирнуултын 7-р зүйл, цаашилаад 1963 оны БНМАУ-ын Иргэний хуулийн 6-р зүйлийн агуулгатай адил зохицуулалт болгохыг бил төвөгтүйхэн олж харж болно<sup>2</sup>. Цаашилаад харьцуулсан эрх зүйн үүднээс дүгнэж авч үзвэл 1961 оны “ЗСБНХУ-ын Иргэний хуулийн талаарх үидсэн зарчмын”-ын 7-р зүйлээс решепц хийсэн зохицуулалт хэмээн дүгнэж болох юм<sup>3</sup>. Тус 7-р зүйлийн агуулга одоо ч ОХУ-ын Иргэний хуулиид системийн

<sup>2</sup> 1963 оны БНМАУ-ын Иргэний хуул, 6-р зүйл “Ирги буюу албан байгууллагын иэр төр, алдар хүчинийг гутавсан мэдээ таврасан этгээд түүхийн эзгүүн зөвийн нотолж нийтийн улзгийн эзгүүн зөвийн нотолж нийтийн шүүхэл шаардах эрхтэй”, 7.2-т “Эн зүйлийн 1 дахь эхийт зассан мэдээ таврасан этгээд түүхийн эзгүүн зөвийн нотолж нийтийг бол учирсан гэм хоригын ариглагч улзгийн эзгүүн зөвийн нотолж нийтийг тавласан шүүхэл шаардах эрхтэй”, 7.3-т “Иэр төр, алдар хүнд, эхийг хоригийн иэр хүчинийг гутавсанас учирсан гэм хоригын ариглагч улзгийн эзгүүн зөвийн нотолж нийтийг тавласан шүүхэл, журмын дагуу шүүх тодорхойлжин” гэв тус тус явсан.

<sup>3</sup> Тус асуудал хамаавар харьцуулсан эрх түйн дэлгэрнүүг судалгаам. Р.Пуримбаатар “Монгол Улсын Иргэний хуулийн давь иэр төр, алдар хүнд, эхийг хоригийн иэр хүчинийг тавласан хэмжээг харьцуулсан эрх түйн үүднээс тусламжийн эзгүүн зөвийн нотолж нийтийг тавласан шүүхэл шаардах эрхтэй” Хууль дэлгэлжжээ, Уб, 2018 он, №6 дахь тал.

тайлбарын агуулга нь өөрчлөгдлүүй хуульчлалдсан байдаг билээ.

Тиймээс өгүүллийн гол зорилго болох “мэдээ” гэх нехцэлийн агуулгыг тодруулахын тулд ЗСБНХУ (цаашид “ЗХУ” гэх) болон ОХУ-ын Иргэний хуулийн зохицуулалтын талаарх судлаачдын тайлбарыг товч авч үзэх зайлшгүй шаардлагатай болж байна. Юун түрүүнд ЗХУ-ын талаар нягтлан үзвээс тухайн үеийн судлаачдын хувьд факт болон тухайн фактын талаарх үнэлэмж, санал зэрэгтэй хооронд нь ялгаж үзэг байжээ<sup>4</sup>. Гэхдээ судлаач нарын бүтээлийг аваад үзвэл тайлбарын хувьд саналын зөрүүтэй байдал ажиглагдана. Жишээ нь нэрт судлаач О.С.Иоффегийн хувьд факт болон тухайн фактын талаарх үнэлэмжийг хооронд нь ялгаж хэрэглэж шаардлагатай байгааг чухалчлаад тухайн үнэлэмж нь факт (гэхдээ тухайн факт нь үнэн байх)-ын агуулгатай улдаж байваас энэ нь хувь хүний оюун санааны дотоод эрх чөлөөтэй холбоотой асуудал болно хэмээн үзжээ<sup>5</sup>. Тиймээс ч үнэн фактын талаарх үнэлэмж нь алдаатай байсан ч ЗХУ-ын Иргэний хуулийн 7-р зүйлийн дагуу хариуцлага хүзүүлэгч тохиолдолд хамаарахгүй гэсэн тайлбарыг санал болгосон байна<sup>6</sup>.

Харин судлаач А.В. Беляевский ялгаатай тайлбарыг дэвшүүлсэн бөгөөд түүний тайлбар хожим олонхийн дээжилгэйт өвчээ. Түүнийхэр бол хүний нэр төр (честь), алдар хүнд (достоинство) нь худал факт тедийгүй үнэн фактын талаарх алдаатай эсхүл туйширсан үнэлэмжийн улмаас гутаагдах боломжтой бөгөөд шүүхийн зүгээс аль алхынг нь хүлээн авч шийдвэрлэх ёстой гэжээ<sup>7</sup>.

<sup>4</sup> P.F.CARTER -RUCK AND R.WALKER, CARTER-RUCK ON LIBEL AND SLANDER, BUTTERWORTHS, 360 (3D ED, 1985)

<sup>5</sup> O.S.Ioffe, The New Codification of Civil Law and Protection of the honour and dignity of the Citizen, The Soviet Review VOL.4, No.3, TAYLOR & FRANCIS LTD, 64 (1963). Р.П.: Хориж оюун санааны эрх чөлөөн дотоод болон гадаад гэм ашиглан авч үзэл судлаач О.С.Иоффегийн хувьд логод эрх чөлөөн олонхи нийтийн боловно. Эөөрөр хэлбэл, итгэх угышшилгэтийг бийх трайни зарчилж тооцононо гэж үзэх байсан хэрэг.

<sup>6</sup> Ibid, al 64.

<sup>7</sup> Беляевский А.В., Судебная защита чести и достоинства граждан. М., 1966 ст.к

Улмаар дараах асуудлыг судалж тогтоох нь шүүхийн үүрэг хэмээн үзсэн байна. Үүнд: 1.Тухайн факт нь алдаагүй илэрхийлгэсэн эсэх, 2.Тухайн фактад үнзлэмж нь суурилсан эсэх, 3.Үнзлэмж нь тохиromжтой эсэх зэрэг болио<sup>9</sup>.

Эндээс дүгнэвэл ЗХУ-ын судлаачдын хувьд Иргэний хуулийн 7-р зүйл дэх “мэдээ” гэх нөхцөлийг факт төдийгүй, тайлбар, санал, шүүмжлэлийг ч мөн агуулсан ойлголт хэмээн тайлбарласан байгаас бил олж харж болох юм.

Харин ЗХУ-ын дээр зохицуулалтыг уламжлан авсан ОХУ-ын хувьд 1994 оноос факт болон тайлбар, санал, шүүмжлэл зэргийг ялгах талаарх маргаан судлаачдын дунд дахин явагдсан байна. Судлаач А. Эрдэлевскийгийн хувьд ОХУ-ын Иргэний хуулийн 152-р зүйлийн 152.1 дахь хэсгийн “...гутаасан этгээд түүнийхээ болит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол шүүхэд хандаж уг мэдээг няцаахыг тухайн этгээдээс шаардах эрхээй” гэх нөхцлийг авч үзээд тус зохицуулалт нь зөвхөн тодорхой фактын талаарх мэдээг л хамран зохицуулсан гэж тайлбарласан байна. Учир нь зөвхөн фактын талаарх мэдээ нь л бухгалтээс эсхүл хэсэгчлэн болит байдалд нийцэгжийг байх боломжтой гэж үзжээ. Фөрөөр хэлбэл, уг “мэдээ” гэх ойлголт нь ердийн утгаараа аль аль тохиолдлыг хамарч болох боловч, Иргэний хуулиан дахь мэдээ тараах ойлголт нь зөвхөн фактын талаарх мэдээг л хамарсан ойлголт хэмээн үзжээ.

Мөн судлаач С.Потапенко үзэхдээ “Хэрээ шүүхийн процессын дагуу хэн нэгний саналын зөв зүйтэй эсхийг шийдвэрлэхээр болох юм бол энэ нь аливаа хүний өөрөө засан тохинох эрхэд териин зүгээс хүчээр оролцсон хэсэг болно” гээд факт болон тайлбар, санал, шүүмжлэл зэргийг хооронд нь ялгах шаардлагатайг онцлон тайлбар, санал, шүүмжлэл зэргийн хувьд хохирол нөхөн төлөх зохицуулалтыг бус, харин няцаах аргыг ашиглах нь зүйтэй

гэсэн саналыг дэвшүүлжтийн байна<sup>10</sup>.

ОХУ-ын хувьд 1996 оноос Европын хүний эрхийн конвенцод ийлдэх орж улмаар ОХУ-ын Лигэд шүүхийн 2005 оны тогтоол дугаар 3-ыг баглан гаргасны дагуу ОХУ-ын шүүх нь Европын хүний эрхийн шүүх (ECHR)-ийн шийдвэрт өөрийн шийдвэрийн агуулгын ийнцүүлэх үүргийн хүлээсэн<sup>11</sup>. Тус тогтоолын дагуу судлаачдын дээрх маргаан, мэгтэлжээнд дээд шүүхийн зүгээс тодорхой хариут өгсөн гэж дүгнэж болох юм.

Тус 2005 оны Дээд шүүхийн тогтоол дүгнэгээр 3-ын 9 дүгээр зүйлийн 3 дахь догол мөрд “Европын хүний эрхийн шүүхийн зүгээс фактыг санал, шүүмж (убеждения, мнения), үнзлэмж (оценочные суждения)-ээс ялгах ойлгох ёстой гэж үзсэн байна. Тиймээс эдгээрийг Иргэний хуулийн 152-р зүйлийн дагуу шийдвэрлэхгүй байх ёстой. Учир нь санал, шүүмж, үнзлэмжийг болит байдалд нийцэж буй эсхийг нь нотлох боломжтүй” гэж тайлбарласан байна<sup>12</sup>. Энэ нь Иргэний хуулийн 152-р зүйлд заасан “тараасан мэдээ” гэх ойлголт нь зөвхөн тодорхой нэг үйл явдал, үйл хөдлөл буюу фактыг ойлгоно гэж тайлбарласан хэрэг бөгөөд судлаач А. Эрдэлевскийгийн тайлбартай агуултын хувьд ашиглалтадаа байна гэж дүгнэж болох юм.

Дээрх судалгаанд үндэслэн Монгол Улсын Иргэний хуулийн 21-р зүйлийн 21.2 болон 511-р зүйлийн зохицуулалтыг дүгнэн үзвэл эдгээр зохицуулалт дахь “мэдээ тараасан этгээд түүнийхээ үзүүн зөвийг нотолж чадахгүй бол” гэх эсхийг зөвхөн фактын талаарх мэдээг тараасан

<sup>9</sup> Потапенко С., Судебная практика Верховного Суда Российской Федерации по спорам о защите чести и достоинства личности в СССР. М., 1971 ст.56

<sup>10</sup> Постановление Пленума Верховного Суда Российской Федерации от 24 февраля 2005 г., Дмитрий Головинов, Сергей Потапенко, Применение российскими судами положений Конвенции о защите прав человека и основных свобод и практики Европейского суда по правам человека: теоретические и практические аспекты, Законодательство и практика, Масс-медиа, №3, 2005 г., ст.18-31

<sup>11</sup> Постановление от 24 февраля 2005 г. статья 9. Тус тайлбар нь Европын хүний эрхийн шүүхийн Pederson v.Denmark 42 Евр. Ст. N.R. №49017/99, (17 December 2004) шийдвэрт узажэсэн болно.

тохиолдолд л хэрэглэх боломжтой хэмэн тайлбарлах боломжтой болж байна.

Харин тайлбар, санал, үнэлээмжээс ияэрхийлсэн этгээдийн үйлдэл нь Иргэний хуулийн 497-р зүйлийн урьдчилсан нөхцөлийг хангасан тохиолдола түүнд хохирол нөхөн төлөх хариуцлагыг хүзээгээс боломжтой гэж тайлбарлах гарын байгаа боловч, эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэгч буюу хохирогч шаардсан тохиолдола гэм буруутгүйгээр хариуцлага хүзээлгэх зарчмын тулгуурласан 511-р зүйлийн зохицуулалтын баримтлаахаас өөр арагтай болох тул бусдын тараасан тайлбар, санал, үнэлээмжийн улмаас иэр тэр, алдар хунд, ажил хэргийн иэр хүнд нь гутаагдсан этгээд үүний улмаас учирсан эдийн бус хохирлыт нөхөн төлүүлэхээр шаардах боломжгүй болж байна.

Гэвч Иргэний хуулийн 511-р зүйлийн 511.1 дэх хэсгийн “ад хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан” гэх нөхцөлийг системийн хувьд нь дараах байдлаар тайлбарлах боломжтой байж болох юм. 511-р зүйлийн 511.1 дэх хэсгийн хувьд энэ нь зөвхөн тодорхой фактыг тараасны улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлүүлж тохиолдолд л хэрэглэгдэх зохицуулалт бөгөөд харин факт төдийгүй, тайлбар, санал, үнэлээмжийн улмаас эд хөрөнгийн хохирол учирсан бол 497-р зүйлийн дагуу хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах боломжтой төдийгүй тайлбар, санал, үзлээмжийн улмаас учирсан эдийн бус хохирлоо 497-р зүйлийн дагуу шаардах эрхийт энэ нь кяягаарлахгүй. Учир нь 511-р зүйлийн 511.1 дэх хэсгийн хувьд “ад хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан” гэх нөхцөлөөр дамжуулан дээрх системийг бий болгосон байна гэж үнэлэх бүрэн боломжтой байгаа бөгөөд энэ нь Иргэний хуулийн 230-р зүйлийн 230.2 дахь хэсгийн “тагихүү хуульд тусгайлан заасан тохиолдолд” гэж нөхцөлийг зорчсөнд тооцогдохгүй гэж тайлбарлах нь ионвочтой биз ээ.

## 1.2.ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН СУДАЛГАА

1. Улсын Дээд Шүүхийн 2004 оны 04-р сарын 15-ны өдрийн 230 дугаар тогтоол

Хэргийн агуулга: “М” Хадгаламж Зээлний Хорошионы бүх гишүүдийн хурлаар иргэн Э-гийн талаар 11000000 сая төгрөгийн алдагдал гаргасан, ажлын хариуцлага алдсан, ёс зүйн алдаа гаргасан, бензин, гар утас, утасны клип зэрэгт үргүй зардал гаргасан гэж дүгнэсэн. Иргэн Э уг дүгнэлт нь түүний иэр төрийн гутаасан гээд хорошионы гишүүдийн мэдээлэлд Үндэслэлгүйгээр гутаагдсан Иэр төрийг сэргээж, сэтгэл санааны хохиролд 5 сая төгрөгийг гаргугулахаар Чингэлтэй дуургийн шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.

Анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэг: Иргэний хуулийн 511-р зүйлийн 511.1, 511.2 дахь хэсгийг баримтлан Э-ийн иэр хүидийг сэргээж, “М” ХЗХ-ээс 50 мянган төгрөг гаргуулан Э-д олж, түүний иэр төрийг гутаасныг тус хорошионы бүх гишүүдийн хурлаар няцаалт хийхий “М” хадгаламж зээлийн хорошионаа тэргүүнд давалгахаар шийдвэрлэжээ<sup>13</sup>.

Давж заалдах шатны шүүхийн магадлалын тогтоох хэсэг: Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн өмгөөлөгчийн гомдлыг хаягахгүй орхин шийдвэрлэжээ<sup>14</sup>.

УДШ-ийн тогтоолын хянах болон тогтоох хэсэг: “М” ХЗХ-ноос бүх гишүүдийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр тараасан тайландаа тус хорошионы гүйцэтгэх захирал Э-ийн ажлыг дүрэмд заасны дагуу шалгахад илрээн аллаа дутагдлын талаар дурдаж, згээр алдаа дутагдлыг давтан гаргугулахгүй, мөн цашид ажлыг улам сайжруулах талаар дүгнэлт хий гэсэн утгаар буюу ажил хэргийн шүүмжлэлийн шинжлэхүүн мэдээллийг өгчээ. Гэтэл шүүх энзүү мэдээлэл нь Э-ийн иэр төрийг

<sup>13</sup> Чинигчийг дүүргийн шүүх 2003 оны 12 лутгаар сарын 10-ны одрийн 1229 дүгүүр шийдвэр.

<sup>14</sup> Нийслэлийн Давж заалдах шатны шүүхийн 2004 оны 2 дугаар сарын 9-ны одрийн 86 лутгаар магадлал.

гутаасан гэж дүгнэн, иэр хүндийг сэргээж, эдний бус хохирол гэж 50000 төгрөг гаргуулахаар шийдвэрлэсэн нь хууль түйн үндэслэлгүй болсон байна гээд Анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийн 1 дэх заалтыг хүчингүй болгож шийдвэрлэжээ<sup>15</sup>.

## 2.Улсын Дээд Шүүхийн 2005 оны 7-р сарын 7-ны өдрийн 336 дугаар тогтоог

Хэргийн агуулга: 2004 онд сурах бичиг хэвлэх аж ахуйн нэгжийн сонгох тендер зохион байгуулгасан бөгөөд уг тендерт “А” ХХК мөн оролцсон байна. Гэвч тухайн үед тендерийн үзүүлэлтийн хэсгийн алхагчаар ажиллаж байсан Санхүү, эдний засгийн яамны ажилтан Н нь тендер шалгаруулалтад бодитой хандагаагүй гэж “А” ХХК-ийн захирал Э үзсэн тул төлөвлөзийн извтрүүлэгт оролцож “...санхүү, эдний засгийн яаманд Н гэдэг хүн бий. Тендерийт найруулдаг гол хүн” гэсэн мэдээллийг тараасан байна. Тиймээс Н уг мэдээлэл тараасан Э-ийн үйлдэл нь өөрийн нь иэр төр, ажил хэргийн иэр хүндийг гутаасан гэж үзэн Сүхбаатар дүүргийн шүүхэд нэр төр, ажил хэргийн иэр хүндийг нь сэргээж, сэргээсэн тухай мэдээллийг өлөр тутмын сониноор дамжуулан зарлуулах гэсэн шаардлагад тавьж нэхэмжлэл гаргажээ.

Анхан шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэг: Сүхбаатар дүүргийн шүүх Иргэний хуулийн 21-р зүйлийн 21.2-т зааснаар “А” ХХК-ийн захирал Э-ийн өгсөн ярилцлагад Сангийн яамны Эдийн засаг, нийгмийн бодлогын газрын дарга ажилтай Н-ийн нэр, иэр төр, ажил хэргийн нэр хүнд гутаагдсаныг сэргээж, дээрх мэдээндээ “Ө” сониноор дамжуулан няцаалт хийхийг “А” ХХК-ийн захирал Э-д үүрэг болгож шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэг: Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагч Э-ийн гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн байна.

<sup>15</sup> Монгол Улсын Дээд Шүүхийн 2004 оны 04-р сарын 15-ны өдрийн 230 дугаар тогтоог.

Хяналтын шатны шүүхийн шийдвэрийн үндэслэл болон тогтнёөх хэсэг: Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал үндэслэлгүй байна. ...Хариуцагч Э-ийн энэхүү ярилцлага нь Н-ийг хувь хүн талаас нь гутсаан доромжилсон бус төрийн байгууллага, албан тушаалтын үйл ажиллагааны талаар шүүмжилсэн шинжтэй байх тул нэхэмжилэгчийн нэр төр, алдар хүнд гутаагдсан гэж үзэх үндэслэлгүй байна гэж шүүх бүрлэлжүүн дутгизв. Иймд анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож, Н-ийн нэхэмжилэгч хэргэсэлгүй болгох нь зүйтэй гэж үзлээ.

Дээрх хоёр шийдвэрийн агуулгыг дүгнэн үзэвлэл аль аль шийдвэрийн хувьд Улсын Дээд шүүхийн зүгээс “ажил хэргийн шүүмжлэл”, “төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны талаарх шүүмжил” гэх үндэслэлээр өмнөх шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон байх бөгөөд ингээдээ Иргэний хуулийн 21-р зүйлийн 21.2 болон 511-р зүйлийн 511.1 дэх хэсгийн талаар тодорхой тайлбар хийгээгүй байна. Өөрөөр хэлбэл, шүүхийн зүгээс эдгэрээ зохицуулалт нь зөвхөн фактын талаарх мэдээг гардаасан тохиолдолд хэрэглэгдэнэ гэж тайлбарласан эсэх нь тодорхойгүй, эдгэр шийдвэрийн хууль зүйн үндэслэл нь тодорхойгүй байгаа болно.

Учир нь эхний шийдвэрийн хувьд “алдагдал гаргасан, ажлын хариулаага алдсан, ёс зүйн алдаа гаргасан, бензин, гар утас, утасны клип зэрэгт үргүй зардал гаргасан” гэх мэдээ нь фактад хамаарахаа бөгөөд хоёр дахь шийдвэрийн хувьд “...санхүү, эдийн засгийн яаманд Н гэдэг хүн бий. Тендерийт найруулдаг гол хүн” гэх мэдээ нь мөн л адил фактад хамаарахаар байна.

Эхний шийдвэрийн хувьд хариулагыг үгүйсгэх нөхцөл нь шүүмжилэл гэх үндэслэл бус харин Хоршооны тухай хуулийн 18-р зүйлийн 18.3 дахь хэсэгт “Гишүүнээс хасах тухай шийдвэр гаргахас өмнө тухайн гишүүнд гишүүнээс хасах

болсон үндэслэл, шалтгааны танилцуулах ба гишүүн тайлбар хэлж болно” гэж заасны дагуу Хоршооны зүтгэс хууль болон дүрэмд заасны дагуу ажил, үргээ гүйцэтгэсэн гэх үндэслэлээр хариулаагыг нь шүүхийн зүтгэс үгүйгэсэн гэж дүгнэх нь илүү зүйтэй байна. Учир нь дээрх мэдээ нь фактын талаар тусгагсан байгаа болно. Тиймээс шүүхийн хувьд тараасан мэдээний агуулга нь фактын талаар уу, эсхүл субъектив шинжтэй тайлбар, санал, шүүмжлэл үү гэдгийг бус, хоршооны зүтгэс хуульд заасны дагуу ажил, үргээ гүйцэтгэсэн эсэхийг шалгах ёстой байжээ.

Харин хоёр дахь шийдвэрний хувьд шүүхийн зүтгэс фактын талаарх мэдээ тараасан байхад шүүмжлэл байна гэсэн үндэслэлээр хариулагчийн хармуулагыг угүйгэсэн байгаа үндэслэлийн хувьд ихээхэн ойлгомжгүй бөгөөд факт болон тайлбар, санал, шүүмжлэлийн хэрхэн ялгах талаар огт тайлбар хийгээгүй байгаа ивцашид энэ асуудлыг нарийвлан судлах нь онолын төдийгүй практикисн хувьд ч ихээхэн ач холбогдолтой болохыг харуулж байна<sup>16</sup>.

## 2. ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ТӨВЧ СУДАЛГАА

### 2.1. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

Америкийн Нэгдсэн улсын хувьд ч мөн адил тухайн тараагдсан мэдээ нь тодорхой фактын талаар уу, эсхүл тайлбар, санал, шүүмжлэл зэрэг субъектив шүнэлэхийн шинжтэй байна уу гэдгийг ялган авч үзэж байна. Түүнчлэн дээрх субъектив шүнэлэхийн шинжтэй тайлбар, санал, шүүмжлэлийн улмаас бусдын нэр тэр гутаагдах боломжтойг хүлээн зөвлөөрдөг<sup>17</sup>.

<sup>16</sup> Зохиогчийн хувь New York Times Co. v. Sullivan 376 U.S. 254 (1964) 7-ны ердүүн 336 дугаар тогтоогын талаар Иргэний хуулийн Үндэслэлийн индицийн тайлбарлах. Индэг хуулийн гурвалдагч этгээдийн үүгүүлэх нолон (Entwicklungs der Grundrechte) түүн оногын исцэлийн хургуулан судлах боломжтойг эхийн үзүүлж байгаа бөгөөд огтуулжин хэмжээг хэлгэвэртэй тул нийт удамж дэлгэрнүүг судалсангаа оруулжтай болно.

<sup>17</sup> P.F.CARTER -RUCK AND R.WALKER, CARTER-RUCK ON LIBEL AND SLANDER, BUTTERWORTHS, 353 (3D ED 1985).

Харин бусдын санал, шүүмжлэл хэлэх явдлыг дээрх байдлаар хязгаарлах нь төрийн албан тушаалтан болон нийтийн эрх ашигт хамааралтай асуудлын талаарх шүүмжлэлийг ихээр хязгаарлах эредэлтэй учраас Fair comment defense буюу Зохистой шүүмжлэл гэх нөхцөлийг хөгжүүлсээр ирсэн байна.

Энэхүү нөхцөлийн дагуу бол 1. Тухайн шүүмжлэл нь нийтийн эрх ашигт хамааралтай асуудлын талаар байх, 2. Тухайн шүүмжлэлийн үндэслэсэн факт нь унэй байх, 3. Шүүмжлүүж буй эзгээлэд ямар нэгэн гэм хор учирнуулах гэсэй санаагүй байх гэсэн урьдчилсан нөхцлийг хангасан тохиолдолд хариуцлага хулээгдэгтгүй<sup>18</sup>.

Тиймээс дээрх нөхцөлийг хэрэглэхийн тулд факт болон тайлбар, санал, шүүмжлэлийг ялгах тодорхой тайлбарыг АНУ-ын шүүхийн зүтгэс дэвшүүлэх шаардлагатай боловч, бүхий л тохиолдолд үйлчлэх нэгдсэн шалтуурыг дэвшүүлээн жишиг одоогоор гарваагүй байна<sup>19</sup>. Маш тодорхой байдлаар факт болон тайлбар, санал, шүүмжлэлийг ялгах шалтуурын талаар тайлбарласан шийдвэр нь Ollman v. Evans хэргийн талаарх шийдвэр<sup>20</sup> бөгөөд энэ нь Марксист улс тэр судлаач Нью-Йоркийн Их Сургуулийн профессор Оллманы хувь нийтийд танигдсан тоймч Эванский бичсэн “Марксист профессорын санаа” гэх нийтлэлд Оллманыг “Марксист улс

<sup>16</sup> MARC A. FRANKLIN & DAVID A. ANDERSON, MASS MEDIA LAW 254 (4<sup>th</sup> ED. 1990).

<sup>17</sup> АНУ-ын хувь New York Times Co. v. Sullivan 376 U.S. 254 (1964) шийдвэр гарсанас хойж төрийн албан тушаалтад нь хариулагчийн асуулт тайлс-ийн ногдох шаардлагатай гэсэн жишиг тогтолцээний тааныгансаа биеэж ижүүлжин онолын хувьд публик бүгдээ тогтолцээний тааныгансаа биеэж ижүүлжин ялангуяа бий болгоход хүрэхэд тайлбарлах боломжтой бий болгосон гүйдэг. Энээр хоблэх, эзгэржинингийг холбон авч үзж байх ялалтгүүний тайлбарлах боломжтой боловс тус огтуулжин хувьд факт болон бусад субъектив шүнэлэхийн хэрхэн ялгахтай холбоотой асуудлын талаар л харьшуулжагаа зорисон болно.

<sup>18</sup> Мэдүүж хүргүүс тус шийдвэртээс омни Gertz v. Robert Welch, Inc. 418 U.S. 323 (1974), Greenbell Cooperative Publishing Association, Inc., v. Breitler, 398 U.S. 6 (1970), Old Dominion Branch No. 496, National Association of Letter Carriers v. Aydin, 418 U.S. 264 (1974) гэх зэрэг тодорхой нийцэлийн санал болгоочин шийдвэрүүд бийх боловс тус шийдвэрийн хувь илүү шогц бийблэвэр шийдвэрлжин гэлээ утварв нь тус огтуулжин онцлогиin авч үзж байж ялалтгүүний тайлбарлах боломжтой боловс тус огтуулжин хувьд факт болон бусад субъектив шүнэлэхийн хэрхэн ялгахтай холбоотой асуудлын талаар л харьшуулжагаа зорисон болно.

терийн онолыг номлогч" гээд "судлаачдын дунд тэрээр ямар ч байр суурьгүй нэгэн, зүгээр л нэг идэвхтэн (Ollman has no status within the profession, but is a pure and simple activist)" хэмээн бичсэнтэй холбогдуулан шүүхэд ижээмжлэл гаргасан хэрэг болно<sup>21</sup>. Тус инйтлэл гарсны дараагаар Оллманыг сургуулийн захирлаар томилох шийдвэр цуцлагдан гэх мэт үр дагаврууд гарсан байдал.

Энэхүү шийдвэрийн дагуу факт болон тайлбар, санал, шүүмжлэлийг ялгах асуудлыг танигдартан бус шүүгч шийдвэрлэх ёстой гээд ялгахын тулд дараах дөрвөн нөхцөлийг анхаарч үзж нь зохицтой онцолсон байдал. Үүд: 1. Тухайн мэдээг бичихэд ашиглагдсан угийн нийтлэг хэрэглээ болон утга болно. 2. Тухайн мэдээг нотлоу боломжтой эсэх асуудал болно. Өөрөөр хэлбэл тухайн мэдээг үнэи эсэхийг хэлэлцэх боломжтой юу үтгүй юу гэх асуудал. 3. Тухайн мэдээ болон хам сэдэв хоорондын хариулсан хамаарал болно. Мэдээг илэрхийлсэн илэрхийллийг л авч үзвэл факт мэт харгадах боловч, хам сэдэв (context)-тэй нь холбож авч үзвэл тайлбар, санал, шүүмжлэл байх тохиолдол гарч болно гэсэн үг. 4. Тухайн мэдээг тараах үеийн нийгмийн нөхцөл байдлыг харгалзан үзж зэрэг болоно<sup>22</sup>.

Дээрх нөхцөлийг дэвшүүлсэн шүүгч нарын олонхийн зүгээс "судлаачдын дунд тэрээр ямар ч байр суурьгүй нэгэн, зүгээр л нэг идэвхтэн (Ollman has no status within the profession, but is a pure and simple activist)" гэх хэсгийг тайлбарлаадаа тус нийтлэлд Оллманы одоогийн албан тушаалыг тодорхой бичсэн төдийгүй, ижээмжлэгч нь тодорхой байр суурьтай болохыг тодорхой илэрхийлсний дараа бичсэн байх бөгөөд судлаачдын дунд санал асуулга явуулж нийм үр дүнэ хүрсэн гэх байдаагаа бичигдээгүй тул зохиогчийн саналаас хэтрэгчүй хэмээн

тайлбарлах нь зүйтгэй гэж үзжээ.

Харин дээрх шийдвэрээс хойш Оллман хэргийн хувьд дэвшүүлсэн дөрвөн нөхцөлийг зарим нэг байдлаар өөрчилж оролдлогууд мөн хийгдсэн байдал. Үүний нэг тод жишээ нь Mr. Chow of New York v. Ste. Jour Azure хэргийн шийдвэр болно. Тус шийдвэрийн хувьд Оллман хэргийн дөрвөн нөхцөлийг дараах байдлаар өөрчилсөн байдал: 1.Тухайн мэдээг багтаасан текстийн хам сэдэв, 2.Тухайн мэдээг илэрхийлсэн илэрхийллийн утга, 3.Үзин эсэхийг нотлох боломжтой эсэх, 4.Илэрхийлэгдээгүй факт бий эсэх зэрэг болно. Өөрөөр хэлбэл, Оллман хэргийн дөрвөн нөхцөлийн 3 болон 4 дэх нөхцөлийг илгээж, шинээр илэрхийлэгдээгүй факт бий эсэх гэсэн нөхцөлийг шалтаж үзж ёстой гэсэн саналыг дэвшүүлсэн байдал.

Гэвч АНУ-ын судлаачдын хувьд дээрх Оллман хэргийн дөрвөн нөхцөлийг шүүмжлэх хандлага мөн ажиллагдана. Учир нь тухайн шийдвэрийг гаргахдаа цөөнх болсон шүүгч нарын зүгээс "судлаачдын дунд тэрээр ямар ч байр суурьгүй нэгэн, зүгээр л нэг идэвхтэн (Ollman has no status within the profession, but is a pure and simple activist)" гэх хэсгийг факт гэж дүгнэсэн төдийгүй, цаашид ч дээрх дөрвөн нөхцөлийг ашигласан тохиолдолд шүүгч нарын санал хувваагдах, шийдвэрийн хувьд ойлгомжгүй, тодорхой бус болох магадлал өндөр гэж дүгнэж болоюм.

Тиймээс ч үзэн эсэхийг нотлох боломжтой юу үтгүй юу гэсэн гацаа нөхцөлөөр дамжуулан факт уу, тайлбар, санал, шүүмжлэл үү гэгдгийг шийдвэрлэх нь илүү зүйтгэй гэж дүгнэсэн судлаачид ч байгааг энд онцлон тэмдэглэх нь зүйтгэй болов уу<sup>23</sup>.

## 2.2. ЯПОН УЛС

Япон улсын хувьд 1987 оны 4-р сарын 24-ны өдрийн болон 1989 оны 12-р сарын 21-ны өдрийн Улсын Дээд шүүхийн

<sup>21</sup> Ollman v. Evans 750 F. 2d 970 (D. C. Cir. 1984) (en banc), cert. denied, 471 U.S. 1127 (1985) хэргээй наzzad төстэй шийдвэрийн хувь: Сүхбаатар дүүргийн шүүхийн 2011 оны 04 сарын 20-ны өдрийн Дугтгар 654 шийдвэрийн дурдаж болж ком.

<sup>22</sup> Ollman v. Evans 750 F. 2d 970 (D. C. Cir. 1984) (en banc), cert. denied, 471 U.S. 1127 (1985).

<sup>23</sup> Jeffrey E. Thomas, Comment, Statement of Fact, Statement of Opinion, and the First Amendment, 74 Cal. Law Rev. 1001, 1045, 1055 (1986).

шийдвэрээр дээр дурдсан Fair comment defense буюу Зохицой шүүмжлэл гэх нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн байдал. Эдгээр шийдвэрийн дагуу “Тодорхой фактыг үндэслэн илэрхийлсэн санал болон шүүмжлэлийн хувьд хариуслага хүлээлгээдээ тухайн үйлдэл нь нийтийн эрх ашигтай хамааралтай факттай холбогдох, зорилго нь гагшгүү нийтийн эрх ашгийн төлөө байгаа тохиолдолд тухайн санал болон шүүмжлэлийн суурин болсон факт нь чухал хэсгийнхээ хувьд үзни болох нь нотлогдсон бол бусад гэм хор учруулах зэргээр санал болон шүүмжлэлийн шинжийг агуулаагүйгээ бусад тохиолдолд тухайн үйлдэл нь хууль бус биш байна.” гэсэн жишигийг бий болгосон байдал<sup>24</sup>.

Харин факт уу эсхүл тайлбар, санал, шүүмжлэл уу гэсэн асуултад Улсын Дээл шүүхийн 1997 оны 9-р сарын 9-ны өдрийн шийдвэрээр анх удаагаа Улсын Дээл Шүүхийн 1956 оны 7-р сарын 30-ны өдрийн шийдвэрийг нийлээд тус шийдвэрийн дагуу бий болгосон “ердийн үүшигчдын анхаарал болон үнших arga baril”-ын шалгнуурыг факт болон тайлбар, санал, шүүмжлэлийг ялгахад мөн адил ашиглах боломжтой гэсэн шийдвэрийг гаргасан байна.

Улмаар “сонины нийтлэл дэх нэр герийг гутаасан байж болзошгүй хэсгийн талаар зөвхөн тухайн хэсэгт ашиглагдсан үгийн ердийн утгыг гол болгон ойлгосон тохиолдолд нотлох баримт зөргийт ашиглан тухайн хэсгийн талаар нотлох боломжтой гэж шууд тайлбарлах боломжгүй байсан ч тухайн хэсгийн өмнө болон дараах хам сэдэв болон тухайн нийтлэлийг гаргах үеийн ердийн үүшигчидын мэдээг, түршлэгээ зэргийг үзэлн үзээд тухайн хэсгийг шууд бус байдалаар болон тойруу замаар илэрхийлсний улмаас өөр агуулыг илэрхийлийк байвал факттыг илэрхийлсэн гэж дүгнэх иż зүйтэй гэсэн шалгнуурыг дэвшүүлсэн байдаг.

Харин тайлбар, санал, шүүмжлэлийг хэрхэн ангиллах авч үзж талаар Япои улсын судлаачид өөрсдийн саналыг тодорхой

<sup>24</sup> 参照昭和62年4月24日第二小法廷民集41巻3号490頁。最判平成元年12月21日第一小法廷民集43巻12号2251頁。

илэрхийлсэн байх тул дор тус бүрийн агууллыг товч танилцуулъя.

Эхлээд судлаач Мацуи Шигэноригийн ангиллыг авч үзье. Тэрээр 1.Бусдын зан чанар, чадвар зэргийн талаарх үнэлэмж, 2.Реторикийн хэтрүүлэг ашигласан тохиолдол, 3.Фактын талаарх мэдээ мэт харагдах боловч, объектив байдаар нотлох боломжгүй тохиолдол, 4.Тодорхой фактын талаар таамагласан тохиолдол гэж ангилсан байна<sup>25</sup>.

Харин судлаач Ямагучи Шигэнкигийн хувьд 1.Бусдын нэр төрийг гутаагаагүй факт илэрхийлэгдсэн бөгөөд үүнд үндэслэн шүүмжлэл, санаалыг илэрхийлсийг тохиолдол, 2.Шүүмжлэл, санал л илэрхийлэгдсэн тохиолдол, 3.Бусдын нэр төрийг гутаасан факт илэрхийлэгдсэн бөгөөд шүүмжлэл, санал мөн илэрхийлэгдсэн тохиолдол гэж ангилжээ<sup>26</sup>.

Түүчинчлээ судлаач Сэгава Нобухиса үзэхдээ 1.Тодорхой фактад суурилсан санал, шүүмжлэл, 2.Хийсвэр бөгөөд тодорхой бус фактны талаарх илэрхийлэл болон санал, шүүмжлэл илэрхийлэгдсэн тохиолдол, 3.Тодорхой фактыг далд байдлаар ч илэрхийлэгүй хийсвэр бөгөөд үнэлэмжийн шинжтэй илэрхийлэл гэсэн ангиллыг дэвшүүлсэн байна<sup>27</sup>.

Дээрх судлаач нарын ангилалд үндэслэн өөрийн ангиллыг дэвшүүлсэн судлаач Канда Такаогийн хувьд 1.Тодорхой факт (уйн хөдлөл)-ийн талаарх санал, шүүмжлэл боловч, тухайн фактад холбогдох хүний нэр төрийг гутаасан үр дагаврыг бий болгохуүц тохиолдол, 2.Фактын талаар илэрхийлсэн бөгөөд түүнд үндэслэн тухайн фактад холбогдох хүний зан чанар, чадварын талаар ухамсартайгаар өөрийн санал, шүүмжлэлийг илэрхийлсэн тохиолдол, 3.Бусдын зан чанар, чадварын талаар шууд өөрийн санал, шүүмжлэлийг илэрхийлсэн тохиолдол хэмээн ангилахыг

<sup>25</sup> 松井茂紀「意見による名誉毀損と表現の自由」民商113巻3号356~359頁。

<sup>26</sup> 山口成樹・法協109巻11号128頁（最高判平元・1・2・2民集43巻12号2252頁）。

<sup>27</sup> 淀川信久「民法判例レビュー・民事責任」判夕871号61~62頁。

санаал болгожээ<sup>28</sup>.

### III. ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү товч судалгаагаар дамжуулан юу түрүүнд ЗХУ-ын төдийгүй, ОХУ-ын судлаачдын үзэл баримтлагыг судлах замаар Монгол Улсын Иргэний хуулийн 21-р зүйлийн 21.2 болон 511-р зүйлийн 511.1 дэх хэсэгт зохицуулагдсан “мэдээ (орос. сведения)” гэх иөхцлийг хэрхэн тайлбарлах эсэх талаар өөрийн саналыг илрэхийлжэхийг зорилоо. Үүний үр дүнд “мэдээ тараасан этгээд түүнийхээ үзин зөвийн нотолж чадахгүй бол” хэмээн зохицуулагдсан тул зөвхөн үзин зөвийн нь нотлох боломжтой мэдээ буюу фактны талаарх мэдээг л дээрх зохицуулалтын дагуу шийдвэрлэх боломжтой гэсэн дүгнэлтэд хүрсн билээ.

Үүний дараагаар шүүхийн шийдвэрийг судалдаа дүнд манай улсын шүүхийн практикт ч гэсэн фактны талаарх мэдээюүс эсхүлдэгийн, санаал, шүүмжлэлийн гэсэн асуултад хариулт өгөх шаардлагатай хэрэг, маргаан гарч байсан болохыг танилцуулж, шүүхийн зүгээс нэгдмэл нэг шаагуурыг буюу хувь зүйн тайлбарыг дэвшүүлэгүй төдийгүй, факт болон тайлбар, санаал, шүүмжлэлийт хооронд нь бүрэн гүйцэт ялгаж шийдвэрлэхгүй байгаа болохыг тайлбарласан болно.

Түүчинэн жишгийн эрх зүйн бүлд хамаардаг орны төлөөлөл болгож Америкийн Нэгдсэн Улс дахь хууль зүйн тайлбарын асуудлыг *Ollman v. Evans* хэргийн шийдвэр болон түүний талаарх судлаачдын байр сууринд тулгуурлан танилцуулж, дараа нь эх газрын эрх зүйн бүлд хамаарах орны төлөөлөл болгож Япон улс дахь хууль зүйн тайлбарын асуудлыг шүүхийн шийдвэр болон судлаачдын байр сууринд тулгуурлан товч байдлаар тайлбарлахыг оролдоо.

Дээр дурдсан судалгааны үр дүнд сууринлан дараах дүгнэлт болон саналыг дэвшүүлж байна.

\* 神田卓夫「意見・論評による名誉毀損」の諸類型と免責事由「損害賠償法の動歴と展望：山田卓生先生古稀記念論文集」250頁。

1. Монгол Улсын өнөөгийн тогтолцоо тъ 3ХУ, ОХУ-аас репети хийстн бөгөөд зөвхөн фактны талаарх мэдээ тараатасы тохиолдолд л Иргэний хуулийн 21-р зүйлийн 21.2 болон 511-р зүйлийн 511.1 лэх хэсгийн дагуу шийдвэрлэгж боломжтой байна. Гэвээдээр тогтолцоо нь хариушлагыг үндэслэх зарчмынхаа хувьд гэм буурут үндэслэн хариушлага хүлээлгэх зарчмын бус, харин гэм буурут үндэслэлгүйгээр хариушлага хүлээлгэх зарчмын тулгуурласан хэм хэмжээ болно (гэм буурут үндэслэн хариушлага хүлээлгэх зарчмын баг зүүсэн гэм буурут үндэслэлгүйгээр хариушлага хүлээлгэх зарчмын гэх үзэгдэл).

2. Иргэний хуулийн хэм хэмжээг системийн үүднээс тайлбарлавал, тайлбар, санаал, шүүмжлэлийн улмаас эдийн бус хохирол учирсан бол энэхүү хохирлыг Иргэний хуулийн 497-р зүйлийн дагуу нехэн төлүүлэхээр шаардах эрхтэй байна. Энэ нь Иргэний хуулийн 230-р зүйлийн 230.2 дахь хэсгийн зарчмыг зөрчихөөргүй байна. Түүчинэн фактны талаарх мэдээний улмаас эд хөрөнгийн хохирол учирсан бол мөн адил 497-р зүйлийн дагуу хохирлоо нехэн төлүүлэхээр шаардах эрхтэй гэж тайлбарах боломжтой байна (практикт ийм байдлаар субсумц хийчүүг байгааг энд онцлон тэмдэглээн нь зүйтэй).

3. Харьцуулсан эрх зүйн судалгааг нэгтгэн дүгнэвээс АНУ төдийгүй Японы хувьд факт болон тайлбар, санаал, шүүмжлэлийг ангилахдаа нотлох баримтаар нотлох боломжтой эсэх гэсэн шалгуурыг голчлон ашиглаж байж бөгөөд хам сээдэв, тухайн үсийн нийтийн нехцэл байдал, унишигчдын мэдээлт, мэдээлэл зэрэг хүчин зүйлийг мөн тухайн хэргийн онцлогоос хамаарая ашиглах боломжтойг нийтлэг байдлаар хүрээн зөвшөөрсөн байгааг манай улсын хувьд ч практикт анхааран үзэх шаардлагатай.

4. Харьцуулсан эрх зүйн судалгааны хүрээнд авч үзсэн судлаачдын байр суурийг нэгтгэн дүгнэвэл дараах байдлаар нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнддэйг гутасан үйлдлийг

ангилах боломжтой байна. 1.Гугаасан шинжтэй буюу агуулгатай бүс мэдээ тараагдсан ба шүүмжлэл, санаалаа илэрхийлсэн тохиолдол, 2.Шүүмжлэл, санаал л илэрхийлэгдсэн байгаа тохиолдол, 3.Гугаасан шинжтэй буюу агуулгатай мэдээ тараагдсан ба шүүмжлэл, санаалаа давхар илэрхийлсэн тохиолдол эзрэг болно.

Ангилал 1-т хамаарч байх тохнолдолд фактны талаарх мэдээгүй үндэслэн хариуцлагага хүлээлгэхгүй тул түүнд үндэслэн гарсан санал, шүүмжлэл нь бусдын нэр төрийг гутаасан эсэжийг дүгнэж, 497-р зуйлний урьдчилсан нөхцөлбийг хангасан тохнолдолд хариуцлагага хүлээлгэх боломжтой<sup>29</sup>. Гэхдээ тухайн фактад үндэслэсэн санал, шүүмж эсэхийн мөн ашиг логик хамаарлын хүрээнд авч узах шаардлагатай.

Харин ангилал 2-т хамаарч байх тохиолдодд зан суртахууны хэм хэмжээнд харш илэрхийлийг ашигласан эсэх гэж мэт нөхцөлийг харгалзан узж, 497-р зүйлийн дагуу шийдвэрлээнд. Эөөрөө хэлблэл, хэт доромж уг хэллэгт ашигласан, хөтүүлгүүг буруу буюу хожижтэй ашигласан гэх мэт тохиолдода хариуслага хүлээлгэнэ тэсэн уг. Энэ тохиолдод ямар нэгэн фактыг дэлд байвалар илэрхийлсэн гэж дүгнэх боломжтой эсэхийт хам сэдэв, нөхцөл байдал зэргийг ашиглан тайлбарлаж тогтоон.

Ангилал 3-т хамаарч байвал энэ тохиждод фактүүн талаарх мэдээ нь нэр төрийн гутасан агуулгатай тул 21, 511-р зүйлийн дагуу гэм бууруг үндэслэлгүйгээр хариуцлага хүлээлгэх боловч, харин санаал, шүүмжлэлийн хувь энэ нь тухайн фактад үндэслэсэн бол хариуцлага хүлээлгэх үндэслэл бурдаж боловч, үндэслэлгүй бол 497-р зүйлийн дагуу шалгаж үзэх шаардлагатай болно.

Ном зүй

Р.Пүрэвбаатар “Монгол Улсын Иргэний хуулиуд дахь нэр төр, алдарт хүнд, ажил эзгийн нэр хүндийн талаар зохицуулсан хэм хэмжээ: харьцуулсай эрх зүйн хувьнээс дутгын нь.” Хууль дээдлэл ёс, УБ., 2018 он, хув. 83

P.F.CARTER -RUCK AND  
R.WALKER, CARTER-RUCK ON LIBEL  
AND SLANDER, BUTTERWORTHS, 360  
(3D ED.1985)

O.S.Ioffe, *The New Codification of Civil Law and Protection of the honor and dignity of the Citizen*, THE SOVIET REVIEW VOL.4, NO.3, TAYLOR & FRANCIS LTD, 64 (1963).

Белявский А.В., Судебная защита чести и достоинства граждан. М., 1966 ст.8

Белявский А.В., Придворов Н.А.,  
Охрана чести и достоинства личности в  
СССР. М. 1971. ст. 56.

Эрделевский А., Утверждение о факте и выражение мнения - понятия разного рода. Российская юстиция. 1997 № 6 ст. 17.

Потапенко С., Судебная практика Верховного Суда Российской Федерации по спорам о защите чести и достоинства, "Законодательство и практика масс-медиа", 2004, №5 ст. 29

Дмитрий Голованов, Сергей Потапенко, Применение российскими судами положений Конвенции о защите прав человека и основных свобод и практики Европейского суда по правам человека: теоретические и практические аспекты, Законодательство и практика, Масс медиа, №3, 2005 г. ст.18-31

MARC A. FRANKLIN & DAVID A.  
ANDERSON, MASS MEDIA LAW 254 (4<sup>TH</sup>  
ED. 1990)

Jeffrey E. Thomas, Comment, Statement of Fact, Statement of Opinion, and the First Amendment, 74 Cal. Law Rev. 1001, 1045, 1055 (1986).

松井茂記「意見による名誉毀損と表現の自由」民商113巻3号358-359頁

山口成樹・法協109巻11号128頁（最判平元・12・21民集43巻12号2252頁）

瀬川信久「民法判例レビュー・民事責任」判  
タ871号61-62頁。

神田孝夫『「意見・論評による名誉毀損」の  
諸類型と免責事由』「損害賠償法の軌跡と展  
望: 山田卓生先生古稀記念論文集」250頁。

Чингэлээй дүүргийн шүүх 2003 оны  
12 дугаар сарын 10-ны өдрийн 1229 дүгээр  
шийдвэр

Нийслэлийн Давж заалдах шатны  
шүүхийн 2004 оны 2 дугаар сарын 9-ны  
өдрийн 86 дугаар магадлал

Монгол Улсын Дээд Шүүхийн 2004  
оны 04-р сарын 15-ны өдрийн 230 дугаар  
тогтоол

New York Times Co. v. Sullivan 376  
U.S. 254 (1964)

Gertz v. Robert Welch, Inc. 418 U.S. 323  
(1974)

Greenbelt Cooperative Publishing  
Association, Inc., v. Bresler, 398 U.S. 6 (1970).

Old Dominion Branch No.496, National  
Association of Letter Carriers v. Austin. 418  
U.S. 264 (1974)

Ollman v. Evans 750 F. 2d 970 (D. C.  
Cir. 1984) (en banc), cert. denied. 471 U.S.  
1127 (1985)

最判昭和62年4月24日第二小法廷民集41巻3  
号490頁。

最判平成元年12月21日第一小法廷民集43巻  
12号2251頁。

---oo0---

## УУЛ УУРХАЙН ТӨСЛҮҮДИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТСӨН ОРОН НУТГИЙН ИРГЭДЭД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОЖ БҮЙ ПРАКТИК



МУИС-ийн ХЭС-ийн магистрант  
П.Байгалмаа

### ТҮЛХҮҮР ҮГ:

Нөхөн олговор, Үндсэн хуулийн үзэл баримтлал, орон нутгийн иргэдийн эрх ашиг, малчид

### ТОВЧЛОЛ:

Монгол зэрэг хөгжих буй улсуудын эдийн засагт зам, барилга байгууламж, шахилгаан станц барих зэрэг дэл бүтгийн төслүүд, ашигт малтмалын тодорхой иөөшүйг түшиглэсэн уул уурхайн олборлолтын төслүүд ихээхэн чухал үүрэгтэйн зэрэгцээ тухайн төслүүдийн үйл ажиллагаанаас байгаль орчин, орон нутгийн иргэдэд үзүүлэх нөлөөллийг нарийвчлан судлан тогтоож, иргэдийн эрхийг зөрчигдөхөөс хамгаалах, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь чухал юм. Тус орны хувьд уул уурхайн хайлгуул, олборлолтын үйл ажиллагаа явагдаад 20 орчим жил болж буй хэдий ч өнөө хүр тазар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт болон нөхөн олговрыг зохицуулсан хууль, журам, олон улсын жишигт инийцэн стандарт байхгүй байна.

Газрын харицаатай холбоотой нөхөн олговрын одоогийн эрх зүйн зохицуулалт нь хүн ам одноор суурьшсан хот суурин газрын дахин төлөвлөлт, хөгжүүлэлт болон улсын тусгай хэрэгцээтэй холбогдох явшуу хүрээнд гарч байгаа учир уул уурхайн шууд болон дам нөлөөнд өртөн эрх ашиг нь зөрчигдөх буй малчид хуулийн хамгаалалтаас гадна үлдсэн хэвээр байна.

Үндсэн хуулийн үзэл баримтлал уул уурхайн үйл ажиллагаанаас үзүүн газрын нь эргүүлэн авсан малчдад нөхөн олговор олгох үндсний тогтоож өгсөн боловч, тухайлсан хуулиар зохицуулалт зайлшгүй шаардлагатай болохыг нөхөн олговрыг практикт хэрэгжүүлж буй туршлага болон олон улсын стандартад тулгуурлан харуулахыг зорив.

Цаашид, нарийвчилсан хууль, журам боловсруулан батлахаас гадна Үндсэн хуулийн үзэл баримтлал, олон улсын хүний эрхийн норм, стандартын хүрээнд газрын харицаатай холбоотой нөхөн олговрын онолын судалгааг ч гүнзгийрүүлэх шаардлагатай.

### ҮДИРТГАЛ

2019 оны 10 сарын байдлаар Монгол Улсын нутаг дэвсгэр дахь ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо 2861-т (хайгуульн 1197, ашиглалтын 1664) хүрээд байгаа ба хамрах талбайн хэмжээ нь 7.7 сая га буюу нийт газар нутгийн 4.9 хувийг эзэлж байна!. Энэ хэмжээ ашигт малтмалын хайгуульн оргил үе буюу 2005 онд 44.4 хувьд хүрч байсан билээ. Улсын төсвийн орлогын бараг 30 хүргэлх хувийг дангаараа бүрдүүлдэг уул уурхайн бүтээгдэхүүний экспортогоос эдийн засаг

“Эрдэж, багийн статистик мэдэг”, 2019 оны 8 сар, Ашигт малтмал, газрын тосны газар <https://mrtam.gov.mn/public/page/133/2019-08-mon.pdf>

нэ шууд хамааралтай байдаг улсын хувьд энэ хэмжээ буурахгүй, харин ч нэмэгдэх магадлалтай. Төрөөс тусгай зөвшөөрөл авсан уул уурхайн компаниудын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа нь тухайн орон нутагт уламжлалт хэлбэрээр болжээр сэлгэн, нүүдэллэн амьдарч ирсэн малчдын газар эзэмших, ашиглах эрхийг зөрчсөнөөс ус, бэлчээрийн нөөц хомстож, Үндэсний хуулиар олгогдсон эрх ашиг нь зөрчигдех явдал түгээмэл болоод байна.

Олборлох салбарын эрх зүйн зохицуулалтын талаарх судалгаа, мэдээлэл нь ихэвчлэн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, нөхөн сэргээлт, гэрээ болон байгаль орчинд нөлөөлж буй серег нөлөөллүүдийн хүрээнд хийгдэх нь түгээмэл байна<sup>2</sup>. Харин уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас орон нутгийн иргэдийн өдөр тутмын амьдрал, уламжлалт мал аж ахуй, нүүдэлчин соёлд үзүүлж байгаа серег нөлөөлөл, эрхийн зөрчилүүдийг хүний эрхийн болон салбар дамнаасан хандлагаар судлах, зөрчигдсөн эрхийг хэрхэн сэргээх талаар санал, санаачилгагарахаявдлутмагбайна. Гэхдээ энэ чиглэлийн олон улсын байгууллагууд, төслийнд санхүүжилт бүхий судалгааны алжлууд цөөнгүй хийгдэгийг дурдах нь зүйтгэй. Жишээ нь, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, ХЭҮК-ийн дэмжилгээний ээр Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэнгээс 2012 онд хийсэн “Монгол Улс дахь уул уурхайн үйл ажиллагаанаас хүний эрхэд үзүүлэх нөлөө” судалгааны тайлан<sup>3</sup>, мөн Даян Дэлхийн Байгаль Хамгаалах Санг (WWF)-гийн захналгаар Ногоон Хөгжлийн Хөтөч ТББ-ын 2017 онд хийсэн “Уул уурхайн шийдвэр гаргалтанд талуудын оролцооны мэдлэг, хандлага, дадлын

үнэтгээний тайлан<sup>4</sup>” зэргийг дурдаж болно. Энэжүү өгүүлэлгүүр уул уурхайн төслийн нөлөөллийн бүсэд амьдарч байгаа орон нутгийн иргэдийн орон байртай байх, мэдээлэл авах, мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах<sup>5</sup>, зөрчигдсөн эрхээ сэргээлтэх, ялангуяа нөхөн олговор авах эрхийн асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжоор хэрхэн зөхижуулсан болон хэрэгжүүлж байгаа практикийн талаар хөндөж, эрх зүйн дүгнэлт гаргахыг зорилго болгов.

Уул уурхайн хайгуул, олборлолтын төслийндийн үйл ажиллагаа явуулж буй талбай нь бүгд хөдөө орон нутагт байна. Тэдээр талбай нь малчдын уламжлалт байдааар өвлөн эзэмшиж, ашиглаж ирснэ өвлийн, хаваржаны газар болон амьжиргээны үзүүсэн эх үүсвэр болсон бэлтгээр, усны нөөц бүхий талбайтай давхардсааас үүдэн малчдад шууд ба дам байдааар серег нөлөөлөл үзүүлж байна. Үндэс, малчдын газар эзэмших, ашиглах эрх зөрчигдех, бэлтгээр нутаг хязгаарлалтадаас өмнөх байдаараа малаа болцээрлүүлж боломжгүй болох, ингээнээр малын тоо толгой болон малаас авах ашиг шим буурах, усны нөөц хомстож, хүн мал үндэни усаар гачигдах, мөн уламжлалт нөудэлччин соёл, уламжлалт сергөөр нөлөөлөх зэрэг хорондоо хамаарал бүхий олон асуудлыг дагуулах болжээ. Энэ нь ялангуяа Өмнөговь зэрэг усны нөөц баатай, эмзэг экосистем бүхий газар нутагт бүр ч хүнд тусг байгааг Оюу Толгой ХХК-ийн эсрэг тус аймгийн Ханborgод сумын малчдын үүсгэсэн заргаас харж болно<sup>6</sup>. Энэ талаар нөхөн олговрыг практикт хэрхэн хэрэгжүүлж байгаа хэсэгт дэлгэрэнгүй авч үзнэ.

<sup>2</sup> Д.Ренчиндорж “Ашигт мийтишлын тусгай зөвшөөрлийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” 2016 он. Н.Бакрын “Монгол улсын хуулын хамгийн үр ашигтай уул уурхайн гэрээг тодорхойлох нь” УБ, 2018 он.

Х.Чинбат “Ашигт малтмалын хайл, ашиглагч эрхийн иргэний эрх түйн эс суурвалж” УБ, 2019 он. Г.Сурахбаев, Б.Өлзийбаяр “Ашигт малтмалын тухай хуулийн 2006 оны шинэлгээ” 2018 он.

<sup>3</sup> Газар чөлөөлөгт, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн төлбөрийн зохицуулалтыг хамруулж үзсн.

<sup>4</sup> Уул уурхайтай хөбөбийт асуудлыар, ялангуяа нүүлгэн шилжүүлэлт болон нөхөн олговрын талаар иргээгээ зөвийн байдал зэргийг яич үзсн. “Уул уурхайн хөрөнгө оруулалтын төвлөвлийн талуудын орчингоо ийнзүүлжээ замын Монгол орны ард иргээ мал сургиийн зурагтамжар орчны булагчад бэхжээ” байгаль орчиний хамгаалах нь” төсөв.

<sup>5</sup> Загэр эрхүү “Байгаль орчны асуудлыар мэдээлэл авах, шийдвэр гаргахад орохдох, эрхээ хамгаалууснах талаар Аархусын Конвенцii”-оор багасгажсан. Монгол Улс нийзэн орох талаар 10 гаруй жил хамгаалж байгаа болон ажлыг хэрэг болоогүй байна. [https://www.uneece.org/fileadmin/DAM/env/pdf/documents/Aarhus\\_Convention\\_in\\_Mongolian.pdf](https://www.uneece.org/fileadmin/DAM/env/pdf/documents/Aarhus_Convention_in_Mongolian.pdf)

<sup>6</sup> [http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents / OT-2\\_Assessment\\_Report\\_MON.pdf](http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents / OT-2_Assessment_Report_MON.pdf).

Ул уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөс хохирсон орон нутгийн иргэдийн нийтлэг эрх ашгийг бодолцож нийтийн нөхөх олговор олгох, хувь малчин өрхөд учирсан хохирлыг бодитой үнэлэх, нүүлгээ шилжүүлэлт явуулах тохиолдолд орон нутгийн иргэдэд урьдчилан мэдэгддэг байх (зөвхөн нутгэн шилжүүлэлт төдийгүй төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмвө орон нутгийн иргэдэд мэдээлэл өгдөг, тэднээс зөвшөөрөл авдаг, иргэд мэдээлэлтгэээр шийдвэр гаргадаг нөхцөл боломжийг бүрдүүлэх нь нэн чухал), учирсан материаллаг болон сэтгэл санааны хохирлыг бодитойгоор нөхөн төлөх, згээр үйл ажиллагаанууд нь иргэдийн амьзигдааны түвшинг өмнөх байдлаас нь бууруулахгүй байх боломжийг бүрдүүлэх зэргээр орон нутгийн иргэдийн өмчийн эрх болон газар өмчлөх, эзэмшиг, ашиглах эрхийг хамгаалах шаардлагатай байна.

Үндсэн хууль болон бусад хуулиуд дахь нөхөн олговрын зохицуулалт

Монгол Улсын Үндсэн хуулийн (1992) 16.3 дахь кэсэгт "... Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн зд хөрөнгийг дайлан авбал нөхөх олговор, үнийн төлнө" гэдгүндээс зохицуулалт бий. Мөн Газрын тухай хуулийн (2002) 20.1.4 кэсэгт "бусдын эзэмшил гарыг аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээнд авахтай холбогдуулан гэрээний хугацаа дусахаас өмнө гарыг солих буюу эргүүлэн авах тохиолдолд тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсизээр нөхөн олговор олгох шийдвэр гаргах эрхийг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийг. Төлөөлгөгчийн Хурал хэрэгжүүлэхээр заажээ. Дээрх заалтуудаас харвал, нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэгүй нөхцөл нөхөх олговор олгох нөхцөл үүсэхгүй, тэгээд ч төр биш төрөөс зөвшөөрөл авсан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зүгээс хохирлын нөхөн олговрыг олгох тохиолдолд здэээр заалтууд хамааралгүй мэт. Гэхдээ "Үндсэн хуульд гарыг төрөөс эргүүлэн авахдаа ... нөхөн олговрын талаар шуул тусгаагүй нь ... Үндсэн хуулийн үзэл баримглалд

нийцэхгүй гэсэн агуулгагүй юм"<sup>1</sup>. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу малчны хувийн эзэмшигийн өвөлжэе, хаваржааны газар, нийтийн эзэмшигийн бэлчээрийт ашиглах, газрынхаа үр шинийг хүртэх боломжгүй болож байгаа нь газар эзэмшиг эрхэд халдаж буй зөрчил, гарыг шууд бусаар эргүүлэн авч буй гэж үзж болох тул нөхөх олговор олгох үндэслэл болох юм.

Тэгвэл ул уурхайн салбарын суурь хууль болох Ашигт малтмалын тухай хуулийн (2006) 41.1 дэх хэсэгт "Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуульн болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжэе, хувийн болон нийтийн зориулалттай орон байр, бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэй хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байгуулалттай холбогдсон зардлыг харинчаа" гэжээ. Гэхдээ энэ заалт нь тухайн өмчийн эзэнд зөвхөн материаллаг гэм хор учирсан байхыг шаардсанаас биш хохирлыг хэрэн баримтжуулах, эд хөрөнгийг хохирлыг ямар хугацаанд, хэрхэн барагдуулах тухай нарийвчилсан зохицуулалтыг тусгаж өгөөгүй<sup>2</sup>, түүнчлэн нүүдэлчни соёл уламжлал, ёс заншил, нутгийн иргэдийн "нүтгээ" гэх сэтгэл зэрэг мөнгөөр үнэлэх боломжгүй, эдийн бус баялагт учирч болох хохирлыг авч үзэгүй, мөн шилжүүлэн байгууллах ямар нөхцөлийг шаардлагатай тохиолдолд гэж үзжийг ч тодорхой тусгаагүй байна.

Үндсэн хуулиар нөхөн олговор олгох үндснийг тавьсан хэдий ч уг асуудлыг тусгайлан хуулиар нарийвчлан зохицуулах зайлшгүй шаардлагатай ба нөхөн олговрын асуудал онолын түвшинд ч хангалттай судлалдагайгүй тэмдэглэх нь зүйтэй. "... Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйд "дайчлан авах", "эргүүлэн авах", "улсын

<sup>1</sup> Д.Ганѓабаттар, "Нөхөн олговрын тухай Үндсэн хуулийн үзэл баримтлалын ипотолын үндэс". Хууль дэхийгээ сэлтүүл, №51/96, 2013 он, 45 дахь тал.

<sup>2</sup> Гэртэй тухай хуулыг чиг төрийнхнээ зохицуулалт харьцаангуй тодорхой туссан байлаг, 43 лутгаар зүйлд.

тусгай хэрэгцээ”, “ийнгийн зайлшгүй хэрэгцээ”, “нөхөн олговор” зэрэг нэр томьёо, түүний утга агуулгыг дэлгэрэнгүй тайлбарласан Үндсэн хуулийн Цэцийн шийдвэр гараагүйн дээр энэ талаар хийсэн судалгаа хомя байна...”.

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх зорилтын хүрээнд иргэний өмчийг төрөөс эргүүлэн авах, дайчлан авах тохиолдолд олгох нөхөн олговор болон нүүлгэн шилжүүлэлтийн эрх зүйн зохицуулалт 2014 оноос хойш харьцаангуй дэвшвилттэй хийддэж байна гэх эхлж болно. Энэ хүрээнд “Нийслэлийн иутаг дэвсгэрт газрыг худалдан авах болон нөхөн олговортойгоор худалдан авах, солих журам” (НИТХТ-ийн 2014 оны 126 тогтоол), “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль” (2015), “Газрыг тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагний тогтоох, ашиглах журам” (ЗГ-ын 2017 оны 287-р тогтоол), “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны нөхөн олговор олгох журам” (ЗГ-ын 2018 оны 222-р тогтоол) зэрэг хууль, тогтоомжид батлагдан гарч, хэрэгжниж байна. Дурдагсан хууль, журмууд хэдийгээр хот, суурин газрыг дахин төвлөх, хөгжүүлжэй холбоотой асуудлудын хүрээнд батлагдсан хэдий ч тусгасан үзэл баримтлал, зарчмууд нөхөн олговрын нийтийг шаардлага, олон улсын жишигт дөхөж очсоныг тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал, 287-р тогтоолын 3.6 дахь хэсгэгт нөлөөлөлд өртж байгаа иргэн, ААН, байгууллагатай нөхөн олговрын талаар урьдчилсан тохиролцох зүйлсийг нарийвчлан тусгасан, мөн 222-р тогтоолд “Нөхөн олговрын хэлбэр, хэмжээг тогтоохдоо нийтийн эрх ашигийг эрхэмлэх, олон нийтийн оролцоо хангах, мөн гарз, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшиг иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашиг, амьжиргаа, аж ахуйн үйл ажиллагааны нөхцөлнүйг өмнө байснаас

дордуулахгүй байх зарчмыг баримталын<sup>10</sup>. Түүничлэн, нөхөн олговрын үнэлгээний зүйлд, “өмчлөх, эзэмших эрх бүхий газар, газрын үндсэн бурдэл хэсэгт хамаарах тухайн газар дээрх үл хөдлөх хөрөнгө буюу барилга байтууламж, газар чөлөөлөх зардал, түр суурьшуудаа зардал, төсөл хэрэгжүүлэхээр сонгосон талбай дахь өөрийн өмчлөл, эзэмшилжийн газар, үл хөдлөх эд хөрөнгөе ашиглан аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны цэвэр ашиг хамаарна<sup>11</sup>” гэжээ.

Ул уурхайн компаниудаас орси нутгаттай хамтран ажиллах зохицуулалт хийж оролцлогуудын хүрээнд “Уурхайн үйл ажиллагаанаас бий болох хөгжлийн боломжуудыг орон нутгийн иргэл хүртэж болон уурхайн үйл ажиллагааны нөлөөлэлд өргөх иргээдийн нийгэм, соёл, эдийн засгийн тогтвортой байдлыг сайжруулах явдлыг хангах” зорилго бүхий Ором нутгаттай хамтран ажиллах гэрзийн загварыг<sup>12</sup> Хогян Ловелс компани 2015 онд УУЯ-ын захналгаар бэлтгэсэн байх ба 4.6(g) хэсэгт Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн төлбөрийн харьцаангуй тодорхой заалтуудыг<sup>13</sup> оруулж ёсеси ч албан ёсоор батлагдан, практикт хэрэгжиж эхлээгүй байна.

<sup>10</sup> “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны нөхөн олговор олгох журам” ЗГ-ын 2018 оны 222-р тогтоол, 2.1 дахь заалт.

<sup>11</sup> Мөн тогтоол 3.1 дахь заалт.

<sup>12</sup> <http://www.mongolianminingjournal.com/a/61074>

<sup>13</sup> (i) Компани нь нийтийн болон күүйн эзэмшилжийн орон байр, худал, малын өвлийнхийн хашаа, бусад байгуулалт болон түүх, солбам дурсгалт гарын өмчлөгч, эзэмшигчээс Хөхбогд хуулийн засаг дагуу тагшгэрт урууцасан хөхцөлж бүрэн нохин төлин. (ii) Хэрэв шаардлагатай бол Компани нь хөнгөнчийн үнс эсчүүд урууцасан хөхцөлж комиссог тогтоохаар бус узлыгээ хийгэжсоно. (iv) Уурхайн үйл ажиллагааны узмаас нүүргүүдийн хийх залбшгүй шаардлагатай тохиолдлоо Компани нь (i) тухайн үүгэлэн шилжүүлжээ гарал болдит зардал, тухайлбай орон байр, мал амьтны болон малын хашаа нүүргүү болон дахиин барих зардлыг төлөх, (ii) шаардлагатай тохиолдлоо нүүргүүдийн бүй мал, амьтны хүрэлцэхийн тоогоор, шаардлагатай хамгахуйд чанар бүхий усны худаг эсчүүд ормын шооногийг шинжилж засах эсчүүл шинээр гаргана. Энэ тохиолдолд нийхүү нүүргүү шилжүүлэх бүй Орон нутгийн иргэлтгэй худал, шооногийн гүний хамгаж, тоог тохиолцено. (vi) Нүүргүү шилжүүлжийн түүнч хамрагдсан Орон нутгийн иргэл болон Орон нутгийн биеийншийн байгууллагатай зөвлөлдсөнцийн эзэр шийдвэртээс багасаа энэ асуудалар гарын байгууламж. Нүүргүү шилжүүлж хамрагдсан Орон нутгийн иргэл бий болсон тохиолдлоо байна.

\*Д.Гангабаатар. “Нохөн олговрын тухай Үндсэн хуулийн үзүүл баримтлын и源源不断ын үндэс”, Хууль дээдлэх 86 сэргүүл, №51, УБ., 2015 он, 40 дахь тал.

Уурхайн компаниудаас орон нутгийн иргэлцэл нөхөх олговор олгож байгаа практик

(Оюу Толгой төслийн жишээн дээр)

Уул уурхайн төслийдийн үйл ажиллагаанаас эрх ашиг нь зөрчигдэж байтаа орон нутгийн иргэд, малчдын эрхийт хамгаалаах эрх зүйн зохицуулалт дутмаг байгаагаа Оюу Толгой мэтийн мега төслийд, өөрсдийнх нь эсрэг гомдол үүсгэсэн орон нутгийн иргэдийн гомдлыг барагдуулахын тулд өөрийн болон санхүүжүүлэгч байгууллагынхаа мөрдөг жишиг зохицуулалт баримтлан, уурхайн нөлөөллийн бүсээс иргэдийг нүүлгэн шилжүүлэх болон нөхөх олговор олгож буй практик байгааг жишээ болгон авч үзээ.

Оюу Толгой төсөл (OT) нь Монгол Улсын Өмнийн говьд оршиг OT-ийн эс, алтын уурхайг ашиглах зорилготой 12 тэрбум долларын хөрөнгө оруулалттай төсөл юм<sup>14</sup>. Уурхайн лицензийт талбай нь УБ хотоос урагшaa 550 км<sup>2</sup> буюу Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрладаг. Тус сум нь 15,150 км<sup>2</sup> газар нутагтай, засаг захирагчны 5 багтай, 2018 оны эцэсний байдлаар 7668 хүн амтай, үүнээс 389 маачин өрх байжээ<sup>15</sup>.

2012 оны 10-р сарын 12-ны өдөр Ханбогд сумын иргэд, малчдын төлөөлөл бүхий “Говийн гарз широо” ТББ, “Оюу Толгойн Хяналт” ТББ-ын туслаалтаатайгаар Олон Улсын Валютийн Сан (ОУВС)-ийн Эрх Зүйн Хяналт, Зөвлөгөө, Омбудсманы Газар (ЭЗХЗОГ)-т дараах асуудлуудаар

гомдол гаргажээ<sup>16</sup>. Үүнд, төсөл нь орон нутгийн бэлчээрийн газар, усны нөсцийг ашигласнаас үүдэн малчдын амьжиргааг доройтуулж, улмаар уламжлалт нүүдлийн соёлд эрсдэл учруулж байгаад болон нөлөөлэлд өртсөн малчдад 2004, 2011 оид хийгдсэн эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэд олгосон нөхөн олговор хангалтгүй, нүүлгэн шилжүүлэлт зохих ёсоор хийгээгүй болохыг дурдах, уг асуудлыг судлан үнэлэлт дүгнэлт гаргаж өгөхгүй хүсч, зарим шийдлүүдийг санал болгосон байдал Тус төсөл нь ОУВС-ийн зээлдэгч болохын хувьд ЭЗХЗОГ тухайн гомдлыг өөрийн журмаар авч хэлэлциэд, тухайн гомдол нь гомдол хянан шийдвэрлэх шаардлагыг хангаж байна гэж үзсэн тул харагдаж бус хөндлөнгийн шинжээчийдийг шалгаруулан ажиллуулжээ.

Үг баг нь ОУВС-ийн хувьд үйл ажиллагаанд баримталааг Байгаль орчин, Нийтийн Тогтвортой Байдалд баримтлах Гүйцэтгэлийн стандарт<sup>17</sup> (Performance Standards on Environmental and Social Sustainability) хэмээх баримт бичгийн дагуу нөхөн олговрын асуудлыг хянаж үзээд тайлаа, дүгнэлээг гаргажээ. Гүйцэтгэлийн стандарт нь харилсан уялдаа бүхий 8 бүлэг стандарт байх ба ОУВС-ийн санхүүжилт бүхий төслийдийн бүхий л хугацаанд баримтлах ёстой байдаг. Гүйцэтгэлийн стандарт 5 буюу “Газрыг дайлан авах болон албадан иүүлгэн шилжүүлэлт” гэсэн хэсэгт нөхөн олговрын наад захын стандартуудыг, тухайлбал, нүүлгэн шилжүүлэлтийг зайлшгүй явуулахаар болболов, төсөл хэрэгжүүлэгч тухайн нүүлгэн шилжүүлэлдэж байгаа иргэн буюу хүмүүст алдсан дэс хөрөнгийг нь бүрэн нөхөн төлөх, нөхөн төлбөрийг бусад туслаалцааны хамт олгох ёстой ба энэхүү стандартад заасны дагуу амьжиргаагаа урьдны адил залгуулах буюу сайкруулахад нь туслах ёстой. Нөхөн олговрын стандартын ил тод, тухайн

<sup>14</sup> ОТ ХХК-ийн хувьшавал 66%-ийг Канад улсын бүртгэлтэй “Tropicana Hills Resources” компанийн зүмшиг ботогод үлдсэн 34%-ийг Монгол Улсын төрийн өмчтэй Эрэлжэх Оюу Толгой ХХК узушшиг “Tropicana Hills Resources” компанийн нь Торонторийн Хөөрөнгийн Биржийн хувьшад гаргасан багаад хамгийн том хувьшад эзүүнчийн нийтийн олон улсын түвшний уул уурайн томоологиии компанийн билээ Рио Тинто компанийн болно. Төслийг санхүүжүүлтийн 4.5 тэрбум амдолларыг Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУВС)-ийн санхүүжүүлж буй “А” түрүүн түүл, минь олон улсын ариалын банигуултийн иймийн 1 тэрбум илүүлээр хүртэй “Б” түрүйн эзүүлэс бүрдэвээс. [http://www.caob-ombudsman.org/case/case\\_detail.aspx?id=191](http://www.caob-ombudsman.org/case/case_detail.aspx?id=191)

<sup>15</sup> Өмнөговь аймгийн Статистикийн цэлтийн тоо баримт, 2018 он. <http://www.umin.gov.mn/nuo.mn/uploads/www/76/file/dinamik%202018%20negigele1.pdf>

<sup>16</sup> ЭЗХЗОГ-т албан ёсоор гомдол гаргасан захидал. [http://www.cao-ombudsman.org/caob/document/links/documents/OyuTolgoiCAOCComplaint\\_Oct122012\\_Redacted.pdf](http://www.cao-ombudsman.org/caob/document/links/documents/OyuTolgoiCAOCComplaint_Oct122012_Redacted.pdf)

<sup>17</sup>[https://www.ifc.org/wps/wcm/connect/24e6bbfc-5de3-444d-bc9b-226188c95454/PS\\_English\\_2012\\_Full-Document.pdf?MOD=AJPERES&CVID=jkV-Xoh](https://www.ifc.org/wps/wcm/connect/24e6bbfc-5de3-444d-bc9b-226188c95454/PS_English_2012_Full-Document.pdf?MOD=AJPERES&CVID=jkV-Xoh)

иүүлгэн шилжүүлтийн нөлөөлэлд өртсөн бүхийл хүмүүст таарч тохирсон байх ёстой. Мөн Стандарт 7 ийн Орон нутгийн угуул иргэдтэй холбоотой харилцааг зохицуулсан ба энэхүү стандартад "Ихэнхдээ, нутгийн угуул иргэдийн эднаг засаг, нийэм, эрх зүйн статус нь газар, байгалийн болои сөйлтой холбоотой эрх ашиг, сонирхлоо хамгаалах боломжийн хязгаарлаж байдаг нь тэдний хөгжлийн төслүүдээс үр ашиг хуртэж, оролцож бэрхшээл учруулагдаг байх талтай" гээд энэхүү стандартын зорилго нь хөгжлийн төслүүдийн нутгийн угуул иргэдэл учруулах сэргээллийн нөлөөллийн урьдчилан сэргийлэх, сэргийлэх боломжгүй бол тэрхүү нөлөөллийг багасгах буюу нехөн төлөх шаардлагатай<sup>18</sup> гэжээ. Мөн уг баримт бичигт дурдагдсан хамгийн чухал зарчмын бол төслийн бүхий л хугацаанд төслийн нөлөөллийн өртсөн орон нутгийн иргэдтэй Мэдээлэлтэйгээр Зөвшүүлэх болон Оролцоо (Informed Consultation and Participation) харилцааг хөгжүүлэх, мөн Чөлөөтэй, Урьдчилсан байдлаар, Мэдээлэлтэйгээр Зөвшөөрөл авах (Free, Prior and Informed Consent) зарчмыг баримтлахын чухлыг дурдсан байна. Гэхдээ энэхүү стандартууд 2012 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн буюу 2004, 2011 оны нүүлгэн шилжүүлэлтийн үед хэрэглэгдэх боломжгүй байжээ.

Малчдын зүгээс гомдол гаргасиаас хойш буюу 2013 оны 8 дугаар сараас эхлэн малчид болон төслийн зүгээс хэлцэл хийж, асуудлаа ярилцаж эхэлсэн байх ба энэхүү хэлцэл үргэлжилсээр 2015 оны 6 сард малчид, иргэдийн төлөөлөл, орон нутгийн засаг захиргааг болон ОТ төслийн төлөөлэл бүхий Гурван талт зөвлөлийг албан ёсоор байгуулж, харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсгээ зурсан байна. Тус зөвлөлд орон нутгийн засаг захиргааг төлөөлөн сүмын ИТХ-ын дарга болон засаг дарга, малчдыг төлөөлэн 5 малчин, ОТ төслийг төлөөлэн нийгмийн харилцааны еренхий менежер орсон байх бө зөвлөлийн үйл ажиллагааг ЭЗХЗОГ-ас чиглүүлсээр иржээ. Зөвлөлөөс ЭЗХЗОГ-ийн хяналт

судалгааны ажлыг гүйцэтгэх Олон талт мэргэжлийн шинжээчдийн баг (ОТМШБ)-ийн сонгон шалгаруулах, судалгаа, үзүүлэлтийн ажилд туслацаа үзүүлэх чиглэлд голлон анхаарч ажилласан байна.

Хөндөмчийн шинжээчдийн багийн 2017 оны 1 дүгээр сард олон нийтэд иэлгэлтэй болгосон үзүүлээний эсийн тайланд аих гомдол гаргасан асуудлуудтай холбоотой буюу балчээр, усны чанар, хүртээмжийн үнэлгээ, өнгөрсөн 10 жилийн хугацаанд малчдын хөрөнгө, амьжиргаанд гарсан өөрчлөлтийн дүн: шинжилгээ, Үндэслэл голын өөрчлөлтийн холбоотой томъёлын асуудал зэргүүд багтсанаас гадна нехөн олговортой холбоотой дараах дүгнэлтүүд гарсан байх ба үүн:

1. 2004 оны нехөн олговрын хөтөлбөрт зориудан хийдэсн нөлөөллийн үзлэгээ нь малчад учруудах нөлөөллийг бууруулах Үндэслэл болохоор хангалттай байж чадаагүй. Нууцын шилжүүлэх төлөвлөгөө байгаагүй.

2. 2011 оны нехөн олговрын үндэслэл болсон судалгаанууд, нөлөөллийн үзүүлээнүүд, нүүлгэн шилжүүлэлтийг төлөвлөгөө дийлэнх нь зөхжэй, хангалттай байсан байна. Гэхдээ нөлөөллийн бүсийг тогтоо тал дээр дутагдалтай байснаас нөлөөлэлд өртсөн зарим малчыг тодорхойлоогүй, мөн нехөн олговрын багцын элементүүд тогтвортой байж чадаагүй гэх мэт сүл талууд байна.

3. 2012 оноос хойш төсөлд гарсан өөрчлөлтүүд, бүтээн байгуулалтуудыг одоо байгаа нөлөөллийн үзүүлээнд хамруулаагүй.

4. Нөлөөллийг тодорхойлох аргачлал дутмаг байсан гэдэг нь 2004 ба 2011 оид нехөн олговр олговол зохих байсан малчид байна гэсэн үт. Үүнд, өвөлжөөний лицензийтэй малчдад нехөн олговр авах эрх олгосон шиг хаваржватай эсвэл, балчээр, ус ашиглаж байжныг нотолж болохуйц (гэхдээ гэрчилгээгүй) малчид, нехөн олговрын эрх олгох гортиг шугамын гадна гэхдээ нехөн олговр авсан малчдтай нэг балчээр, худаг ашиглаж байсан малчид, түүнчлэн

<sup>18</sup>Мөн тэнд, Гүйцэтгэлийн стандарт 7. Хуудас 47

ОТ-н нүүлгэн шилжүүлэлтийн улмаас өөрсдийнх нь ашиглаж байсан нутагт нүүлгэн шилжүүлэгдсэн хүмүүсийн улмаас амьжиргаа нь хохирсныг баталж чадах аливаа малчид орно.

5.2004 оны нехен олговрын үйл явц ОУСК-ийн 2012 оны Гүйцэтгэлийн стандарттай олон талаар нийцэгээгүй.

6.2011 оны нехен олговрын үйл явц нэлээд сайжирсан хэдий ч тодорхой хяналт тавиж болохуйц Амьжиргаа сэргээх төвлөгөө байхгүй учир нийцэгээгүй, гэрээг нууцлах зохиустүү заалт оруулсан<sup>19</sup>.

Эдгээр дүгнэлтүүдэд үндэслэн, дараах зөвлөмжийн гаргажээ. Үүнд, нехен олговортой хамааралтай хэсгүүд нь: (i) Гурван талт зөвлөл 2004 ба 2011 оны нехен олговрын хөтөлбөрт гомдолгой байгаа малчдыг нэхэмжлэл гаргах боломжир хангахын тулд Нехен олговрын нэхэмжлэлийн хороо байгуулах, (ii) 2011 оны нехен олговрын хөтөлбөрт аудитийн шалгalt хийлгэж, амьжиргааг сэргээж чадаагүй өрхүүдэл зорилсан хөтөлбөр боловсруулах, (iii) Аудитийн дүгнэлт гаргалдан тохиолддог олон олговор авч байгаа хүмүүст 2011 оны нехен олговрын гэрээгээр олгосон түр ажлын байранд ажиллах боломжийг үргэлжлүүлж олгох, (iv) Бэлчээрийн нийт хүргээж бууруусын төлөр болгож нийтийн нехен төлбөрийн хөтөлбөр хэрэгжүүлэхийг зөвлөсөн зэрэг болно.

Гурван талт зөвлөлийн үйл ажиллагаа явагдаж байгаа ба дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхээр ажиллах эхэлжээ. Нехен олговрын нэхэмжлэлийн хороо байгуулан, малчдын голдмыг барагдуулах гэрээг болон үйл ажиллаганы төвлөгөөг орох нутгийн засаг захиргаа, ОТ, малчдын төлөвлөлтэйтөр байгуулж, 2017 оны 11 сарын 27-ны байдлаар 112 нэхэмжлэлийг хүлээн авч, нэхэмжлэлийн шаардлага хангасан ижэмжлүүдийг шийдвэрлэн ажиллаж байгаа юм<sup>20</sup>. Ийнхүү нүүдэлчин

малчид, уул уурхайн компани, орон нутгийн засаг захиргаа хоорондоо бүрэн тохиролцоонд хүрсэн гэж үзсэн<sup>21</sup> тул ЭЗХНЗОГ ба Гурван Талт Зөвлөлт хөвх албан ёсны уулзалтыг 2019 оны 3 сарын 22-нд Ханбогд суманд, туршлага солиоюу арга хэмжээг 2019 оны 3 сарын 25-нд Улаанбаатар хотоо зохион байгуулж, зуучлан чиглүүлж үйл ажиллагаа дуусгавар боллоо байна.

Нехен олговрын олон улсын стандарт ба сайн туршлагын тухайд

Газрын эрхтэй холбоотой нехен олговрын хувьд олон улсын хэмжээнд мөрдөгддэг олон талт гарээ зэрэг заавал мөрдөгдхөрөө эрх зүйн баримт бичигн байхгүй боловч НҮБ-ийн Хүис, Хөдөө, Аж Ахуйн Байгууллага (FAO)-аас боловсруулсан “Үлс, үндэстний хүнсний аюулгүй байдлын үүднээс Газар, Загас агуулур, Ойн Эзэмшилийн Харнуулагатай Засаглалд баримтлах Сайн дүрийн Зөвлөмж”<sup>22</sup>(2012) нь хүлээн зөвшөөрөгдсөн стандартад тооцогддог. Хэдийгээр зөвлөмж боловч төр болон хувийн хувшилийн байгууллагуудын зүтгээс олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн өмчтэй байх, орон байтай байх эрх, хүрэлцэхүйц түүвнийн амьжиргаатай байх эрх болон Хүний Эрхийн Түгээмэл Тунхагал, Эдийн Засаг, Нийгэм, Соёлын Эрхийн тухай ОУ-ын Пакт, Нутгийн Угуул Иргэдлийн Эрхийн тухай НҮБ-ын Тунхагал зэрэг баримт бичгүүдэд тусгагдсан хүний эрхийн үндэсн зарчим, нормыг тусгасан байдал<sup>23</sup>. Энэхүү зөвлөмжийн шалгур үзүүлэлтүүдийн дагуу 50 гаруй улсад хийсэн судалгаагаар улс орнуудын газрын эзмшил, газрыг дайчлан авахтай холбоотой харилцааг хуульчилсан хууль, тогтоомжуудын

<sup>19</sup> <http://www.caio-ombudsman.org/cases/document-links-links-196.aspx>

<sup>20</sup> The Voluntary Guidelines on the Responsible Governance of Tenure of Land, Fisheries, and Forests in the Context of National Food Security (VGGT) <http://www.fao.org/tenure/voluntary-guidelines/en/>

<sup>21</sup> The Status of National Legal Frameworks for Valuing Compensation for Expropriated Land: An Analysis of Whether National Laws in 50 Countries/Regions across Asia, Africa, And Latin America Comply with International Standards on Compensation Valuation. Nicolas K.Tagliarino. Land 2017, 6,37. www.mdpi.com/journal/land

дийлэх их нөхөх олговрын үнэлгээг тогтоох олон улсын стандарттай ийцсхгүй байгааг тэмдэглэсэн байна. Хөгжлийн байгууллагуудын зүтгэс газар эзэмшилтэй холбоотой харилцааг зохицуулахаар гаргасан норм, стандарттууд нь тухайн байгууллагуудын санхүүжүүлэлт бүхий төсөл, хотөлбөрүүдийн хэрэгжилтэнд хяналт тавих зорилгоогоос гадна хүний эрхийн суурин зарчмуудыг тогтоож байдаг. Тухайлбал, “Газрыг эргүүлэн авах, Газрын ашиглалтанд тавих Хязгаарлалт болон Сайн дурын бус дахин суурьшуулалтанд баримтлах Байгаль орчин, Нийгмийн стандарт 5”<sup>24</sup> (Дэлхийн Банк), “Хөгжлийн үйл ажиллагаанаас үүдэлтэй Нууцгэн шилжүүлэлт болон Гэр оронгийг болоход баримтлах Үндсэн зарчмын ба Удирдамж”<sup>25</sup> (НУБ), ОУСК-ийн Гүйцэтгэлийн Стандарт 5 болон 7 (дээр дурдсан), Азийн Хөгжлийн Банкаас боловсруулсан “Шилжкин суурьшуулалтанд баримтлах гарын авлагы”, “Бизнес ба Хүний эрхийн талаар баримтлах үндсэн зарчмууд”<sup>26</sup> (НУБ) зэргийг дурдаж болно.

Орон нутгийн иргэдийн эзэмшил, өмчлөлийн газрын эрхийг тусгайлсан хуулиар хамгаалсан түршлага олон улсад цөөнгүй байдгас Австралии улсын Натив тайтийн эрхийн тухай буюу нутгийн уутгуул иргэдийн газрын эрхийт баталгаажуулсан (Native Title Act 1993) хуулийг онцлоюн үзвэл зохино. 1992 оныг хүртэл Австралийн хувь тогтолцоожор нутгийн уугуул иргэдийн уламжлал, заншлын хуулийн дагуу тэдний эзэмшиж байсан газар болон устай холбоотой ямар ч эрхийг хамгаалдагтүй байжээ<sup>27</sup>. Муррэй арлын уутгуул иргэд дээд шүүхэд

ижэмжлэл гаргаснаар тус улсын шүүхээс аих удаа Торрес Стрэйт Арлын уутгуул иргэдийн уламжлалт заншлын хувь болон уламжлал нь тэдний газраа өмчлөх эрхийн үндэс байж болохыг хүлээн зөвшөөрснөөр 1993 онд уг хуулийг баталж, 1998, 2007 болон 2009 онуудад нэмэлт, зөрчилтэл оруулжээ. Уг хуулиар Торрес Стрэйт арлын уутгуул иргэдийн газар болон усны талар эзэлж байсан уламжлалт эрхийг хүлээн зөвшөөрснөөр байдал байна.

Нутгийн уутгуул иргэдийн эрхийг хэрхэн хамгаалдаг вэ? Нутгийн уутгуул иргэдийн эрхийг хамгаалах зорилтобр хараат бус, төрөлжсөн шүүх байгуулгадсан байдал<sup>28</sup>. Эрх нь зөрчигдлөө гэж узян шүүхээ нэхэмжлэл гаргасан уутгуул иргэнээс шүүх дараах хөр асуултыг тавьдаг байна. Нэгэ, уутгуул эрхээ хамгаалуулахаар нэхэмжлэл гаргасан уутгуул иргэдийн бүлгийн заншлын хувь болон уламжлалын дагуу тэдний оршин амьдардаг уламжлалт газар нутаг нь тэдний эрх, ашиг сонирхолтой холбоотой юу? Хэрвээ холбоотой гэдэг нь тогтоогдвол, шүүхийн зүтгэс дараах асуултыг тавих ба тэр нь, хэрвээ нэхэмжлэл гаргасан орон нутгийн тухайн газрыг зарах гэх мэтийн үйл ажиллагааг Засгийн газрас явуулбал уутгуул иргэдийн уламжлал, сёйл хэсэгчилсэн болон бүхэлдээ устах аюулаа орохуу? гэж асуудаг байна.

Нутгийн уутгуул иргэдийн эрхийг хамгаалах нөхөх олговор нь эдийн засгийн бус хохирлыг нөхөн төлөхөд төвлөрөх ёстой ба үүнд нийгэм, соёлын үйл ажиллагаанд саад учруулсны төлөөх нөхөн төлбөр, нутаг усаа алдсантай холбоотой сэгтэл санааны хохирлыг нөхөн төлөх зэрэг багтах учирттай<sup>29</sup>. Австралийн уутгуул иргэдийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа зөвхөн хууль, төрөлжсөн шүүхээр хязгаарлагдахгүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг нийгмэлэг, Засгийн газрын дэмжлэгтэйгээр явагддаг судалгаа,

<sup>24</sup> The 2016 World Bank Environmental and Social Standard 5 on Land Acquisition, Restrictions on Land Use and Involuntary Resettlement (ESS5) <http://pubdocs.worldbank.org/en/796881511809516397/ESS5-FactSheet-WB-ESF.pdf>

<sup>25</sup> United Nations Basic Principles and Guidelines on Development-based Evictions and Displacement, 1997, [http://www.hic-sarp.org/documents/Handbook%20on%20UN%20Guidelines\\_2011.pdf](http://www.hic-sarp.org/documents/Handbook%20on%20UN%20Guidelines_2011.pdf)

<sup>26</sup> UN Guiding Principles on Business and Human Rights, Implementing the UN’s Protect, Respect and Remedy Framework. [https://www.ohchr.org/Documents/Publications/GuidingPrinciplesBusinessHR\\_EN.pdf](https://www.ohchr.org/Documents/Publications/GuidingPrinciplesBusinessHR_EN.pdf)

<sup>27</sup> <https://austraproject.com.au/what-native-title>

<sup>28</sup> <http://www.nnti.gov.au/aboutus/Pages/default.aspx>

<sup>29</sup> HOW CAN JUDGES CALCULATE NATIVE TITLE COMPENSATION? Researcher: Paul Burke BA/LLB MLit (Anthropology) [https://nintis.gov.au/sites/default/files/products/discussion\\_paper\\_research\\_outputs/how-can-judges-calculate-native-title-compensation.pdf](https://nintis.gov.au/sites/default/files/products/discussion_paper_research_outputs/how-can-judges-calculate-native-title-compensation.pdf)

шинжилгээний ажлууд болон уутуул иргэдийн хүүхдүүдэд олгодог сургалтын тэтгэлэг зэрэг цогц үйл ажиллагаанаас бүрддэг байна.

## ДҮГНЭЛТ

1. Монгол Улсын Үндсэн хуулиар бэлчээр ашиглах эрхийн ийтигээг эрх ашиг гэж үзэн хамгаалж, нөхөн олговор олгоходоо зохицуулжээ. Гэхдээ газар ашиглах, эзэмших үйл ажиллагаа олон талтай, ялангуяа уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй серог нөлөөллөөс орон нутгийн иргэд, нүүдэлчийн малчдын эрхийг хамгаалах, тэлэнд учрах эдийн застийн хохирлоос гадна байгаль орчин, уламжлалт мал аж ахуй, нүүдэлчин, соёл уламжлалт учирч буй хохирлыг бодитоор үзэлж шаардлагатай.

2. Ашигт малтмалын тухай хуулиар Үндсэн хуулийн нөхөн олговор олгох узэл баримтлалыг явшуулсан гэж үзэх үндэслэлтэй тул иехөн олговрын асуудлаар тусгайсан хууль боловсруулж батлах ийн зүйтэй. Үндсэн хуулийн узэл баримтлалын дагуу нийтээр эзэмшидэг бичлэгийн болон малчдын эзэмшийн өвөлжээ. хаваржааны газрыг шууд болон шууд бусаар эргүүлзи авсан бол нөхөн олговор олгогдох үндэслэлтэй хэдий ч уг асуудлыг нарийвчлан зохицуулсан хууль, журам байхгүйгээс орон нутгийн иргэд, малчдын орон байртай байх, хангалттай хэмжээний амьжиргааны зүйсвэртэй байх, газар эзэмших, ашиглах, эд хөрөнгө өмчлөх, зорчигдсөн эрхээ нөхөн сэргээлгэж нөхөн олговор авах зэрэг олон тооны эрх зорчигдэж байна.

3. Практикт ОТ мэтийн томоохон төслийд нөхөн олговрын асуудалд нааштай хандаж, зохицуулах оролдлого хийж буй нь сайшаалтай хэдий ч энэ нь олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн стандартад бүх талаараа нийцсэн гэж үзж бодомжгүй, хөндөнгийн шинжээчдийн үзүүлээ дүгнэлт зөвхөн санхүүжүүлэгч байгуулагын гүйцэтгэлийн стандартад тулгуурлан, явцуу хүрээнд хийгдсэн болохыг анхаарах хэрэгтэй. Ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагаа явуулж буй доогоод болон гадаадын хөрөнгө оруулалттай бусад компани, төслийдийн хувьд эрх зүйн тодорхой зохицуулалт, стандартгүй улмаас орон нутгийн иргэдийг тохиролцоо хийх, эсвэл өөрсдийн саналыг тулгах байлаараар шийдвэрлэх, нөхөн олговрыг үнэлэхэд компанийн дур зорг давамгайлых, эсвэл орон нутгийн иргэд нөхөн олговор олж авч чадахгүй, эрхээ зөрчүүлж байгаа нь иргэдийн мэдлэг, мэдээлэл дутмаг, орон нутгийн засаг захиргаа чадвас сүл, зохицуулалт хангалттүй байгааг харуулж байна.

4. Газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхтэй холбоотой тулгамдсан асуудлууд, ялангуяа дайчлан авсан газрын нөхөн олговор, газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн асуудал, олон улсын норм стандарт, гадаад орнуудын эрх зүйн эхицуулалт, сайн туршилага зэргийг дэлгэрүүлэн судлах, энэ чиглэлд судалгааны байгууллага, төсөл хөтөлбөрүүд, мөн их дээд сургуулиуд аянхаарлаа хандуулж, салбар дамнасан хандлагаар хандах, судлаачдыг дэмжих шаардлагатай байна.

## БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛСЫН ӨМГӨӨЛӨГЧДИЙН БАЙГУУЛЛАГА



**Монгол өмгөөлөгч ХХН-ийн  
өмгөөлөгч П.Оюун-Эрдэнэ**

### ТҮЛХҮҮР ҮГС:

Өмгөөлөгчдийн байгууллага, өмгөөллийн холбоо, байгууллагын бүтэц, зохион байгуулалт, өмгөөлөгчдийн байгууллагын гишүүнчлэл, өмгөөлөгч, өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа.

### 1. Бүгд Найрамдах Чех Улсын тухай товчхон

Бүгд Найрамдах Чех Улс (Грекэр “Český republiky”, цаашид “БНЧУ” гэх) нь төв Европ тивд байрладаг улс юм. Тус улс нь 1918-1992 онд Чехословак улсын бүрэлдэхүүнд байсан бөгөөд 1993 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр Чехословак улс тайван замаар Бүгд Найрамдах Чех болон Бүгд Найрамдах Словак хэмээх хоёр улс болон хуваагдсан байна.<sup>1</sup> БНЧУ нь 2004 оны 5 дугаар сарын 1-нд Европын Холбооны гишүүн орон болсон. БНЧУ-ын нийслэл хот нь Прага. Мянган тэмдэгт нь Чех крон (когула - CZK) бөгөөд 1 евро ойролцоогоор 25 CZK-той тэнцдэг. Албан ёсны хэл нь Чех хэл болно.

БНЧУ нь газар зүйн байрлалын хувьд эх газраар хүрээлэгдсэн, далайд гаргцгүй бөгөөд баруун хэсгээрээ Герман, өмнөд хэсгээрээ Австри, зүүн хэсгээрээ БН

Словак, хойд хэсгээрээ Польш улсуудтай хиллэдэг. Нутаг дэвсгэрийн хэмжээ нь 78,866<sup>2</sup> хавтай дөрвөлжин километр газар нутагтай. Европын холбооны хамгийн сууриний хүн амийн тооллогоор (2019-10-17-ны байдлаар) БНЧУ нь 10,595,062<sup>3</sup> хүн амтай байна.

### 2. Өмгөөлөгчдийн байгууллагын түүхэн тойм

БНЧУ-ын өмгөөлөгчдийн байгууллагын түүхийг авч үзжээс эмне БНЧУ нь Чехословак улс байсан буюу социализмын чөйчин өмгөөлөгчдийн байгууллагын талаар төв авч үзье. Тухайн үед Өмгөөлөгчдийн төв гэж мэргэжлийн байгууллага байсан ба хэлбэрийн хувьд бие даасан байсан хэдий ч бодит байдал дээр ийн байгаагүй аж.<sup>4</sup> Өмгөөлөгчдийн бүх байгууллагуудыг коммунист намын гишүүд удирдаж, хянах байсан хүнд үед өмгөөлөгчийн хувь хүнийхээ хувь хараат бус байдлыг чухалчилж, өмгөөлөгчийн мэргэжлийн үргээ биелүүлэхийт эрмэлзэж байсан ўюм.<sup>5</sup>

Коммунист дэглэм нуран унасны дараа хуулын мэргэжилд холбогдох шинээтгэлийн хийж, тухайн үед үйлчилж байсан өмгөөллийн хуулийт 1990 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Өмгөөллийн тухай хууль<sup>6</sup> 128/1990 Coll (The Law on Advocacy, Nr.128/1991 Coll) хэмээх нэрээр баталсан<sup>7</sup>. Ийнхүү хараат бус, бие даасан мэргэжлийн байгууллага болох Чехийн

<sup>2</sup> Дэлхийн 195 улс орнуудыг нутаг зэвсгэрийн хэмсэгтэй байр эзлэхэд 115-д бичигдэг байна.

<sup>3</sup> <http://www.worldometers.info/world-population/czech-republic-population/>.

<sup>4</sup> Хуулианд өөрийн удирдлагын байгууллагын тухай ярилцлагат, БНЧУ-ын өмгөөлөгч Владислав Иноусеч, 27-р тал, Хууль эзлэлж ёс, №1 шуварл 16, У6, 2018 он, 27 дахь тал.

<sup>5</sup> Мон тэнд.

<sup>6</sup> Энэхүү хуулийн нэр нь Чех хэлэр “Zákon o advokacií” гэж бөгөөд үүнтэй Англи хэл рүү “The Law on Advocacy” гэж оруулсан байна. ЧӨХ-ны албан ёсны шахим хуудаст “Act on Legal Profession” гэж оруулсан байгаа болон үүнтэй Монголын энэхүү “Өмгөөлөгчийн тухай хууль” хэмсэн хөрвүүлэв.

<sup>7</sup> The Legal profession in the Czech Republic, Dr.iur.Stephan Heidenhain. 2008, Page 2.

Өмгөөлөгчийн Холбоо (англиар “The Czech Bar Association”, чехэр “Český advokátní komora”, шашид “ЧӨХ” гэх) байгуулгасан бөгөөд ЧӨХ нь тус улсын хууль зүйн мэргэжлийн хамгийн том байгууллага юм.<sup>8</sup>

Дашгамд дурдахад, ЧӨХ-ны уггуул нь 1868 онд бий болсон ба тухайн үеийн үйл ажиллагааны хэлбэр нь 1990 оноос хойш буюу одоогийн ЧӨХ-ны эрхэлж буй үйл ажиллагааны хэлбэрт хадгалагдан үлдсэн байна.

### 3. Өмгөөлөгчийн байгууллагын гишүүнчлэл

Чехийн өмгөөллийн тухай хуульд зааснаар БНЧУ-ын нутаг дэвсгэрт хууль зүйн туслацааг өмгөөлөгч болон хувь хүү<sup>10</sup> үзүүлдэг.

Түүнчлэн тус хуулийн 2 дугаар хэсгийн 2-т заасны дагуу дээрх нэр дурдсан этгээдүүд холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тохнолдолд Нотариатын, Тусгай зөвлөөрөлтийг гүйцэтгэгчийн, Patentийн өмгөөлөгчийн, Татварын зөвлөхийн, Хууль зүйн туслацаа үзүүлэх эрхийг тусгай хууль тогтоомжир олгогдсон этгээдийн, Угсэн байгуулгасан хуулийн этгээдийн болон хувь хүнд ажиллаж буй ажилтны. Хоршооны гишүүд эсхүл зэвсэгт хүчиний гишүүдийн, Эрхэлж буй хөдөлмөр, үйлчилгээг үзүүлж байгаа этгээдийн зэрэг үйл ажиллагааг давхар эрхэлж болно.<sup>11</sup>

<sup>8</sup> Чехийн Өмгөөлөгчийн Холбооны албан ёсны шалмын хуудас <https://www.cacl.cz/cz/>.

<sup>9</sup> The Legal profession in the Czech Republic, Dr. iur. Stephan Hedenbäin, 2008, Page 5.

<sup>10</sup> “Хувь зүйн” гэж Европын гишүүн орны иргэн, Европын заны эзслэхийн бүс нутгийн хэлэлцээр иждэх орсон гэрээг улсын иргэн эзслэх. Швейцарийн холбооны иргэн, эзслэх бусад орны байлыгн их оршин сүүг иргэн тэргүүт хамарварна.

<sup>11</sup> Чехийн Өмгөөллийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийг үйл ажиллагаагаа на тус тусдаа хуулийт гэж зассан. Эдгэр нь Act No. 358/1992 Coll. on Notaries and Their Activities (The Notarial Procedure Act); Act No. 237/1991 Coll. on Patent Attorneys, as amended. (Editorial note: replaced by Act No. 417/2004 Coll. on Patent Attorneys and Alteration of the Act to Protect Industrial Property.); Act No. 523/1992 Coll. on Tax Consulting and the Chamber of Tax Advisors of the Czech Republic; Act No. 120/2001 Coll., on Licensed Executors and Execution (the Execution Procedure Act) and Alteration of Some Other Acts түүрх болно.

Тус хуулийн 2 дугаар бүлэгт “Өмгөөлөгч” гэж ЧӨХ-ны өмгөөлөгчийн нэсийн жагсаалтад бүртгэгдсэн, ЧӨХ-д гишүүнчлэлтэй этгээдийг хэлнэ гэж хуулийлсан байна.

Чехийн өмгөөллийн тухай хууль (англиар “The Law on Advocacy”, чехэр “Zákon o advokaci”<sup>12</sup>-д “Өмгөөлөгч” гэж нэр томьёог Чех хэлэр “advokáti” гэсэн байна. Харин ЧӨХ-ны албан ёсны цахим хуудаст тус хуулийн англи хэлнээс орчуулсан хувилбар байгаа бөгөөд уг хувилbart “lawyer” (энэ нь монгол хэлнээ “хуулын”, “өмгөөлөгч” юм) гэсэн нэр томьёогоор хэрэглэсэн байна. Иймээс, “advokáti” нь монгол хэлнээ “өмгөөлөгч”<sup>13</sup> гэсэн нэр томьёогоор орчуулгадаа нь зохицтай.

Чехийн Өмгөөллийн тухай хуульд заасны дагуу “Өмгөөлөгч” нь дараах үйл ажиллагаагаа<sup>14</sup>г эрхэлнэ. Үүнд:

- Бусад байгууллагын өмнө болон шүүхийн өмнөх урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд үйлчилгүүлэгчээ төлөөлэх;

- Эрүүгийн хэрэгт өмгөөлөгчөөр оролцох;

- Хууль зүйн зөвлөгөө өгөх;

- Хууль зүйн дүгнэлт, баримт бичгийн төслийн боловсруулах;

- Бусад хууль зүйн туслацаа үзүүлэх үйл ажиллагаанд оролцох зэрэг болно.

Чехийн өмгөөллийн тухай хуульд “гадаадын өмгөөлөгч” (foreign lawyer)-ийн талаар тус хуулийн 3 дугаар бүлэгт зохицуулалт орсон. Энэхүү нэр томьёо өмнө нь хэрэглэгдэх байсан ба БНЧУ нь Европын холбоонд нэгдэн орсноор “Европын өмгөөлөгч”<sup>15</sup> (The European lawyer) болж өөрчлөгдсөн. “Европын өмгөөлөгч”-ийг дотор нь “зочин Европын өмгөөлөгч” (The visiting European lawyer) болон “бүртгэгдсэн Европын өмгөөлөгч”

<sup>12</sup> Чехийн өмгөөлчийн холбооны албан ёсны шалмын хуудасын Чех хэлтэй буюу эх хэлтэй нь бичигдсэн Өмгөөллийн тухай хуулийн нь авсан болно.

<sup>13</sup> С.Нарангарыч, Монголын эрх түйн эх төлийн бич, Уб., 2015 он, 334 дэх тал. С.Нарангарыч, Орчин үенийн Орос-Монгол хувь түйн тайлбар төлийн бич, Уб., 2017 он, 10 дэх тал.

<sup>14</sup> Чехийн Өмгөөллийн тухай хуулийн 1 дүгээр түйн.

<sup>15</sup> Чехийн Өмгөөллийн тухай хуулийн 2 дүгээр түйн, 5 дугаар зүйлийн б-д.

(The Established European lawyer) гэж ангилдаг ба “зочин Европын ёмгөөлөгч” нь ЧӨХ-оос мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах шаардлагагүйгээр нэг сар хүртэлх хугацаанд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх ёстой<sup>16</sup>. Харин “Бүртгэгдсэн Европын ёмгөөлөгч” нь Хууль зүйн мэргэжлийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан, ЧӨХ-д албан ёсоор бүртгэгдсэн этгээдийг хэнлээ.

2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар ЧӨХ-д 11.883<sup>17</sup> ёмгөөлөгч бүртгэлтэй байгаа бөгөөд ЧӨХ нь бүх ёмгөөлөгчдийг заавал гишүүнчлэлтэй байхыг шаарддаг.<sup>18</sup>

1990 оноос хойш идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж буй ёмгөөлөгчдийн тоо эрс ессен байна.<sup>19</sup> Дараах хүснэгтээс энэхүү ёсөлтийг харна уу.

*Хүснэгт I. Бүртгэлтэй ёмгөөлөгчийн тоо (оноор)*



Чехийн ёмгөөллийн тухай хуулний 36, 37 дугаар зүйл заасны дагуу хууль зүйн мэргэжлээр суралцаж байгаа оюутан буюу “Хууль зүйн мэргэжлийн дадлагажигч” (legal trainee) ЧӨХ-д бүртгүүлж болдог.

Мөн гадаадын компани (foreign company) Чехийн ёмгөөллийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан шаардлагын дагуу ёмгөөллийн үйл ажиллагаа эрхэлж болно.

#### 4. Ёмгөөлөгчийн байгууллагын чиг үүрэг

ЧӨХ нь Прага хотод 1996 онд үүсгэн байгуулагдсан, Чехийн ёмгөөллийн тухай

хуульд өрсөн “No. 555/2004” нэмэлт, өөрчлөлтөөр 2004 онд ЧӨХ-ны салбар нь Брино хотод үүсгэн байгуулагдсан бөгөөд эдгээр төв болон салбар байгууллагууд нь харьялах нутаг дэвсгэрийнхээ хүрээнд ёмгөөлөгч болон Европын ёмгөөлөгчийн нэрийн өмнөс ЧӨХ-ны эрх хэмжээг хэрэгжүүлжийн төлөө сарийшиг агуулж байгууллага юм.<sup>20</sup>

ЧӨХ нь дараах зорилтыг үйл ажиллагаанд даа удирдлага болтодог. Үүдээ:

- ЧӨХ нь ёмгөөлөгчийг этийндээ нэгтгэсэн мэргэжлийн өөрөө удирдах ёсны (self-governing) байгууллага;

- ЧӨХ нь бүх гишүүдийнхээ хүрээнд удирдлагыг хэрэгжүүлдэг мэргэжлийн байгууллага;

- ЧӨХ нь хуудийн этгээдийн эрхтэй байгууллага болно.

Чехийн ёмгөөллийн тухай хуульд заасны дагуу ЧӨХ нь холбогдох дур эм, журам баталдаг, ёмгөөлөгчийн бүртгэл болон бүртгэлээс хасах асуудал, ёмгөөлөгчийн шалгалтыг зохион байгуулах, ёмгөөлөгчийн мөргэжлийн үйл ажиллаганы зөвшөөрөл оптох, түүний мэргэжлийн үйл ажиллагаанд хяналт тавих, ёмгөөлөгчдөд сахилгын арга хэмжээ авах эзрэг үйл ажиллагааг эрхлэн явуулдаг байгууллага юм.

#### 5. Ёмгөөлөгчийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, удирдлага

Чехийн ёмгөөллийн тухай хуулийн 41-р зүйл заасны дагуу ЧӨХ из дараах бүтэцтэй байх бөгөөд шаардлагатай, энэ үзвэл Зөвлөх байгууллага (Advisory body)-ыг нэмж байгуулж болно.<sup>21</sup>

<sup>16</sup> Чехийн ёмгоелийн тухай хуулийн 35 дутгвар зүйлийн j-d

<sup>17</sup> <https://www.caek.cz/en/>.

<sup>18</sup> The Legal profession in the Czech Republic, Dr.iur.Stephan Heidenhain. 2008, Page 5.

<sup>19</sup> The Legal profession in the Czech Republic, Dr.iur.Stephan Heidenhain. 2008, Page 5.

<sup>20</sup> Чехийн ёмгоелийн тухай хуулийн 40 дутгэр түйл.

<sup>21</sup> Чехийн ёмгоелийн хуулийн 41 дутгэр түйлний (b).



ЧӨХ-ны Их хурал дөрвөн жил тутамд хуралаад бөгөөдэл хуралд бүх өмгөөлөгчид оролцох эрхтэй. ЧӨХ-ны Их хурлаар дээр дурсасан бүтэцтэй байгууллагуудын гишүүдийг сонгодог байна.

ЧӨХ-г бүрдүүжж байгаа дээрх бүтэцтэй байгууллагуудын эрх үүрэг, харинуухаас асуудлын талаар төвич авч узье:

**Ассемблей (The Assembly).**<sup>22</sup> Ассемблей нь ЧӨХ-ны эрх барих дээд байгууллага бөгөөд бүх өмгөөлөгчид Ассемблейд оролцох эрхтэй. Тухайн өмгөөлөгчийн өмнөөс бусад өмгөөлөгч түүнийг төлөөлон оролцохыг хуулнаар хориглогдот. Ассемблей өмгөөлөгчийн дундаас шууд, и nuu санал хураалтаар 4 жилийн хугацаатайгаар сонгодог.

Ассемблей нь мэргжлийн дүрэмд заасан ЧӨХ-ны зохион байгуулалтын журам (code of organization), мэргжлийн дүрэм, ЧӨХ-ны нийгмийн болон бусад сангийн дүрэм, өмгөөлөгчийн үйлчилгээний хэлсийн ханш<sup>23</sup> зэргийг

баталдаг байгууллага болно.

Удирдах зөвлөлийн гишүүд (The Board of Directors).<sup>24</sup> Удирдах зөвлөлийн гишүүд нь ЧӨХ-ны гүйцэтгэх байгууллага ба удирдах зөвлөлийн бүрэлдхүүнд 11 гишүү, 5 орлогч гишүүн багтдаг.

Удирдах зөвлөл нь өмгөөлөгчийг ЧӨХ-ны гишүүнчлэлээс хасах, шаардлага хангагчийг хууль зүйн мэргжлийн дадлагажигчдын иэрсний өмгөөлөгчийн бүртгэлээс хасах, өмгөөлөгчийн болон дадлагажигчийн үйл ажиллагаа эрхлэх зөвхөөрлийн түргэлзүүлэх зэрэг шийдвэр гаргадаг.

Удирдах зөвлөл нь ЧӨХ-ны нийгмийн болон бусад сангийн санхүүгийн зарцуулалтын удирдан зохон байгуулалт, ЧӨХ-ны сургалтын боловсролын баримт бичгийн болон хэвлэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал гэх зэрэг ажлыг харинчдаг.

**ЧӨХ-ны холбооны ерөнхийлөгч (The President of the Bar).**<sup>25</sup> ЧӨХ-ны ерөнхийлөгч нь ЧӨХ-ны бүхий л асуудлаар гишүүдийн иэрийн өмнөөс төлөөлөн ажилладаг. ЧӨХ-ны ерөнхийлөгч нь Чехийн Өмгөөллийн тухай хуулийн 18.2-д заасны дагуу өмгөөлөгчийг томилж, мөн хуулийн 18(4)-д заасны дагуу тэдний эрхийг нь хасах; өмгөөлөгчийг орлон ажиллах өмгөөлөгчийг томилох; өмгөөлөгчийн эрх залгамжлажчийг томилох; өмгөөлөгчийн бүртгэлээс иэрийг нь хасуулсанар өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг цуцлах; Хуульд заасан шаардлага хангагчийг дадлагажигч нарын иэрсний бүртгэлээс хасах, Хууль зүйн дадлага хийж буй хуульдийн эрхийг түргэлзүүлж гэх мэт асуудлаар шийдвэр гаргадаг.

ЧӨХ-ны холбооны ерөнхийлөгч нь өмгөөлөгчийн, хууль зүйн мэргжлийн дадлагажигчийн, консорциум, компаниүүд болон гадаадын компанийн талаар Европын өмгөөлөгчдийн бүртгэлд тайлагнагдад.

ЧӨХ-ны холбооны ерөнхийлөгч нь Чехийн Өмгөөллийн тухай хуулийн дагуу

<sup>22</sup> Чехийн Өмгөөллийн тухай хуулийн 42, 43 дугаар заалт.

<sup>23</sup> Comparative analysis of bar associations and law societies in select European jurisdictions, 2017, Page 15.

<sup>24</sup> Чехийн Өмгөөллийн тухай хуулийн 44 дугаар заалт.

<sup>25</sup> Чехийн Өмгөөллийн тухай хуулийн 45 дугаар заалт.

болон бусад дүрмээр хүлээн үргүйнхээ дагуу аливаа асуудалд арга хэмжээ авах, шийдвэр гаргах эрхтэй.

**Хяналтын зөвлөл** (The Supervisory Council).<sup>26</sup> Хяналтын зөвлөл нь ЧӨХ-ны үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлдэг байгууллага бөгөөд ийт 54 гишүүнээс бурддэг. Хяналтын зөвлөлийн даргыг хяналтын зөвлөлийн гишүүдийн дундаас сонгодог.

Хяналтын зөвлөл нь Чехийн Өмгөөллийн тухай хууль болон бусад холбогдох хуульд заасны дагуу ЧӨХ, түүний дэд байгууллагуд, ЧӨХ-ны ажилтнууд, өмгөөлөгчид, европын өмгөөлөгчид, хууль зүйн дадлагажигч нарын үйл ажиллагаанд хяналт тавьдаг байгууллага юм.

**Сахилгын хороо** (The Disciplinary Commission).<sup>27</sup> Сахилгын хороо нь Чехийн өмгөөллийн тухай хууль болон Сахилгын дүрэмд заасны дагуу сахилгын арга хэмжээ авах эрхтэй бөгөөд ийт 83 гишүүнээс бурддэг.

Сахилгын хорооны дарга болон орлогыг бүх гишүүдийн дундаас сонгодог ба сахилгын шийтгэлийн комиссыг тус хорооны гишүүдийн дундаас сахилгын хорооны дараа томилдог.

Давж заалдах **сахилгын хороо** (The Appellate Disciplinary Panel).<sup>28</sup> Давж заалдах сахилгын хороо нь Чехийн Өмгөөллийн тухай хууль болон сахилгын дүрэмд заасны дагуу өмгөөлөгчдөөс сахилгын арга хэмжээ авах эрхтэй бөгөөд 11 гишүүнээс бурддэг.

Давж заалдах сахилгын хорооны гишүүнээр сонгогдохын тулд өмгөөлөгч нь 40 нас хурсэн. Уидрах зөвлөлийн гишүүн болон Хяналтын зөвлөлийн эсвэл Хяналтын зөвлөлийн гишүүнээр 3-аас доошгүй жил ажилласан байх шаардлагыг хангасан байна.

Давж заалдах сахилгын хорооны даргыг мөн л бүх гишүүдийн дундаас сонгож, чөлөөлдөг. Давж заалдах сахилгын хорооны дарга нь Давж заалдах сахилгын хорооны гишүүдийн дундаас сахилгын хорооны комиссыг томилдог.

<sup>26</sup> Чехийн Өмгөөллийн тухай хуулийн 46 дутвар заалт.

<sup>27</sup> Чехийн Өмгөөллийн тухай хуулийн 47 дутвар заалт.

<sup>28</sup> Чехийн Өмгөөллийн тухай хуулийн 47а дутвар заалт.

**Шалгалтын хорооны удирдах зөвлөл** (The Examination Board of the Bar). Шалгалтын хороо нь өмгөөлөгчийн шалгалтыг зохион байгуулдаг. Өмгөөлөгчийн дадлагажигчаар гурван жилийн хугацаатай хөдөлмөрийн гэрээтийгээр ажилласан байх, дадлага хийх хугацаандыа ЧӨХ-ноос зохион байгуулгадаг заавал суух ёстой мэргэжлийн сургалтуудад суух зэрэг шаардлагыг Өмгөөлөгчийн шалгалт өгөх хуульдад тавьдаг. Эдгээр шаардлагыг хангасан токиолдол өмгөөлөгчийн шалгалтанд орох эрх үүснэ.

Өмгөөлөгчийн шалгалт гурван өдөр үргэлжилдэг бөгөөд Иргэний эрх зүй (гэр бүлийн эрх зүй, хөдөлмөрийн эрх зүй багтаасан), Худалдааны эрх зүй, Эрүүтийн эрх зүй гэсэн 3 салбарыг хамрруулсан “бичтийн шалгалт”, мөн таван гишүүдээс бүрдсэн шалгалтын комиссын авлаг “аман шалгалт” гэсэн хэсгүүдээс бурддэг. Аман шалгалтад дээр дурдсан гурван салбар дээр Үндсэн хуулийн эрх зүй, Захиргааны эрх зүй, Өмгөөлөгчийн мэргэжлийн эрх зүй нэмэгдэнэ.

Шалгалтын комиссын тэргүүн нь өмгөөлөгч чайхнаад байх бөгөөд бусад гишүүд нь шүүгч, их сургуулийн багш-судлаач гишүүд байна.<sup>29</sup>

## 6. ДУГНЭЛИТ

Чехийн Өмгөөлөгчийн Холбоо нь өмгөөлөгчийд эгнээндээ иргээсэн, заавал гишүүнчлэлтэй, мэргэжлийн өөрөө удирдах ёсны зохион байгуулалтын бүтэц бүхий хуулийн этгээдийн эрхтэй байгууллага юм.

Бүгд Найрамдах Чех Улс нь 1993 хүртэл социалист системтэй улсуултын нэг болох Чехословак Улс байхдаа тухайн үеийн Өмгөөлөгчийн байгууллага нь улсын харьмааланд байсан бол эдүгээ мэргэжлийн өөрөө удирдах ёсны, төрийн бус зөвхөн өмгөөлөгчийн гишүүнчлэлтэй байгууллагын хэлбрээр үйл ажиллагааны явуулж байна.

<sup>29</sup> Хуулийн өөрдийн удирдаагын байгуулалтын тухай ярилцлага, БНЧУ-ын өмгөөлөгч Владимир Йиоусс, хуусас 31, Хууль дээдлэг ёс, №1 цуврал 61, Уб., 2018 он, 31 дахь та.

## МАНСУУРУУЛАХ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧДЫН ШҮҮХИЙН СЭТГЭЦ ЭМГЭГ СУДЛАЛЫН МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭХ ҮЕИЙН СЭТГЭЦИЙН БАЙДАЛ



СЭМҮТ-ийн ШСЭСК-ийн эрхлэгч, АУ-ны  
магистрант С.Байгальмаа

### ТУЛХҮҮР УГС:

Мансууруулах бодис, гэмт хэрэг, шүүхийн сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ, сэтгэцийн байдал.

### ТОВЧЛОЛ:

Монгол Улсад мансууруулах бодисын хэрэглээ нэмэгдсэнийн улмаас уг төрлийн гэмт хэрэгт холбогдогчдын тоо жилээс жилаа өсч байна. Мансууруулах бодистой холбосотой гэмт хэрэгт холбогдогчдын шүүхийн сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийлгэх үеийн сэтгэцийн байдлыг тодорхойлсон болно.

### Судалгааны ажлын үндэслэл:

Төв мэдрэлийн системийн үйл ажиллагааг цочроож сэтгэцийн хөөрөл, сүүгэлний баясал, хий үзэгдэл буюу бусад солио үүсгэж, эсвэл төв мэдрэлийн системийн үйл ажиллагааг саатвуулж булчнин сулруулах, нойр хүргэх, тайвшруулах зэрэг үйлчилгийг үзүүлэх чадвартай, эмзэлгийн бус зориулалтаар тогтмол хэрэглэвэл эмгэг хэрэгзэг бий болгох чадвахийн эм бодисуудыг сэтгэц идэвхт бодис гэж нэрлэдэг<sup>1</sup>. Мансууруулах бодис мөн

<sup>1</sup> С.Багальмаа. Сүүгийн түгүг судал. Уб., 2013 он, 469 дараа тал.

эсэкийг эмнэлгийн, нийгмийн, хуулийн хэмжүүрээр тогтоодог<sup>2</sup>. Мансууруулах, сэтгэц идэвхт эм бодисуудыг наркотикууд, сэтгэц идэвхт чадвартай сэтгэц нөлөөт бодисууд, олон улсын хяналтанд ороогүй сэтгэц идэвхт бодисууд гэж гурван бүлэгт ангилсан үздэг<sup>3</sup>.

Харин өвчиний олон улсын 10 дугаар ангилалд мансууруулах, сэтгэц идэвхт эм бодисын төрлийг нь харгалzan 10 дэд бүлэг эмгэг болгон хуважээ<sup>4</sup>.

НҮБ-ын Мансууруулах бодис болон гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс 2014 оны байдлаар дэлхий дахинд 15-64 насны 250 сая хүн мансууруулах бодис хэрэглэж байна<sup>5</sup> гэж мэдээлсэн бол 2016 онд 275 сая болсон тухай дурджеэ. Дэлхий даяар хамгийн өргөн хэрэглэгдэг мансууруулах бодисын тоонд каннабис (192 сая хэрэглэгч), амфетамины болон опиоидын төрлийн мансууруулах бодисууд (34 сая хэрэглэгч), экстази (21 сая хэрэглэгч), кокайн (18 сая хэрэглэгч) оржээ<sup>6</sup>.

Мансууруулах, сэтгэц идэвхт эм бодис ба донтолтын Европын хяналтын төвийн 2015 оны тайланд мансууруулах, сэтгэц идэвхт эм бодисын тоо төрөл жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд НҮБ-ын 1961, 1971 оны конвенцын жагсаалтанд орсон мансууруулах, сэтгэц идэвхт эм бодисуудыг оролцуулаад нийт 560 гаруй төрлийн мансууруулах, сэтгэц идэвхт эм бодис байна гэж дурджеэ<sup>6</sup>.

<sup>2</sup> ЭМЯ, НЭМХ, СЭМҮТ, ДЭМБ. Мансууруулах эм бодис ба нийгмийн үзүүл мэнд. Уб., 2016 он, 11 дэх тал.

<sup>3</sup> С.Багальмаа. Мансууруул судал. Нэгдүгээр хэсэг, Уб., 1999 он, 4-5 дэх тал.

<sup>4</sup> Л.Эрэлнүүбэр. Архиалт ба мансууруул. Уб., 2015 он, 123 дараа тал.

<sup>5</sup> United Nations Office on Drugs and Crime. «World Drug Report 2016-web.pdf». New York 2016.

<sup>6</sup> United Nations Office on Drugs and Crime. «World Drug Report 2018-web.pdf». New York 2018.

2013 оны байдлаар дэлхийн нийт гэмт хөргийн 1/5 орчмыг мансууруулах, сэтгэц идэвхт эм бодисын шалтгаант гэмт хэрэг эзэлж байсан байна<sup>7</sup>. Монгол улсад 2014 онд эн төрлийн 62 хэрэгт 144 хүн холбогдон шалгагдаж байсан бол 2018 оны 12 дугаар сарын байдлаар 197 хэрэгт 402 хүн холбогдсон байна<sup>8</sup>.

2011 онд мансууруулах, сэтгэц идэвхт эм бодистой холбоотой гэмт хэрэгт шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийлгэгчийн тоо 11 байсан бол 2018 онд 252 болж ёссэн байна<sup>9</sup>.

2002-2003 онд Тайвань улсад мансууруулах, сэтгэц идэвхт эм бодис хэрэглэдэг гэх өгүүлээмжтэй, гэмт хэрэгт холбогдсон ювер наасныхын дунд хийгдсэн судалгаагаар судалгаанд оролцогсын эшгүүдний 10,3%, эжүүдний 1,7 %, төрсөн ах, эгч, дүү нарынх нь 1,5% нь тус тус мансууруулах бодис хэрэглэдэг гэж харнуулсан байна<sup>10</sup>.

2010 онд БНХАУ-ын метамфетамин хэрэглэгчдийн дунд тамхи татах зан үйл болон никотины хамаарлыг үнэлж судалгаагаар метамфетамин хэрэглэгчдийн 55,4% нь никотины бага ба дунд зэргийн хамааралттай гэсэн үр дүн гарчээ<sup>11</sup>.

Монгол Улсад мансууруулах бодисын хууль бус хэрэглээж жилээс жилд нэмэгдэж байгаатай уялдан уг төрлийн гэмт хэрэгт холбогдогчдын тоо есч байгаа тут мансууруулах бодисын хэрэглээний түвшин, түүнд нөлөөлөх эрсдэлд хүчин зүйлсийг судлах нь иżн чухал хэрэгцээтэй байгаа тут бид энэхүү судалгааг хийх үндэслэл болж байна.

<sup>7</sup> EMCDDA-Europol 2015 Annual Report on the implementation of Council Decision 2005/387/JHA.

<sup>8</sup> Цагдаагийн срөнхий газар, Хар тавихийт тэмзүүгээс газрын дүн мэдээл, 2018 он.

<sup>9</sup> СЭМҮТ, Сэтгэгчийн эрүүл мэндийн статистик үзүүлэлтүүд, үб., 2018 он.

<sup>10</sup> Hsueh-Ling Chang, MD; Sue-Huei Chen, PhD; Chien Huang, MS, Temperament of Juvenile Delinquents with History of Substance Abuse/Original article/. Chang Gung Med J 2007; 30: 47-52.

<sup>11</sup> Ziyun Wang, Bao, Shiyuan Yan, Zhi Lian, Zhenjun Jia. An Investigation of Cigarettes Smoking Behavior and Nicotine Dependence among Chinese Methamphetamine Users Two Provinces / Research Article/. Biomed Research International Volume 2014, Article ID 175205, 9 pages.

Судалгааны зорилго:

Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдогчдын ёмне нь гэмт хэрэгт холбогдсон байдал ба шүүхийн сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийлгэх үеийн сэтгэгчийн байдлыг тодорхойлох;

Судалгааны зорилт:

Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдогчдын ёмне нь гэмт хэрэгт холбогдсон байдлыг тодорхойлох;

Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдогчдын шүүхийн сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийлгэх үеийн сэтгэгчийн байдлыг тодорхойлох.

Судалгааны ажлын ёс зүй:

АШҮҮЧС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын корононы 2017 оны 05 дугаар сарын 19-ийн өдөр хурлын шийдвэрээр судалгааг хийх ёс зүйн зөвшөөрөг авсан /Дугаар №2017/3-07/. СЭМҮТ-ийн Шүүх сэтгэц эмгэг судлалын кабинетэд мансууруулах, сэтгэц идэвхт эм бодистой холбоотой шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийлгэгчдэд судалгааны ажлын зорилго, судалгааны ажлын талаарх мэдээллийн таницуулж судалгаанд оролцохыг зөвшөөрсөн оролцогиоос судалгааг авсан.

Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн ба арга зүй:  
Судалгааны загвар:

Үг судалгааг дескриптив судалгааны загвараар чанарын судалгааны аргаар (асуумж, эмнэлзүйн үзлэг, тусгай сорил, ярилцлагы болон баримтын судалгаа) тусгайлан боловсруулсан карт ашиглаж судалгааны мэдээлэл болои баримтыг цуглуулсан.

Судалгааны хамрах хүрээ:

Судалгаанд 2017 оны 08 дугаар сарын 01-ийн өдрөөс 2018 оны 02 дугаар сарын 01-ийн өдрийг хүртэлх хутгацаанд буюу б сарын хутгацаанд СЭМҮТ-ийн Шүүх сэтгэц эмгэг судлалын кабинетд мансууруулах, сэтгэц идэвхт эм бодистой холбоотой шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээ хийлгэгчдийг хамруулсан

бөгөөд судалгааны шалгуурыг хангасан 106 оролцогчоос судалгааг авсан.

#### Судалгааны ажлын зарим үр дун:

Бидний судалгаанд 18-41 наасны, эрэгтэй 94, эмэгтэй 12, нийт 106 оролцогч хамрагдсаны 99,1% нь Улаанбаатар хотын харьяалалтай, дундаж нас нь  $24,5 \pm 6,1$  байлаа.


#### Гэмт хэрэгт холбогдсон байдал

##### Хүснэгт 1.

| Мансууруулах бодис                                      | Бодит тоо | Хувь |
|---|-----------|------|
| Хэрэглэсэн  | 49        | 46.2 |
| Хадгалсан   | 7         | 6.6  |
| Худалдаалсан  | 2         | 1.9  |
| Хадгалсан, хэрэглэсэн                                   | 19        | 17.9 |
| Хэрэглэсэн, хадгалсан, худалдаалсан                     | 2         | 1.9  |
| Хэрэглэсэн, бэлтгэсэн, хадгалсан                        | 16        | 15.1 |
| Бэлтгэсэн, хадгалсан                                    | 9         | 8.5  |
| Хувь бусар гадаллас оруулж ирсэн, хадгалсан, хэрэглэсэн | 2         | 1.9  |
| Нийт  | 106       | 100  |

Судалгаанд хамрагдагсдын 49 буюу 46.2% нь мансууруулах бодис хэрэглэсэн, 19 буюу 17.9% нь мансууруулах бодис хадгалсан, хэрэглэсэн, 16 буюу 15.1% нь мансууруулах бодис хэрэглэсэн, бэлтгэсэн, хадгалсан гэх хэрэгт холбогдсон байв.

##### График 1.




Судалгаанд хамрагдагсдын 20 буюу 18.9% нь өмнө нь гэмт хэрэгт холбогдож байсан гэж харилсан.

##### График 2.




Тэдгээрийн 12 буюу 60% нь өмнө нь мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдож байжээ.

#### График 3.



Судалгаанд хамрагдагсдын 51 буюу 48.1% нь мансууруулах бодисыг "Нэг удаа" хэрэглжүүлж үзсэн, 16 буюу 17% нь "Хөөр удаа" хэрэглжүүлж үзсэн, 28 буюу 26.4% нь "Гурав ба түүнээс дээш удаа" хэрэглж байсан, 10 буюу 9.5% нь "Хэрэглэж байгаагүй" гэсэн харилту өгчээ.

##### График 4.



Судалгаанд хамрагдагсдын шүүхийн сэтгээц эмгэг судалын магадлан шинжилгээ хийлгэх үеийн сэтгээцийн байдлыг тодорхойлоход гэмт хэрэгт холбогдсон улмаас 36 буюу 34% нь "Сэтгэл түгшилттэй", 30 буюу 28.3% нь "Айлас, сэтгэл түгшилттэй", 8 буюу 7.5% нь "Айдастай", 4 буюу 3.8% нь "Бухимдалтай" байсан бол 28 буюу 26.4% нь гэмт хэрэгт холбогдсон ч гэсэн "Сэтгэл санаа хэвний байна" гэж харилсан.

#### ДҮГНЭЛТ

Судалгаанд хамрагдагсдын 49 буюу 46.2% нь мансууруулах бодис хэрэглэсэн, 19 буюу 17.9% нь мансууруулах бодис хадгалсан, хэрэглэсэн, 16 буюу 15.1% нь мансууруулах бодис хэрэглэсэн, бэлтгэсэн, хадгалсан гэх хэрэгт холбогдсон байсан бөгөөд уг судалгаанд хамрагдагсдын 20 буюу 18.9% нь өмнө нь гэмт хэрэгт холбогдож байсан гэж харилсан. Тэдгээрийн 12 буюу 60% нь өмнө нь

mansuuruulaх бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдох байснаас үзжэд mansuuruulaх бодисын хэрэглээний улмаас давтан гэмт хэрэгт үйлдэх явдал бий болоод байгааг харуулж байна.

Судалгаанд хамрагдгасдын шүүхийн сэтгэц эмгэг судалын магадлан шинжилгээ хийлгэх үсийн сэтгэцний байдлыг тодорхойлоход гэмт хэрэгт холбогдоно улмаас 36 буюу 34% нь “Сэтгэл түгшилттэй”, 30 буюу 28,3% нь “Айдас, сэтгэл түгшилттэй”, 8 буюу 7,5% нь “Айдастай”, 4 буюу 3,8% нь “Бухимдалтай” байсан бол 28 буюу 26,4% нь гэмт хэрэгт холбогдоно ч гэсэн “Сэтгэл санаа хэвний байна” гэж хариулсан. Үүнээс үзвэл mansuuruulaх бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдоно улмаас 78 буюу 73,6% -д нь сэтгэл зүйн харин урвалууд болох “айдас, сэтгэл түгшилт, бухимдал”-ын шинж тэмдэг илрөч байсан. Харин 28 буюу 26,4% нь гэмт хэрэгт холбогдоно ч гэсэн “Сэтгэл санаа хэвийн байна” гэж хариулсан нь анхаарал татах байлаа.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Mansuuruulaх бодисын I-2 удаагийн хэрэглээгээр хүчтэй хамаарал үүсч болдог. Учир нь зарим төрлийн mansuuruulaх бодис архи, согтууруулах ундаанаас 60-100 дахин илүү хүчтэйгээр донтуулах үйлчилгээтэй байдал. Иймд mansuuruulaх бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдохгчдыг давтан гэмт хэрэгт холбогдох асуудлаас урьдчилан сэргийлж чиглэлээр Эрүүл мэндийн, Хуулийн болон Боловсролын байгууллагууд зөвлөлдөх уулзалт хийж тодорхой шийээлдэх хурч хамтран ажиллах;

Mansuuruulaх бодистой тэмцдэг төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ерөнхий боловсролын сурагчид, нь дээд сургуулийн оюутнууд, албан байгууллагуудад болон бусад зорилтот бүлэгт mansuuruulaх бодис хэрэгжээс урьдчилан сэргийлж чиглэлээр үе шаттай үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар явуулах;

Цаашнд ЦЕГ, ТЕГ, ДХИС, СЭМҮТ болон бусад байгууллагууд хамтран mansuuruulaх бодис хэрэглэгчдийн судалгааг үндэсний хэмжээнд зохион байгуулах шаардлагатай байна.

---000---

## ТАТВАР ТӨЛӨХӨӨС ЗУГТАХ ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ ШИНЖ



ХУИС-ийн ахлах багш С.Ренцендорж,  
өмгөөлөгч О.Чулуунцээг

### ТҮЛХҮҮР ҮГС:

Гэмт хэрэг, татвар төлөхөөс зугтах,  
татварын залилан, татвар төлөхөөс  
зайлсхийх, гэмт хэрэг төгсех

### ТОВЧЛОЛ:

Улс орны хөгжил үсрэнгүй болох  
тусам нийгэм өргөжин тээж, шинэ төрлийн  
гэмт хэргүүд оноор бий болсоор байна.  
Гэмт хэргийн төрөл, үйлдэгдэх шинж чанар  
нь улам нарийч, тэднийг танин судлах,  
илрүүлэх явдал мэргэжлийн ойлголтыг  
батжуулахад хүрчээ. Өөрөөр хэлбэл,  
шинижлэх ухааны тувшинд гэмт хэргийн  
шинж, төрлийг авч үзэн түүнээс урьдчилан  
сэргийлэх болдит боломжуудыг эрж хайх  
шаардлага тулгарсан.

Эрүүгийн гэмт хэргээс татварын  
гэмт хэрэг нилээд онцлог, санхүүгийн  
нарийн мэдлэг шаардсан, үйлдэгдэх хэлбэр  
ниль далд мэргэжлийн тувшинд хийгддэг  
онцлог шинжтэй.

Иймээс татварын гэмт хэргийн  
ерөнхий ойлголт, нэр томъёоны онцлог  
ялгаа, гэмт хэргийн төрөл, хэлбэр, гэмт  
хэрэг төгсех үйлдлийг тодорхойлох ёстой.

### 1) ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ, ТҮҮНИЙ ҮНДСЭН ШИНЖ

Гэмт хэрэг буюу зөрчил гэсэн  
ойлголтыг ялан авч үзэх нь зүйтэй юм.  
Монгол Улсын хуулиар хууль, захиргааны  
хэм хэмжээний актыг зөрчсөн, хуульд  
шийтгэлэг оногуулахаар заасан үйлдэл, эс  
үйлдэхүүн улмаас хохирол, хор уршиг  
учирсан бол гэмт хэрэгт тооцино гэжээ. Гэмт  
хэргийн шинжийг ийхиүү тодорхойлоходоо  
эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт  
хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд,  
эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн  
болон үзүүслэний ашиг сонирхол, аюулгүй  
байдал шууд учирсан үр дагаврыг гэмт  
хэргийн хохиролд тооцох ба харин гэмт  
хэрэг үйлдэж хохирол сууруулсын улмаас  
үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор  
уршигт тооцино. Тухайлбал, гэмт хэргийн  
улмаас учирсан хохирлын хэмжээг их  
хэмжээний хохирол<sup>1</sup>, үлээмж хэмжээний  
хохирол<sup>2</sup>, бага хэмжээний хохирол<sup>3</sup> гэж  
ангилсан.

Гэмт хэрэг үйлдэгдэх явцад  
учирсан хохирол, хор уршигийн хэмжээ  
тодорхойлогодох хэдий боловч гэмт хэрэг  
үүсэх учир шалтгааны илрүүлэх нь  
нэн чухал байdag. Нэг хэсэг эрдэмтэд нь  
гэмт хэргийн шинж чанар, нийгмийн хор  
аюулын зэрэглэлийг тогтоож, хохирогчийн  
зүгээс түүнд хэрхэн хандаж байгааг ойлгок  
мэдэх, хохирох явдлын эрсдэллийг үнэлж  
цэгнэх, гэмт хэргийн улмаас учирсан  
хохирлын шинж чанарын үзлэх, хохирогч  
ба гэмт этгээдүүдийн хоорондын харилцааг

<sup>1</sup> Их хэмжээний хохирол – тавин мянган ижигтэй тэнцх  
хэмжээний төгрөг, түүнээс дэвших хэмжээ.

<sup>2</sup> Үзүүлж хэмжээний хохирол – арван мянган ижигтэй тэнцх  
хэмжээний төгрөг, түүнээс дэвших хэмжээ.

<sup>3</sup> Бага хэмжээний хохирол – түрван түүн ижигтэй тэнцх  
хэмжээний төгрөг, түүнээс дэвших хэмжээ.

судлах хэрэгтэй гэж үздэг<sup>4</sup> бол нөгөө иэт хэсэг эрдэмтэд нь .... хохирох эрдэл нь био сэтгэц, ийнхийн үзэгдэл болох нь, гэмт хэргийн улмаас хохирсон этгээдүүдийн тоо чанарын үзүүлэлт, хохирих явдлын уг сурвалж, гарвал, түүнийг үүсгэж байгаа нехцэл байдал, гэмт хэрэгтэн ба хохирогчийн харилцааны мөн чанар ба зүй тогтол, гэмт халдлагас хохирогчийг хамгаалах арга хэлбэр, хохирлыг арнлагах журам зэргийг харгалзан үзэхийг зөвлөдөг байна<sup>5</sup>.

Сүүлийн үед хөгжингүй орнуудад гэмт хэргийг илрүүлэхдээ дараах нехцел байдлыг тодруулахыг шаардах болсон. Үүнд:

» Гэмт хэргийн нехцэл байдлыг шинжлэн судлахад хуулийн мэргэжлийн байгууллага оролцооос гадна гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нехцелийт нийгмийн сэтгэл судлаач, хувь хүний төвөлшил, зан араншиг тодорхойлохдоо сэтгэл зүйл нарыг тус оролцуулан тухайн хэргийн нехцэл байдала дүгнэлж гаргуулах;

» Гэмт хэрэг үйлдсэн, хохирсон этгээдийн нийгмийн шинж байдал, хэрэг үйлдэх чадвар, үйлдэгдсэн газар, хэргийн хугацаа, хэргийн нехцэл байдалд нөөөлөх хүчин зүйл зэргийг баттаж тогтоо;

» Гэмт хэргийн шалтгаант холбоо, үйлдэгдсэн хэлбэр, гэмт хэргийн төрөл, хүлээлгэх хариулагыг зөв зүйлчлэх;

» Гэмт хэргийн улмаас учирсан хохиrol, хор уршиг тодорхой болгох;

» Тухайн гэмт хэрэг үйлдэгдээнийг хэрхэн нотлох, нотлох баримтыг хангальттай, хөдөлшгүй байдлаар батгалгаажуулах;

» Төрөлжсөн байгууллага, судлаач, мэргэжилтийэр хэрэгт холбогдолтой асуудлуудад мэргэжлийн дүгнэлт гаргуулах гэх мэт.

Гэмт хэрэг нотлогдох хүртэл гэм бурууугүй байdag ба гэмт хэргийт үйлдсэн нь **баламжит эргэлзэгүйгээр** нотлогдсон байхыг шаардах болсон. Боломжит эргэлзэгүй байдлыг алдаатай баримтанд

суурilan шийдвэр гарган эрдээлийт бууруулах анхдагч аргачлал гэж үзж болох юм. Манай улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1-р зүйлийн 1.15.2-т “Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллаадгач, шүүгдэгчийн гэм буруутай эсэхд, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хууль. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд ашигтайгаар шийдвэрлэн”, мөн тус хуулийн 36 дугаар зүйлийн 36.2.3-т “Шүүхийн шийдвэр нь тодорхой, ойлгомжийт, түүнийг биенгүүлжээд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байхар бичигдсэн байна” гэсэн заалтаас үзэж нотлох баримт эргэлзэгүй байх ёстойг гэсэн шинжийг тодорхойлсоор байна.

## 2) ТАТВАРЫН ГЭМТ ХЭРЭГ, ЗҮЙЛЧЛЭЛИЙН ЯЛГАА

Татварын эрх зүйн зохицуулалт болох татварын тухай хуулийг зөрчсөн үйлдэл нь давхар гэмт хэрэгээ үйлдэл ба хор уршиг, үр дагаварын хувьд ноцтой бол тусгайлан эрүүгийн хариулага хулээлгэх үйлдлийг гэмт хэрэг гэж үздэг байна.

Татвар төлөхөөс зугтахыг улс орнууд гэмт хэрэг гэж үздэг байна. Уг гэмт хэрэг ийн татвар төлөхөөс зугтах (уклонение от уплаты налогов buoy tax evasion)<sup>6</sup> эсвэл татварын залилан (tax fraud) гэсэн ойлголттой холбоотой юм.

Татвар төлөхөөс зугтах нь ихэнхдээ гэмт хэргийн шинжтэй бөгөөд хууль тогтоомжийн заалтыг урьдаас мэдэж байдаг<sup>7</sup> ба мэдсээр байж хууль зөрчин үйлдэгдэг байна. Өөрөөр хэлбэл татвараас зугтах үйлдэл нь татварын үүргээ бүрэн биенгүүлэгүйгээс хууль зөрчин татвараас төлөхгүй эсвэл хэт бага хэмжээгээр төлөхийг хэлнэ. Энэ нь төлөх ёстой татвараас төлөөгүй тохиолдолд тухайн этгээдээ татвар төлөх үндсэн үүргээсээ

<sup>4</sup> Freda Adler, Gerhard O.W Mueller, William S.Laule, Criminology. New York, 1995. p.397.

<sup>5</sup> Полубинский В.Ив Правовые основы учения о жертве преступления, М.,1979. с.28.

<sup>6</sup> Victor Thuronyi. Comparative tax law. Kluwer law international. Great Britain, 2003. p.223

<sup>7</sup> Непелев С.Г. Налоговое право. Юристъ. М.:2003. с.575.

зориуд санаатайгаар зайлсхийж буй хууль бус үйлдэл юм. Үүнийг татвар төлөхгүй байх нь өөрөө хууль бус, ёс зүйтгүй үйлдэл байдаг гэж тайлбарлаж болох юм. Ёс зүй бол зан суртахууны зарчим бөгөөд ёс зүйт төлөвшүүлснээр татвар төлөх үүргэ бүрэн хэрэгжих боломжтой ба зөв үйлдлийн илрэхийлэл болно. Тухайлбал, татварын тайлангаа хуулийн хугацаанд гаргаагүй ба зохиц байгууллагад тушаагаагүй, татварыг нуун дарагдуулах болон орхигдуулах замаар санхүүгийн бүртгэл хөтлөөгүй буюу санхүүгийн баримтас зохих ёсоор бүрдүүлэгтэй, татвараа буруу тодорхойлон тайлагнасан, орлого зарлагаа хуурамчаар бүртгэсэн, орлого тайлагнахгүйгээс гадна хуулиар зөвшөөрсөн бус байдлаар зардлаа тайлагнах, татвар болон татварын өөрөө төлөхгүй байх, хуурамч баримт бүрдүүлж худал мэдүүлэх, хуурамчаар буцаан олголт авах тооцог хийсэн, хуурамч алниваа нэгжийн изр дээр данс нээх гэх мэт.

Харин татварын залилай<sup>8</sup> гэж хэн нэгэн этгээд татвар ногдуулах үйл ажиллагаанд болон төлбел зохих төлбөрөөс ямар нэгэн байдлаар зориул санаатайгаар зайлсхийн оролдлого хийх үйлдлийн ойлгоно. Тухайлбал, татварын залиланийн шинжийг авч үзээл үйлдэх боломж бүрдсэн байх, татварын хуулийн хэрэгжилгэнд саал учирнуулах, татвар төлөх үүргээ биелүүлэхгүй ба татвараа зориул санаатайгаар төлөхгүй байх, татварт ногдуулах орлогого тодорхойлохыг хүснэггүй санаатай орхигдуулах, хуuran мэдлих зорилгоор ашигийн зохицуулалт хийх, данс бүртгэл ба холбогдох баримтуулж хуурамчаар үйлдэх, няялтиан бодох бүртгэлийн зарчмыг санаатай буруу ашиглах, нуун дарагдуулах буюу халхавчлах чадвар илүү байх зэрэг хууль бус үйлдэл хийхийт завдахыг оролддог байна. Харьцангуй бага хэмжээний мөнгөн дүнгээр мэдэгдэн илрэч байгаа ч хуурамч байдлыг бий болгон үүсгэн татварын залилан үйлдсэн бол эрүүтийн ял оногдуулах үндэслэл болдог.

<sup>8</sup> Internal Revenue Service tax code. In America. §7201.

Иймд татвар төлөхөөс зугтах буюу татварын залилангийн шинжтэй үйлдлийг гэмт хэргийн шинжтэй хууль бус үйлдэл буюу татварын орлогыг бодит бусаар худал буюу буруу хэлбэрээр төлөх үйлдэл гэж үзэн эрүүтийн хариушагаа ба бисэр ял эдлүүлэх шийтгэлийг улс орнууд оногдуулдаг байна.

Татвараа төлөхөөс зайлсхийх (обход налогов буюу tax avoidance) нь эдийн засгийн тодорхой зорилго, ашиг сонирхолд нийцүүлэхийн тулд татварын бүртгэлийн тодорхой үйлдэл, тооцоололдоо зохих ёсоор хуулийн дагуу тооцох үйлдлийг хийх боловч шууд буюу шууд бус аргаар дамжуулан татварын хэмжээг багасгах үйлдэл юм. Өөрөөр хэлбэл санхүүгийн төвлөвлөтийн арга барилд үндэслэн үе штагтайгаар татвар төлөх үүргээ хуулийн дагуу багасгай мэдэгдэх ба хувийн санхүүгийн нэхцэл байдалдаа төлөх ёстой орлогын татварын хэмжээг багасгах бууруулан өөрчлөх замаар хуулийн дагуух аргачлалын ашиглагхыг хэлнэ гэсэн уг.

Татвар төлөхөөс зугтах нь татварын хуулийн бүхэлд нь зөрчсөн үйлдэл буюу орлогого тайлагнахгүйээр хууль бус аргаар татвар төлөхөөс зайлсхийдэг бол татвараас зайлсхийх нь хэлбэрийн хувьт татварын хуулийг зөрчөөгүй боловч хуулиар татвар ногдох зүйлийн үндсэн шинжийг өөрчилж, татвар ногдуулах нөхцөлийг тойруу замаар хуульд заасан үндэслэлээр зөвшөөрөгдсөн аргаар зайлсхийээр өөрчлөн үйлдсэн<sup>9</sup> гэдгээрээ ялтагддаг байна. Татварын гэмт хэрэгт татвар төлөхөөс зугтсан, орлогын нууснаас гадна татварын хэргийг илрүүлэхэд саад болсон, татвараас зугтаж болоцоо олгосон этгээдүүд хамаардаг байна.

Татвар нуух (tax shelter) гэдэг нь татвар ногдуулах орлогынкоо хувийг багасгах буюу бууруулах зорилгоор хийж буй хуулийн арга юм.

Татварын гэмт хэргийг илрүүлэхийн тулд мөрдэн шалгах ажиллагааг үндэсний болоод олон улсын түвшинд зохион байгуулахыг улс орнууд эрмэлзэсээр байна. Тухайлбал, Татварын хэргийн

<sup>9</sup> БНСУ-ны Татварын гэмт хэргийг хүзүүлэхгээ хариушагын тухай хуулийн 3-р бүлгийн 1-р хэсг. 1951 он.

талаарх мөрдөн шалгах байгууллагын шийдвэр нь мөрдөн шалгах байгууллагын мэдэлд зөвхөн бичтийн хэлбэрээр байна. Гагихүү зөвтөсөн нөхцөл байдал байгаа тохиолдолд мэдээллийг талууд амаар өгөх эрх үүснэ. Ингэхдээ мэдээллийн нууцыг хамгаалахад анхаарал хандуулах шаардлага үүсч болно. Шинж чанараараа нууц, эсхүл нууцлах үндсэн дээр шилжүүлж өгсөн аливаа мэдээллийг эрх бүхий байгууллага үндэслэлийн дагуу нууц гэж үзэх ёстай байдал. Мэдээллийг шилжүүлж өгсөн талын зөвшөөрөлгүйгээр задруулж болдоггүй билээ гэжээ. Мөн хөдөө аж ахуйн тухай хэзэлцээрийн 13 дугаар зүйлд “1994 оны Тариф, худалдааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйл болон Татаасын хэзэлцээрийн V хэсгийн дагуу хөхирол, эсхүл түүний заналхийлэл тогтоогоогүй бол саармагжуулах татвар<sup>10</sup> ногдуулаас чөлөөлгөдөх аливаа саармагжуулах татварыг нэвтрүүлэхтэй холбогдсон мөрдөн шалгах ажиллагааг эхлэж зохиц ёсоор хүлээндэг хандаж ёстой” гэсээс гадна эцсийн саармагжуулах татварын хэмжээ нь менгэн барьцаа болон ерийн үргээр баталгаажуулсан дунгээс их байвал тэдгээрийн хоорондын зөрүүг хураан авдаггүй. Харин эцсийн татварын хэмжээ монгөн барьцаа болон ерийн үргээр баталгаажуулсан дунгээс бага байвал илүү дунг буцаан өгөх, эсхүл ерийн үргийг аль болох богино хугацаанд хэрэгсэж болгох боломжтой болгод байна. Түүничлэн татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэллэлцээрийн 12 дугаар зүйлд “Ашиг сонирхол нь хөндөгдж байгаа Гишүүд болон саармагжуулах татварын мөрдөн шалгalt хийлгэх сонирхолтой байгаа талд мөрдөн шалгах байгууллагад шаардлагатай байгаа мэдээллийн тухай мэдэгдлийн илгээх бөгөөд тэдгээрийн үзэж байгаагаар дурдсан мөрдөн шалгалтад холбогдолтой бүх нотолгоог бичгээр ирүүлэх боломж олгоно. Нууц мэдээллийг хамгаалах тухай шаардлагыг бодолцон

<sup>10</sup> Аливаа барьсаны үйлдвэрлэл, боловсруулалт, эсхүл экспортод шуул болон шудаа бусав оплож буй татавсыг саармагжуулах зорилгоор ноглуулж буй тусгай татварыг саармагжуулах татвар гэнэ.

сонирхолтой нэг гишүүн, сонирхолтой талын бичгээр ирүүлсэн нотолгоог сонирхолтой бусад гишүүн, эсхүл мөрдөн шалгалтад оролцож байгаа сонирхолтой талд нэй даруй хүргүүлийн” гэж заасан ба сүлжмэл, нэхмэл эзэл болон оёмол бүтээгдэхүүний тухай хэлэлцээрийн 5 дугаар зүйлд “Зайлсхийн гэдгийг нотлоход хангальтай баримт нотолго нь мөрдөн шалгасны үр дүнд гарч ирсэн бол тэндээ нь: бааралын гарал үүслийн хийнхэн орон, газар, хэгээд зорилтуулсан шийдвэрээр татварын нөхцөл байдлын талаар нотлох баримт илэрсэн бол” үг асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай зүй зохистой арга хэмжээ авна гэж гишүүд тогиролцов” гэсэн нь мөрдөн шалгах ажиллагааны цар хүрээ, хэрэгжилт нийлэд нарийн ур чадвараар Мэргэжлийн ондөр тувшинд тодорхой шалгуураар шийдвэрлэгдэг байна.

Татварыг гэмт хэрэг гэж үзэх эрүүгийн хэрэг үүсгэх нөхцөл шалтгааны талбарын орнууд туршилагыг товч дурдвал:

► АНУ-д Сангийн яамны харьяа татварын хэрэг бүртгэх алба ажилладаг ба холбооны цагдаагийн байгууллага татварын орлоготой холбогчтой зүйлийг мөрдөх эрхгүй, зөвхөн утганаан татварын гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс мөрддэг байна. Татварын хэргийг холбооны шүүх болон татварын шүүхээр авч хэлэлцдэг. Ингэхдээ татварын шүүхээр шийдвэрлэгдэх яицад хуурамж баримт бүрдүүлэсэн, худал мэдүүлэг өгсөн нөхцөлд хэрэг бүртгэл дахин явагдж эрүүгийн хэргийн шүүхээ шилжигдэн шийдвэрлэгдэг байна.

► Япон улсад Сангийн яамны гадаад салбарыг татварын алба харьялагдаж, үндэсний татварын албаны эрүүгийн мөрдөн байцаах хэлтэстэй бөгөөд татварын хийштэй шалгалтын тасаг буюу мөрдөн байцаалтын тасаг гэсэн бүтэцтэй ажилладаг. Эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд завал хуульч байхыг шаардлагатай ажилдаа ур чадвартай, олон жил үр бүтээлтэй ажилласан туршилагатай хүмүүсээс шалгаруулж эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажилд томилдог. Татварын хэргийг шалгахдаа хуульд зааснаар 8 сар саармагжуулах татвар гэнэ.

хүргэл хугацаанд хэрэг бүртгэлт явуулж шууд прокурорт шилжүүлдэг. Хэрэг бүртгэлийн явцад үндэсний татварын алба нь Хууль зүйн яам болон Дээд шүүхтэй харилцагаа ба бусийн болон орон нутгийн татварын алба нь орон нутгийн шүүхийн байгууллагатайгаа хамтран хуулийн дагуу тэгзэртэй зөвшүүлэн ажилладаг. Хэрэг бүртгэгч нь эрүүтийн хэрэг үүсгэдэггүй ба шаардлагатай нотлох баримтыг цуглувуж прокурорт шилжүүлэв. Прокурор хянах үзээд яланы дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлдэг. Татварын хэрэг дээр узлэг, нэгжлэг явуулах, хөрөнгө хураах, байцаалт явуулахдаа “Үндэсний татварын зөрчлийн хяналтын тухай хууль”-ийн дагуу заавал шүүхээс зөвшөөрөл авч гүйцэтгэх журмыг баримтлагдаг байна.

► Манай татварын алба нь 1995 оноос эхлэн татварын байгууллагын дэргэд цагдаагийн гэрээт тасаг<sup>11</sup> буюу хэрэг бүртгэх тасаг<sup>12</sup> байгуулж байсан. Уг алба нь татварын хууль тогтоомж зөрчсон, татвар төлөхөөс зайлсхийсэн буюу татвар ногдох орлогго иуусан үйлдэлд эрүүтийн хэрэг үүсгэн хэрэг бүртгэлт явуулж цагдаа, прокурорын байгууллагад шилжүүлдэг байжээ<sup>13</sup>. Үйлмаар хэрэг бүртгэлийн албыг цагдаагийн байгууллагатай иртгэх<sup>14</sup> ажиллагаагаа хийж байсан түүхтэй юм. Татварын гэмт хөргийн талаар тусгайсан зохицуулалт хийж хуулийн байгаагүй ч тустай зүйл заалтыг хуулийн тусгаж байсан байна. Тухайлбал,

- Татвар ногдуулалт, төлөлтэд хяналт тавих, татвар хураах тухай 1996 оны хуулийн 4 дүгээр зүйлийн §4.3-т “tatварын албаны даргын шийдвэрээр татварын хууль тогтоомжийг зорсентэй холбогдуулан хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах үйл ажиллагаа явуулж байгаа болон прокурорын байгууллагын эрх бүхий албан тушаалтанд уг зөрчид нь холбогдох

<sup>11</sup> Монгол Улсын Сангийн сайдын 1995 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 98 лутгар тушаал.

<sup>12</sup> Үндэсний Татварын Ерөнхий Газрын даргын 2001 оны 168 тоот тушаал.

<sup>13</sup> Ж.Батбаяр, Ж.Уннаа . Монгол нутгийн татвар үүсч хөгжсөн түүхийн танилцаа. УБ, 2011 он, 148 дахь тал.

<sup>14</sup> Үндэсний Татварын Ерөнхий Газрын даргын 2002 оны 9 дүгнээр сарын 4-ийн одрийн 163 тоот тушаал.

асуудлаар танилцуулах”, мөн тус хуулийн 27 дугаар зүйлийн §27.2-т “tatвар төлөгч татвараа төлөхөөс зайлсхийсэн, хуулинд заасан хугацаанд татвараа төлөөгүй, татварын төлбөрийг ул маргандлах журмыар төлүүлэх боломжгүй тохиоддодаа татварын алба татвар төлөгчтэй тохиорцож эд хөрөнгө, цалин, бусад орлогос татварын төлбөрийг гаргуулахаар байсан ч татварын төлбөрт эд хөрөнгө гаргах ажиллагааг хүндэтгэн үзэх шалтгааныгүйзээр саатуулсан, татгалзсан бол Татварын алба татварын хэрэг бүртгэх ажиллагаа явуулж, хэргийг зохих журмын дагуу шиндвэрлэнэ” гэж зааж байжээ.

- Эрүүтийн хуулийн 2002 оны өөрчлөлтөр тус хуулийн 166 дугаар зүйлийн §166.1 ба §166.2-т “tatвар ногдох их хэмжээний бодон онц их хэмжээний<sup>15</sup> орлого, эд хөрөнгө, ажил, үйлчилгээ, бусад зүйлийг нүүх<sup>16</sup>, гэлгээрин тоо хэмжээг зориуд бурууруулан<sup>17</sup> мэдээлэх, байнгаа оршин суугаа газар, хаягаа өөрчлөх эзргэр албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн бол” эрүүтийн харнишлага хүлээлгэнэ гэж заасан.

- Татварын эрх зүйн шинэчлэлийн хүрээд батлагдсан 2008 оны Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн §33.2.6-д “tatварын алба нь татварын хууль тогтоомжийг иоцтой зөрчсон, эсхүл их

<sup>11</sup> Ходолмын хөслийн доод хэмжээг Монгол Улсын Засгийн Газрын 2007 оны 350 тоот тогтооюулж шат 642 төгрөг 85 мянган буюу сард 108 000 төгрөг, Ходолмын, Нийгмийн шөвшигийн гурван талт үзүүлсний хорооны 2011 оны 1 тоот тогтооюулж шат 835 төгрөг 71 мянган буюу сард 140 400 төгрөг, 2013 оны 7 тоот тогтооюулж шат 1142 төгрөг 85 мянган буюу сард 192 000 төгрөг, 2016 оны 4 тоот тогтооюулж шат 1428 төгрөг буюу сард 240 000 төгрөг гэж тогтооносоо хийн буюу 2008 оноос эхлийн их хэмжээ 13 500 000-21 600 000 төгрөг, оны их хэмжээ 21 600 000 төгрөгээс дээш байхар зохицуулж байсан. Харин 2015 оны эрүүтийн хуулийн шинжилгээнээс наиртуулгар 1350-10000 ижэж, 5400-27000 ижэж, 20000-120000 ижэгтэй тийм хэмжээний тогтолцоог тогтолцоо куулжилсан. Нэг ижэжийг 1000 төгрөг гэж үзүүл.

<sup>12</sup> Албан татвар ногдох орлого, эд хөрөнгө, бусад үйлчилгээний нүүх гэлгэйт тухайн үйлчилгээний биец байдалар нь татварын албаныас өнгөлжилэх дадлаж буюу данс бүртгэл, тайлан балансад тусгахгүй байх, үйлчилгэлгүйзэр бусад шинжүүлэх, хууль бус хийцүүр халхавчны, хуурайчвар орлогт үүсгэх, холбогдох баримт бичигийг нууцлалыг хийн.

<sup>13</sup> Тоо хэмжээний бурууруулж гэлгэйт орлого, эд хөрөнгө, ажил үйлчилгээний тоо хэмжээ, үзүүлийн дунг пагтны бодох бүртгэл, тайлан ынцэл, тайлан түнцэл, орлого, татвар тодорхойлож хуудасын дуттуу мэдээлж татварын хэмжээг багвар тооцохыг ойлж оно.

хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих” гэжээ.

- Эрүүгийн хуулийн 2015 оны шинэчилсэн найруулгаар эдийн засгийн гэмт хэргийн нэг төрөл нь татвар төлөхөөс зайлсхийн гэмт хэрэг гэж зүйлчлэн тус хуулийн 18 дугаар зүйлийн §18.3-т татварын эрх бүхий байгууллагын шийдвэрээр<sup>18</sup> эцслээн тогтоосон нэг зуун сая төгрөгнөөс дээш хэмжээний татвар төлөхөөс санаатай зайлсхийнсэн, гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол эрүүгийн хариушлага хүлээлгэжээр хуулийнсаас гадна тус гэмт хэрэг үйлдсэн хүи, хуулийн этгээд нь төлбөл зохих татвар, түүнд ногдох алдангийг нөхөн төлсөн бол ялаас чөлөөлгөхөөр хуулийн төслэл санаачилж байсан. Одоо хүчин төглөрд хэрэгжиж буй хуулийн заалтад “Татвар төлөгч хувь хүб, худийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан татвар төлөхөөс зайлсхийн зорилгоор их хэмжээний татвар ногдох орлого, эд хөрөнгө, баараа үйлчилгээг зориуд худал тодорхойлсон, нутсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дочин цагаас долоон зуун хорин цаг хүргэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл изг сараас нэг жил хүргэл хугацаагаар зорчих шийнг хязгаарлах ял шийтгэнэ” гэсэн заалтыг тусган хэрэгжүүлж байна.

Татвар төлөхөөс зугтаж гэмт хэргийт манай улсын хуулинд татвар төлөхөөс зайлсхийг тэж томъёолон уг гэмт хэргийн бүрэлдэхүүний объект нь үндэсний татварын тогтолцоо албан татвар төлүүлж талаар хуулнар тогтоосон хийгээл заавал дагаж мөрдөх журам, субъектнүү тал нь албан татвар төлөхөөс санаатай зайлсхийг эсэн гэм бууругийн шүүд санаатай, шунхайад сэлдэгтэй байх, объектнүү тал нь

татварынхаяа хэмжээг бууруулах, төлөхгүй байх гэсэн зорилго бүхий нэзвхитэй үйлдэл ба эс үйлдэлүү, субъект нь зөвхөн албан татвар төлөх үүрэг бүхий этгээд байна<sup>4</sup>.

Татвар төлөхөөс санзагтайгаар зайлсхийн гэмт хэргийн ялгадах онцлог шинж нь ёвт үлдэж ашиг орлогод тодорхой хэмжээгээр нэмэгдуулж санаа зорилго агуулна. Тус гэмт хэрг нь хэлбэрний бүрэлдэхүүнтэй бөгөөд татвар ногдох их хэмжээний орлого, эд хөрөнгө, ажил үйлчилгээ бусад зүйлийг нууснаар, тэдээрийн тоо хэмжээг зориуд бууруулан мэдэлслэээр, үүний түнд байнга оршин суугаа газар хаягаа ёөрчилснөөр бүрдэл төгснөн гэж манай улсын хуулинд тайлбар хийгдсэн байдал.

Харин БНСУ татварын гэмт хэргийг Эрүүгийн хууль. Эрүүгийн байцаа шийтгэх хууль. Татварын гэмт хэргийг хянан шалтгаан тухай хууль, Татварын гэмт хэрэгт хүзээлгэх харинчлагын тухай хууль, Орон нутгийн татварын тухай хууль. Гаалийн тухай хууль зэрэг хуулиудад татварын нелөөллийн шинжилгээний үндсэн дээр тусгайлан суурь судалгааг хийж нарийвчлан зохицуулагдаа байдлаар тусгаж өгчээ. Хууль тогтоомжийн хүрээнд татвар төлөхөөс зутгах гэмт хэргийн төгсөх шинжнийг тодорхойлоходоо татвар төлөх хугацаанд багтаан төлөөгүй тохиолдолд, мэдүүлэх хугацаа өнгөрсөн үед, тайлгнах, төлөх хугацаа өнгөрсөн буюу хэтэрсэн бол, илмэгждсэн өртгийн албан татвар буцаан авсан үед гэх мэтээр авч үздэг байна.

Татварын хууль тогтоомжийн зөрчил нь нэг талаас тавар төлөгчөөс улсын изгэдсан төсөв ба улсын татварын албаны өмнө хүлээсэн санхүүгийн үүргээ үл билүүлжсан эсвэл зүй бусаар билүүлжсан үйлдэл, эс үйлдэл гаргасны нь төлөө хариуцлага хүлгэлгэх негеэ талаас татварын аль ч шатны байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомж буруу хэрэглэсэн, албан тушаалтан эрх мэдлийн хэтрүүлж ажилласнаас үүдэн гарсан үйлдэл, эс үйлдэлд хүлээх хариуцлага багтана. Хариуцлага нь албадлагын нэгэн

<sup>18</sup> Татварын эрх бүхий байгууллагын шийдвэр гэж татвар төлгөөчөс төлөхийг зөвшөөрсөн, эсхүл хуульд заасан гомдол гаргах хугаца дүүссэн татварын нөхөн ногдуулалтын аж, магадгүй шийдвэрээ зөвлөхөн шийдвэр болго.

<sup>19</sup> Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. Монгол Улсын Дээд Шүүх Хамис-Зайсантийн Сая Уб. 2010 он.

зүйл, харин хариуцлагын арга хэмжээ нь албадлагын онцгой төрөл мөн<sup>20</sup> гэж үздэг. Иймээс хариуцлага нь албадлагын бүрэлдэхүүн хэсэг юм. Татварын хүрээн дэх албадлага нь урьчилан сэргийлэх, хууль бус үйлдлийн таслан зогсоох зэрэг хэлбэрээр тодорхойлогдоно. Тухайлбал; урьчилан сэргийлэх арга хэмжээ нь татварын албанаас авч хэрэгжүүлэх хуулийн хэрэгжилтийг хангах шууд үйл ажиллагааны зорилтууд юм. Эдгээр үйл ажиллагаанд татварын тайлангаа гаргахгүй болои бүртгүүлэхгүй байх явдлын илрүүлж тогтоох, мөн татварын хяналт шалгалт хийх зэрэг арга хэмжээ хамаарна.

Татварын албадлагыг шийтгэл хэлбэрээр хэрэгжүүлдэг. Шийтгэл нь төрийн эрх бүхий албан тушаалтнаас зөрчил гаргасан этгээдэд хууль тогтоомжийг үндэслэлийн хэрэглэж буй албадлагын цээрэлэл үзүүлэх нөвлөвлийн арга хэмжээ гэж тодорхойж болох юм.<sup>21</sup>

Татварын шийтгэлийн зорилго нь эрх зүйн зөрчил шинээр үүсэхээс урьчилан сэргийлэх, зөрничгээ этгээдийг хууль тогтоомжийг дээдэлэн хүндэтгэх үзүүлэх болдol, эрх зүйн ёс сурталчуутай болгох, гаргасан зөрчилд нь зэмэлэл цээрэлээ үзүүлжээд чиглэдэг гэж үзүү. Тухайн шийтгэл үндэслэлтэй зөрчилдөө тохирсон байх ёстой.

Татварын байгууллага нь хууль зөрчсөн зарим тодорхой үйлдлүүд бүсдэгээс бодвол ноцтой бус байдгийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд энэ байдалд ийнчүү лэн шийтгэлийнхээ системийн бүтүүшгийг сонгож боловсруулдаг байна. Тухайлбал, олон улсын хэмжээнд татварын үйл ажиллагаанд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бүртгүүлэхгүй татвар төлөгчдөд оногдуулах, тайлан гаргаагүй этгээдэд оногдуулах, татвараа буруу тодорхойлсон тохиолдолд<sup>22</sup>, хугацаа хожимдуулж төлбөр

хийсний шийтгэл<sup>23</sup> гэж ангилдгаас гадна албадан хураах, гуравдагч этгээдээс төлбөр гаргуулах, хөрөнгийг нь битуумжилж барьцаанд авах, дампууруулах, үүргийн шилжүүлэх гэх мэт.

Гэмт хэрэг төгсөх үе шатыг дараах байдааар авч үзүү тайлбарлах болдю. Үүнд:

- Ногдуулах аргаар тогтоох. Татвар төлөгчтэй татвартөлөхөөс зайлсхийх зорилгоор татвар ногдуулах орлогоо мэдүүлэхгүй татварын байгууллага татвар ногдуулах орлогыг тогтоохгүй, шалгалах хийх эсэээ шийдэж чадаагүй бол татвар төлөх хугацаа байх боломжтүй бөгөөд мэдүүлэх хугацаа өнгөрсөн үед хэрэг төгсөнө. Татвар төлөх хугацаанд багтаан төлөөгүй тохиолдолд татварын хэрэг төгсөнө. Татварын албанаас татвар ногдуулах орлого болон татварын хэмжээг тогтоохыг ногдуулах аргаар тогтоосон татвар гэж үзж болно. Татвар төлөгчөөр бүртгүүлэхгүй нь татвар ногдуулах, төлөх, сунгах үүрэг, түүнтэй уялдаж хүлээх хариуцлагасаа чөлөөлгөхдөх үндэслэл болохгүй<sup>24</sup>.

- Тайлгалих аргаар тогтоох. Татвар төлөгч татварын тайлан гаргаж өгсөн эсэээс үл хамааран тайлгахаа, төлөх хугацаа өнгөрснөөр татварын гэмт хэрэг төгсөнө. Татвар төлөгч татвар ногдуулах орлого, татварын хэмжээг тайлагнасан боловч татварын байгууллага тайлангийн алдааг илрүүлж, дахин тооцож, татвар төлөх үүргийг дахин баталгаажуулсан тохиолдолд ч тайлгахаа, төлөх хугацаа өнгөрсөн бол гэмт хэрэг төгсөнө. Тайлгахаа аргаар тогтоох татвар - татвар төлөгч өөрөө татвар ногдуулах нөхцөлийг судлаад татвар ногдох зүйл, ногдуулах орлого ба татварын хэмжээг тайлагнан, татвар төлөх үүргэгдэг татварын арга юм. Тухайлбал, Татварын тайлан тушаах, төлөх хугацааг тухайн төрлийн татварын хуулиар

<sup>20</sup> И. Долгорсүрэн Ж. Залхиргамын албадлага. Уб. 1999 он, 29 дэх тал.

<sup>21</sup> Долгорсүрэн Ж. Залхиргамын хариуцлага. Уб., 1998 он, 61 дэх тал.

<sup>22</sup> Шүүх эрх мэдэл (хэрэгжилт, онол, практик). ХЭҮТ, ЧДШ Уб., 2003 он, 52 дэх тал.

<sup>23</sup> Монголын төр, эрх нийгэлтүүлэл. Монгол Улсын Дүүл Шүүх. Уб., 2002 он, №4. 36 дэх тал.

<sup>24</sup> Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн 13-р зүйлийн 13.8 дэх талт.

тогтоох ба татвар төлөх, тайлагнах эцсийн хугацаа адил байна<sup>25</sup>.

• Татвар хасуулах. Хэдийгээр тайлант хугацаанд хасуулах тайлан гаргасан ч гэсэн энэ улиралд тогтоосон татвар байхгүй байсны улмаас хасалт хийх боломжтүй болж дараагийн тайлант хугацаанд шилжүүлэн авсан гэвэл хууль бус үйлдэл нь энэ улиралд үйлдэгдсэн ч үр дагавар үүсч байгаагийн сард гэмт хэрэг төгсөн. Татвар буцаан авсан ёе буюу татварын буцаан олголт – татвар төлөгч тайланд өөрчлөлт оруулж, буцаан авах асуудал юм. Тухайлбал, албан татвар төлөгчид буцаан олголтыг олгох тохиолдол нь албан татвар суутган төлөгчөөс худалдан авсан

байх, худалдан авалт татварын албанад бүртгэгдсэн байх, албан татвар ногдсон бараа, ажил, үйлчилгүэ байх, бүртгэлийн хэрэгсэл буюу бүртгэлийн машинд бүртгэгдсэн байх<sup>26</sup>.

### ДҮГНЭЛТ

Татварын гэмт хэргийг шийдвэрлэжээ татвар төлөхөөс зутгах буюу татварын залилангийн үйлдлийт татвар төлөхөөс зайлсхийх үйлдлийс ялгаа ойлгож, түүнээ хамаарах гэмт хэргийн бүрзэлжүүнийн оногчтой цийдвэрлэх нь зүйтэй юм. Мөн татварын гэмт хэргийн үйлдлийт зорчлийн шинжээс ялган тодорхойлж, гэмт хэрэг үйлдэгдсэн нохцел шалтгааныг зөв зүйлчлэх шаардлага үүссээр байна.

<sup>25</sup> Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн 43-р зүйлийн 43.5 дахь заалт.

<sup>26</sup> Монгол Улсын Нэмэгдэсэн ортгийн албан татварын тухай хуулийн 15 дутжар зүйлийн 15.3 дахь заалт.

## ШАШНЫ БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮЖИЛТ БА ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



УБХИС-ын Аюулгүй байдал судалтын  
докторант Х.Мариам

### ТОВЧ АГУУЛГА

Энэхүү огүүлээр шашны байгууллагын санхүүжилт болон түүний эрх зүйн зохицуулалтыг судалж, төрийн хуулийг улсын онцлогт тогиртуулан боловсруулж, хууль тогтоодоо зөвхөн мэргшсэн хуудасид төдийгүй шашин судлаачид, аюулгүй байдлын мэргжилтийн зөвлөмжийг авах, шашны байгууллагад ирж буй гаднын санхүүжилтийг хялгаарахад чиглэгдэж буй гадаадын туршилагыг судалж Монгол Улсын уламжлал, онцлогийг тусгасан санал дэвшүүлэхийг зорьсон.

### НЭГ БАРУУНЫ ОРНУУДЫН ШАШНЫ САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААР БАРИМТАЛЖ БҮЙ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Барууны орнууд шашны нийгэм, олон улсын харилцаанд эзлэх байр сууринт судлаад икэхэн анхаарч ирсэн. Эрдэмтэн судлаачид 2001 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр АНУ-д болсон халдлагаас хойш шашин аюулгүй байдал хоёрын холбоог нягт судалж байгаа бөгөөд шашны зохицуулах

эрх зүйн механизмыг боловсронгуй болгох<sup>1</sup> ажлыг хийсээр байна. Өнөөдөр нийгэм хөгжиж, даяаршлын үйл явц хурдтай ернэж байгаа учраас шашин нэг улсын хилээс хальж хөрш орон, бус нутагт хурдаар нөлөөлдөх болсон. Үүнийг дагаад шашны санхүүжилт зөвхөн дотоодоос бус хөрш орон, бус нутаг, шашин нэгт үds орнуудаас ирж байна. Өнөө уед байнжсон сондог гадаадын санхүүжилтийн шүүмжлэлийн нэг бол улс орнууд шашин ашиглах явдал юм. Шашин бусад улс орны улс төр, нийгмд нөлөө үзүүлэх арга хэрэгслэ<sup>2</sup> болон хувираад байна. Ялангуяа, Туркийн Засгийн газрын Шашны хэрэг эрхлэх газар “Диянет”, Саудын Араб, Катар, Кувейт ээрж орнууд<sup>3</sup> ним төрлийн үйл ажиллагааг шүүд болон шүүд бус байдлаар хэрэгжүүлж ирсээр байна. Тиймээс барууны улс орнууд дээрх үйл ажиллагаатай тэмцэх зорилгоор арга хэмжээ авч эхэлсэн.

БНФУ-ын Ерөнхийлөгч Э.Макрон 2018 онд шашны байгууллага болои сүм, хийдүүдийн санхүүжилт, хандив цуглуулах, лалын шашны номлогч (имам) нарын сургалтын талаар эрх зүйн зохицуулалт хийх зорилгоор судалгаа хийж зөвлөлдөх ажлын хэсэг байгуулсан<sup>4</sup>. 1905 онд батлагдсан Төр, сүм хийдийн талаарх хуулийг шинэчилж, лалын шашинд ирж буй гаднын санхүүжилтийг зогсох санал гаргасан. Лалын шашны үйл ажиллагаа, сүм хийд барих ажил ний их хэмжээний хөрөнгө шаардлагдаг

<sup>1</sup> Jonathan E. Shaw, The role of religion in National Security Policy Since September 11, 2001, 2011.

<sup>2</sup> Jaco Beyers, Religion as political instrument, J.Study relig. Vol.28 n.1 Pretoria, 2015.

<sup>3</sup> <https://www.foreignaffairs.com/articles/turkey/2019-01-10/turkeys-bid-religious-leadership>

<sup>4</sup> <https://www.diy.com/deutsch-dem-deckmantel-der-hilfsorganisationen-aufzueben>

<sup>5</sup> <https://www.brookings.edu/blog/order-from-chaos/2019/05/01/islam-makre-in-france-debating-the-reform-of-muslim-organizations-and-foreign-funding-for-religion/>

учир түүний санхүүжилт нь гадаадын улс орноос ирэх тохиолдолд их байдаг. Гадаад улсын санхүүжилт Франц улс дахь шүтгэч нарын хандивас их байдаг аж<sup>6</sup>. Нэг жишиг дурдахад Саудын Арабын Хаяйт Уласаас БНФУ-д сугаа Оны бөгөөд бүрзү эрхт Элчин сайд Халид бин Мухаммед Аль Анкаригийн мэдэгдсэнээр Франц улсад үйл ажиллагаа явуулж буй 8 сүм хийдэд (мечеть) ийт 3,7 сая европийн хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд 14 номлогч (имам) нарыг цалинжуулгад байна. БНФУ-ын эрх зүйн зохицуулалтад<sup>7</sup> 1 жилийн хугацаанд 153 000 европогос дээш хэмжээний хандив авсан нэгдэл хөндлөнгийн хяналт шалгалтаар шалгагдан байх ёстой. Гэхдээ уг зүйл заалт нь зөвхөн тодорхой үйл ажиллагаа эрхэлдэг, санхүүжилтийн мөнгөй дундажаван тохиолдолдуулж эрзгэждэг. 2016 оны 7 дугаар сарын 14-ний өдөр Ница хотод болсон террорист халдлагын дараа Ерөнхий сайд асан М.Валл тодорхойгүй хугацаагаар сүм хийдүүдийн (мечеть) гаднаас ирэх санхүүжилтийн зогссоно<sup>8</sup> хэмзэн мэдэгдэж байсан хэдий ч ажил хэрэг болоогүй.

Европын зөвлөлөөс гаргасан тайландаа гишүүн орнуудын парламентаас шашны санхүүжилттэй холботой асуултын хариултуудыг нийтэлсэн бөгөөд зарим орнуудын шашны санхүүжилтийг зохиулсан хууль, журам дутмаг байгааг харж болно. Гишүүн орнуудыг дотоодын хандив болон гаднаас (хувь хун, байгууллага, Засгийн газар) ирж буй санхүүжилтийг улсынхаа хууль журамд албан алсаалж тусгасан эсэхнийг асуухад бүтгүүгээрээ тусгассан байна.

ХБНГҮ-д мөн сүм, хийдийг гадаадын санхүүжилтээс хараат бус байлгах үүднээс “сүмийн татвар”-тай болгох талаар

хэлэлцэж байна<sup>10</sup>. Уг санал нь католик, протестант шашны “сүмийн татвар”-тай төстүй бөгөөд татвартыг тухай муж нь цуглуулж холбогдошишины байгууллагад дамжуулан өгдөт. ХБНГУ-д лайн шашны 900 гаруй сүм Туркийн Засгийн газраас сануучилжээ авдаг<sup>11</sup>.

ХОЁР МОНГОЛ УЛС ДАХЬ  
ШАШНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсад зөвшөөрэлтэй. зөвшөөрэлтгүй үйл ажиллагаа явуулж буй гадинийн яз бурийн шашны байгууллага, сүм хийд, тэндээс нийгмийн сэргэл зүйлүүзүүлэх серөг нөлөөлөл хяналтуү шахуу байна. Шашин шүтэж эрх нь хувь хүний асуудал боловч шашин хооройлын зөрчил, шашны харгис уреталыт дэлгэжүүл эхгүй байх, шашны итгэл үзүүмшилээр далимдуулж нийгмийн сэргэл зүйд сергеер нөлөөлж нийгмийн тогтвортгуй байдал бий болох, эзгрээс урьдчилан сэргийлж нь төрийн үүрэг юм. Шашин сүрмийн асуудал нь тухайн улсын үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулаад байгаа бусад улс орнуудын нөхцөл байдлаас үзэжд шашны асуудлыг урсгалы нь орзих нь хэдээ запруулж болшгүй аюу, зынالын эх үндэс болдог гашуун сургамжийн судалж, цаг алдалгүй шийдвэртэй алхам, зохицуулалт хийхийг мэргэжилтнүүд<sup>12</sup> зөвлөж байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээ хийсэн “Эрх зүйн шинэтгэлийн болгын баримт бичиг боловсруулахад дэмжилгээ үзүүлэх нь” судалгааны “Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн 208 оноос хойших хэрэгжилт” дэд хэсэгт “Монгол Улсад шашны байгууллага, сүм хийдийн тоо жилээ жилд өсөн нэмэгдэж байгаа бөгөөд олон төрлийн шашин номпол сургаалаа түгээж үйл ажиллагааг явуулж байна; тухайн шашны байгууллагууд үйл ажиллагааг эрхлэхдээ ТББ-ын нэр дээр халхваачлан үйл ажиллагаа эрхлэх явдал

<sup>8</sup> Rapport d'information fait au nom de la mission d'information sur l'organisation, la place et le financement de l'Islam en France et de ses lieux de culte, Sénat session extraordinaire de 2015-2016, Enregistré à la Présidence du Sénat le 5 juillet 2016.

<sup>7</sup> L'article 4-1 de la loi du 23 juillet 1987 les soumet en effet aux dispositions de l'article L. 612-4 du code de commerce.

<http://www.leparisien.fr/politique/mosquées-l-idée-choc-de-valls-30-07-2016-6004693.php>

<sup>9</sup> Regulating foreign funding of Islam in Europe in order to prevent radicalisation and Islamophobia. Council of Europe. Doc 14617 report 23 january 2017.

<sup>10</sup> <https://www.dw.com/en/germany-mulls-introducing-mosque-tax-for-muslims/a-46866041>

<sup>11</sup> [https://www.scmp.com/news/world/europe/article/3009927/germany-considersmosque-tax-replace-foreign-funding](https://www.scmp.com/news/world/europe/article/3009927/germany-considers-mosque-tax-replace-foreign-funding)

<sup>12</sup> Д.Адьыбазар, "Монгол Улсын атоод аюулгүй байдлын эрдэм бүхий зарим асуудал". Стратеги судалж сэтгүүл дутамр 53, 35 дахь тал, 2011 он.

түгээмэл болсон байна; Монгол Улсын хэмжээнд шашны байгууллагын бүртгэл, тоо, судалгаа хангалигийн буюу нэгдсээ тоо бүртгэл байхгүй байна; шашны асуудлыг гаргаж тавихдаа шашин шүтэх эрхийн үүднээс голчлон судалгаа хийгдсэн бөгөөд үндэсний агуулгүй байдал, Монгол Улсын төрийн боллогын үүднээс шашны асуудлыг зохицуулах тухай дорвийт судалгаа хийдээгүй байна” гэж дүгнэсэн<sup>13</sup>.

Ийнхүү өнөөгийн нийгэм, эрх зүйн шинэчлэлийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үүсээн чиглэлд<sup>14</sup> Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг “Шашны байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт, бүртгэл зөвшөөрлийн тогтоошоо, хариуцлага тооцох механизмыг тодорхой болгох”<sup>15</sup> чиглэлээр шинэчлэх зорилтыг давшүүлжээ.

1993 онд батлагдсан Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар<sup>16</sup> зохицуулж ирсэн иньтмийн харилцааны төвлөр байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарсан тул хуулийн төслийг Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль болгон ережмээлийн шинэчлэсэн нариуулгын хэдбэрээр боловсруулах ажлыг 2018 онд эхлүүлсэн. Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндэсний хуулийн үзэл баримтлалд тутгүүрлан, Монгол Улсын нэгдэн орсой хүний эрхийн талаарх олон улсын грээний суурь зарчимд ийнцүүлэн тодорхойлино. Мөн шашны бүлэг, шашны байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээллийг ил тод, нээлттэй байх журмыг тогтооноо. Энэ хүрээнд шашни бүлэг, шашны байгууллагын орлого болон бусдын өгсөн хандивыг хэрхэн бүртгэх, гадаадын иргэн, байгууллагын хандив,

санхүүжилтэд тавих хяналт зэрэг асуудлыг тодорхой болгох, шашны байгууллагад үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан мэдээ гаргаж, тайлагнах үүргийг хүлээлгэх аж<sup>17</sup>.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн шалгалтын мэдээгээр 2016 онд улсын хэмжээнд б өөрчлөн шашны 20 гаруй урсгалын 848 хуулийн этгээд шашны чиглэлээр үйл ажиллагааг явуулж байгаагас 54.2% нь христин, 34.6% нь буддын, 5.1% нь исламын, 1.6% нь бусад чиглэлийн шашны байгууллага<sup>18</sup> байна.

#### ГУРАВ. МОНГОЛ УДС ДАХЬ ШАШНЫ САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААРХ ЗОХИЦУУЛАЛТ

Монгол бол шашны элдэв урсгалуудын хувьд өмнө нь иээгдээгүй атар дагшин газар. Тийм ч болохоор элдэв санхүүжилтэй шашны урсгалууд орж ирэх, батжин тогтноо бололцоото орон гэгддэг болсон нь нууц биш. Исламын шашинтнууд 40 орчим сүм хийд (мечеть), 7 исламын шашны сургалтын төв ажиллуулдаг бөгөөд эдгээр сүм хийд (мечеть), сургалтын төвд нийт 3000 орчим суралцагч Исламын шашинд суралцаж байгаа ажээ<sup>19</sup>. Мөн нийслэл Улаанбаатар хотод Исламын соёлын төв баригдаж байна. Исламын шашны сүм хийд (мечеть), төвүүд Казахстан, Турк, Персийн булангийн улсуудын шашны байтууллагуудаас санхүүгийн тусламж авдаг. Мөн сүүлийн үед нэмэгджэй буй христ, католик сүм, санваартан нар гаднаас санхүүжилтээ<sup>20</sup> авдаг байна. Ерөнхийлөгч Шашны боллогын зөвлөх 2018 оны 10-р сард хэвлэлд өгсөн ярилцлагадаа зарим гадаад орны санхүүжилтгэй төрийн бус байгууллагууд хууль зөрчиж шашни үйл

<sup>13</sup> Төр ба шашны харилцаа: шашны байгууллагын бүртгэл, харилц болон газар устасны шашны зохицуулах эрх түйн механизмыг заргаруулсан судалгааны тайлан. Хууль түйн үзүүлэлтийн хуулият, 2018 он.

<sup>14</sup> Монгол Улсын Их курлын 2017 оны 01 дугаар сарын 111-ний өдрийн 11 дугаар тогтолцоол.

<sup>15</sup> Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүргэн боловсронгуй болгох удаас чиглэл 160 дагуу зорилт.

<sup>16</sup> Төр, сүм хийдийн харилцааны тухай 1993 он.

<sup>17</sup> Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн шинтгчилсэн нариуулгын төслийн үзүүлэлтийн хуулият, ХЭДХЯ, 2018 он.

<sup>18</sup> ХЭДХЯ-ийн сайдын 2016 оны А/73 дугаар туталваар байгуулжсан Ажлын хөтөнчийн шалгалтын дүс.

<sup>19</sup> <https://2009-2017.state.gov/documents/organization/134451.pdf>

<sup>20</sup> Олон улсын шиншил эрх чөлөөний тухай илтгэл, Төрийн Департамент, 2009 он.

ажиллагаа явуулдаг талаар дурдсан<sup>21</sup> байдал.

Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн төслийн хориглох зүйлийн жагсаалтын 27.2.8 “Гадаад улсын Засгийн газар, түүнээс санхүүжлэг хуулийн этгээд, шашны байгууллагаас хандив авах” зэрэг үйл ажиллагааг хязгаарласан<sup>22</sup>.

“Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай” хуулийн төслийн хэлээцүүгийн үеэр сайшах зүйл гарсан хэдийн ч шүүмж цөөнгүй байсан гэдгийг дурдах нь зөв бол уу.

Төр нь шашнаа хүндлэх ганц арга бол мөнгө хаанаас орж ирснийг хянах буюу татвар хэмээн Нарханжид хийдийг үсгээн байгуулагч Д.Мэндбаяр ярилгагадаа дурдсан байдал<sup>23</sup>.

Мөн гаднын шашны гаж урсгал орж ирэх, үйл ажиллагаа явуулах боломж нөхцөлжилж энэ хуулиар хаах, нарийн зохицуулж өгөөгүй, хууль боловсруулахад шашин судлаачдыг борлуулагч, зөвхөн хуульчид л ажилласан нь шүүмжлэлтэй хэмээн МУИС-ийн Шашин судлалын тэнхимийн багши С.Дэмбэрэл байр суурин илрхийлсэн. Мөн тэрэр шашны байгууллагыг зүгзэрлэгж ажхуйн нэгжийн байр сууриас үзэх учир дутагдалтай гэдгийг тодотгосон.

#### ДӨРӨВ. ДУГНЭЛТ, САНАЛ:

Нийгмийн амьдралын томоохон үзэгдэл, үйл явцад шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаанд тулгуурлаж хандах цаг болсон. Энэ нь шашны асуудалд ч хамаарна. Шинжлэх ухааны судалгаанд тулгуурлан үндэстний шашны шинэчлэлийн асуудлыг оновчтой, уламжлалаа хадгалах, шинийг нэвтрүүлсэн бодлого, үзэл баримтлал боловсруулах нь чухал хэмээн «Төр, сүм хийдийн харилцаа : орчин үе» сэдэвт онол-практикийн бага хурлын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч

асан Н.Багабаиди<sup>24</sup> дурдсан.

Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хууль батлагдсаннаар иргэдийн шашин шүтэх, эс шүтэх нь эрх чөлөөтэй байх эрхийг хангах нөхцөл бурдаж, эрх зүйн зохицуулалтын хүрээнд үүссээд байгаа зөрчил арилж, иэгдсэн зохицуулалттай болох<sup>25</sup> хэдий ч олон улсад болж буй үйл явдал, шашны урсгал, гадаадын улс орнууд шашны нөлөөллийн арга хэрэгсэл болгон ашиглаж байгааг харгалзаж эрх зүйн зохицуулалт боловсруулах нь чухал юм. Монгол Улсад гадаадын шашны байгууллагын салбар, төлөөлөгчийн газар байгуулах асуудал тул тус асуудлыг нарийвчлан хуульчилж, хяналт тавих механизмыг бүрдүүлэх шаардлагыг тулгамдах байна. Гадаадын санхүүжилтийг хориглох систем нь өөрөө цаашид шууд бус санхүүжилтийг татааж, далд мөнгөний эргэлт үсгэж эрэлдэлтий тул шашны байгууллагын санхүүжилтийг дотоод, гадаад эх үүсвэрээд нь салгаж тухай бүр нарийвчилсан зохицуулалт хийх нь зүйтэй гэж үзж байна.

#### ТАВ. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Монгол Улсын Үндэсний хууль 1992 он.
- Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал 2010 он.
- Төр, сүм хийдийн харилцааны тухай 1993 он
- Монгол Улсын Их хурлын 2017 оны 01 дүгээр сарын 111-ний өдрийн 11 дүгээр тогтоог.
- Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүргэл боловсронгуй болгох үндэсэн чиглэл 160 дахь зорилт.
- Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын

<sup>21</sup> <https://mn.usembassy.gov/2018-international-religious-freedom-report-mn/>

<sup>22</sup> Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай (Шинжчилсэн найруулга) тосол, 2018 он.

<sup>23</sup> [http://tqim.mn/article/CEm3y\\_14863](http://tqim.mn/article/CEm3y_14863)

<sup>24</sup> Төр, сүм хийдийн харилцаа : орчин үе. ШУА, Философи, социологи эрхийн хурсын, 1998 он.

<sup>25</sup> Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай хуулийн теслийн тухай тамирчилтуулж ХЭДХЯ 2018 он.

төслийн үзэл баримтлал, ХЭДХЯ, 2018 он.

- Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай (Шинэчилсэн найруулга төсөл, 2018 он.

• ХЭДХ-ийн сайдын 2016 оны А/73 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн шалгалтын дүн.

- "Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний тухай" хуулийн төслийн тухай танилцуулга ХЭДХЯ 2018 он.

• Төр ба шашны харилцаа: шашны байгууллагын бүртгэл, харгис болон гаж ургаслын шашнын зохицуулалт эрх зүйн механизмын харьцуулсан судалгааны тайлан, ХЗҮХ 2018 он.

• Төр, сүм хийдийн харилцаа : опчин үе. ШУА, Философи, социологи эрхийн хурээлэн, 1998 он.

• Д.Альяабазар, "Монгол Улсын дотоод аюулгүй байдлын эрдэл бүхий зарим асуудал", Стратеги судалгаан сэтгүүл дугаар 53, 35 дахь тайл, 2011 он.

• Олон улсын шашны эрх чөлөөний тухай илтгэл, Төрийн Департамент, 2009 он.

• Rapport d'information fait au nom de la mission d'information sur l'organisation, la place et le financement de l'Islam en France et de ses lieux de culte, Sénat session extraordinaire de 2015-2016, Enregistré à la Présidence du Sénat le 5 juillet 2016.

• L'article 4-1 de la loi du 23 juillet 1987 les soumet en effet aux dispositions de l'article L. 612-4 du code de commerce.

• Jonathan E.Shaw, The role of religion in National Security Policy Since September 11, 2001, 2011.

• Jaco Beyers, Religion as political instrument, J.Study relig. Vol.28 n.1 Pretoria, 2015.

• Regulating foreign funding of Islam in Europe in order to prevent radicalisation and Islamophobia. Council of Europe, Doc 14617 report 23 january 2017.

- <https://www.foreignaffairs.com/articles/turkey/2019-01-10/turkeys-bid-religious-leadership>

- <https://www.dw.com/de/unter-dem-deckmantel-der-hilfsbereitschaft/a-36757769>

- <https://www.brookings.edu/blog/order-from-chaos/2019/05/01/islam-made-in-france-debating-the-reform-of-muslim-organizations-and-foreign-funding-for-religion/>

- <http://www.leparisien.fr/politique/mosques-l-idee-choc-de-valls-30-07-2016-6004693.php>

- <https://www.dw.com/en/germany-mulls-introducing-mosque-tax-for-muslims/a-46866041>

- <https://www.scmp.com/news/world/europe/article/3009927/germany-considers-mosque-tax-replace-foreign-funding>

- <https://2009-2017.state.gov/documents/organization/134451.pdf>

- <https://mn.usembassy.gov/2018-international-religious-freedom-report-mn/>

- <http://itoim.mn/article/CEm3y/14863>

---000---

**“ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ПАКТЫН 19 ДҮГЭЭР ЗҮЙЛТЭЙ ҮНДЭСНИЙ ХУЧИН ТӨГӨЛДӨР ХУУЛЬ ТОГТООМЖ, НИЙЦЭЖ БАЙГАА ЭСЭХ БОЛОН ТЭДГЭЭРИЙН ХУУЛИЙН ХИЙСЭН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ”**

**ТҮЛХҮҮР ҮГС:**

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, Жагсаал, цуглаан хийх эрх, мэдээлэлтэй байх эрх, мэдээлэл авах эрх,

**ТОВЧЛОЛ**

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь хүний мөн чанар, оршин байгаатай нь холбогдон гарч ирдэг, төрөөс тогтоодогтгүй түүнээс ангид оршдог, хүний төрөлт буюу оюун санааны эрх болохын хувьд Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1945), Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт түүний нэмэлт протокол (1966), Хүний эрхийн хорооны үйл ажиллагааны туржурам (1978), Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай Нью-Йоркийн гэрээ (1953), Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенци (1950), Хүний эрхийн тухай Америкниийн конвенц гэх мэт Олон улсын Конвенционоор баталгаажуулж ирсэн.

Энэхүү судалгааны ажлаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хэрэгжилтийн үр дагаврыг судлах үүднээс уг эрхийн тухай зохицуулсан Монгол Улсын холбогдох хуулийн хэрэгжилтийн явь дахь хүндэрэл, бэрхшээл, нийтгэмд үзүүлж буй зерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэн, цаашид зохистх, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулахыг зорьсон болно.

**УДИРТГАЛ**

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн (цаашид “Үндсэн хууль” гэх) Арван зургадугаар зүйлийн 16-д “итгэл үнэмшилтэй байх, үзл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэх, нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал цуглаан хийх журмыг хуулиар

тогтооно.”, 17-д “тер түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлсан хамгаалбал зохих нууцал хамаараахгүй асуудлаар мэдээлэлтэй хийх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийтийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувьхүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;” хэмээн тус тус заасан.

Үзэл бодлыг чөлөөт байдлаар бий болгох явдал нь харилцааны үйл явцад хэрэгждэг. Үүний тусд нэг талаас үзэл бодлоо илэрхийлж түгээх эрх чөлөө, нөгөө талаас илэрхийлсэн үзэл бодлыг хүлээж авах буюу мэдээлэл авах эрх чөлөө байх шаардлагатай.<sup>2</sup> Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 болон 17 дугаар заалтуудад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, түүнийг хүлээж авч өөрнийн үзэл болол, итгэл үнэмшилтэй байх эрхийг хүний үндсэн эрхийн хэмжээнд баталгаажуулж байгаагийн зэрэгцээ мөн харилцааны үйл явцыг Үндсэн хуулиар хамгаалах зорилтыг тавьж байгаа юм. Уг зорилтыг хэрэгжүүлж чухал үйл явц нь Үндсэн хууль нийцэн хуулиудыг Хууль тогтоогчийн зүгээс баталж мөрдүүлэх явдал юм.

ХЭҮК-оос 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрүүдэд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ийт 623 гомдол хүлээн авч шийдвэрлэсэнээс б нь үзэл бодлоо чөлөөтэй

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхийтээ №1, 1992 он.

<sup>2</sup> Мориц Лоренц, “ХБНГУ-ын Үндсэн хуулийн 5.1.1-р замтад тодорхойлсон үзл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг арчичлав байх тогтолцоогоон чухал элемент хөмжин үзэх ю.” Ханс Зайделийн сан, Төр эрх зүйн хуудас зргэнүүлэл, Уб., 2000 он, №7, 106 дахь тал.

илэрхийлэктэй холбоотой гомдол байна.<sup>3</sup> Дээрх тоон үзүүлэлтийг харвал Монгол Улсад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн зөрчил харьцангуй бага мэт харагдаж байгаа хэдий ч Мэдээллийн эрх чөлөөний төлөөх Хил хязгааргүй сурвалжлагчид олон улсын байгууллагаас гаргасан Хэвлэлтийн эрх чөлөөний<sup>4</sup> индексээр Монгол Улс 2016 онд 180 орноос 60 дугаар байр, 2017 онд 69 дүгээр байр, 2018 онд 71 дүгээр байранд тус тус орж, сүүлийн гурван жилийн хугацаанд тогтмол доширсоор байна.<sup>5</sup> Үүнээс үзвэл үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хүрээнд анхаарч сайжруулах асуудал байсаар байна.

Иймд энэхүү үзүүлэгээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн талаар зохицуулсан Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлжээдээ үндэсний хэмжээнд хүчин төгөлдөр үйлчилж буй 685° хуулна шууд холбоотой 38 хуул /хувсгалт 3-ийг үзж/ байгаагаас Монгол Улсын Үндсэн хуулинд заасан “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг” хуулийн зорилтоос эхлэн хангахад чиглэсэн байдлыг харгалzan үзж сонгосон болно.

**Судалгааны хүрээ:** Итгэл үнэшилтгэй байж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндэсний арга нь уг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цутглан хийх эрх чөлөө юм.<sup>7</sup> Иймд уг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цутглан хийх эрхийг хангах хоёр хуулинд хэрэгжилтийн үр дагавыг тооюу юм. Дээрх судалгааны хүрээнд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний

<sup>3</sup> Монгол Улсын Хүний эрхийн үзүүлсний комисс, 2018 оны үйл засаглалын тайлбар, 18 дахь тал, <http://pib.mn/ru/medzhezhin-zagts-erchiniin-uyuul-zasgalzalayn-tailbar/>

<sup>4</sup> Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын шатны 19 дүгүүр түймийн 2-д хүн оврүүс сонгосон бусад аргаар угсаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг гэж массан байна. Үүнтэс үзүүл “ковчиг мозгийнхийн трач чөлөө” нь угзэл бодлоо илэрхийлэх эрхийн дээр засвиши аргуудас “Сонин, хамин, логотивыг угзэл бодлоо илэрхийлэх” гэсэн зөвлөн илгээс арга блэгж юм. Энэ талбары шашин дэлгэрүүзэн авч үнэ.

<sup>5</sup> World Press Freedom Index, accessed April 1, 2019, <https://rsf.org/en/ranking/2018>

<sup>6</sup> <https://www.legalinfo.mn/> сүүлийн үзүүлсэн 2019.04.22.

<sup>7</sup> ХБНГУ-ын Хамис Зайдэйний сан, Монгол дахь төлөөлогийн газар, Эрх зүйн боловсролын академи, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, Уб., 2009 он, 98 дахь тал.

тухай хуулийн 1, 2 дугаар зүйл, 3 дугаар зүйлийн 1, 4 дүгээр зүйл, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 14 дүгээр зүйлийн 1.1-д заасан зохицуулалтыг сонгон авч, тэдээрэйн зерэг, сөрөг талыг судалж, хэртэжилтийн үр дагаврыг үзэлжээр судалгааны хүрээг тоогтоо.

**Судалгааны зорилго:** Эзикүү үзүүлэлтийн зорилто нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн тухай зохицуулсан холбогдох хуулийн хэрэгжилтийн явулах хүндэрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж буй ээрэг, сөрөг нөлөөллийг илрүүлж, цашид зохицстой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт егех, санал боловсруулахад оршино.

## НЭГ.ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ОЙЛГОЛТ

Үзэл бодлоо илэрхийлэх эрх нь дундад зуун ба хэмжээлшгүй хаант засаглалаас орчин үеийн тоталитаризмыг хүртэл олон янзын хэлбэрээр илэрхийлэгджээ ирсэн үзэл бодлын дарааныгийн ягсэн хариулт юм. Христос шашин нөхрөхж байсан дундад зууны Европт зөвхөн лам хуврагуд бүх зүйлийн зөв буурут шүүн тогтоо эрхтэй байв. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг байх нь зайлшгүй шаардлагатай юм байна гэсэн олон нийтийн ухамсрлыг бий болгоход хэмжээлшгүй хаант засаглалын дураараа авирлах явдал мөн нөлөөлөв. Байгалийн шинжлэх ухаан хөгжин шашиныг шахаж эхэлсэн үеэс хаант засаглалын үзэл бодлын дарангуйдал улам хүчтэй болж эхэлсэн юм. Хаад ноёд өөрийнгөө бүхнийг мэдэгч эзэм мэтээр өргөмжилж өөрийгөө шүүмжлэх болон өөрнийн нь болдогод гарсан алдаа дутагдлын талаар мэдээлэл тараахыг шууд хориглож байв. Үүнд хариу болгож 1789 онд Францын Хүний ба иргэний эрхийн тунхаглалын 11 дүгээр зүйлд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн эрхийг түүхэнд анх

удаа тунхагласан юм.<sup>8</sup>

1924 оны Үндсэн хуулийн 3 дугаар зүйлний 7 дахь хэсэгт “элдэв хэргийг жинихэн ард түмнээр шүүмжээх эрхийг хүндэтгэж, тус улсаас аливаа хэвлэх, нийтлэх явдлыг бүртгэн гүйцэтгэвэл зохино”, 1940 оны Үндсэн хуулийн 85 дугаар зүйлд “Хөдөлмөрчийн ашиг тусад нийцүүлэн мөн Бүгд Найрамдах Монгол Ард улсын байгуулалтыг батттан бэхжүүлэхийн төлөө, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын иргээд хуулиар батлан олгох эрх нь: “Чөлөөтэйгээр уг хэлэх, чөлөөтэйгээр хэвлэн нийтлэх, хурал ба индрийн хурлыг чөлөөтэйгээр явуулах, гудамжаа жагсах, явах” нь тус тус чөлөөтэй” гэж заасан бол 1960 оны Үндсэн хуулийн 87 дугаар зүйлд “БНМАҮ-ын төрийн байгууллыг хөгжүүлэн бэхжүүлэх зорилгоор хөдөлмөрчдийн эрх ашигт нийцүүлэн БНМАҮ-ын иргээдээ: “Уг хэлэх, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, жагсаал ёслол уйлдэх эрх чөлөөг хуулиар батлан олгоно”, гэж тус тус заасан байна. Харни одоо үйлчилж буй 1992 оны Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хамгаалж, дор дурдсан заалтаар баталгаажуулсан.

Арван зургадугаар зүйлийн 16.

“Итгэл үзмэшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, уг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тоостооно.”

Арванзургадугаар зүйлийн 17.

“Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлсан хамсаалвад зохиц нууцад хамарагчгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, угсын батлан хамсаалах, үндэсний аюулгүй байдал, нийтийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр байгууллага, хувь хүний нууцыг

<sup>8</sup> Мориц Лоренц, “ХБНГУ-ын Үндсэн хуулийн 5.1.1.1-р залтцаа тодорхойлсон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн арчилвал ба плокаризмын чухал элемент хэмээн үзэх нь”, Төр, эрх зүйн хуудас-Эргчүүлэл, Уб., 2000 он, №7, 106 дахь тал.

#### ХУУЛИАР ТОГТООН ХАМГААЛТАА.<sup>9</sup>

Үг хоёр заалт нь иргэдийт засаг төрийн байгууллагын үйл ажиллагайд оролцох, хяналт тавьж, авлига, хувь суртал чирэгдэл, бусармаг явдалтай тэмгийг баталгааны үндэс нь болдог.

Итгэл үзмэшилтэй байж үзэл бодлоо илэрхийлэх нь хүний сэргэл зүй, улс төр, ёзүй болон бусад шинжийг илэрхийлсэн процесс юм.<sup>10</sup> Энэ эрх чөлөө нь хүний мөн чанар, оршин байгаатай нь холбогдои гаряа ирдэг, төрөөс тогтоодогтүй түүнээс анхид оршидог, хүний төрөлх буюу оюун санааны эрх гэж ойлгож болно. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөө нь маш эмзэг, байнга хөндгдэж байдаг бөгөөд түүнийг маш зөв, соёлтой хэрэглэх, хамгаалах учиртай.<sup>11</sup>

Үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө нь:

- Мэдээлэл, үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, (уг халз);
- Бичгээр буюу хэлэгээр (хэвлэн нийтлэх);
- Уран сайхны хэлбэрээр үзэл бодлоо илэрхийлэх эрх;
- Түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар үзэл бодлоо илэрхийлэх эрх;
- Эрж хайх (мэдээлэл авах);
- Хүлээн авах (мэдээлэл хүлээн авах);
- Түгээх эрх;
- Тайван жагсаал, цуглаан хийх эрх;
- Эвлэлдэн нэгдэх эрх;
- Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх;
- Ажил хаях;
- Өлсгөлөн зарлах зэрэг “нэгэн” багц эрх<sup>12</sup>, эрх чөлөөний бурдал энхжүү улс төрийн эрх, эрх чөлөөний эх сурвалж, аянхдаг суурь эрх бол үзэл бодлын эрх, эрх чөлөө юм.

<sup>9</sup> Монгол улсын Үндсэн хууль, Төрийн илдэлээл эмсээгээ №1, Уб., 1992 он.

<sup>10</sup> Ж.Амарсанаа, “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”, Хамс Зийдслийн сан, Төр, эрх зүйн хуудас-Эргчүүлэл, Уб., 2000 он, №7, 103 дахь тал.

<sup>11</sup> Глоб Интернейшнл ТБ, “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”, Стүгүүлч ба хууль, Уб., 2001 он, №3, 23 дахь тал.

<sup>12</sup> Хууль зүйн үзүүлсний хэрэглэлийн, Хэмжэлийн эрх чөлөөний тухай хуультай холбоотой судалгаа, Уб., 2004 он, 2 дахь тал.

Иргэн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хүрээнд төр, нийгэм, орон нутгийн хүрээнийн асуудлыг шийдвэр үйл хэрэгт дараах байдлаар оролцож болно. Тухайлбал,

- Оршин буй газрынхаа баг, хороондын иргэдийн нийтийн хурал, олон нийтийн пулсаанд оролшох;
- Улсын Их хурлын гишүүнээр дамжуулах;
- Олон нийтийн санал асуулга явуулахад оролцох;
- Хуулийн хэлэлцүүлэг, санал шүүмжлэлд оролцох;
- Төрийн бус байгууллагаар дамжуулах;
- Сонин, хэвлэл, төлөвийн эрх үзэл бодлоо илэрхийлэх;
- Төрийн байгууллага, албайн тушаалтанд захидал бичих;
- Жагсаал цуглаанд оролцох;
- Өөрсдийн санаалаа өргөн барих;
- Олон нийтийн хандажаа уг хэлэх<sup>13</sup> зэргээр бодлогаа боловсруулах бүх шатны үйл ажиллагаанд оролцож болно.

Гээни хэдий ч үзэл бодлоо илэрхийлэх эрх нь дээрдурдсан эрхээр хязгаарлагдахгүй бөгөөд итгэл үзүүлжтэй байж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн арга нь уг хэлэх, хэвлэл нийтийн, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөө юм.<sup>14</sup>

### ХОЁР. ҮЗЭЛ БОДЛОО ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХИЙН ХЯЗГААРЛАЛТ

Үндсэн хууль болон олон улсын хүний эрхийн грээний дагуу хэзээ ч ямар ч тохиолдолд хязгаарлаж үл болох түйлэн (абсолют) эрхүүд бий. Жишэлэлээр, эрүү шуулт, хүнлэг бус, хэрчгий, доромж хандлагаас ангид байх. Үзэл бодлойт байж (энэ нь үзэл бодлоо илэрхийлэхээс ялгаатай) эрхийг ямар нгээн байдалар хязгаарлаж болохгүй.<sup>15</sup> Харин түйлэн эрхээс бусад

<sup>13</sup> Монгол улсын Хүний эрхийн үндсэн комисс, "Хүний эрхийн цуврал нийтийн", УБ, 2012 он, 54 дж тал.

<sup>14</sup> ААНГУУ-и Ханс: Зайдэлэйн сан Монгол дахь төлөөлгөгчийн газар, Эрх зүйн боловсролын академи, Монгол улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ, 2009 он, 98 дж тал.

<sup>15</sup> О.Монхсайхан, "Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний нийтийн цуврал нийтийн", Эрх түйн ститгүүл, УБ, 2017 он, №2, 7 захын чад.

хүний үндсэн эрх, эрх чөлөөг бусдын эдлэх эрхээр хязгаарлаж болно. Үндсэн эрхийн агуулга, заагийг нарийвчлан тодорхойдох эрх үүргийг Үндсэн хуулиар хууль тогтоо байгууллагад ногдуулж болох юм. Энэхүү эрх үүргийг хязгаарлаагүй тохиолдолд үндсэн эрх нь засаг захиргааны байгууллага үйл ажиллагаагаар хуулийн дагуу явуулах ёстой гэсэн эрх зүйт төрийн ерөнхий зарчмаас өөр баталгаа угтуй болно. Хуулийн үндсэн дээр үндсэн эрхийн баталгааг хөндж болно хэмээсэн тайлбар бүхий баталгаа нь үндсэн эрх чөлөө, эрхэд гагихүү хуулийн үндсэн дээр халдаж болно гэсэн хууль зүйт төрийн ерөнхий зарчмаас урган гарч байгаа юм.<sup>16</sup> Хууль тогтоогчийн үндсэн эрхийн хязгаарлалт нь:

- Үндсний аюулгүй байдлыг хангах;
- Нийгмийн хэв журмыг хангах;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх;
- Бусдын эрүүл мэнд, ёс сууринхууныг хамгаалах;
- Хүний нэр тэр, алдар хүндийг хамгаалах;
- Шүүхийн хараат бус байдлыг хангах гэх мэт<sup>17</sup> зайшигүй шалтгаанаар уг эрхийг эдлэхэд тодорхой хязгаарлалт тогтоодог ч уг эрхийн жам ёсны мөн чанар болох үзэл бодлойт байх эрхийг хязгаарлан хөндөх ёсгүй юм.

### ГУРАВ. ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХ ЧӨЛӨӨ БОЛОН ХУУЛЬГОДХОО ХУУЛЬ ТОГТООМОЖ БУСАД ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТ

Дээр дурлсанчлан<sup>18</sup> жагсаал цуглаан хийх эрх чөлөө нь Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний үндсэн аргын нэг юм. Учир нь улс төр, нийгэм, зийн застгийн тодорхой асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд иргэн ганицаарах үзэл бодлоо илэрхийлбэл тийм

<sup>16</sup> Мори Лоренц, "ХБНГУ-ын Үндсэн хуулийн 5.1.1.1-р залгыл тодорхойлсон үзэл бодлоо чөлөөгийг илэрхийлэх эрхийг арчиллаа ба плорализмын чухал элемент хэмжээг үзүүлжээ. Төр, эрх зүйн хуудас-Эрэгцүүлэл, УБ, 2000 он, №7, 107 дахь тал.

<sup>17</sup> Монгол улсын Хүний эрхийн үзүүлжилж үзүүлжилжийн комисс, "Хүний эрхийн цуврал нийтийн", 2013 он, 59 дж тал.

<sup>18</sup> Энэ талаар судалгаваны 4 дж талд дурдаж огон

ч үр дүнтэй биш бөгөөд хамгаараа цуглаад үзэл болдоо илэрхийлбэл үр дүнд хүрж магадлал нь нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл, жагсаал, цуглаан нь хүмүүст дуу хоолойгоо хүчтэй илэрхийлэх боломж олгодог, олон нийтийн анхаарлын илүү татдаг төдийгүй хэвлэл мэдээллийн хэрэгслийг ч татан оруулж чаддагаараа аливаа шийдвэр гаргалтанд илүү нөөцөлүүдээгээж халж болно. Цуглаан нь мөн улс төрийн намын гол үйл ажиллагаанаа нэг бөгөөд хүмүүсийн үзлэл болдлыг чөлөөтэй илэрхийлэхийг зөвшөөрхөгүйгээр ардчилсан сонгууль явагдах боломжгүй. Мөн, цуглааны үеэр хүмүүс өөрдийн итгэл үнэмшил, шашин шутлэг үзэл болдлыг илэрхийлдэг учраас энэ эрх чөлөө нь итгэл үнэмшилтэй байх, шашин шутлах, үзэл болдоо илэрхийлэх эрх чөлөөтэй хамт хэрэгждэй.<sup>19</sup> Энэ ч үүднээс үзлэл болдоо илэрхийлэх, уг хэлэх эрх чөлөө болон тайван, жагсаал цуглаан хийх эрх нь нэг нь нөгөөгүйгээр хэрэгжих боломжгүй хоорондоо нягт уялдаа холбоотой байдгаараа оншлог юм. Үзэл болдоо чөлөөтэй илэрхийлэх гол арга болох тайван жагсаал, хийх эрхийг дотор нь:

1. Тайван жагсаал, цуглааныг санаачлах эрх;
2. Тайван жагсаал цуглааныг зохион байгуулах эрх;
3. Тайван жагсаал цуглаанд оролцох эрх гэж гурав ангилан авч үзэж болдог байна.<sup>20</sup>

Жагсаал цуглаан хийх эрх чөлөөт хангах үүднээс УИХ-аас 1994 оны 7 дугаар сарын 7-ны өдөр “Жагсаал цуглаан хийх журмын тухай” хуулийг баталсан. Уг хууль нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16-д заасан хүний үндсэн эрх хэрэгжих чухал баримт бичгийн нэг болсон бөгөөд анх батлагдаадаа жагсаал, цуглаан зохион байгуулахдаа Засаг даргаас “зөвшөөрөл” авдаг байсан бол 2005 онд энэ хуульд нэмэлт, өөрчлөлт

<sup>19</sup> О.Мөнхсайхан, Жагсаал цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжүүт, Шүүх эрх мэдээ сэргүүл, Уб., 2018 он, №1, 15 дахь тал.

<sup>20</sup> Д.Ороско, Тайван, жагсаал, цуглаан хийх эрх, түүний эрх зүйн үндсийг шинийн тэхникч асуудал, Хууль дээдлэх ёс, Уб., 2004 он, №3, 41 дахь тал.

оруулж “зөвшөөрөл” гэдэг үгийт өөрчилж “мэдэгдэл” болгосон. Мэдэгдлийг бүртгүүлсний үндсэн дээр кагсаал, цуглаан зохион байгуулах нь үндэсний аюулгүй байдалд эрдэл учруулах, нийгмийн дэг журмыг алдагдуулах, хүн амын эрүүл мэндийг хожирох, бусдын эрх чөлөөнд халдах аюулт байдлаас сэргийлж зорилготой хэдий ч дээрх зохицуулалт ийншигүй шаардлагатай тохирсон эсэх нь эргэлзээтэй байна. Тухайлбал:

Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дутгэр зүйлийн 1-д “Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлнэ.” Жагсаал, цуглаан хийхэээр төлөвлөсөн гудамж, талбай нь хөөр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамгаарах газар нутгийг хамарч байгаа бол мэдэгдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгч бүртгүүлнэ.” хэмээн заасан бөгөөд Засаг дарга мэдэгдлийг хүлээн авсан эхэээ ажлын 3 одрийн дотор бичгээр мэдэгдэх Үүрэгтэйгээр зохицуулсан. Мэдэгдлийн тогтолцоо нь нэг талаас Засаг даргад мэдэгдсэн тэр өдрөө л жагсаал, цуглаан хийж болдог. Нөгөө талаас жагсах, цуглаан хийж болдог байгаа хүмүүс рүү бусад ирэгд болоод байгуулаагас халдаж, саал учруулахаас сэргийлж. Мөн жагсаж, цуглааж буй иргэд эмх замбаараагүй байдал бий болгож бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд хожирол учруулахаас юм бол таслан зогсооход бэлэн байна. Ийм учраас мэдэгдэх ёстой байлаг. Үүнийг мэдэгдлийн тогтолцоо гэх бөгөөд Энэ нь өөрөө нийгмийн дэг журам, үндсний аюулгүй байдал зэрэг ашиг сонирхлуудыг зайлшгүй хамгаалахад зориулагдсан тогтолцоо юм.<sup>21</sup> Гэтэл дээрх хуулийн заалт дахь мэдэгдлийг бүртгэх үүрэг бүхий субъект болох Засаг даргыг Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 9-д төрийн улс төрийн албан хаагч байна гэж хуулын тус. Иймд тодорхой иэг улс төрийн үзэл суртал зэрэгээс үүдэн Засаг дарга жагсаал, цуглаан хийх мэдэгдлийг бүртгэхгүй

<sup>21</sup> О.Мөнхсайхан, Иргэлдийн жагсаал, цуглаан хийх эрх чөлөө Засаг даргын эзэмжээр халж, боож байна, /приншилага/, <https://ikon.mn/n/zly>

байх удаашрах ээрэг нөхцөл байдал үүсэх боломжтой харгааж байна. Энэ талаар жишээ дурдвал, Захигравын эзргийн анхан шатны шүүх 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдөр ижээмжлэгч Давий-Осор овогтой Ариун-Адъяа, Янжин овогтой Мөнхбат, Цэлхүү овогтой Ууган, Доржпүрэв овогтой Хатсанслэнгий нарийн нэхэмжлэлтэй Сонгино хайрхан дүүргийн Засаг даргад холбогдох эзргийг хянан хэлэлцэх 406 дугаартай шийдвэр гаргасан бөгөөд дээрх шийдвэрлийн агуулга нь Сонгионхайрхан дүүргийн Засаг даргын жагсаал, цуглааныг бүртгэхгүй байгаа эс үйлдэхүүг хууль бус хэмээн бүртгэхийн давлалт шийдвэрлэсэн байна.<sup>22</sup> Үүнээс гадна практикт Засаг дарга хуульд заагаагүй үндэслэлээр мэдэгдлийт бүртгээсээ татталзах тохиолдод гардаг байна. Жишээ нь: 2006 онд “Эрүүл нийгэм” иргэний хөдөлгөөнөөс жагсаал, цуглаан хийх мэдэгдэл өгөхэд Засаг дарга “Өөр үйл ажиллагаатай давхцасан, автомашини хөдөлгөөнээс саад учруулна, иргэдийг бухимидуулна” тэсэн шалтгаан хэлж, татталзсан байна.<sup>23</sup>

Иймд дээрх хуулийн зохицуулалтас үзүүлж ирэгийн үзэл бодлыг Засаг дарга хяналж жасаал, цуглаан хийх мэдээллийг бүрдгүй эсвэл бүртгэхгүй байх эрх зүйн орчин бурдсан байна.

ДӨРӨВ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ БОЛОН ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ БУСАД ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТ

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах үүднээс УИХ-аас 1998 онд баталсан "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай" хуулийн 2 дугаар зүйлд хэвлэл мэдээллийн чөлөө, мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хяглаарласан хууль батлан гаргахыг, 3 дугаар зүйлд төрөөс олонийтийн мэдээллийн агуулагад хяналт / цензуур/ тавихыг, 4 дутгэр зүйлд төрийнхийн байгууллага оффшорийн мэдээлд хэвлэл

мэдээллийн хэрэгсэлтэй байхыг тус тус хориглож хувьлалт мэдээллийн хэрэгсэл нь өврийн нийтэлж, извтрүүлж байгаа зүйлийн төлөө харинцлага хүлээлгэхээр заасан байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаатай шууд хөлбогдох эрх зүйг агуулдыг судалж үзэхэд Олон улсын гэрээ 4, хууль 44 /хөвсрэлт 1-ний узэх/, УИХ-ын тогтоол 6, Улсын дээд шүүхийн тайлбар 14 байлаа. Эдгээр актыг судлах явцад зарим алдаа дутагдалтай хийгдэж ёстой ажиллагаа хийгдэгжүүг үр дүн нь гаргарагүй байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал, 2005 онд баталсан Олон нийтийн радио телевизийн тухай хуулиар төрийн мэдэлд байсан үндэсний хэмжээний радио, телевизийт “олон нийтийн” болгоц өөрчилж, 2011 онд баталсан Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрх чөлөөний тухай хуулиар төрийн байгууллагаас олон нийтийн ажлыг сонирхолд хамаарах мэдээлэл авах иргэдийн эрхийн баталгаажуулсан.

УИХ-аас 2003 оны 41 дүгээр тогтоолоо Монгол Улсад хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр батлагдсан бөгөөд уг хөтөлбөрт “Нууц хамгаалах хуулиудаар тогтоосон илүү хязгааралтгыг арилгах зэрэггээр төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтын үйл ажиллаганы их тод байдлыг хангаж, энэ талаар иргэд, хувьзлалтад мэдээллийн ажилтын хүснэгт шаардлагатай мэдээлэл гаргаж өгөх үүрэг, харшуулага нргэдээс мэдээлэл олж авах түгээх эрхийг нь нарийвчлан тодорхойлсон хууль, эрх зүйн үндэсний бүрдүүлэн”, “Олон нийтийн хувьзлал мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг дэмжин төрийн болон орони нутгийн өмчид байгаа хувьзлал мэдээллийн хэрэгслийг зах зээлийн харилцаанд нийцүүлэн бие даасан байдлыг бэхжүүлэх зохион байгуулалт эрх зүйн арга хэмжээг авна”, “Хувьзлал мэдээллийн эрх чөлөөтийг холбогдох хууль тогтоомжид судалгаа хийж, зөрчинийт зүйл, заалтыг хүчинчтүй болгох, нэмэлт, ширчлэлт оруулах зэрэгээр хууль тогтоомжийг боловсрондийн

[Page 1 of 1] [Page Number: 1138] [Page Type: Main]

3 О.Менжалихан, Иргэдийн хэгсын, цуглалын хийх эрх чөлөө  
Засаг даргын узмыгчур хаах, боож байна, /врилишлаг/, <https://ikom.snn.ru/zly>

боловоно", "Мэдээллийн эх сурвалжаа нууцлах хамгаалах сэргүүлчийн эрх, үүргийг хуулиар баталгаажуулж, иргэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтан узэл болдоо чөлөөтгий илрхийлж эрхээ здлээдээ хүчин нэр, нэр төр, алдар хүнийн халдашгүй байх эрхийг зөрчихөөс сэргийлж, зөрчигдсэн эрхийг нь бүрэн сэргээх эрх зүйн механизмыг тодоттон сайжруулна" зэрэг ажлыг гүйцэтгэхээр тусгасан боловч дээрх ажлын хүрээнд хийгдэх зарим арга хэмжээнүүд төдийлөн хэрэгжээгүй байгаа нь энд талаарх хийгдсэн судалгаа болон тайлан мэдээнүүдээс харагдаж байна.<sup>24</sup>

УИХ-аас 2004 оны 26 дугаар тогтоолоор Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай тогтоол гаргасан бөгөөд уг тогтоолоо "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлыг судлан боловсруулж шийдвэрлэнэ" гэж заасан ч хэрэгжээгүй байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нь өөрөө тунхгийн шинжлэй учир хуулийн зүйл заалтууд нь өөр бусад хуультай зөрчилдсөн гэж үзж болохоор 5 хууль байна. Үүнд:

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-д "Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд харьяа агентлаг, аймаг, нийслэл /дүүрэг/-ний цэргийн штаб, батлан хамгаалах чиглэлийн улсын үйлдвэрийн газар, цэргийн сургууль, судалгаа шинжилгээ, сургалт-үйлдвэрлэл, түршилт, соёл, урлаг, спорт, эрүүл мэнд, хэвлэл мэдээллийн байгууллагатай байна.", Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд "Хот сонин, радио, телевизтэй байж болно" гэж тус тус заасан байгаа нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1-д "Төрний байгууллага өөрийн мэдээл

хэвлэл мэдээллийн хэрэгслэгэй байхыг хориглоно." гэсэн заалттай зөрчилдэж байна. Өөрөөр хэлбэл, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд заасны дагуу төрийн байгууллагад харьяалагдах хэвлэл мэдээллийн байгууллага байх ёстой юм.

2005 онд батлагдсан Олон нийтийн, радио төлөвзүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4-д "Олон нийтийн радио, төлөвзүйн хэвлэл, мэдээлэл, нэвтрүүлгийг дамжуулж байгаа бол эх сурвалжийг заавал дурдана." гэж заасан нь мэдээллийн эх сурвалжaa нууцлах хамгаалах сэргүүлчийн эрх. Үзэл болдоо илрхийлж эрх чөлөөг хаасан зохицуулалт болсон гэж үзж болохоор байна.

Түүнчлэн 2016 онд батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4-д "Сонин хэвлэл, төлөвзүйн, цахим сүлжээ ашиглаж, хүхийн хувийн нууцаад халдаж дуу, дуу-дүрсний, дүрсний бичвэр, гэрээ зураг тараасан, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж мэдээлэсэн, олны өмнө гутаасан ажилтан, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд хуулиар заасан хариушлага хүлээнгэнэ." хэмээн заасан бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараасан тохиолдолд ямар хариушлага хүлээнгэх нь тодорхойгүй байна.

Мөн 2015 онд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар гутгях, доромжлох асуудлыг тус хуулиар бус, Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэхээр болсон гэх мэт хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хэрэгжүүлэх зөрэг эрх, зүйн орчин бүрдсэн хэдий ч цаашид анхаарах асуудал байсаар байна.

Монгол Улсад олон жил Эрүүгийн хуулиар гутгэлгээ, доромжлолыг гэмт хэрэгт тооцож ал шийтгэж ирсэн байдал. 2015 оны шинэчилж найруулсан Эрүүгийн хуулиас халсан нь үзэл болдоо илрхийлж, уг хэлэх эрх чөлөөг хамгаалахад чухал нөвлөлсөн хэдий ч 2017 оны Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 21 дүгээр зүйлд "1.Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон

<sup>24</sup> Мэдээллийн эрх чөлөөний талеөх Хил хэлэгваргийн сурвалжлагч, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн орчин судалгаа, <https://mongolia.mom-rsfs.org/mn/translation-context/translation-law/>.

худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган изгэжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийт хорин мянган изгэжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тортогоно.” хэмээн хуулийлж өгсөн бөгөөд ажил хэргийн нэр хүнд гэх ойлголтыг оруулж өгсөн нь зөрчлийн хүрээг өргөжүүлсэн зохицуулалт болсон.

Ингэснээр албан тушаалтнууд гүтгэх, доромжлох гэмт хэрэгтай адилхан гүтгэх зөрчлийг өөрслүүн эсрэг эсхүл нийтийн ашиг сонирхлын төлөө шүүмжийт хааж бооход ашиглах эрсдэл хэвээр байна. Мөн Зөрчлийн хуулиар гүтгэсэн гэж их хэмжээний төгрөгөөр тортог шийтгэх хүлээлгэх боломж нь үзэл болдоо илрэхийлэх болон хэвлэх нийтлэх эрх чөлөөт өдлэхэд айдас төрүүлдэг. Их хэмжээний тортгууль төлөх айдас нь нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуултыг хэвлэх, мэдээлэхээс хэвлэлийнхэн татгалзахад хүргэн,<sup>25</sup> гэж үздэг байна.

## ДУГНЭЛТ

